




ШОТА
ДУСТАВЕЛИ

БАРСАН
ХЭВНЭГТ
БААТАР



ШОТА РУСТАВЕЛИ

БАРСАН
ХЭВНЭГТ
БААТАР



УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ХЭРЭГ ЭРХЛЭХ ХОРОО
УЛААНБААТАР

1965

Д. ГОМБОЖАВ
орчуулж
Х. ПЭРЛЭЭ
найруулан засав

НАЙРУУЛАН ЗАСАГЧААС

Гүрж түмний яруу найрагч
Гүн ухаант Шота Руставелийн
Оюун сэтгэлийг булаан эзэмдэгч
Оргил сайхан уран найргийг
Залуу шүлэгч Доржийн Гомбожав
Завдан сонирхсж орчуулав.
Эрэлхэг баатрын явдлыг хавархагч
Энхрий хайрт сэтгэлийг бахархагч
Уйгагүй уншигч нарт таалагдаж,
Утгыг танилцуулж чадах аж.
Олон түмний шүүмжээр тунгаагдтугай!
Орчуулга зохиолын санд ортугай!


1961—10—31.

Х. ПЭРЛЭЭ



**БАРСАН
ХЭВНЭГТ
БААТАР**





О Р Ш И Л

Эрхт дээд тэнгэрт энэ хорвоог бүтээж
 Эрдэнэт хүний төрлийг орчлон дахинаа заяаж,
 Эх болсон дэлхий, эрхэм бүхнийг соёрхож
 Энгүй буянт эздэд хаан ширээ хайрлажээ.

Орчлон дахиныг бүтээсэн оройн дээд эзэн минь
 Ороолон шулмыг намнах зориг хүчийг хайрла!
 Орон дэлхийг орхитол зүрхний галыг дүрэлзүүл
 Осол гайгаар хийсэн хилэнций минь хөнгөвчил!

Үзэмж төгөлдөр мэлмий тунгалаг наран хатан Тамарыг
 Үлэмж сүрт сэлэм, дуулгын эзэн арслан зоригт эрийг
 Үзсэн хүн нүд хужирлаж бал амтлагч баатрыг
 Үг зүйж мөнхлөн чадах буюу болхи би

Эртнээс би магтсан хатан хаан Тамарыг
 Элэг зүрхний угаас бишрэн бишрэн дуулъя.
 Энэлэх нулимсан нуурт дэвтсэн бийрээ барья
 Энхрий олны зүрхэнд дуулал минь нэвтлэн шингэтүгэй.

Хайр чулууг бутчиж хатан төмрийг эмтэлдэг
Хаш эрдэнэ адил тэгш цагаан шүд
Хавтгай гуа цогцос харах нүд, хөмсөг
Хамаг сайхан бүхний нь би магтах учиртай



Үгийн уран угалзаар Тариэлийг алдаршуулж
Үйлс тавилан нэгтэй гурван баатрыг дуулахад
Онц билэг, цэцэн үг, ой ухаан бүхнийг
Оюун сэтгэл, онгон суу над харамгүй хайрла

Түмэн зовлон амссан Тариэль шиг хүн байхгүй
Түүнийг өрөвдөн хямрахад урсах нулимс барахгүй
Үлгэр домогт байсныг үнэт эрдэнэ болгон
Үг шүлэг найруулан Руставели гэгч хэлхлээ

Энэ дууллаа зохиоход оюун ухаан балайрч
Эр цэргийг захирагч хатан хааныг биширч
Амь насаа зориулавч сэтгэлийн зовлон анагаашгүй,
Амраглаж аврах буюу хөнөөхөөс өөр аргалшгүй.

Гар гар дамжин явсан сувд эрдэнэ адил
Гайхамшигт Ираны домгийг Гүрж аялгуунд нийлүүлэн
Уран шүлэг болгон угалз хээ мэтгэнэм,
Уян зүрхийг бэртээсэн хатантны таалахыг горилном.

Харах нүдийг гялбуулагч гэгээ гэрлийг мөрөөднөм,
Хайлж шаналсан сэтгэл бөглүү хөдөөд гунигланам,
Энэ бие минь зүдэж авралыг хүлээн гиоүрнэм,
Эрэлхэг гурван андыг магтах шүлэг минь оргилном.

Арвин хорвоогийн тавиланд сэтгэл ханавал таарна,
Ажиллах нь ажиллахад зоригтой нэг нь тулалдана,
Амрагийн сэтгэл цоргиж сэгхийхгүй бол
Алив нэгнийг бүү хэл, амьтны хэлэхээс бүү зов.

Яруу найраг гэдэг мэргэдийн сургаал адил,
Язгуурт тэнгэр заяагаад өөрөө ч бас зугаацдаг,
Чихтэй болгон сонсож амт шимтий нь амсдаг,
Чин сайхныг нягтхан илчилж чаддаг нь нандин.

Ялдам шүлгийн үнэргүй бадаг мөрхөн холбочихоод
«Яруу найргийн оргил» гэж илжиг шиг орилогч байх юм,
Ганц хоёр шад шүлэг гай болж хэлхчихээд
Гаарч шүлэгч боллоо гэж өөрийгөө бүү хуур.

Хайр сэтгэл бат бол хамаг мууг тэвчинэ.
Хань ижлээс холдохдоо шүүрс алдан тарчилна.
Хувь тавилан бэрх ч өнө л түүнээ мөрөөднө.
Хувиршгүй амрагаа л таалан таалан энэрнэ.



Өнөө маргаашийг харж хэн хүнтэй шалиглахыг
Өнө батын сэтгэл гэж мангуу толгойтон бодно.
Шалдар булдар багачуул л ингэж санана.
Шаналж зовлон даагч л ёстой ариун амраг.

Догдолсон сэтгэлээ барьж амар тайван байх
Дотно хонгороо санаж зовлон амсаж суух
Хагацан одохын цагт гунигийн дээдийг эдлэж
Хайртны хилэнг тэвчих янагийн ёс буюу.

Амссан зовлонгоо нууж амрагаа ичээхгүйн учир
Амьтан хүний дэргэд ажиг ч үгүй явж
Хоёр биеэрээ учрахад зовлон жаргалаа хуваалцах нь
Хорвоо ертөнцийн ивээсэн янагийн ёс буюу


Өргөсөн тангаргаа няцааж амрагийн ёсыг зөрчвөл
Өрөөл ханиа хорлож өөрийгөө зовоох биш үү.
Нууцгай сэтгэлээ задруулбал янаг бүсгүй ичиж
Нүүр хийх газаргүй зовон шаналах биш үү.

Сэтгэлтэй гэж хашгичиж хөөрхий бүсгүйг зовоон
Сэхэшгүй шарх олгохыг ихэд гайхнам би.
Худал үг гэдэг шалиг хүний ёс буюу.
Хуурамч дурлал гэгчийг нээх гэдэг дэмий буюу.

Аглаг ойд очиж даяанч адил суухдаа
Алив будлианыг тайлж амрагаа дурсаж байхдаа
Алаг зүрх шаналахыг буруу гэхгүй боловч
Амьтан хүний дэргэд сэтгэлээ барих нь зүй.

Шүлэгч гэдэг нэрийг бишрэх хувьтай.
Шүр сувдан эрдэнэ дэмий үрэхгүй байлтай.
Үнэнч амрагаа өргөж уран дуулах увьдастай.
Үгийн аялгуу уянгалж харамж горилохгүй нь ноттой.

Цор ганц түүнээс л үүрд би дуулсаар
Цохолж бүх нууцаа дэлгээгүйдээ бахаднам.
Чанд хатуугаас нь халшралгүй мөнхийн хайраар дурссаар
Чанагш бас түүнээ дээдчилэн өчнөм.



I

АРАБЫН ХААН РОСТАНЫ ҮЛГЭР

Уран цэцэн үгтэй, эелдэг, даруу өглөгч
Улсыг мэргэн жолоодогч, шударга хуульч, зоригтон,
Урьдын ерөөлөөр учирсан, хүчит цэргээр алдаршсан
Ухаант хаан Ростан Араб оронд байжээ.

Гэр нэвт гэрэлтэй, туурга нэвт туяатай
Гэнэт нэг харсан ч сэтгэл зүрх булаадаг
Гоц их ухаантан магтаж байвал таарах
Гов ганц охиноос өөр үргүй юмсанжээ.

Өсөж өөдөлж яваад нь нар хүртэл атаархам
Өлзийт тэр охиныг Тинатин гэдэг юмсанжээ.
Хаан, шадар түшмэлтэйгээ зөвлөлдөхөөр урин дууджээ.
Хамаг язгууртан нь ирж эрхэмсэг эзэндээ бараалхажээ.

«Над та нар тусал, харамгүй зөвлөлгөө өг,
Нар нэгэнт шингэвэл, өтгөн харанхуй болдог.
Сарнай цэцэг хэрэв өнгө нь гутаж муудвал
Сайхан цэцэрлэгээс зайлж шинэд ороо өгдөг.»

Үхэх цаг ойртдоо, өглөх гэдэг зовлон.
Өнөө маргаашгүй боллоо, ертэнц гайгаар дүүрэн,
Нандин үнэтэй юм гэсэн ч байсан биш үү?
Нарнаас гуалиг охин минь төрийн жолоог бариг!»

Өнөр түшмэл хариулж, «Өтөлж өвгөрсний талаар
Өндөр ивгээлт хаан минь дэмий ярих хэрэггүй.
Өнгө нь хатсан ч сарнай, цэцэг бүхнээс тансаг
Өчүүхэн од олон ч сартай зүйрлэх аргагүй.

«Эзэн хаан минь сарнай гутах болоогүй
Энэний тухай тэгж хэлэх тохиромжгүй
Харин таны таалал санасанчлан бүтнэ.
Хайрт гуа охин тань төрийн жолоо барина»

Эм ч гэсэн хаан хүний үр хойно
Энд бид зусардахгүй, ухаантан шиг захирна.
Энгүй гуад нь тэнцэх үйл ажлын тэтэм байна.
Эр, охин ч гэсэн арслангийн зулзага ялгаагүй.

Уулын мод шиг гуа усан болор шиг цэвэр
Ургах нар, сар шиг жавхаатай төрсөн эр
Удамт жанжны хүү Автандил гэдэг баатар
Уяруулам харцтай нь тулгарч Тинатинд сэтгэлтэй болжээ.

Залуу баатрын зүрхэнд нууц дөл бадарч
Зайдуу байхдаа цонхийж, саргай цэцэг шиг гутаж
Хожим дахин уулзахдаа зүрхний нь шарх хөндөгдөж
Хосгүй ийм сэтгэлтнийг өрөвдөж байвал таарах аж.

Аав нь хувьтай охиндоо хаан ширээгээ өгөхөд
Автандил баатрын зүрхэнд алсын найдлага төрөөд
«Ариун болор дүрийг ахин ахин харах нь
Аягүй шаналсан бие засарч мэдэх нь» гэжээ.

«Эцэг нь би охиноо хатан хаан болголоо.
Энхрий ивгээлд нь багтагчийг наран адил гийгүүлнэ.
Эрхэмлэж түүнийг бишрэгчид хүрэлцэн ирвэл зохино» гэж
Элч зарлагаа хаан арван зүгтээ мордуулжээ.

Эзэн хааны ордонд цэрэг, ард дүүрэн
Эд бүгдийн дотор Автандил жанжин содон
Баруун гарын түшмэл нь хаан ширээг залахад
«Бахдал төгс түшгээ» хэмээн олон цөмөөр биширчээ.



Ариг тансаг охиноо хаан дагуулж ирээд,
 Алтан өнгөт ширээнд урин залж суулгаад,
 Эзний дээл, малгай өөрийн гараар өмсгөөд
 Эрдэнийн үнэт таягаа өргөн барьж өгчээ.

Дээдийн заяагаа мэдэж, охин бүхнийг ширтэхэд,
 Дэргэдэх торгон цэрэг, аав нь бас сөгджээ.
 Алдар цуугий нь магтаж, бүрээ цан хангинажээ.
 Анхил охины нүдийг ариухан нулимс бүрхжээ.

Асгаран гарах нулимс үер адил урсаж
 Давын ширээг залгахдаа охин зовохыг үзээд хаан
 «Эцгээ, үр нь орлодог энэ ертөнцийн жам.
 Эрслэн би зөрчвөл хөнөөлгөн мөхөх байсан»

«Мэгшиж уйлахаа боль, миний үгийг сонс!
 Мэдэл эрхээ өгч Арабын эзэн болгов.
 Мэнд амгалан улсдаа чи ганцаар өмөг.
 Мэргэн ухаан зарж, зөв зүйтэй захир...» гэв.

Бузар өвсийг ч наран сарнай адил гийгүүлнэм.
 Булт олныг ивгээж ядуу, чадуугүй тэтгээрэй.
 Өглөгч элбэг байвал буруу санаатан ч биширнэм
 Өгөөмөр рашаан хайрлав гэж далай эс ширгэнэм.

Хаан дээдсийн чимэг нь өглөгч талбиун нь буюу
 Хар санаатан ч атугай буянтныг шүтэх буюу.
 Харамч хявцаг байваас өөдлөх гэдэг ёсгүй.
 Хайрлаж түгээсэн хишиг эргэх гэдэг мадаггүй».

Ухаант эцгийн сургаалыг хатантан таалан сонсоно.
 Уулын сэргэлэн харц нь номын мөрийг дагана.
 Эзэн хаантан ийнхүү элбэг найр дэлгэв.
 Ээх нарны гэрлээ Тинатин хатан хиртээв.

Хатантан зарлиг болруун: «Хаан эзэн эцэг минь
 Хан сангаас өв хөрөнгийг минь авчруулмуу!»
 Хөвчин их баялгийг олноор түгээн баривч
 Хөлтэй баян сан хотойх гэдэг учиргүй.

Дээд язгуурт түшмэд, доод төрөлт харцас
 Дээр дооргүй бүгдэд хишиг буянаа хүртээнэм.
 Хатантан ийн өчрүүн: Эцгийн сургаал даганам.
 Харамж шан цөм дураар хүртвэл зохином.

Арвин сангаас эрдэнэ хүссэн ёсоор авагтун.
Адуун олон сүргийг одоохон хурааж ирэгтүн.
Хармын сэтгэл огтхон ч үгүй, бэлэг сэлэг түгээвэл
Харваас дайчин цэрэг чадал мэдэн базаажээ.



Хотонд чоно орох мэт хайргүй хишиг авцгааж
Хотол даяар алдаршсан унаган хүлгийг барьжээ.
Дээд тэнгэрийн хур мэт баялаг бүхэн цалгилж
Дээр, доор, эр эмгүй хувь хувиа хүртжээ.

Зугаа цэнгэл дэлгэрч өдөр өнгөрөх нь хоромхон.
Зузаан их найранд цэрэг олноор умбана.
Эзний царай барайж тэргүүн юүгээ духайна
Эрхбиш гунигийн учрыг олохыг түмнээр бодно.

Нарнаа гялалзах чимэгтэй Автандилыг бүхнээр таалнам.
Нааш цаашаа хөдлөх нь барсын адил шаламгай.
Автандил баатрын хажууд түшмэл Сократ суугаад
«Аягүй юунаас болоод хаантан гунинам?» гэлээ.

«Хэтийн явдал дурсан гуньж байгаа буй заа.
Хэрхэвч өөр учир байх ёсгүй дээ» гэнэм.
Автандил хариу өчрүүн «Тайтгаруулах хялбархан
Алиа хошныг хөөрвөл хаантан сэргэх нь амархан»

Алтан тагшаа дарс амсар дүүргэн бариад
Алдарт эзний өлмийд Сократ, Автандил сөгдөөд
Амар тайван сэтгэлээр наргиант яриа дэлгэв.
Ачит түшмэлийн өчих нь хэлцэх газаргүй мэргэн.

«Инээж мишээхээ болиод хаантан та гуниглажээ.
Их сан чинь дунд орж ингэх чинь аргагүй болжээ.
Хамаг хураасан өвийг харамгүй охин чинь тараанам.
Хаан ширээгээ өгчихөөд ийн зовж байх гэж.»

Энэх үгийг сонсохдоо эзэн хаан мишээж
Эрслэн ийнхүү өчихөд нь гайхах сэтгэл төрөн
«Хайрлах бодолгүй тутмаа миний охин сайн
Харамч хявцаг зан над ч байхгүй билээ.

Гуних учир энэ биш, ухаан саруул түшмэл минь
Гүнхсан залуу цаг өнгөрч би өтөлнөм.
Эр биеийн минь зоригийг энэ биендээ шингээх
Эрэлхэг дайчин эр манайд эс олдном.

Ганц заяасан охин минь эрх танхил өсжээ.
Гай болоход тэнгэрээр хүү эс заяажээ.
Зүтгэж чармайхын хүчээр энэ хүү Автандил,
Зүгээр нум харвах, тоглохдоо баахан овоолдог.



Эзний өчих үгийг сэтгэл амар хүлцэн
Элэг зүрх мишээн баатраар мишилзэн духайнам.
Яралзсан лавай шүднээс, талд гэрэл харваж
Ямар учраас инээснийг хаантай асууж соёрхном.

Хаантан бас өчрүүн: «Инээх зүйл алга»
Хариу Автандил хэлрүүн: «Та хэрэв таалбал
Өчин хэлэх үгий минь гоморхон хилэгнэхгүй соёрхвол
Өлмий дор чинь сөгдөж учирлах үг байнам»

Эзэн хаан өчрүүн «Гэм хор байхгүй
Эрхэм охиноороо тангараглая, өчих үгээ хэлэгтүн»
Автандил баатар хэлрүүн «Өчих үгэндээ оръё.
Аягүй бүү зовогтун, хэлэх үгийг болгоогтун.

Харвах намнахдаа эзэн минь, үнэнч боол чинь дутахгүй.
Хайрлаж зарлиг буугтун, цэрэг олон мэдэг.
Сайрхаж хөөрөх явдалгүй, сайныг сорьж үзье.
Сайхь өчсөн бүхнийг зэр зэмсгээр туршъя.

Хаан эзэн өчрүүн «Чамтай сориод яанам.
Харин хэрэв тэнцвэл буцахыг эс таалнам.
Итгэлт хүмүүсийг гэрчээр хоёул сонгож авнам.
Ид бахтай нь хэнийг хээр хөдөө шалганам».

Яриа хөөрөө цэглэж эзний үгийг даган
Яах аргагүй баярлан, инээдэм, наадам хосолном.
Хожим шалгарах цагт мөрий тавьсан нь гэвэл
Хожигдсон нэгнээр гурван өдөр толгой нүцгэн явах гэжээ.

Хаантан зарлиг болруун: «Хоромсого саадаг бүхий
Харц боол арван хоёр биднийг дагаж мордогтун.
Чиний боол Шермадин тэднийг удирдаж одогтун.
Чигч үнэнээр тэд харвах, намнахыг тоологтун».

Ангуучдад эзэн өчрүүн: «Хүрээ бөлон явагтун.
Араатан гөрөөс хайж биднээ эргүүлж өгөгтүн».
Эр цэрэгтээ хэлрүүн, «Дуудахад бэлэн хүлээгтүн»
Эзний найр төгсөвч баяр цэнгэл өрнөв.



II

РОСТАН. АВТАНДИЛ ХОЕР АВЛАСАН НЬ

Угалз тавьсан хуйтай сэлэм хажуудаа зүүсэн
Уран гоё хийцтэй алтан нөмрөг өмссөн
Омгolon цагаан хөдөгтэй, зандан адил цэгцхэн
Онцгой нэгэн баатар хааныг урин иржээ.

Зэр зэвсгээ базаагаад хаан авд мөрдов.
Зэрэгцэж бараа бологч хүн олон дагав.
Дайн тулагнд бэлдэх шиг хөл үймээн ихсэж
Дайчин сум шунгинаж араатанд гай тарив.

«Арван хоёр анчин нааш нь одоо явуул!
Ашгүй сайн нум сум биенд нь бэлэн байлга!
Харваж намнаж дуусангуут тоогий нь гаргах хэрэгтэй гэж
Хаан Ростан баатарт айлдаж зарлиг буулгав.

Хөндий уруудан араатан үер адил урсана.
Хөндөлдөх өндрийн тэртээгээс буга согоо, янгир
Хулан тахийн сүрэг хуйлран хуйлран ирнэ.
Хурц сум хайргүй, эзний аяар исгэрнэ.

Морин туурай гачигнаж тоос манан дэглэв.
Мөрөн голын адил араатны цус урсав.
Хоромсого сум нь барагдвал дахин дахин авчирч
Хоромхон зуур ч амрахгүй араатан гөрөөс намнав.

Орох газар хайж олон араатан бужигнав.
Огторгуйн эзэн тэнгэр онц л их хилэгнэв.
Анд нөхөд нь харин Автандилыг биширч
«Арслан адил баатар» гэж ам амандаа гайхав.

Уужим талыг нэгжиж аваа сая дуусгав.
Урсгал бяцхан горхи, өндөр уул дайралдав.
Морь нэвтэрч чадашгүй шугуйд араатан оров.
Мохошгүй анчид алжаавч эрэмгий зориг нь нэмэгдэв.

«Би арай дөнгүүр» гэж хоорондоо алиалан маргаж
Бие биеэ ширтэж анчид хөөрөн зогсов.
Хааны зарлиг ёсоор харц боол цугларав.
Хамаг үнэнийг шударгаар хэлэхийг хаан айлдав.


Айж зусардаад яахав. Үнэнийг хэлж орхив.
Автандил баатар танаас хавьгүй илүү юм байна.
Харвах бүрд нь араатан налсаар унаж байсныг
Хаан танд хэлэлгүй бид яаж болох вэ.

«Авд гарсны олз маань зуун хорин араатан
Автандил баатар бас хөрийг илүү намнасан.
Тавьсан сумандаа тэр нэг ч удаа алдсангүй.
Таны харавсан сум газар шаасан нь цөөнгүй.

Мөрийцэж шагай харваад шалгарч хожих адил
Мөнхүү мэдээг сонсоод кааны гуниг тайлагдаж
Ариун сарнай цэцэгт алтан гургалдай дурлах шиг
Ачлах залуу баатрынхаа алдар цууг магтав.

Амрах газар хайж модны сүүдэрт ирж
Ачит хаан, анчид цөм тэнд цуглав.
Арван хоёр баатрын хуяг дуулга гялалзаж
Аршаан голын эрэг дээр алиалан тэд зугаацав.





III

АРАБЫН ХААН БАРСАН ХЭВНЭГТ БААТАРТАЙ ЗОЛГОСОН НЬ

Ганган хар хөлгийн жолоо сунган барьсан
Гадна талаас нь ажвал арслан адил дүртэй
Эрдэнэс шигтгээ гялалзсан дуулга, бамбай нь сүртэй
Энэлсэн нэгэн баатар голын зах дээр суужээ.

Барсын судалт арьсаар цээжин биеэ ороосон
Бас толгой юугаа барсын арьсаар боосон
Зангидсан гараас бүдүүн зандан ташуур атгасан
Залуу үзэмжит баатрыг хаантан таалан соёрхжээ.

Хайлан уйлсан баатартай нүүр учрахыг зорьж
Хаантан нэг боолыг голын тийш илгээжээ.
Харах нүд мэлмийгээс хасын бороо буухад
Харин элч боол ам нээлгүй гөлөрчээ.

Үлэмж гуад нь сүрдэж үнэн зүрх нь тэвдэж
Үг хэлгүй юм шиг боол баахан зогсоноо
«Үлэмжийн их эзэнтэн. . .» гээд таг дуугүй болчихжээ.
Үйлийн нулимс урсгасан баатар эс ажжээ.

Уйлан гуньсан баатар боолын үгийг таасангүй.
Уулын хөндий уруудсан цэргийн хөлийг тоосонгүй.
Улаан галаар төөнөх мэт зүрх сэтгэл нь гиншээд
Урсан гарах нулимс нь цусны өнгөөр туяарчээ.

Тэртээ алсын явдал сэтгэл дүнд нь бүрэлзээд
Тэр хөөрхий баатар үг дуугүй мэгшижээ.
Тэвчээр хүчээ шавхаад боол дахин дуугарахад
Тэсвэр ихтэй баатар ажиг ч үгүй тонгойжээ.

Өчиг авч чадалгүй өнөөх боол эгээд
Өндөр эзэн хаанаасаа өршөөл нигүүлсэл эрээд
«Өчиж би гуйвч өөдлөн ирэх дургүй байна.
Өнгөнд нь нүд гялбаж өр зүрх чичирлээ» гэв.

Алдарт эзэн хилэгнэж алаг зүрх нь гуниглаж
Арван хоёр баатартаа хатуу зарлиг буулгаж
«Алалдах тулаанд зэхэж зэр зэмсгээ ав!
Аяар урихад ирдэггүй тэрс эрийг авчир» гэв.

Илд сэлмээ хангинуулж идэр бөөлүүд очиход
Илт сүртэй чимээнд нь баатар сая цочиж
Ийш тийшээ харснаа олон дайчин үзээд
«Ийм ч зовлон амсах гэж» гээд илүү ч үг хэлсэнгүй.

Асгаран гарах нулимсаа алгаараа тэр арчаад
Ачит сэлэм, хөрөмсгөө ажиж нэг үзээд
Ахин дуугарахгүйг хичээж хөлөг мориндоо мордоод
Аян замаа буруулж алсыг зорин давхижээ.

Тэрсүүд эрийг барихаар цэргүүд хойноос нь нэхэхэд
Тэнхээ мэдэн далайж баатар ташуураа буулгахад
Тэнцэх эр гарсангүй хиар цохиулан унахыг
Тэмцэх хар элэгтэн ч тэсгэлгүй өрөвдмөөр ажээ.

Эзэн бүр хилэгнэж эр цэргээ нуглуулж.
Эрэлхэг баатрын хойноос хүч сэлбэн явуулавч
Элдэж хүрсэн бүхний нь эгшин зуур тонилгож
Эгнэж очсон заримы нь хоор хооронд нь мөргүүлжээ.

Хаан эзэн өөрөө Автандилыг дагуулаад
Харийн тэр баатрыг омог бадран хөөвч
Харж мэдсэн баатрын сүр сүлд нь мандаад
Хазгайдуухан суугаад биейнхээ чилээг гаргажээ.

Хөөсөн олны дунд хөгшин хааныг харахдаа
Хөлөг морио гуядаад нэгхэн агшин төдийд
Хөх тэнгэрт нисэв үү, хөрст газар шингэв үү
Хөнөөл тарьсан баатар ор мөргүй арилжээ.

Адтай чөтгөр бол уу, идтэй хувилгаан бол уу
Амьд хүн гэдэг л энэ лав биш гэж
Ашид цөм гайхаад алагдсан, шархадсанаа эмгэнэхэд
«Аятай найр маань төгслөө» гэж хаан эзэн өгүүлжээ.

«Эдэлсэн жаргалаа даалгүй эзэн тэнгэр хилэгнэж
Элбэг сайхан тавилангийн жолоог залав бололтой
Эрлэгийн элч өйртож эрхгүй би шаналнам
Эрхт тэнгэр гэсгээвэл одоо яая гэх вэ дээ»

Ингэж өчөөд эзэн энэлэл зовлонд автаж
Идэр анчдаа тарааж санаа алдан шаналжээ.
«Ийм л болох байсан» гэж ганц нэг нь цэцэрхэнэ.
«Иш яадаг билээ» гэж зарим нэг нь хачирхана.

Хаан баахан тайтгаравч гуньж гутсан нь хэвээр
Халамжит нөхөр, хайрт хүү Автандил нь дагасаар
Чивэлт боол явж гэр зуураа үлдсэн ч
Чавхдаст ятгын ая, жаргал бүхэн нь талаар.

Эцэгтээ учирсан гайг эмгэнэж Тинатин мэдээд
Энхрий гуагаа дэлгэж аавынхаа өргөөнд очоод
«Энх түвшин нойрсоно уу, эрхэмсэг түшмэл нь байна уу» гэж
Эзний хаалгачтай уулзаж эелдэг гэгч асуухад

Харийн гайхал баатар гай тарьж орхиод
Харах нүд нь бүрийгээд хааны бие чилээрхээд
Хажуу талд нь ганц Автандил сахина» гэж өчихөд
«Харья даа би тэгвэл, ирсэн гээрэй» гэжээ.

Эзэн хаан удалгүй эрхэмсэг охиноо сурж
«Эрдэнэ ганц охин минь тусалж магадгүй» гэхэд
«Энэлж зовсон Тинатин саяхан нэг ирж
Эрхт таныг тавгүй болохоор буцаад явсан» гэжээ.

Хаан зарлиг болруун: «Охины минь авчир.
Хатаж шаналсан зүрхэнд эм болж мэднэ.
Хамт байвал таатай хамаг гунигаа тайлъя.
Хайрт ганц үр минь яагаад явчив» гэжээ.

Сарны жавхааг бууруулсан сайхан **Охин Тинатин**
Салшгүй ганц энгийнхээ айлдсан ёсоор ирэхэд
Саруулхан духы нь үнсэж дэргэдээ аав нь суулгаад
«Саатаж урилга хүлээв үү, салж юунд одов» гэжээ.

Охин аавдаа өчрүүн: хувь тавилан хатуу
Омог хилэн тань бадрахад зориглон уулзах хэцүү
Онгон сүрт тань дарагдаж од ч унадаг биш үү
Осол гайнд бухимдсанаас ухаан зарвал дээр биш үү»

Хаан охиндоо хэлрүүн: «Учирсан гай их ч
Хамаг зовлон гамшиг чамайг хармагч **тонилдог.**
Харамсал гуниг болгон ор мөргүй арилдаг.
Хатамжилж чи сонсвол миний зовлонг ойлгоно»

Эс таних баатар гайгаар над дайралдаж
Эр зориг, гуа үзэсгэлэнгээ бүхний өмнө гайхуулж
Эрх биш нэгний төлөө энэлэн хайлан гуньж
Эрхэмлэн урьсан ч ирэлгүй миний хилэн бадруулав.

Армаг хөлгөө унаад асгарсан нулимсаа арчаад
Араас нь илгээсэн дайчдыг алж бүрэлгэн сүйтгээд
Албин шулмын адил арилаад алга боллоо.
Ад чөтгөр, амьд хүн алий нь ялган чадсангүй.

Өнөр миний дайчдыг өшөөлж хөрөөж орхиод
Өнөд байгаагүй юм шиг хайх мөргүй арилдаг
Өдөж сэдсэн баатар зол жаргал тонилгож
Өршөөлт тэнгэрийн өмгөөллийг өнөө би алдлаа.

Итгэлт тэнгэрийн аврал илт намайг орхиж
Ивгээл буянд ташуурсан ид үе өнгөрлөө.
Илүүдсэн жаргалыг буцаах идтэн одоо гарахгүй.
Ингэтлээ шархалсан зүрхийг эдгээх шидтэн төрөхгүй.

«**Буянт үйлсийг бүтээгч бурхан тэнгэр гэдэг**
Бузар хар хэргийг хэзээ ч тарих ёсгүй.
Бултын заяаг барьдаг эзэн дээд тэнгэрийг
Булай ийм явдалд эцэг минь хутгаж хэрэггүй.

Албат олныг захирсан алдарт эзэн та
Алс хязгаар байдаггүй арвин нутагтай хойно
Арван зүг тийшээ элч зарлага илгээж
Амьд үхсэний нь мэд» гэж Тинатин заан өгүүлэв.

Ухаант охины үгээр эзэн элч мордуулж
«Уужим хөх тэнгэрийн хаяа тултал явж
Учрах хүн, үзэх газрыг цөхрөлтгүй нэгжиж
Уулзах аргагүй заримд нь захидал илгээ» гэжээ.




Урт замыг туулж эзэн хааны элч
Уулзсан бүхнээс асууж бүтэн жил болоод
Улбаа мөрий нь гаргалгүй урам зориг мохож
Уур омгоос айвч уруу царайлан ирээд

«Өдөр шөнөгүй тэнэж, өл хоолгүй зөвж
Өвч дэлхийг бүхэлд нь хэрэн хэсэн бидрээд
Өшөөт баатрыг олсонгүй, сураг ажиг дуулсангүй
Өршөөлт эзний зарлигийг хөсөрдүүлэв гэжээ.

«Охины минь хэлсэн одоо үнэн боллоо.
Ослын хар шулам шүглэж ирсэн байжээ.
Олхигүй муу гунигийг оргүй таягдан хаяад
Орхишгүй баяр цэнгэлээ сэргээе» гэж хаан айлджээ.

Ингэж өчөөд хаан хурим найр зарлав.
Их багагүй цөм урам зориг сэргэв.
Идтэй бахтай дуучид эртэй баяртай дайчид
Сүртэй дүртэй баярт хөлтэй бүлтэй цэнгэв.





IV

ТИНАТИН БАРСАН ХЭВНЭГГ БААТРЫГ ЭРЭЭР АВТАНДИЛЫГ МОРДУУЛСАН НЬ

Алжаахыг мэдэхгүй Автандил ханзан дээр хажуулдаж

ХЭВТЭЭД

Аялгуут ятга хөгжмөө уяран дарж байхад
Амраг Тинатин хатны бараан царайт боол ирж
«Анхил тансаг хатантан урьж байнам» гэжээ.

Сайхь энэ мэдээг Автандил баатар таалж
Сарнай цэцэг шиг янагтайгаа учран золгохдоо баярлаж
Сайхан өнгөлөг хувцсаа шилэн байж өмсөөд
Санасан бодсоноо биелнэ гэж элэг зүрх мишээжээ.

Энэ мөрөөдсөн хүнтэйгээ өнөө учрахаа бодож
Өег талбиун сэтгэлээр Автандил тухтайхан оров.
Өвч тунгалаг нарны гэрэл гэгээ бүдгэрүүлж
Өнгө зүс нь туяарсан хатантан гүниглан заларчээ.

Ариун цогцсоо хучсан суусар нөмрөг намируулаад
Алтнаас илүү үнэтэй тансаг хангисаг унжуулаад
Хөвөн цагаан хүзүүгий нь гурамсан гээг нь дараад
Хөжилж жирийсэн сормуус нь зүрх зүсмээр ажээ.



Цоморлигоо дэлгээгүй цэцэг шиг цогцсоо чамд түшээхгүй
Цор ганц нарны хувилгаан ч тэр атугай
Харь хүнтэй гэрлэвэл ёроолгүй тамд унана би,
Хайраа хал болгоод хутгаа цээжинд зоогоорой чи»

Эрхэм буянт хатан ийнхүү тангараг тавихад
Эрэмгий баатар өчрүүн: Эрхт гэгээн дэнлүү минь
Чилээсэн гунигаас гэтэлгэж эрслэх замы минь гийгүүлэв,
Чигч боолын ёсоор энэ дэлхийг хөгжөөе.

Дээд тэнгэр заяасан наран гэгээн хатан минь
Дэлхий ертөнцийн од цөмөөр чамайг дагажээ.
Адбиш төгс үзэмж чинь сэтгэлий минь баясгаж
Алтан зам бүдгэрэхгүй, чи намайг гийгүүлнэм.

Бат журамт тангаргаа хоёр биендээ өргөж
Баяр хайрын үгээ хэн хэндээ дэлгэж
Өр зүрхийг шаналгасан зовлон гуниг арилж
Өнгөт хашийн шүдээ яралзуудан хөөрөлдөв.

Хайрын үнэн үгээ давтан давтан хэлж
Хасын эрдэнэ цогцсоо дахин дахин таалж
«Яруухан дүрий чинь харахад сэтгэл булгилах төдийгүй
Ядуухан зүрх шатдаг» гэж баатар ийн өчжээ.

Хагацах мөч тулж хайрын сэтгэл уярч
Харах нүд бүдгэрч хасын мөндөр бууж
Харцаа дэмий буруулж хамаг бие нь дагжиж
Хатан зүрх хайлж босго алхан гарахдаа.

«Салж хагацахын бэрхэд сарнай хялбархан ганддаг
Сацармал болд эрдэнэ шарлаж баахан гутдаг.
Хагацлын хүнд шарх зүрхий минь нэрвэвч
Хайртандаа амиа зориулах нь эрийн ёс билээ».

Орондоо баатар хажуулж уяран уяран хайлна.
Онгон мөндөрт цохиулсан улиас адил дагжина,
Зүүрмэглэх эгшин зуурамд зүйргүй янагаа үзэж
Зүрхний нь зовлон даамжирч хээр яваа шиг хашгирав,

Хувьтай ханиасаа холдон түмэн зовлон амсаж
Хуурай цэцгийг умдлан сувдан нулимс асгажээ.
Эртлэн өглөө нь босоод эмээлт хөлгөө унаж
Эцсийн ёслол үйлдэхээр эрхт дээдэст бараалахжээ.

Сүлдэт баатар эр хаандаа элч зарж
Сүрт их эзний мэлмий тунгалагт бишрээд
«Хаан танаа зөвлөө, хатан илдийн чинь дор
Хамаг дэлхий байна, гэвч нэг үзье.



Хэт нутгаа хэрж хатан хаанаа дуурсгаж
Хэлбэршгүй үнэн бүхнийг эцгийн ёсоор ивгээж
Илд далайсан нэгий нь нулимсанд нь хатааа
Их барьцтай элчийг эзэн танаа илгээе»

Хаан эзэн мишээж хариу тал өгөөд
«Хагацлын удаан хэцүү ч арслан минь чи мордогтун
Хавтай гавьяа байгуулах хүчин чамд төгс
Хайрлах сургаал чинь мэргэн шиг зориг чинь хатуу» гэлээ.

Хаандаа баатар бараалхан тэргүүн юүгээ мэхийгээд
«Харамгүй хэт өргөсөнд тань би ихэд гайхлаа.
Хаа холын замд тэнгэр намайг тэтгэвэл
Харьж ирсэн тухайдаа сарууд дүрийг та чинь үзнэм» гэлээ.

Энэ дэлхийд байхгүй эрэмгий зоригт эрс
Эцэг хүү хөёр шиг тэврэлдэн үнсэлдээд
Хагацахын бэрх бүхнийг баатар хатамжилж одоход
Хаан эзэн хойноос нь зүрх шимшрэн ширтжээ.

Өөг дэлгүү баатар хорин хоногийн турш
Өдөр шөнийг ялгалгүй гав ганцаар явжээ
Эзэнт улс, эр цэргийн эрс цогт баатраа
Энхрий янаг хүн нь тэжээн дагаж байжээ.

Өөрийн төрсөн нутгаар өөд сөөргөө зорчиход
Өвчүү тэлэм баярласан хэргэмтнүүд бэлэг барьжээ.
Нар шиг тунгалаг баатар болзоо хугацаа бодож
Найман зүгийн алсад яаран яаран зорьжээ

Эх дэлхий заяасан эгц хадан цайзтай
Энэ орноо өмгөөлсөн шилтгээндээ баатар бууж
Ан ав хийж гурван хоног саатаад
Аж явдлаа зөвлөхөөр Шерманиныг дууджээ.

Хэзээний бидний таних энэ голч боол
Хэдийний баатрын хань, итгэлт туслагч боловч
Хайрын сэтгэлд автсаны нь хараахан мэдээгүй байжээ.
Хамаг үнэнээ баатар харамгүй түүнд нээжээ.

«Эрхэм чинийхээ өмнө ичсэнээ би нуухгүй
Элдэв юмыг чамтай зөвлөдөг байснаа хаахгүй
Уярсан нулимсаа харин нуудаг байсан билээ.
Учирсан янаг минь одоо жаргал хайрласан» гэлээ.

Наран гоо хатанд нууцгай сэтгэл төрөөд
Нам гүм ганцвараа урсах нулимсанд үмбаад
Өөр бусдаас нууж зүрх шаналж байлаа.
Өөрөө хатан ам өгч миний жаргал ирлээ.

«Харийн тэр баатар хаана байгааг мэдээд
Харьж ирэх цагт гунигий чинь тонилгоё.
Хан тэнгэрийн хүүтэй ч хавьтаж би гэрлэхгүй» гэж
Хатан над амлаж энхжингийн рашаан хайрлалаа.

«Журамт боолын ёсоор эзэндээ зүтгэх учиртай
Жуулчилж холын замд баатар би зорином.
Үнэнч эрийн хувиар янагаа хайрлах учиртай
Үхэх цаг тулгарсан ч эмээхгүй би зорчном.

«Ивгээлт эзэндээ зүтгэх итгэдэг боолын ёс.
Ийм болохоор үгий минь чи сайтар сонс
Эх нутгаа залж эр цэргээ захирч
Энэ төрийн үйлсийг чи хөтөлж байгаарай.

Албат боолоо өмгөөлж цэргээ тулаанд хушуучилж
Арвин өргөл барьж хаандаа элч илгээж
Алсад ийн одсоны ажиг сэжиг авуулахгүй
Анд лотно бүгдийг ивгээн тэтгэж яваарай.

Ан авд мордож алалдах тулаанд оровч
Арслан зориг барьж миний адил үзээрэй.
Гурван жил болоод мэнд явбал эгнэм.
Гунигт гай тохиолдвол эмгэнэл ёс үйлдээрэй.

Хэрэв гай учирвал насан таалал төгссөнийг
Хэнд ч ноогдох хувь тавилан өөрийн эрхгүй амссаныг
Хаан эзэнд айлдаарай, хамаг зоос баялгийг
Харц ядууст хайрлаарай, миний гэрээс энэ шүү.

Түйтгэр гай дайрвал сэтгэл зориг чанга байж.
Түмэнтаа миний төлөө өршөөлт тэнгэрт залбирч
Хонгор эхийн адил идрийн бахыг дурсаж
«Хойтохы минь чи дааж хоцрохыг мэдээрэй»

Эвний энэ үгэнд боолын сэтгэл уярч
Эрдэнэ сувдын хэлхээ шиг элбэг нулимс урсгаж
Хагацахын зовлонг би даахгүй байж мэдэх нэ.
Хатуужиж зорьсон хэргий чинь хорьж яахин чадах»

«Элдвийн үг тоочиж элэг зүрх зовоолгүй
Энэ биендээ хань гэж намайг дагуулж яв.
Энэлж шаналж хагацсанаас газрын гүнд ноирсвол дээр
Эрхэмсэг таныг төлөөлөх хувь алга» гэлээ.

Эзэн баатар хэлрүүн «Эрх дуры минь дага
Элбэрэл сүйт хүн ганц биеэр туулдаг.
Эрдэнэ шигтгээ олоход тэнцэх үнэ байдаг.
Эрхэм тангаргаа умартагч мэсийн амт үздэг.

Сэтгэлийн зовлон мэдрэх сэргэг авхаалж төгс
Сэвгүй сайн хүн чамаас өөр байхгүй.
Хутагт хилээ бэхэлж хөнөөлт дайснаас сэргийл
Хувь зохиол байвал би эргээд ирнэ.

Ганц биеэрээ бидрэвч, зуун хүн явагч
Гарцаагүй тавилан байдаг, тэнгэр намайг тэтгэнэ.
Харьж гурван жил ирэхгүй бол хайлан энэлэх болно.
Харц олон, эр цэргээ чамд даатгая» гэлээ.





V

АВТАНДИЛ ТОРГОН ЦЭРЭГТЭЭ
ЗАХИДАЛ ХАЙРЛАСАН НЬ

Эх үрээс ялгаагүй хувь гавилан нэгтэй
Эрэмгий тэмцэлд хатуужсан үнэн бат итгэлтэй
Сүүдэр бие хоёр шиг ганц шулуун сэтгэлтэй
Сүлдэт түшмэлүүд цуглараад үгий минь сонсогтун:

Хумхийн тоос шиг өчүүхэн би та бүхэндээ зориулж
Хуурмаггүй үнэн үгээ өөрийн гараар бичлээ.
Нуугисан их найраас түр зуур хагацаж
Нум сум хоёрт амь насаа даатгалаа.

Хэрэг зориг гараад хэтийн зам дуудлаа.
Хэрэн тэнэхдээ бас ганцаар явах боллоо.
Хаант улсаа халдах дайсан, хар гайгаас
Халх болж хамгаалж байхыг мэхийн гуйя.

Өнөөгөөс эхлээд амьд эсэхий минь мэдэх хүртэл
Өндөр эрхийг Шермадин эдэлж та нарыг захирна.
Цэцгийн мандлыг ивгээх нар шиг та нарыг тэтгэж
Цээргүй бузар дайсныг лав адил урсгаж байг.



ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯ
ᠤᠯᠤᠰ

Ахын ёсоор бойжүүлсныг минь хүн цөм мэднэ.
Автандил баатар биеэрээ гэж түүнд, үнэнч байгтуу
Бүрээн дуугаар гарч бүгд нягтаа харуулагтун.
Бүрэлгэж би сүйдвэл зовох тавилангаа амсагтун.

Эвэрхүү үгт захидлаа эзэн ийнхүү дуусгаж
Эрдэнийн алтан бүсээ замд гарахаар ороогоод
Эр цэрэг олноо хөдөө хээр гаргаад
Эгшин төдий ч сааталгүй голомтоо орхин морлжээ.

«Дагуул над хэрэггүй» гэж цэргээ баатар тараагаад
Дан ганц биеэрээ эзгүй хээр үлдээд
Хөхрөн хатах зүрхэндээ наран хатнаа бодсоор
Хөлгийн жолоог залж хөндий цээлд оджээ.


Ан гөрөөнд улайрч торгон цэрэг тараад
Ажиг сэжиггүй байхад эзэн баатар холдож
Авилгач дайсан дийлшгүй алдар юугаа дуурсуулж
Алс тэртээ гарч сэтгэл баахан уужирчээ.

Ан аваа дуусаж цэргүүд баатраа эрэвч
Алтан нар арилаад тэнгэр барайн бүрийжээ.
Аялаг баяр нь өнгөрч арван тийшээ довтловч
Аврагч эзнээ ололгүй уйлан хайлан гасалжээ.

«Арслан зоригт эзнийг хэн одоо орлоно» гэж
Ам амьндаа асууж уулзсан бүгдээс сураглажээ.
Зүг чиггүй арилсан баатрын хойноос гуниглаж
Зүрх сэтгэл шархалсан олон цөм мэлмэрчээ.

Эрхт түшмэл бүгдийг Шермадин ордонд урьж
Эзний дээрх захиаг эрслэн үзүүлж өгчээ.
Хэлсэн гэрээсий нь сонсож тэд зүрх шимширч
Хэнхдэг цээжээ даран хэн хэнгүй уухилжээ.

Эцэс сүүлд нь тайтгарч эзэн эзгүй боловч
Эрх засгийг чамаас өөр барих хүн алга.
Захисан тушаасан бүрий чинь зарлиг адил дагана» гэж
Зарц түүнийг эзнээ гэж цөм ёслол мэхийжээ.



VI

АВТАНДИЛ, БАРСАН ХЭВНЭГТ БААТРЫГ ЭРЭЭР БЭДЭРСЭН НЬ

Эртний мэргэн Ээзрийн эгшигт нэгэн найрагт
«Эрсдэх жаварт автах сарнай хөөрхий» гэжээ.
Эр бие ганц эх нутгаас хол
Энэ хорвоог барагч үүнээс өөрдгүй ажээ.

Дөрвөн зүг найман зовхист эзний баатар довтолж
Дөт нутгаа орхиж хүний газар оджээ.
Наран гоо хатнаа эргэн эргэн санавч
Насны жаргал ирж, уулзахаа бодон тайтгарчээ.

Үйлийн эрхээр ийнхүү түмэн зовлон амсаж
Үлээх хөгжмийн дуу, наргиан бүхнийг орхиж
Цасан эрлэгт цэцэг шиг өдөр шөнийг барснаас
Цагийг товчилж нөгцье гэж олонтаа бас боджээ.

Сарнай цэцэг шиг сайхь баатар гутсангүй
Санаа сэтгэлээ хатамжилж эр зориг бариад
Харь олон орноор горьдол мохолгүй тэнэж
Харсан бүхнээс асууж хавьтсан бүхнээс суржээ.

Одтой тэнгэр хөнжилтэй, орчлон дэлхий дэртэй
Орь ганц баатар сэтгэл уяран хэлрүүн:
«Хайр сэтгэл чи зовлон над заяажээ.
Харин чиний төлөө амиа өгвөл зохижээ».

Хөх тэнгэрийн дор хөрст дэлхийн дээр
Хөл хүрээгүй газар үлдээгүй хэдий боловч
Болгоож мэдэх хүн нэгхэн төдий ч олдсонгүй.
Болзоот гурван жилээс гуравхан сар үлджээ.

Ганц ч хүнгүй хоосон цөлд баатар
Гав ганцаар бүхэл сар тэнэжээ.
Раамия, Вис аль нь ч үзээгүй гуниг амсаж
Ашид ганц янаг хүнээ мөрөөдөн санажээ.

Догшин өндрийн оргилд гарч хонох гэтэл
Долоон хоногийн уужим элс цайран харагджээ.
Хадан доогуур голын ус шуугин урсаж
Хажуу эргээр нь ой мод багшран харлажээ.

Өнгөрч одсон сар жилийг тоолон гиюүрч
Өнөөдрөөс аваад хоёрхон сар үлдсэнийг бодож
«Үйлс бүтэхгүй ингээд өнгөрвөл яана
Үйлийн эрхийг юугаар ч давахгүй» гэж шаналжээ.

Одоо би яах вэ, орхиод нутаг буцах уу?
Ор мөр ч гаргалгүй юу хийсэн гэх вэ?
Найдаж захисны нь хөсөрдүүлж баатрыг олоогүй мөртөө
Наран гэрэлт түүндээ юу гэж өчих вэ?

Эрж хайсаар байя гэвч эцэс хойт нь адил.
Эзгүй талд тэнэвч харь баатар алга.
Тогтсон болзоо хожидвол Шермадин хаанд бараалхаж
Тоогүй гунигт мэдээг дуулгана гэдэг лавтай.

«Захиж хэлсэн ёсоор үрэгдэв гэж өчихөд
Захирагч дээд эзэн уй гашуу зарлана,
Яриагүй нэгэнт ингэвэл амьд сэрүүн авч
Ямар нүүрээрээ би нутагтаа очих билээ?»

Бурхан тэнгэр намайг буруу замаар хөтөлж
Булгилж байсан баярыг бугласан гунигаар солилоо.
Амсаж байгаа зовлонд хэмжээ гэдэг алга,
Аргагүй ингэж хэлсэнд минь залхаавал залхааг.

«Болзоот хоног хүртэл бор зүрх уршашгүй
Бодитой дайрах зовлонг тэвчинэ гэдэг нь маргашгүй
Бурхны ивээл орхивол уйлж хайлаад нэмэргүй
Бултад ноогдох тавиланг бултаж зайлж болдоггүй.



«Муу амьд явахаар сайн үхвэл дээр
Мунгинасан чамтай уулзахаар Тинатин тосож ирнэ.
Онцолж баатрыг сураглахад онхийн хоосон чи
Одоо юугаа хэлэх вэ?» гэж баатар дандаа бодно.

Ертөнцийн бүх тохиолтой ер нь би учирсан ч
Ер бус баатрын сураг чимээ дуулсангүй.
Ороолон шулам гэж таасан нь аргагүй үнэн бололтой
Онцын зовлон эдлэвч ашиг үргүй хэвтээ.

Уулыг баатар уруудан ус, ой гэтэлж
Уужим талд ортол уйтгар зовлонд автаж
Хоёр гар нь суларч хараа нь мөн бүрэлзэж
Хосгүй үзэмжит хөндий өмнө нь цэлийн үзэгдэв.

Хүний дуу сонсолгүй бүтэн сар тэнэж
Хүй араатан дайралдавч хөндөлгүй явсаар
Эцсэн ч гэсэн эр хүн хүчээ туйлдан туйлдтал
Эргэж нутгаа зорихоор эгшинд нэг шийдлээ.

Араатан гөрөөс адил өчнөөн төчнөөн тэнэсэн ч
Ачит хүний үр хойно идээ унд мөрөөдөж
Ростомын мутраас урт сумаа зэрлэг үхрийн зүг
Онилон тавьж намнаад түүдэг юугаа асаав.

Морио тавьж идэшлүүлж махаа шарж суутал
Морьт зургаан эрийн бараа тодрон ирэхэд
«Хүн харгүй газар дээрэмчин байхаас зайлахгүй» гэж
Хучит баатар бодоод зэр зэвсгээ зэхжээ.

Агсан морио унаж амдаж тийшээ очвол
Ахмад хоёр сахалт нь нөгөө залуугаа түшжээ.
Сахалгүй тэр залуу тэргүүн юугаа гудайлгаж
Садрах улаан цус толгойноос нь урсжээ.

«Хэн гэгч вэ? Та нар» гэж хэрэг болгон асуухад
«Хэрхэвч битгий ай, бидэнд тус бол.
Хувиараа тусалж, чадахгүй бол гунигий минь хуваалц.
Хууз сахлаа хусалгүй эмгэнэлээ илэрхийл» гэв.

Тулж очоод Автандил элдвийг шалгаан асуухад
Дуслах нулимсаа барилгүй тэд өчсөөр байлаа.
«Ах дүү гурвуул бид, гамшиг зовлонд автлаа.
Ар нутаг гэвэл умарт хятад билээ.

Ан сайтай гэж эндэх нутгийг заахад
Ав ихтэй гэж олуул бид ирсэн юм.
Бүхэл сарын турш араатны сүрэг намнаж
Бүртгэж тоолох аргагүй гөрөөс араатан авласан юм.

Ах дүү гурвуул бид бүхнээс илүү авлаж
Адаг сүүлд нь бүр хоорондоо зөрж
Хэн маань чухам илүүг хэлэлцэн тогтож чадалгүй
Хэрүүл маргаанд аяндаа орсон юм гэлээ.

Залж зурах хүнгүй, зааж харах дагуулгүй
Завсаргүй ганц ганцаар хэн нь мэргэнээ шалгая гэж
Эцэст нь бид шийдээд олз юугаа тээлгэж
Эр цэргээ цөмийг гэр оронд нь буцаалаа.

Ганц ганц хүнд зэр зэвсгээ хадгалуулж
Гамшиг зовлон үзэлгүй, уул талгүй тэнэж
Араатан гөрөөсийг гүйдэлд нь жигүүртэн шувууг тэнгэрт нь
Алдалгүй бид азтай авлаж байлаа.

Хилэн хар морьтой, барсан арьсан өмсгөлтэй
Хилэнт зүрхний шарханд нэрвэж хатсан дүртэй
Гайхмаар байдал нь хэзээ ч хүнд ер байгаагүй
Гайгаар ийм баатар бидэнтэй гэнэт учирлаа.

Газар дэлхийн мэндийг тэнгэрт хүргэх туяа шиг
Галтай хурц гэрэл нь харцыг маань бүдгэрүүлэхэд
Энгүй тэр баатрыг олзлохыг бид хичээхдээ
Эндэж үнэхээр алдаад нулимсанд живэх нь энэ ээ.

Өрсөгчийг барьж авахаар ах нь би бодоход
Өгөөмөр сайхан хөлгөнд, дунд дүү санаархаж
Хамгийн отгон дүү маань халз тулахыг хичээн
Хайхрамжгүй ихэмсэг баатрыг элдэж гарах нь тэр ээ.

Болор эрдэнэ адил гуа юугаа гайхуулж
Бодол болсон баатар биднийг ер тоосонгүй.
Тал дундуур шуугиулж таашааж дуудахад ирсэнгүй
Ташуураа далайн эргэлдүүлж цаашаа арилж одлоо.

Отгон дүү маань зоригтой, огт айсан шинжгүй.
Омогт баатарт ойртоод «Зогс» гэж хашгирахад
Танихгүй тэр баатар илдэндээ ч хүрсэн юмгүй
Ташуур юугаа далайж ганц буулгасан нь энэ дээ.

Ганц цохилты нь даалгүй миний отгон дүү
Газар шааж унаад амьсгаагүй хэвтэж орхиход
Харийн баатар хорсож сүнсий нь нэгмөсөн тонилгож
Харсаар байтал дэргэдүүр ажиггүй өнгөрөөд явлаа.

Эргэж биднийг харсан ч үгүй, эмээж ер тэвдсэн ч үгүй
Эрдэнэт нарны гуяа шиг тэртээ гэнд одном гэж
Автандилд тэд заагаад ахин гиншин уйлахад
Алс холын замд гайхамшигт баатар харагдлаа.

Эх нутгаа орхиод эрхбиш дэмий тэнэсэнгүй.
Эрхэм зорилгодоо хүрэх хойно эргэж гуних хэрэггүй.
Энэнээс хойш Автандил дусал нулимс алдсангүй
Энэлсэн царай нь тайвширч эртний баяр одсонгүй.

«Ах дүү минь, би бол орон гэргүй тэнүүлчин
Аль хэдийнээс хойш тэр баатрыг хайсан
Гайхаад гайхаад баршгүй сайхан мэдээ сонслоо.
Гамшиг зовлон арилахыг та бүхэнд ерөөе.

Зол жаргал ивгээж баяр хөөр ирсэн хойно
Зовлонгоос таныг салаасай гэж бурханд би мөргөө» гэж
Буусан газраа баатар тэр гуравт заагаад
Буурьтай тухалж амрахыг тус бүрд нь ерөөв.

Ингэж хэлээд баатар хөлөг мориндоо мордож
Идэт шонхор торноос салж чөлөөг хүсэн тэмүүлэх мэт
Учрах уулзалтыг бодон ухаан санаа уужирч
Уудам тал дундуур нисэх адил дүүлэв.

Ойртож ирээд баатар мэргэн ухаан зарж
Ойворгон зангаар учирвал гай тарих хялбар
Ухаант хүмүүсийн зорилго нь бэрхийг давахад орших тул
Уулзахын мөчид яах вэ гэж сайтар бясалган боджээ.

Уйтгар гунигт автаж уруу царайлан яваа
Уулзах хүнээс зугтаж үг солихгүй байгаа
Энэ баатартай тулгарвал үхлийн тулаан үүсэж
Эцэст нь бидний нэг дэмий л үрэгдэх болно.

Зовж туулсан замаа талаар өнгөрөөх хэрэггүй.
Зовлонг тэр хэн ч байг толгойн халхтай нь магад
Нэвтэрч болшгүй хэрмэнд тэр орлоо ч гэсэн
Нэхэж орох аргыг би хайх нь зүй.



Хоёр өдөр шөнө, хойно хойноосоо сажилж
Хоол унд ч байхгүй гуниг зовлон амсаж
Хоромхон төдий ч гэсэн холын замдаа саадалгүй,
Хориогүй нүлимс бүрхэж хөндий хоолойд багташгүй.

Бас нэг өдөр өнгөрч үдэш болохын хирд
Байц асга өндөрлөг тэртээд дүнсийн барайв.
Уруудан урссан горхи, тэнгэр баганадсан мод
Учир тоймгүй хүлс урьд талд нь ярайв.

Уулын дотор байгаа хадан агуйг зорьж
Урсгал усыг тойрч баатар эр явав.
Автандил баатар ойд орж модонд авираад
Асгарах нүлимсаа үрсгэсэн баатрыг ажин суув.

Барсан нөмрөгт баатар ойг туулан одоход
Бараан агуй дотроос хар дээлт бүсгүй гарч
Уйлан хайлан угтахад баатар мориноос бууж
Учралт тэр бүсгүйг тэврэн энхрийлж авчээ.

Хайрт эгч АсMAT минь, далайн гүүр эвдэрч
Хайх ганц найдварын нар шингэж орхилоо» гэж
Хэнхдэг цээжээ дэлсэн баатар гуниглан уйлж
Хэн хэнээ тэвэрч тэр хоёр зогсов.

Ойчиж унасан үс нь ой модыг өтгөрүүлж
Онцын их гуниг нь нэг бүхэлд нийлж
Гаслан зовлон болгоны нь цууриа түгээн тарааж
Ганцаар ажсан Автандил гайхан гайхан энэлжээ

Уйлж ханасан бололтой бүсгүй уйлахаа болиод
Удамт хөлөг морины эмээлийг аваад тавьжээ.
Алдарт баатрын өмсгөлийг дараа нь бас тайлж
Агуйд хоёул ороод өдөржин гарч ирсэнгүй.

Учир утгы нь олохгүй Автандил гайхаж суутал
Ургах нарнаас өмнө нөгөөх бүсгүй гарч ирж
Эрмэг хөлгийг барьж дээлийнхээ хормойгоор илээд
Эмээл юугий нь тохож цаашаа хөглөөд явжээ.

Хээрийн агуйд хоноод баатар замдаа ороход
Хэнхдэг цээжээ балбаж хэдэн үсээ зулгааж
Гашуун зовлонд нэрвэгдэж тэр бүсгүй үлдэхэд
Гарцаагүй ирсэн мөрөөрөө нөгөө баатар одлоо.

Янгирыг арслан барьдаг шиг арсланг ч тэгж баримаар
Яруу нар шиг тунгалаг арц шиг ариухан цэнгэлэг
Тэр баатрын дүрийг Автандил сайтар ажиг
Тэсгэлгүй их бишрэн ширтэн ширтэн хоцорчээ.

Өчигдрийн ирсэн замаар ой, талыг туулж
Өнөө сүрлэг баатар довтолгон алсад оджээ.
«Дээд тэнгэр өршөөв» гэж Автандил дотроо бодож
Дэнсэлсэн сэтгэлийн угаас ихэд гайхан байжээ.

«Тэнгэрийн өршөөл дагаж энэ бүсгүйтэй уулзаж
Тэр баатрын тухай, өөрийнхөө тухай ярилцъя.
Үнэн үгийг сонсож үхлийн тулаан хийлгүй
Үйлс учраа мэдье» гэж Автандил шийджээ.





VII

АВТАНДИЛ, АСМАТ ХОЕР АГУЙД ЯРИЛЦСАН НЬ

Уруудан бууж уяанаас морио баатар аваад
Уулын агуйд очиход хаалга нь нээлттэй байжээ.
Үзэсгэлэнт баатраа ирэв гэж бүсгүй эндүүрсэн бололтой
Үйлзэх нулимсаа асгасаар тосон гарч иржээ.

Харийн хүнийг харахдаа хөөрхий бүсгүй балмагдаж
Хад уулыг доргитол мэгдэн хашгирч орхиод
Ум хумгүй нуугдахаар агуй руу гүйсэн боловч
Ухасхийж Автандил баатар бялзуухай шиг түүнийг шүүрчээ.

Бүргэдийн саварт орсон хөөрхий бялзуухайн адил
Бүх хүчээ шавхаж бүсгүй зайлахыг хичээжээ,
Энэрэл тусламж эрж «Тариэль» хэмээн дуудахад
Элдэв гай тарихгүй гэж Автандил сөгдөн өчжээ.

Дэмий хашгирах хэрэггүй, хүний үр байна би.
Дэгжин өнгө нь гутсан сарнай цэцэг үзсэн би.
Ариун диваажингийн иргэн шиг алдарт гоо баатрын
Алив яууц үчрыг над өгөөч гэмгүй »

Бүсгүй хариу өчрүүн «ухаан оюун чинь саруул бол
Бүтэлгүй юм асуухаа одоохон боливол дээр
Асуусан гэр зүйлий чинь хэлж би чадахгүй.
Ашиггүй юм сонирхож санаагаа зовоох хэрэггүй.»

Баатар чамайг мэдэхгүй, сайндаа л би гуниагүй.
Багцаалж бийрээр бичишгүй түүний нууцыг хэлэхгүй.
Өчин хэлэхийг чи над хэдий тушаавч
Өөдөөс чинь зуу дахин «үгүй» гэж хариулна.

Хариу баатар өгүүлрүүн «бүсгүй намайг ойлго
Харь холоос гарч түмэн зовлон амслаа.
Эцэст нь чамтай уулзлаа, баатрын учрыг хэл!
Эс хэллээ гэхэд би явах нь хол.

«Ямар гайгаар би чамтай ийнхүү учирч
Ядарч муудсан цэцгийг хүйтэн хяруу хөнөөв
Далан үг дэлгэж, сүр хүчээр далайлгавч
Даанч үгээ хэлэхгүй» гэж хүүхэн хариу өчив.

Тэнгэр бурхны нэр барьж бүсгүйд мөргөн гуйвч
Тэвчээрт хүүхэн уярч, тэнгэр бурхан тусалсангүй.
Эр баатар хилэгнэж нүүрэнд нь цус харваад
Элдэв зүхэл дэлгэж хутгаа шүүрэх дөхөв.

Баатар эр хэлрүүн «Зовлон гамшгаас өөр
Батад над учрах хувь тавилан алга уу?
Дэндүү нуусан үнэнээ дэлгэж хэлбэл дээр
Дээд тэнгэр гэрчилнэ, эсвэл чамайг хөнөөнө»

Бүсгүй хариу өчрүүн «хэрж тэнэсээр байгаад
Бүр сүүлд нь та галзуурах тун дөхжээ.
Бүрэлгэн хөнөөв гэхэд мөнхөд би дугжирна,
Бүв бүтэн орхиход амьд үлдэвч хэлэхгүй.

Аль газрын хүн, хэн гэгчийн үр вэ чи?
Амьд ахуй цагт маань албаар өчиг авахгүй
Алж бүрэлгэхийг хүсвэл амь биеэ тушаана би
Амьтан хүнд хэрэггүй эрээн цаас шиг устаг чи

Өвсөн чинээ амий минь тастлаа гэхэд зовохгүй
Өнөөгийн энэ зовлонгоос үхэж хагацахад буцахгүй
Хэн гэдэг хүн хэрэг зоригий чинь мэдэхгүй байж
Хэрхэн чамд би учир явдлаа тоочих вэ?

Эрхэмлэж хадгалсан нууцыг хүчээр тайлшгүйг мэдээд
Эрэлхэг баатар эр өөр арга хайж
«Хөөрхий чамайг гомдоов» гэж тэр бүсгүйд хэлээд
Хөвч биеий нь тавьж уйлан хайлан суув.



Ганц ч үг хэлэлгүй Автандил уяран байхад
Гашуун гомдол тайлаагүй бүсгүй дуугүй сууснаа
Урсах нулимс нуур болж цэцгийн хүрээлэн халихад
Удтал тэвчиж чадалгүй зүрх нь зөөлрөн зөөлөрчээ.

Өрөөлийн шаналахыг өрөвдөж өөрөө бүсгүй мэлмэрч
Өр зүрх хайлавч үг хэлгүй суужад
Мөн л гунигт автсаны нь баатар эр мэдээд,
Мөргөн сөгдөн байж ийн гуйж эхэлжээ.

«Энхрий чамайг гомдоож энэ биеэ зовоож
Эгч дүү болох эрхийг нэгэнт алдлаа.
Өдүүлсэн нүгэл зузаан ч түм дахин наманчил гэж
Өнөд сургасан ёсоор өршөөл чамаас гүйя»

«Болхи мулгуугаар гутамшгийг би тарьсан ч
Болгоож бүсгүй чи сэтгэлийн зовлонтыг уучил.
Өрөвдөж энэрч үзээд эрхбиш надад тусал.
Өгөөмөр сэтгэлээр би чамайг хайрлах болно».

Хайрын тухай үг бүсгүй дөнгөж сонсмогч
Хамаг амссан зовлон нь зуу дахин зузаарч
Өндөр тэнгэр эцэг баатрыг өршөөв бололтой
Өөрийн эрхгүй хайлж бүсгүйн зүрх уярав.

Сэтгэлийн зовлонт гэх баатрын үгийг сонсохдоо
Сэхэшгүй зэвий дааж бүсгүй гуньсныг хараад
«Ийм зовлонт хүнийг дайсан ч өрөвдөх биш үү.
Ивгээл жаргал ирэхгүй бол үхэх нь дээр биш үү»

Хайрын хүчинд автсан сэтгэлийн зовлонт эр би
Халамжит наран хатны тушаал даган бэдэрч
Харь баатрыг эрэвч хөвөлзөх үүлийг ч үзсэнгүй.
Харин чамтай учирч хэрэг бүтэх боллоо.

Гоо баатрын дүрийг зүрхний харшинд тахиж
Гоц түүнийг хайсаар гэгээн өдрийг мартав.
Үйлийн лайг барагдуулж жаргал зовлон буюу
Үхэх, сэхэх хоёрын нэгийг чи хайрла.

Бүсгүйн санаа уужирч «анх чамтай уулзахад
Бүр их балмагдаж зүрх зүсэх шиг боллоо.
Үнэн үгий чинь сонсож хэрэг зоригий чинь мэдлээ.
Үүрд чи нөхөр гэж намайг итгэ» гэлээ.

Сайн санаа өвөрлөж зовлон амссан чамд
Сааргүй үнэнч боол болох үүрэгтэй билээ би.
Саяхан хүртэл хөндий байж чамайг би зовоосон ч
Сайхь амьдралаа хайрлахгүй чамд туслахыг амлая

Хэлсэн бүх үгийн минь хэлбийхгүй чи дагавал.
Хэрсэн их замын үзүүрт чи хүрнэ.
Хэрэв үгий минь дагахгүй бол уйлан хайлаад нэмэргүй.
Хэзээд гутамшиг болж золгүй чи өнгөрнө.

Эр баатар өчрүүн «Энэ үгийг сонсоход
Эртний нэг домог эрхгүй над санагднам.
Хоёр хүн явж байтал түрүүч нь худагт унажээ.
Хойно хоцорсон нь ирээд нөхөртөө ийн хэлжээ:

«Энхрий хайрт нөхөр минь эндээ хүлээж байгаарай.
Эргэж олс авчраад чамайг аваръя» гэжээ.
«Хүлээхгүйдээ би хаачихав» гэж нөхөр нь гушигтай мүшилзаад
Хүний газрын худагт живэн живэн доошилжээ».

Хувь заяаны олс бүсгүй чиний гарт байна.
Хуурмаггүй тус хүргэх нь ганц чи мөн байна.
Хатаж шаналсан зүрхэнд рашаан болсон чи минь
Хайрлаж намайгаа өршөө, үгий чинь би дагана».

Энгүй зовлон амсаж энэ хорвоод тэнэсэн
Эрдэмт мэргэд магтмаар баатар чиний үг
Энэхэн зүрхийг эзэмдэв, хэлэх үгийг сонс.
Эрж хайсан зүйлдээ тэгвэл чи хүрнэ.

Харь баатрын тухай мэдэх хүн байхгүй
Хатаг зоригтон өөрөө тусалж нэг магадгүй.
Итгэл найдвар хадгалж ирэхий нь чи хүлээ.
Илүү гуниг өвөрлөж сарнайг битгий хатаа.

Үнэний хэлтэрхийг хэлэхэд, түүнийг Таризель гэдэг.
Үйлээ эдэлсэн боол намайг Асмаг гэдэг.
Түмэн зовлон амсах хувь тавилангийн эрхээр
Түйтгэр гай хүртэж ингэж суудаг юм.

Амар заяа үзэхгүй аглаг талаар тэнэж
Авчирсан ангийн махаар би хооллон суудаг.
Өрөвдөлт түүний хувьд өөр яриа алга.
Өчнөөн удаж ирэхийг өнөө би мэдэхгүй.

Эрж тэнэж хэрэггүй, эндээ чи үлд
Эрхбиш нэг ирэхэд нь элдэвчилж би гуйя.
Та хоёрыг танилцуулж тал болоход тусалъя.
Тансаг хатандаа чи хэлэх үгтэй болно.

Ингэж байтал тэртээгээс голын ус цалгилж
Идэт хөлгийн туурай, зэмсгийн чимээ гарч
Харанхуйг тонилгох дэнлүү шиг гоо баатар ирэхэд
Хайртай боол бүсгүй Автандилыг нуув.

«Тэнгэр өршөөж чиний зорьсон бүхэн бүтнэ,
Тэгэвч чи тэвчиж энд нуугдаж бай.
Харшиж уулзсан бүхнийг хайргүй тэр хөнөөнө.
Харин та хоёрыг эвээр учруулахыг бодъё».

Автандил баатар агуйн гүнд нуугдахад
Аянд явсан баатар хайлан уйлсаар ирэв.
Нулимсан горхи урсаж голыг чиглэн одоход
Нуугдсан баатар хэвээр үгийг даган хүлээв.

Эзэн баатар уйлж үнэнч боол хайлж
Элж дэвтсэн хашар хув адил улайж
Эмээл, хазаары нь авч хөлгийг хашаанд оруулаад
Эгшинд нам болж урсах нулимс татрав.

Барсын эрээн арьс бүсгүй дэвсэж засахад
Барагдашгүй зовлонд автсан баатар эр сууж
Урьд адил нулимс аягаа даван мэлмэрэхийг
Урхинд орсон олзны хүн шиг Автандил ажиглан ширтэв.

Гал юугаа асааж бүсгүй мах шарж
Гайхаж идэж ханашгүй сайхан хоол бэлтгэвч
Өлсөж алжаасан атугай ч ганцын төдий огтлоод
Өнөөх баатар эр дахиж ер амссангүй.

Хоромхон зуур зүүрмэглэж хар даран сэрээд
Хорон тамд орох мэт баатар хашгиран босоод
Шийдэм чулуу хамаагүй өртсөнөөр биеэ балбахад
Шивэгчин бүсгүй энэлж хацар нүүрээ уржээ.

«Ямар хэрэг тарьчихаад ингээд ирэв дээ» гэхэд
«Яахав ан авласан хаантай гэнэт дайралдав.
Олон цэргээ дагуулаад олз омгоо ачаад
Отох сайн анчидтай авлаж тэр явлаа»



Хүний бараа харахдаа цээж давчдан гуньж
Хүй заяагаа даатгаад холуур тойрохыг бодлоо.
Эргэж жолоогоо залж ойд би ороод
Эндээ сэм нуугдаж үүр хүлээхээр шийдлээ» гэв.

Ийм үгийг сонсоод бүсгүй улам шаналж
«Ижилгүй чи ганцаар араатантай нөхөрлөн тэнэж
Хүн төрөлт амьтантай уулзаж зүрхээ дэвтээхгүй
Хүсэлт хонгортоо ч ашиггүй хамаг насаа барж байна.

Энэ ертөнцийг чи эргэн тойрч бараад
Эрхбиш ганц эртэй ч золгох ерөөл алга уу?
Үймэх хилэн дэгдээхгүй хүн ер алга уу?
Үгүй бол хүнийг хөнөөж эсвэл өөрөө өнгөрнө үү?

Баатар эр өчрүүн «Чиний санаа зововч
Байгаль дэлхий гэдэгт анагаах рашаан байхгүй.
Энэ хорвоод үгүй юмыг эрээд бид дэмий
Эр биеэ хөнөөж сүнсээ тонилгох үлджээ»

Хувь тавилан хөнгөлөх над шиг гунигт амьтан
Хурмаст дээд тэнгэр заяаж болно гэж үү?
Зовлонгийн тогоо дүүрэн над шиг хилэнцэт хүн
Зорьж бүхэнтэй учравч чамаас өөр байхгүй»


Хариу бүсгүй хэлрүүн: «Харшилж бүү уурла
Хамгийн дотно зөвлөгч гэж чамд би заяасан
Тохиолдсон нэгэн учралыг тодорхойлж чамд хэлье.
Тогтоож чи сонсоод зөв ухаан зараарай»

«Хэлэх гээд байгаа зүйлээ шууд чи өгүүл
Хэрхэн тэнгэрийн ивгээлгүй над нөхөр заяах вэ.
Өнгө зүсээ ч алдаж араатантай би нөхөрлөсөөр
Өөрөө ч араатан адил болжээ» гэж баатар ийн өчив.

Бүсгүй зориг шулуудаж «Чамайг зовоогоод яахав.
Бүтэлгүй хэцүү зовлонгий чинь нимгэлж хагаслах учиртай
Баатар эр өөрөө чамайг зорин ирсэн бол
Балаг гай тарихгүйгээ чи тангараглаж чадах уу?» гэв.

Баатар эр өчрүүн «Хэрэв тэр ирвэл
Баярын дээдийг амсаж балаг тарихгүй гэдгээ
Хосгүй хайртныхаа нэрээр би батлан тангарагла
Хоёр эрийн нөхөрлөл ид хавтай сайхан»





VIII

ТАРИЭЛ, АВТАНДИЛ ХОЁР УЧИРСАН НЬ

Автандил баатарт бүсгүй гүйсээр хүрч очоод
«Ачит эзэн хилэгнээгүй» гээд хөтөлж дагуулж ирэхэд
«Нарыг хүртэл хиртээх» гэгээн баатар юм гэж
Найрсаг дотноор Тариэль түүнийг тосон угтжээ.

Хос нар мандах шиг хоёр баатар учирч
Хорвоогийн сарнаас ч тунгалаг гэгээ цацруулж
Долоон бурхан адил өнгө гялалзан туяарч
Дотно хоёрын гуалгийг хөвчийн модтой зүйрлэшгүй

Харилхаж бишүүрэх юмгүй хоорондоо тэд үнсэлцээд
Хашийн цагаан шүд нь тана адил яралзав.
Хүзүү юугаа тэврээд уяран уяран хайлахад
Хүйтэрч зэвийсэн нүүр шигтгээ адил улайв.

Ингэж байснаа Тариэль, Автандил баатрыг хөтөлж
Ижил хоёр эр зэрэгцэн суугаад уйлахад
«Гэгээн нарыг гутааж гиюүрч зовоод яана» гэж
Гэмгүй уян үгээр бүсгүй тэднийг аргадав.

Сарнайг хяруу дарж Тариэль ийн хэлрүүн:
Сайхан баатар чи аль газрын хүн бэ?
Хэн гэдэг эр вэ, хэрэг зориг юунд вэ?
Хэрцгий үхэлд ч хэрэггүй зовлонт амьтан би байна»



Автандил хариун өчрүүн: «Арслан адил баатар чи
Араб нутгийн хэрмийг эзлэн төрсөн хүн би
Хайрын гал бадарч халуун орчинд нь шатаж
Хамаг гай зовлон амсаж яваа хүн би.

«Эрхт эзний охин эцгийн ширээг залгасан
Эрхэмсэг хатан түүнд энэ бие минь татагдсан.
Уг нь бид хоёр учирч танилцаагүй боловч
Ухаант хаантай явахад чи бидэнд дайралдсан.

Талд чамайг үзээд уулзахыг бид хүсэхэд
Таашааж тоолгүй одохоор эзэн хаан хилэгнэсэн
Эр цэрэг чамайг элдэж хөөж очиход
Эргэж чи хядаж цусан гол урсгасан

Илд байхгүй атлаа ташуураар боолыг дэлсэж
Илт байгаагүй юм шиг бараа сураггүй арилсан.
Хаан эзэн хилэгнэж, бид уухайлан хөөсөөр
Харах мөр тасарч хөшөө шиг гайхаж хоцорсон.

Чидээрхэж үймсэн хаан хэмжээгүй эрхээ эдэлж
Чиг зүг бүхэнд илч зарлага илгээсэн
Амьтан хүн шаналж адаг сүүлд намайг
Аян замд хөдлөхийг хатан хаан соёрхсон.

«Энэ нэг явдлын учрыг чи мэдээд ир
Эргэж ирсэн цагт хүслийг чинь хангана» гэж
Гурван жил намайг нулимсанд дэвтэхийг тушаасан
Гунхсан янагаа харалгүй өнөө хүртэл тэнэсэн.

Улаан нүүрээрээ чамтай учирсан хүн олсонгүй.
Уур омгоор дайрсан хятанчуудыг л нэг үзлээ.
Ухаан алдтал чиний тушуурдаж орхисон нэг нь
Урт замын хаа ч юм өнгөрч байгаа бизээ.

Эртний тэр явдлыг эргэж Тариэль бодоод
«Эргэх мөргүй өнгөрсөн уг учралыг санаж байна.
Хар зовлонд учруулсан хайртнаа бодож уярсан ч
Хаан та хоёрыг авалж явахыг харсан»

Харин та нар намайг юундаа ихэд хоргоосон юм?
Ханатал эдэлсэн жаргалтан хайлсан намайг өдөж
Үй олон боол хөөж явуулсан хэдий ч
Үрэгдэж би автаагүй, үхдэлээ та нар зөөсөн.

«Эргэж би харахдаа их хааныг үзэж
Элэг зүрх өвдөж түүний биеийг хөндөөгүй.
Эрдэнэт хөлгийн хүчээр хараанаас нь мултарч
Эзэн дээдэст гэмгүй арилж би одсон.

Хойноос хөөсөн улсаас салхин адил зугтахад
Хол хоцорсон тэд буцахаас аргагүй болдог.
Тэр хэдэн эрд халдах хэрэггүй байжээ.
Тэгээд тэднийг би ч хөнөөх учиргүй явжээ.

Найгүй зовлон гамшгийг үйлийн эрхээр эдэлж
Наран гэрэлт баатар гуа чийрэг эр чи
Дээд тэнгэрийн өршөөлгүй олно гэхэд хэцүү ч
Дэргэд нэгентаа ирж надтай учран золгов.

Хариу Автандил өчрүүн: «Намайг магтах юун.
Хамаг чиний үйлс харж ханашгүй алдар.
Энэ хорвоог гийгүүлсэн нарны ихрийн өрөөсөн.
Элдэв зовлон амсавч элж гутрахгүй гавьяа.

Өнөө чамтай учирч сэтгэлийн зовлон мартагнаж
Өлзийт хаанаа орхин чамд бараа болно.
Шил хэдий өнгөтэй ч оюу эрдэнийг гүйцэхгүй.
Шийдэж чамтай одоход гуних сэтгэл нийцэхгүй.

Нөгөө баатар хэлрүүн: «Зүрхний зовлон гэтэлж
Нөхрийн гараа сунгасан ачийг яахин хариулам.
Сэтгэлийн зовлон юугаа эрчүүд зуураа хуваадаг.
Сэвтэшгүй янагаас чинь хагацаасан гайг хэрхэн нөхнөм.

Хааны зарлиг дагаж намайг чи хайн
Хатан зориг барьж тэнгэрийн ивгээл хүртэж
Одоо намайг олсон ч учрыг яаж мэднэ чи.
Осолгүй өөрөө хэлбэл хумхийн тоос болно би.

Хажуунаас Асмаг өчрүүн: «Арслан баатар бүү гунь.
Хайрлаж хэрэв ойшоовол миний үгийг сонс.
Харваас чиний төлөө юунаас ч буцахгүй баатар байна.
Хатаж шаналснаа уудалж хариу сонсвол дээр»

Төрсөн ахын адил үнэн бүхнийг ярь гэж
Төв энэ баатар надаас их гуйсан.
Дээд тэнгэрийн ивгээл хэзээ боловч таатай
Дэлгэж бүхнээ хэлбэл хэнд ч гэсэн баяртай.

Төөнөх галд шахагдах мэт Таризель дуугүй байснаа
«Төвөг гай учрахад эгч минь намайг орхиогүй.
Хувь заяаны эрхээр учирсан зовлонг анагаашгүй.
Хувиршгүй үнэнээ хэлсэн энэ баатар ч хөөрхий» гэв.

Тэнгэр эзэн орхивол жаргалыг яаж олох вэ?
Тэмцэх ширүүн галд иймээс хүн мөхнө.
Өмнөх зам хаагдаж урхинд би орж
Өвч ертөнц гэдэг хувхай ёдор шиг болжээ.

Тэнгэр бурхан гэгч над нэг мишээж
Тэвчиж бүтээн тайтгарах хоёр учрал заяав.
Хайрт янагтаа золгоход Автандилд нэг тусалж
Хамаг үнэнээ тоочоод өөрөө биеэ татъяа.

Автандилд баатар хэлрүүн: «Анд нөхөр гэдэг
Амиа хоохойлж суухгүй үхлээс айхгүй байдаг
Тэнгэр заримыг тэтгэж нөгөөг цаазалж байдаг
Дэс дараалан тоочоод амиа би бүрэлгэе

Асматад баатар хэлрүүн: Ойртож чи ирээд
Амь тэмцэх үед зүрхийг усаар шүршээрэй
Үхэж өнгөрөв гэхэд алдхан нүх малтаж
Үүрд миний нойрсох өлгийгий минь бэлдээрэй

Үг юүгээ бэлдэж нөмрөг юүгээ аваад
Үүлэнд орсон нар шиг баргар царайлж суугаад
Хөмхийгөө зууж санаандаа бүхнийг бясалгаж
Хөөрхий баатар төдхөн уйлан хашгиран өчив.

Олдохоо байсан эрдэнэ, онцын хайртай янаг минь
Оюун санаа, амьдрал, жаргал баясал бүхэн минь
Агар зандан чамайг хэн үндсээр нь сугалж
Амраг сэтгэлийн галд намайг хаяж орхив?



IX

ХУВЬ ЗОХИОЛЫНХОО ТУХАЙ АВТАНДИЛД ТАРИЭЛЬ ӨЧСӨН НЬ

Хувь зохиолын учрыг сонсож чи болгоо
Хуримталсан явдал бүхнийг хэлж чадах бол уу.
Үнэнч янаг минь хичээвч миний зовлон арилахгүй
Үүрд зовж хайлах тавилан минь хувирахгүй

Энэтхэг хаант оронд эзэн хаан долоо бий.
Эрх төртэй Парсадаан зургаан улс эзэлж бий.
Хааны хаан тэр баян бөгөөд удамтай
Ханагар жаргал эдэлсэн арслан адил жанжин.

Саридаан нэрт эцэг маань долоодох улсыг захирч
Саруул нутагтаа өмөг, зовлон гэмшиггүй аж төрж
Их анд мордож ид чадлаа үзүүлж
Ил далдын гомдолгүй тавтай сууж байлаа.

Гэвч эцэг маань ганцаардаж зүрх сэтгэл шархалж
«Гэмтэн дайсантай тулж нутаг усаа өмгөөллөө.
Эрх ямбыг эдэлж элбэг цэнгэн сууж байна.
Эзэн хаан Парсадаанд дагаар оръё» гэлээ.

Энэ шийдээ хэлж эзэнд элч мордуулж
«Энэтхэгчүүд цөм чамайг дагах хувьтай.
Энэ биеэ тушааж чамд зүтгэх ёстой.
Эвийн үнэн тангаргийг үр ач санаг» гэжээ.



Энэ үгийг сонсож эрэлхэг Парсадаан мишээж
«Эрхт гэгээн тэнгэрт ертөнцийн эзэн би өчмүү
Энэтхэг их улсын эрх адил эзэн чи
Эрхэмсгээр бараалхаж ирмүү хүж барилцъя» гэжээ.

Эзэн хаан эцэгт маань хаант улсыг үлдээж
Энэтхэг их гүрний жанжин цол олгожээ.
Хаан ширээ орхисон ч эрх ямбаа эдэлж
Хамаг их гүрний хайр хүндийг хүлээжээ.

Эцгий маань хаан өөрийн адил үздэгсэн
Эрэлхэг тийм жанжин ч өөр хаанд байхгүйсэн.
Аюулт дайсанд аянга, ан авд цогтой.
Аавтайгаа би зүйрлэшгүй, надтай бусад нь адилгүй.

Хаан хатан хоёр үр хүүхэдгүй байжээ.
Хамаг ард цэрэг нь тэнгэрт өчин гуйжээ.
Үйлийн лайгаар тэгэхэд би заяасан учир
Үндэс сураг нэг юм авъя гэж хаан өгүүлжээ.

Үрийн адилаар би хаан, хатныг дээдэлж
Үй олон цэрэг, улсаа захирахыг сурч
Ухаант хааны эрдмийг мэргэд багшаар заалгаж
Улаан нар шиг тунгалаг арслан шиг сүртэй болжээ.

Ташаа буруу яривал эгч минь залруулах бизээ.
Таван нас хүрэхдээ сарнай шиг би тунсаг болж
Арслангийн зулзагыг хүртэл дэгдээхэй адил ноолоход
Алаг үргүй хаан тайтгаран хөөрдөг байжээ.

Өдөр шөнө хоёр зүйргүй ялгаатай ижил
Өнийн нарнаас тунгалаг зандан адил гуалиг
Олон цөмд магтагдсан тийм хүн байсан сан.
Одоо бүр сүг болжээ, эгч ч гэсэн мэднэ.

Таван настай байхад минь хатандаа охин заяав гээд
Тайвуу байдлаа алдаж баатар ухаан бүдэгрэхэд
Асмагт усаар шүршвэл тэр баахан сэргээд
«Амьдрал жаргал үрслэн нар шиг эхин байлаа» гэв.

Үзэмж гуа охин мэндэлж төрсөн тухай
Үй түмэнд зарлаж элч зарлага морджээ.
Тэнгэр хүртэл мишээж нар сар наадаж
Тэнд эндгүй хөгжиж амьтай бүхэн баярлажээ.

Эрхэм тансаг бүхний нь эвлүүлэх үг дутна
Эзэн хаан найрлаж цөм цэнгэн баярлаж
Эрхт дээдэст бараалхаж хөрш олон цувж
Эртний заншил ёсоор цэрэгт бэлэг барьжээ.

Хаан, хатан хоёр биднийг тэгш хайрлаж
Хамт нэгэн дор хүн болгож байсан сан.
Нэг гэрийн хүүхэд шиг өссөн тэр янагийн
Нэрийг одоо хэлье, зовлон жаргал минь энэ сэн.

Өр зүрхний хайртнаа Таризель дурсаж санахдаа
Өөрийн эрхгүй муужрахад Автандил харанхуйлжээ.
Бүсгүй ус шүршсэнд баатар баахан сэргээд
Бүгдийг би хэлээд дуг нойрсъё» гэжээ.

«Санаж яваарай, түүний минь Нестан-Дарьжаан гэдэг **сэн**.
Саруул гүн ухаантай саран гуа бүсгүй сэн.
Долоон нас хүрэхдээ ч нарнаас тунгалаг байсан сан.
Дотно түүнтэй хагацаад зовлонгийн ихийг үзсэн сэн.

Хүүхэн өсөж торниж би тулаанд бэлдээж
Хүйтэн мэсээр тоглож арсланг хөнөөж явахад
Ийм болсныг үзэж намайг аавд илгээж
Ид чадалт охин ширээ залгах боллоо.

Хаан охиноо энэрч хаш чулуун баганатай
Харш ордон барьж цэцгийн хүрээлэн ургуулжээ.
Аршаан булаг ундарсан ахуй сайхан газар
Алаг зүрх эмтэлсэн амраг бүсгүй суужээ.

Өдөржин шөнөжин тэрээр амтат тамхи уугиулж
Өндөр цамхгийн оройгоос орчин дахиныг ажиж
Цэцгийн хүрээлэнд явдагсан. Түүнийг асрах нэртэй
Цээргүй бөөгийн сүйт эм Давар гэгчээр дагадаг сан.

Мяндас тансаг бүрдсэн хивсэн асар дотор
Мянга түмнээс буйд гүнж ахай туяарна.
Асмат хэмээх шивэгчин, хоёр боол эмсийн дунд
Ариун байгалийн элгэн дээр гуа авхай бадамлана.

Арван тав хүрсэн ч хаан намайг асарч
Алтан нар мандавч, гэгээ тасравч нэгэн дор
Арслан хүчтэй наран туяатай зандан адил гуалиг
Алив зугаа наадамд дандаа түрүүлч өөдлөг.

Харавсан суманд өртөж араатан гөрөөс бужигнаж
Халж хорхойшсон би-гээр ангийн хойноос нэхдэгсэн.
Өдөр шөнөгүй найрлаж хөл хөгжөөн болдог сон.
Өнөө амрагаас хагацаж амьд явахаас өнгөрчээ.

Сариданы үе элж аав минь тэнгэрт халихад
Сайхан найр хийхээ Парсаданы ордон больжээ.
Айж бэмбэгнэгч дайсны хацарт туяа харваж
Анд нөхдийн нь зүрхэнд аньшгүй шарх суужээ.


Эмгэнэлийн хар хувцас жилжин би өмсөж
Эцгийн хойноос шаналж үргэлж ганцаар хайлдаг сан.
Хаан ч бас гутарч түшмэл над илгээж
«Хар хувцсаа тайлбал барав, Тариэль хүү минь» гэжээ.

Эн сацуу баатартаа бид ч бас зовном гээд
Эзэн дээд хаан бэлэг сэлэг ирүүлжээ.
Үе залгах хувьтай гэж хааны зарлиг бууж
Үй олон цэргийн жанжнаар намайг тохоон тунхаглажээ.

Зүрхийг гал төөнөж улмаар би шаналахад
Зүг зүгээс түшмэл түшиж эмгэнэл юугаа тайлав.
Энэтхэгийн хаан тайтгарч намайг нийтээр хүндэлж
Эцгийн адил дотночилж хаан намайг таалав.

Зэрэг хэргэм нэмлээ гэж хаантан хатантан талархаж
Зэрэгцүүлж дэргэдээ суулгасан нь цаанаа л нэг учиртай.
Өндөр тушаалаас айж, би баахан булзавч
Өршөөлт эзний зарлигийг дагаж явах хуультай.

Он жил өнгөрч баргий нь би мартаж
Ой ухаан самуурч нэгмөсөн ярих хэцүү.
Хорвоо гэдэг хуурамч, зовлонгийн үр цацнам.
Хорон тэр гамшиг биднийг гал шиг төөнөнөм.



Х

ТАРИЭЛИЙН СЭТГЭЛЭЛ ДУУН

Урсах нулимсанд ханаж уг яриагаа дэлгэн
 Ухаант хаан бид аваас буцаж явтал
 «Уулзья, эвий охинтой» гэж хаан гар атгалаа.
 Учралт явдлыг ийн бодоход уярахгүй байж болох уу?

Тэнгэр бүхэлд нь тольдсон цэцэг хүрээлэн намирнам
 Тэнгис адил цэлийсэн усан сан цалгинам.
 Хөхөөн дуунаас уянгалаг цэцгийн шуугиан сонсодном.
 Хөвсгөр хивсэн дэвсгэрт тансаг ордноо морилном.

Хатан хаанд ангийн дээж өгөх зарлиг буухад
 Хайр сэтгэлийн зовлонд үүрд би унасан юм.
 Тэр цагаас хойш түмэн гамшиг эдлэв.
 Тэвчээрт чулуун зүрхийг эрдэнэн цүүц эмтлэв.

Наран адил охиноо хаан бусдаас харамнаж
 Нандигнаж нуусан хөшгийг сая нэг сөхөв.
 Тэргүүн жанжин охинд минь авын дээж барина гэж
 Тэнд байсан шивэгчинд хаан зарлиг болов.
 Эрхэмсэг хатныг хармагц зүрхийг илд шархлуулж
 Эцэс сүүл байхгүй сэтгэлийн тамд унав.

«Нарнаас хурц гэрэлтэн хаана одоо шингэнэм» гээд
Найргүй гунигт автан Таризель ухаан алдав.
»Амар заяагүй аялал хамаг хүчий нь барж» гээд
Автандил, АсMAT хоёр хад доргитол уухитав.



Усаар АсMAT шүршиж баатар хэдий сэргэвч
Ухаан оюун нь бүдгэрч удтал дэмий шаналав.
Санаа алдан мэлмэрч саатаж баахан суугаад
«Сайхан түүнийг санах нь сааршгүй зовлон мөн» гэв.

Амьдрал жаргал гэгчид хөл алдан ташууравч
Аанай хуурамчийг мэдэхэд цэнгэлийг мартан гиюүрнэм.
Тэрслүү бүхнийг давдаг мэргэдийг би биширнэм.
Тэнхээ хэрэв хүрвэл учрал бүхнийг өгүүлнэм.

Авын дээжийг өргөтөл хараа нэгэнт бүдгэрч
Аль байсан газраа эрхгүй би унажээ.
Арайхан сэргэж ажихад уй гашуу болж
Аяны онгоцыг үдэх мэт үй олон шавжээ.

Эзний тансаг ордонд би хэвтнэм билээ.
Эрхт хаан хатан шадар түшмэл хүрээлнэм.
Санваарт олон сахиж лусын хорлол гэнэм.
Сайхь түмэн хайлж хацар нүүр нь чинэрнэм.

Эгшнээ сэргэх төдийд эзэнтэн намайг тэвэрч
«Элдэв учралаа өч» гэж эрхгүй надаас гуйлаа.
Өчих чадалгүй би, зүрхнээ цус харваж
Өвч бие дагжин ухаан дахин балартлаа.

Лам багш цуглаж аврал гүрэм айлдаж
Лай ланчгийн эрхээр чөтгөр шүглэв гэлдэхэд
Гурван өдөр ухаангүй, элий балай хэвтэж
Гуниг зовлонгийн ихийг биеэр би амсав.

«Эмнэж анагаашгүй өвчин, санааны гэм» юм гэж
Эмч домч цөм арга баран өгүүлж
Элдвээр үгээ сольж намайг дэмийрч байхад
Энхрий хатны нулимс мөрөн адил урсав.

Амьд үхсэний хооронд гурав хоног хэвтээд
Ашгүй нэг сэргэхдээ учир бүхнийг ухаж
Эгээ л бүр өнгөрөөгүй энэхэн амь биеэ
Эрхт дээд тэнгэрт даатган би мөргөв.

«Эзэн дээд тэнгэр өршөөж намайг тэтгэ,
Энгүй ядарсан биенд тэнхээ тамир хайрла,
Хааны ордноос явъя хамаг нууц задарна» гэхэд
Хатан зүрх чангарч тэнгэр бурхан ивгээв.

Өндийж намайг дээшлэхэд харцууд хаанд дуулгав.
Өгөөмөр хатан хоромхон над гүйж ирэв.
Хаан эзэн малгайгүй бүхнийг умартан ирж
Хамгийн өмнө зогсож тэнгэрийг дээдлэн бишрэв.

Тал талаас шахаж эм над уулгахад
«Тайтгарч бие засрав, тал хөндийд зугаалъя» гэж
Хаанд би гуйж хөлөг морь зэхэж
Хамт хоёул мордож хээр газар зорив.

Зээлийн газар өнгөрч голын тэртээ ирээд
Зэрэгцэж одохоо больж салах ёс гүйцэтгэв.
Гэртээ би ирэхэд зовлон улам даамжирч
«Гэсгээх үхэл намайг түргэн ав» гэж өчив.

Гандсан цэцэг адил миний царай шарлаж
Гашуун зовуурт зүрхийг түмэн мэс сүлбэж
Шаналж байтал хаалгачийг нэгэн боол дуудав.
«Шавдаж цөм мэдэв үү?» гэж би ихэд гайхав.

Ямар нэгэн хэргээр Асматын элч ирлээ.
Яах учры нь гайхтал янагийн захидал байлаа.
Хэрхэн би түүний хайрыг татнам билээ.
Хэмжээгүй их гайхаж зүрхээ тэмтэрч билээ.

Хайр сэтгэлээ илчилсэнд хачирхан би гайхсан ч
Хамаа намаагүйд үзнэ гэж таг байхгүйг хичээн
Итгэл тэслэв гэж гомдож орхихоос эмээж
Ихэд оргилсон янагийн халуун захидал илгээв.

Өдөр хоног өнгөрч өнөөх гуниг өрнөж
Өргөн олон түмэн, цэргээс би холдож
Эзний ордонд очихгүй домчийн гар харж
Энэ ертөнцийн хүний зовлонг хатамжилж байлаа.

Эм тан нэмэргүй, зүрхэнд манан харваж
Энгүй зовлонгийн шалтгааныг тайлах хүн дутахад
Эзэн нэг өдөр «цусы нь ханавал дээр» гэхэд
Эмзэг учраа нуухаар би ч бас зөвшөөрөв.

Гар юугаа боолгоод гиюүрч хэвтэж байтал
Гаднаас боол ирж «Асматын элч ирэв» гэв.
«Амар заяа үзүүлэхгүй, надаар бүсгүй яана даа» гэж
Амин зуураа гайхаж оруулахыг би тушаав.

Сайны ерөөл бүхэнтэй захиаг би үзэхдээ
Санаа сэтгэлийн угаас уулзах хүслий нь гадарлаж
Зүрх сэтгэлийн зааврыг дагах цаг иржээ.
Зүйтэй тушаалаа хайрлахад хожимдохгүй би очъё» гэв.

Ингэж хариулаад дотроо «улам их зовно биз.
Их цэргийн жанжин нэртэй хүн атлаа
Эмс хүүхэн хөөцөлдвөл алдар нэр гутаж
Эх нутгаас хөөгдөнө» гэж эмээн би бодлоо.

Хааны элч ирж мэнд усаа мэдээд
Халамжилж зөвлөсөн ёсоор цусаа хануулсан уу гэхэд
«Эзний сургаал дагаад илтэд одоо засарч байна.
Эрхэмсэг ордонд бараалхана, улам сайжирна» гэлээ.

Ордонд бараалхахад хаан «Одоо алжаахаа боль» гээд
Онгон хөлөг авчирч зэр зэвсэггүй мордуулаад
Араатан, жигүүртэн сүргийг айлган намнан явагч
Агссан нум сумтай харваачаа дагуулав.

Авын ихийг агнаж найрын дээдийг хийж
Аялгуу, дуу өрнөж хөл хөгжөөн дэгдэн
Эрдэнэс сангийн ихийг хаан харамгүй хайрлаж
Эзний шадар олон энгүй их баяжив.

Энэх их найр ч миний гунигийг тайлсангүй.
Элэг зүрхний зовлон эрхбиш ер хайлсангүй.
Аяга тагш юмаар шаналангаа нимгэлэх санаатай
Анд нөхдөө урьж найрыг гэртээ залгав.

Ингэж байтал нярав сандран гүйж ирээд
«Их жанжин таныг нэг хүүхэн хүлээнэм.
Битүү нөмрөг нэвт гоо үзэсгэлэн туяарна» гэхэд
«Би түүнийг хүлээе. Нааш нь явуул» гэлээ.

Найраас гэнэт гарахад нөхөд цөм гайхвал
«Намайг хүлээж бай, удахгүй ирнэ» гэлээ.
Амрах өргөө тушаа боол харуулдан зогсном.
Агсам сэтгэлээ барья гэж би түр бодном.


Ороод гэвч очвол хүүхэн сэм угтаад
«Орон гэрт чинь ирүүлсэн дээд эзнийг магтъя» гэв,
Бүсгүй хүн ингэхэд би баахан гайхаад
«Бүх сэтгэл ариун гэнэн хонгорт» итгэв.



Хивс дэвссэн вандан дээр би очиж суувал
Хиртхийж бүсгүй эвгүйрхэн хажуу тийш боллоо.
Намайг мөрөөдөн гуньдаг бол зайлах учир юун?»
Нам гүмд дарагдан дуугүй гэхэд тэр зогслоо.

«Хүндэт таны өмнө би баахан ичнэм,
Хүслээ барилгүй таныг мөрөөдөв гэж бодов уу.
Энэ бүх хэрэгт амгалан байдаг чинь сайн.
Эрхт дээдэс намайг тэтгэж байна» гэлээ.

Ачит хааны зарлигаар танай гэрийг зорьж
Амьтан хүнээс нууж ирсэндээ би эмээнэм.
Үзэсгэлэнт бүсгүй, танд зүрх сэтгэлээ нээлээ.
Үгээр хэлшгүй зүйлийг бичсэн захидал энэ» гэв.





XI

НЕСТААН-ДАРЬЖААНААС ЯНАГТАА ИЛГЭЭСЭН АНХНЫ ЗАХИДАЛ

Сэтгэл зурх эзэлсэн янаг ийн бичжээ.
«Сэв шарх гэдэг арслан чамайг гутаана уу?
Энэ бие минь чинийх, доройтон гуних юун?
Энэлж шанлагчийг тоохгүй, Асмаг бүгдийг өчнө.


Янаг сэтгэлт хүн үхэл бодон гишүүрнэ үү?
Ялгуусан дайчны ёсоор баатар гавьяа байгуул.
Эртнээс манай улс Хятаныг эзэлж байлаа.
Эдүгээ тэд уравжээ, хайргүй тэднийг залхаа.

Чиний хатан болохыг хэзээнээсээ би мөрөөдсөн ч
Чин үнэнээ гэвч хэлж чадахгүй явлаа.
Ухаан алдаж унахы чинь гэгээвчээр би хараад
Уй гашуут явдлы чинь хожим хойно мэдлээ.

Үнэн бүхнийг өгүүлье. Үгий минь чи сонс.
Үйлсгүй Хятаныг дарж ялалтын баяраар ир.
Хоосон нулимсаа тат, сарнайг бүү гандуул
Хон харанхуйгий чинь гийгүүлэх нарны туяа би» гэжээ.

Нөмрөгийн дор дэвтэлгүй Асмаг бүхийг өчигөд
Нөр их жаргал зүрх сэтгэл эзэлж
Нар зүрхэнд гийж толь сэтгэлд цэлмэж
Нандин эрдэнээс нүүрэнд туяа харван мишээв.





XII

ТАРИЭЛЬ ЯНАГТАА ЭХНИЙ ЗАХИДАЛ ИЛГЭЭВ

Элэг зүрхний амрагтаа би захиа бичиж
«Эгнэгт тэнцэх хүнгүй гоо үзэсгэлэнт дагина
Эрдэнэт нарнаас тунгалаг шөнийн гэгээн саран
Эгэл биеийн зовлон эгнэгт чи хөнгөлөв» гээд

Өөр үг алга гэж Асматад би хэлрүүн:
Өөрийн хатанд өчөөрэй: «Миний нарыг мандуулж
Үйлийн ихээс гэтэлгэж үхлийн савраас аварлаа.
Үнэн сэтгэлт чинийхээ захисан үгийг биелүүлнэ» гэв.


Асмаг хариу хэлрүүн: Энэ бидний яриаг
Амьтан хүнээс нуухыг хатантан биднээ тушаасан
Зарц бүсгүй над сэтгэлтэй мэт бай гэж
Захиж чамд хэлээд сайн цаг хүлээе» гэсэн.

«Мэргэн ухаант үгэнд миний сэтгэл хөгжиж
Мэтгэж зөрөх аргагүй үнэн үгийг болгоож
Уран хатны оюунд үдийн нар бүдгэрч
Уул биеэ гутаахгүй учрыг би ойлгов.

Аяга дүүрэн эрдэнэ Асматад би Барихад
«Алдарт хатны буянд алттыг эдэлж ханасан.
Гангалах гэж бодоогүй сайны ерөөл болгоё» гээд
Ганц цэнгийн бөгж гартаа тэр зүүв.

Эргэж бүсгүй одоод баатрыг гуниг тайлж
Элэг зүрхнээ шигдсэн эрлэгийн илд тонилж
Анд нөхдийн найранд ахин очиж наргиал
Алт эрдэнэ тэргүүтнийг ашдын бэлэг болгов.





XIII


ТАРИЭЛ ХЯТАНЧУУДАД ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН НЬ

Элч мордуулж Хятанд захидал бичиг илгээж
«Эрхт тэнгэр тэтгэсэн Энэтхэг их хаантны
Эрхэм зарлигийг дагавал хайр шан хүртээнэ.
Элэг буруу аашилбал өөрийн биеийг үрнэ.

Ах дүү харцас, энэх зарлигийг ухаж
Агуу үнэнийг сахиж бидэндээ хүрэлцэн ирэгтүн.
Аяндаа та нар ирэхгүй бол нуулгүй бид очно.
Амдаж цөм ирвэл цус урсахгүй байхсан

Элч буухиа илгээж сэтгэл улам уужирч
Эзний ордонд бараалхаж найр наргианд цэнгэж
Санаж сарвайсан бүхнийг тэнгэр надад заяаж
Саар гай таригч араатан надаас эмээв.

Хээр холын замд хэрэн тэнэмээр санагдахад
Хэт бодлоо орхиж нөхдөө урин цэнгэвч
Хүсэл сэтгэл тогтохгүй юм бүхэн дэмий
Хүй гунигт автаж энэ хорвоогоо зүхэв



XIV

НЕСТААН ДАРЬЖААН ТАРИЭЛЫГ УРИВ

Ордноос буцаж ирээд нойрсохоор хэвтсэн хэдий ч
Огтхон ч нойр хүрэхгүй амрагийн царай үзэгдэж
Янагийн нөгөө захидал уншин уншин байтал
Ямар нэг юм шивнэв, зарцыг хаалгач дуудаад.

«Асматын элч» гэхэд оруулж ирэхийг тушаавал
«Алаг зүрхий чинь шархалсан бүсгүй хүлээнэм» гэжээ.
Харанхуйг гэрэл давж зовлонгийн гинж тасарч
Хамаг бүхнээс нууцгай, зарцаа дагуулан очив.

Цэцгийн хүрээлэнд орж бараа бологч нуугдтал
Цэх өмнөөс гэнэт Асмаг инээмсэглэж угтаад
«Зүрхэнд шаасан зүүгий чинь өнөө би сугалъя.
Зүйргүй ариун сарнайтайгаа одоо чи золго» гэв.

Эрээн хивсэн хөшгийг хүч мэдэн өргөхөд
Эрдэнэ шигтгээн ширээнд хатантан заларч байнам.
Шингэшгүй наран дэнлүү тансаг цогцос тугтарч
Ширгэшгүй гүн нуур шиг хоёр нүд нь гялалзнам.

Хатан ер дуугүй, би хөдлөхгүй зогсном.
Хайрын эелдэг нүдээр инээмсэглэж намайг ширтнэм
'Асматад хатан шивнэвэл «Чамтай ярихгүй нь харь» гэв.
'Ахин би гуньж зовлонгийн галд унав.


Эргэн босго алхаж Асматын хамт гарч
«Энэ хорвоо сая л анагаах гэсэн бус уу.
Эрхбиш итгэл төрүүлээд дахин гэсгээх нь юу вэ?
Элдэв хагацлын зовлонд ханав биш үү би» гэв.

Харну Асмаг өчрүүн: «Сэтгэлээ чи барьж
Хар гунигийг хааж жаргалын үүд нээ.
Хатантан баахан ичингүйрч биеэ эс эзэмдэв» гэж
Хамаг зовлон тайлах хувь тавилан амлав.

«Сэтгэл анагаах рашааныг бэлэг адил хүлээе.
Сэргээх мэдээ агуулсан захидал чи илгээж бай.
Халуун хайрыг хөргөхгүй бичиг олон явуул.
Хар гай учирсан ч надаас бүү нуу.

Ийн нэг уулзаж гашуун нулимс урсгаж
Итгэх сэтгэл замхарч мартаг хүчин дутаж
Нойрсохоор хэвтсэн хатны бие туяарч
Номин харанхуй шөнөтэй би нөхцөн эвссэн,





XV

ХЯТАНЫ ХААН РАМАЗ ТАРИЭЛД ХАРИУ ЗАХИДАЛ ИРҮҮЛЭВ

Элч зарлага эгэн хариу бичиг авчирвал
Эгдүү хүргэм үгтэй гажуу захидал байлаа.
«Эмээж бид айхгүй бат бэх хэрэмтэй.
Эзэн чинь маньд падгүй, эндээ бид хаантай»

«Хаан Рамаз биеэр Тарил чамд бичнэм.
Хамаа намаагаа алдсан чиний захидалд гайхнам.
Эзэн намайг чи яахин дуудахыг зорив?
Эрхбиш одоо болино гэж би үнэхээр найднам» гэнэ.


Эр цэрэг цуглуулахаар элч би мордуулж
Энд тэндээс хүмүүс эгнэгт яаран хурж
Одноос олон дайчин цуглаж нэгэнт ирлээ.
Онгон тал, уул, зам бүхнийг дүүрлээ.

Өстөн дайсанд хилэгнэж гэртээ гогтож чадалгүй
Өчнөөн дайчин ирснийг үзээд сэтгэл уужирлаа.
Эр зориг, эрэмгий чадал, хурдан хөлөг
Эрэлхэг хорезмын илд зэвсэг энэ бүхнийг бахадлаа.

Хаан төрийн сүлдэт хар, улаан тугаа
Хамгийн манлайд мандуулж цэрэг эртлэн хөдөлгөв
Үерийн ус шиг цувсан цэргийг харавч гуньж
Үйлийн эрхээр амрагтайгаа уулзсангүйдээ хайлав

Хорвоогийн зовлон хэцүү, гэртээ би гуниглан
Хоржигнох цутгалан адил халуун нулимс урснам.
Гай гамшиг гэдэг жаргалаас илүү эрхтэй.
Гар хүрэхийн аргагүй сарнайд санаархах бэрхтэй.





XVI

ТАРИЭЛ, НЕСТААН ДАРЬЖААН ХОЕР УУЛЗСАН НЬ

Санаандгүй гиюурч байгал Асматын элч ирж
Сааргүй зовлонд хатсан би захидал авав.
«Уйлан хайлан байснаас ирвэл дээр биш үү!
Учирч уулзахыг хүсэж хатанган хүлээнэм» гэжээ.

Туйлгүй их баярлаж гэгээ тасрах төдийд
Тухалж би гараад цэцэрлэгт хүрч очив
Асмаг бүсгүй намайг хуучин газраа угтаж
«Арсланг сар хүлээнэм, бушуухан ор» гэлээ.

Үзэмжит багана чимэглэсэн ордноо намайг оруулахад
Үлэмж гоогоо илтгэсэн саран дагина заларч
Нов ногоон өмсгөлтэй эрхэмсэг түүнийг харахад
Ноцож дүрэлзсэн сэтгэл аяндаа сүрдэн үймэв.

Дэлгэж дэвссэн хивсний ойр дөхөж очвол
Дэндүү гуниг арилж сэтгэл оюун сэргэв.
Хурмастын нарыг дагуулахгүй сайхан төрсөн хатан
Хулгай нүдээр ширтсэнээ нүүр юүгээ буруулав.



«**Жанжинд олбог өг**» гэж хатантан шивэгчиндээ
 Жавхаат наран хатантай би зэрэгцэн сууж
 Сайны дээдийг хэдийгээр эс горьдох боловч
 Сайхь хорвоод тал өгч амрагийн үгийг сонсов.

«**Үг дуугүй** байлаа гэж дэмий чи хилэгнэж
 Үдийн наранд гандсан цэцгийн адил гутаж
 Уйтгар гунигт автан усан нулимс урсгасан ч
 Угаасаа миний ичимхийг болгоож үзэх бизээ.

Эрийн өмнө ичих нь эмийн үүрэг боловч
 Энэ байгаа сэтгэлээ үүрд нуувал буруу.
 Хүний өмнө инээвч нүдэн далд уйлж
 Хүй үнэнээ хэлэхээр Асматыг чамд илгээсэн.

Сэтгэл зүрхээ нээсэн тэр цагаас эхэлж
 Сэвгүй хайрын ханиа гэж чи намайг үзэгтүн.
 Энэ хэлсэн үг маань чамдаа өгөх тангараг.
 Эргэж үгээ буцвал хумхийн тоос болог.

Дайн тулаанд орж уравсан Хятаныг номхруулан
 Дархан хилээ бэхэлж тэнгэрийн тааллаар ялагтун.
 Өстнийг дараад уулзана, удвал харин уйдна.
 Өр зүрхээ орхин сүй болгоод минийхийг авбал таарна».


Хариу би өчрүүн: «Чиний төлөө зүтгэж
 Халуун галаас харихгүй, чи намайг тэтгэж
 Үрж намайг гутаалгүй үүрд нар шиг гийгүүлсэн.
 Үйлсгүй хар Хятаныг арслан адил хөнөөнө.

Мөхөх тавилант этгээд надаас ер илүүгүй
 Мөн биш хоёрыг бурхан тэнгэр ялгана.
 Хашийн тунгалаг харц чинь харанхуй зүрхийг гийгүүлсэн
 Хайргүй үхэл иртэл би чинийх болно.

«Хэн хэндээ бид үнэнчийн тангараг өргөж
 Хэд хэд дахин хайр сэтгэлээ баталж
 Хээр холын оронд чамайгаа би мартвал
 Хэмжээгүй дээд цаазаар тэнгэр гэсгээг гэлээ.

Элэгсэг үг хэлэлцэн алим жимс амсан
 Энгүй жаргалын дээдийг эгшин төдийд эдлэн
 Хагацан одохын үед уярлын нулимс урсаж
 Хатан зүрх зөөлрөвч баяр бахдал төрнө

Болрын адил амрагаа орхих гэдэг хэцүү
Болдын адил зүрх уйтгарт дарагдаад давчуу
Харин тэгэвч ыар наймайг гагцаар гийгүүлж
Хагацах гэрхэн хоромд зүрх гэдэг чулуу.





XVII

ТАРИЭЛ ХЯТАНЫГ ДАЙЛСАН НЬ

Их бүрээгээ үлээж цэрэг цуглуулахыг тушаахад
Илхнээ цөм хуран дайн тулаанд бэлэн
Хулгай муу Хятаны хилд арслан адил цөмөрч
Хуучин зам нарийдаж шинэ замаар цував.

Энэтхэг нутгийг орхиж холын аян зориход
Элч зарлагаа Рамаз ирүүлье гэж боджээ.
Энэтхэг газрын ямаа манай чононоос илүү гэж
Эрсхэн үг хэлж намайг зөөлрүүлэхийг горьджээ.

Элдэв бэлэг сэлтээр намайг хуурахыг хичээж
«Эрсдүүлж биднийг хөнөөхгүйг үнэнээс бид гуйя
Эрлэгийн бугуйл хүзүүн дээр зэхээтэй байгааг ухаж
Эрхэм тансаг бэлгээ тэрс санаагүй барья»

Хийсэн нүглээ наманчилж өршөөл бид гуйнам
Хилэнцэт биднийг өршөө, цэрэг зэвсэг хэрэггүй
Хэлмэгдүүлж манийг хөнөөлгүй цөөн цэрэгтэй ирэгтүн
Хэрэм, цайз хот бүхнээ бид нээж өгье» гэжээ.

Х элэх үгий нь сонсохоор түшмэлээ би цуглуулбал
«Хэзээнээс Хятаг гэдэг итгэж болохгүй улс
Хэдхэн цэрэг очиход хядан талж мэдэх юм
Хэтдээ чи залуу учир мэргэдийн үг сонс»

Эрэлхэг зоригтон сонгож чи тийшээ од
Эр цэрэг чинь дагана, элч илгээж бай
Эрхбиш чин үнэн бол тэнгэрийн нэрээр тангараглаг.
Эргэж буувал тэднийг хайр найргүй хөнөөгтүн» гэв.

Мэргэн энэ үгэнд миний сэтгэл ханаж
«Мэнд амар аж төрөх үнэхээр дээд юм шүү
Чиний хэлснийг таалж цэрэггүй би очье
Чин сэтгэлээс баярланам» гэж Рамазд хариу өгөв.

Эрэлхэг гурван зуун дайчин шилж би аваад
Эр цэргээ орхиж» намайг дагаж явагтун
Элдэв хэрэг гарвал дохио өгөхийн сацуу
Эрслэн дайрч ор» гэж тушаал юугаа буулгав.

Гурван хоног өнгөртөл мөнхүү элч ирж
Гуа үзэмж бүрдсэн бэлгийн дээж барьж
Эрхэмсэг дүрий тань харахаар хаан хүсэн хүлээж
Эрэлхэг жанжныг угтан яаран айсуу» гэлээ.

«Үнэн мөнийг эрэх сэтгэлийн аяыг дагаж
Үлэмж хүслийн эрхээр таныг амдан явнам» гэхэд
«Энэ хэлсэн үгий тань зарлиг мэт дагаж
Эцэг хүүгээс дотно уулзья» гэж би өчлөө

Балар ойн чөлөөнд түр амарч байтал
Бас мөнөөх хааны элч ирэн мэхийж
Агт сайхан хөлгийг бэлэг болгон бариад
Амдан золгохыг хаантан тэсгэлгүй хүлээнэм» гэлээ

Өргөө гэрээ орхиж энэ л замыг дагасаар
Өршөөлт тантай үүрээр уулзья» гэж хаантан өчжээ.
Халх майхан төдий биш ханагар ордон байгуулж
Хаан Рамазын элчтэй хамт бид нойрсов.

Сайн хүний ачийг саарч гээх гэж байхгүй
Салж элчээс холдон нэгэн хүн ирээд
Эрхэм танд өртэйгөө би мартаж тусгүй
Энэрэх халамжийг таягдан урваж тэрслэх ёсгүй

Хар нялхаас аваад аав тань намайг тэтгэсэн
Хартай урвалтыг мэдээд би элчийг нэхсэн
Сарнай цэцэг шиг гуа таныг хөнөөж болох уу?
Сааралтгүй үгий минь бүхэнд та дуулгаарай

Хар санаа өвөрлөж таныг урхидахыг зорьж
Харь дайсан этгээд зуун мянган цэрэг зэхжээ.
Цаахан талд нь бас гурав дахин их хүч бий
Цагдах аюулаас зайлах арга бодвол дээр бий

Хаан ч яахав таныг бялдуучлан найрсаг угтана.
Хамаг байдгаар хуурмаглана, гэвч нууц тушаалаар
Утаа тавих үед нэгэн зэрэг дайрч
Учиргүй олон болохоор цөөн та нарыг дийлнэ» гэлээ

Зүй зохис ёсоор түүнд тал өгөөд
Зүгээр хэрхэвч орхихгүй өршөөж аврахыг амлала.
Хэнд ч үл мэдэгдэн элчтэй буцахыг сануулаад
Хэзээ ч мартаж ёсгүйг тэр хүнд би өчлөө.

«Элдэв яриа туслахгүй, юу л болбол болог гэж
Эрэлхэг дайчиддаа би ганц ч үг хэлсэнгүй
Эр цэргийнхээ зүг элч зарлага мордуулж
Эн даруй ир» гэж тушаал чангалан буулгав.

Өглөө болоход элчид ийн би хэлрүүн:
«Өөрийн тань дүрийг харахыг бас яарнам»
Учрах гайгаас эмээлгүй, хувь тавилан гэдэг
Ухарч бултавч олно» гэж бодсоор үд боллоо.

Тэртээ хөндийн орчин тоос манан дэгдэхэд
Тэвчиж чадалгүй би «дайсан энэ айсуу
Ирт мэс, эр хүчээр дайсныг би хөнөөнөм» гэв
Илт учирсан явдлыг дайчин цөм мэдэв

Тэдгээр хүмүүс бидэнд буруу санаа өвөрлөжээ.
Тэрслүү дайсны эсрэг хэн маань ч цуцахгүй тэмцэнэ.
Хар санаат хааны сүнсийг бид тонилгож
Харь бодолтны заяаг ирт мэсэнд даатгана

Ах дүү минь цөм, дуулга бамбай өмс» гэж
Анд нөхөдлөө өгүүлж, бүгд тулаанд зэхэв.
Нэгийгээ үзэх мөч улам бүр дөхнө
Нэгдэж бид жагсаад дайсныг угтан яарна

Дайсан ойртож ирэхдээ тулаанд бэлдсэний маань үзэж
Даруй элч зарж, хуяг бамбайг харахдаа
Элэг зүрх өвднөм, тангараг няцах нь уу» гэжээ
Энэ үгийн хариуд би ийн өчлөө.



Буруу санаа өвөрлөсний чинь бултыг би мэдсэн
Бузар хэрэг чинь гэвч биелж ер чадахгүй
Хэрэв та хүсвэл нэгийгээ үзвэл зохино.
Хэт үхлий чинь зөгнөж сэлэм маань сугарнам» гэлээ

Элч зарлага нь буцахад эргүүлж нааш нь илгээсэнгүй
Этгээд дайснаа илчилж утаан дохио өглөө
Хоёр жигүүр болон цэрэг нь цуван дөхөвч
Хосгүй олноос мятралгүй тулахаар бид зэхлээ

Ган дуулгаа өмсөж ирт сэлмээ далайгаад
Галзуу дайсныг цохихоор тэсэн ядан хүлээгээд
Урьд хожид гараагүй тулаанд догшрон оровч
Угаас олон дайсан бат нягт байлаа

Онцгойрон дайрч ороход минь галзуурч гэж нэрлэвэл
Ончилж гол хүчий нь зориг гайхуулан дайрахад
Толгойн цэргийг цавчихад сэлмийн үзүүр хугаравч
Тоогүй сайн зэвсгийг хатаасан гарыг магтнам

Тахиан сүргийг дайрах догшин харцагын адил
Танаггүй дайсныг морьтой нь дээш хөөргөн шидлэхэд
Тавхай юугаа гялалзуулж хүмүүс агаарт эргэлдэн
Таних төдий мөр дайсны цэрэг үлдээлээ

Дайсан цөм намайг даруй шуугин дайрч
Дайн тулаан ихсэж харийн цус урсаж
Сүрэг сүргээр мориноосоо ундуй сундуй унаж
Сүлд хийморь нь мөхөж, намайг харахдаа зугтлаа

Үдэш болох хирд дайсны харуул хашгируун:
«Үйлийн эрхээр биднийг тэнгэр дахин гэсгээнэм
Үүл манан адил сүрт дайчид ойртном
Үй олон тэднийг тоолох нүд дутнам!»

Өдөр шөнөгүй шавдаж жанжин наддаа туслахаар
Өнөр олон цэрэг маань айсуй яваа ажгуу
Уул гангыг давж тулааны газрыг чиглэн
Улам улам ойртохдоо сүрт бүрээгээ татнам

Дайчин цэргийг үзэж хар элэгтэн буруулахад
Дайсныг тулааны талбараар хашгиран элдэн хөөв
Миний илдийг даалгүй Рамаз өнхрөн унав
Мэгдэж баригдсан харьтныг газар нухчин хүлэв.



Манай сүүлчийн анги зугтсан дайсныг үлдэн
Мангуурч сандран хөнөөгдөгсдийг олзлон баривчилж авлаа
Амарч тайвшраагүй дайсанд зүүд шиг явдал учирч
Амьдын төдий үлдсэн нь гаслан гиншин гунилаа

Тулааны талбарт амрахаар бүх цэргээ дуудахад
Тухалж намайг харахаар тэд цөм яарав
Шархадсан нэг гараас чинь цус урсан урсаж
Шагшин намайг магтах үг олохгүй байнгаав

Ямбатан дээдэс намайг нулимс урсган шагшив
Ядарч цуцахгүй тулахыг цэрэг бүхэн гайхав.
Зарим нэг нь үгээр магтан магтан биширч
За бас тэгээд ойртон төврэхийг хүсэв.

Олз омог хайхаар цэрэг юугаа тараавал
Олж авсан бэлэгтэй цөм эргэж ирэв.
Хэрэг болбол дайсны цусыг урсгахыг тушааж
Хэрэм цайзны хаалгыг дайсан дуугүй нээв.

Бузар хэргий чинь мэднээ» гэж би Рамазд хэлрүүн:
Бултах аргагүй баригдсан чи амьд үлдье гэвэл
Бэхлэлт бүхнийг найр тавих тушаал чи өг
Бэлнээ үүнээс үхарвал үхэх цондон чинь тэр»

Хариу Рамаз өчрүүн: «Үг дуугүй дагая
Хааны ёсоор би түшмэлдээ тушаал өгье
Энд тэндгүй цөм цэрэгт зарлиг буулгая
Энэ байгаа орноо чиний мэдэлд тушаая»

Тэдний нэг түшмэлийг цэрэгтэйгээ хамт одуулбал
Тэмцэх зүрхгүй дайсан бэхлэлт бүхнээ өгч
Залуу хөгшин ялгаагүй уйлан хайлан гиншнэм
Захгүй үнэт олзыг дийлсэн би-гээр хүртнэм


Харийн Хятан орныг үзэн харж явахад
Хамаг баялгийн түлхүүрийг надад гардуулж өглөө.
Эгэл ардад хандаж: «та бүхэн тайвшир
Элж зовсон та нарыг би хөнөөхгүй» гэлээ


Энд тэндгүй хэгжиж сав бүгдийг нэгжиж
Эрдэнэ баялгийг үзэхэд хэлэх үг алга
Харин бүхнээс онцгой алчуур нөмрөг нэгэн
Хаа ч хэн ч ханашгүй тансаг зүйл олов.



Хэн гэгч урлаж хаанаас чухам авчирсныг
Хэлж би чадсангүй. Дайчин цөм гайхнам
Тэнгэр бурхан бүтээж гэж олноор түүнийг биширнэм.
Тэр гэх нэргүй болдоос бөх гэнэм.

Энэ нандин зүйлийг наран хатандаа авч
Эрхэм тансаг бүхнийг эзэн хаандаа сонгов
Түмэн тэмээ ачиж бэлэг сэлтээ явуулж
Түшиг их эзэндээ мэнд сайнаа илгээв.





XVIII

ТАРИЭЛ ЭНЭТХЭГИЙН ХААНД ЗАХИДАЛ ИЛГЭЭЖ НУТАГТАА ЭГЭЖ ИРСЭН НЬ

«Өндөр эзэн таны өлмий бат оршиг!
Өшөөлж уравсан дайсныг хөнөөж би номхруулав
Үнэн бодит мэдээг цагт нь явуулж чадсангүй
Үлэмж их олз баригдсан хааныг аваачнам»

Гамшиг бүхний уурхай Хятаныг би дайлж
Гайтай зоргоор явдлыг тэр улсад устгаж
Хамаг баялгийг хурааж тэмээ малд ачаад
Харийн тэр орны хот хөдөөг эзлэв»

Уг улсын хааныг олзлон авч явнам» гэж
Уул эзэндээ би захидал бичиг илгээв.
Эзэн хаан угтаж «Магтах үг дутнам»
Энэ биений шархыг өөрийн гараар боов.

Хаан эзний зарлигаар цэргийн хуаран байрлаж
Харилцан учрах, хүүрнэхийг урьдаас цөм бэлдэж
Баяр наадам товлож эзэн дээдсийн дэргэд
Бараалхаж би суувал хаантан элдвээр таалнам.

Үлэмж наргиан болж, урт шөнийг хугаслан
Үнэгэн харанхуйн үеэр, хотыг зорин хөдлөв
Хаан зарлиг болруун: «цэрэг цааш одог
Хар урвагч Рамазыг харахыг би хүснэм»



Олзны хаан Рамазыг эзэнд бараалхуулж ирвэл
Олиггүй буруу санаатныг хаантан хүү шигээ угтаж
Осол хэрэг тариагүй гавьяатан мэтээр үзэх нь
Онцын зоригт эрийн уужим сэтгэл буюу.

Эзэн хаан Парсадан, Рамазд тал өгөөд
Энгүй хүндлэн дайлж удтал ярьж хөөрөөд
Өглөө болоход харин ялыг урьдчилан шийдэж
Өршөөл үзүүлэх биш үү» гэж надаас өөрөө асуулаа.

«Хэт нүглийг тэнгэр өршөөж байдаг адил
Хэмжээлшгүй эрхээ эдэлж та өршөөн соёрх гэхэд
Эзэнтэн буруут этгээдэд хүн зарж очуулаад
Эдүгээ чамайг өршөөв. Дахин хилэгнүүлэв зээ» гэжээ.

Түмэн алтан зоос өөрийн хөрөнгөөр авч
Түшиг их эзэнд барихаар Рамаз тогтов.
Өндөр эзэн тэднийг өршөөж тавихаар барахгүй
Өнгийн тансаг эдээр чимж өгөөд буцаав.

Хариу Рамаз талархан, толгой юугаа мэхийн
Харьж уравсан хэргийг тэнгэр өршөөж хэлтрүүлэв.
Дахин нүгэл үйлдвэл хоромхон зуур бүү тэвч» гээд
Даруй түргэн нутагтаа цөм бүрэн буцав.

Хаан эзний элч үүр цүүрээр ирж
Хагацан салнаас хойш гурван сар өнгөрлөө
Энэ хооронд би ангийн мах зооглосонгүй
Эрхбиш амрах нь чухал ч авлабал дээр биш үү» гэжээ.

Ордонд хүрч очвол олон цөм цуглажээ
Омогт харцага шонхор мөн дүүрэн ажээ.
Наран хаантан бэлдчихээд баатраа хүлээн суужээ.
«Найгүй гуагий чинь үзэн баярлаж байнам» гэжээ.

Хатандаа хаан шивэгнэн, надаас нууж хэлрүүн:
Хатуу тулаанд Тариэл улам ч гуа болдог
Онхийн зовуурьтай байсан ч нөхдөө тэр хөгжөөдөг
Олон үг ярилгүй миний хэлснийг дагаарай!

Хатан чамд хэлэхэд олон удаа бясалгаж
Хаан ширээг охиндоо шилжүүлбэ гэсэн билээ
Ариун гуа дагины маань олон даяар үзэг.
Авлаад биднийг ирэхэд минь хоёул биднийг амдаарай.

Уул, талыг дамжиж авлах гэдэг бахтай
Урам зориг хөгжөөн харцага, шонхор хавтай
Эргэж буцахдаа сэлмээр баахан цавчиж зугаалаад
Энгүй талыг орхиж гэрийн зүг зорив

Байшин гудамж талбайд биднийг угтан сонирхож
Баахан хүн миний ганган тансгийг гайхнам
Эцэж ядраад хэдийгээр цонхийн цайсан атугай ч
Энэ олон цөм амьсгаа даран ширтнэм.

Олзны нөгөөх алчуураа ороосон маань зохиж
Онгон сүрийг улмаар дэгжүүлж байгаа ажээ
Хаан мориноос бууж ордноо цөм орвол
Хасын гэрлээр туяарсан хайртнаа үзэж догдлов

Шижир туяат хувцас нь ордныг бүхэлд нь гийгүүлж
Шивэгчин олон хүүхэн нь эгнэх адил зогсож
Гэр, гудамж бүхнийг туяа харван гийгүүлж
Гэгээн болор оюу, сарнай цэцгийг мялаажээ.

Шархтай гараа өргөсхийж баатар намайг алхахад
Шамдан хааны хатан амдан над ирээд
Төрсөн эхийн адил хацры минь үнсэж
«Төрөл арилжих дайсан л чамд учирна» гэлээ

Хаантангай зэрэгцэн сууж, хайртнаа эрслэн харж
Хайр энэрэл хүртэх нь дээдийн жаргал билээ.
Өөд өөдөөс ширтэх нь нэг ёсны яриа
Өөр тийш харах минь ёстой нэг зовлон

Зугаа цэнгэлд дассан манай заншил ёсоор
Зузаан их найр хөлтэй, бүлтэй болов
Архи дарс гэдэг алтан хундагаар мэлтийж
Аягүй согтсон нэгийг ч гаргахгүй наргиж билээ.

Эн зэрэгцэн найрлахад сэтгэл ихэд хөгжин
Эгц хараа мөргөлдөхөд мөрөөдөл баахан намжин
Догдолсон зүрхийг тогтооход тэвчих сэтгэл дэмжин
Дотно хайртнаа харахад жаргал гэдэг хэмжээгүй



Дуулан цэнгэгч олныг дуугаа намжихыг тушаахад
Дуулгаварт гэд мэхийж хаантав ийн өчрүүн:
«Баатар эр Тариэлийг магтах үг алга.
Бахтай энэ дайчин маань дайсны зүрхийг чичрүүлнэм.


Зүй ёсоор бахдаж чимж гуалах ёстой ч
Зүгээр гэлээ гэхэд, энэ өмсгөл зохижээ
Эрдэнэ баялгийн зуун санг чамд би тушаанам.
Эртний ёсоо хүндлэн дуртай хувцсаа төхөөр»

Эрдэнийн зуун сангийн зуун түлхүүр барихад
Эзэн хаандаа мэхийж би тал өглөө
Хаан, хатан хоёр ээлжээр намайг тэвэрч
Хамаг олон цэрэг эрдэнэ бэлэгт ханалаа.

Хаантан ширээнээ заларч хөгжин, дуулан цэнгэж
Хаш хундага хавирч хөгжим ятга хангинаж
Бүдэг бадаг болоход хатантан найраас гарч,
Бүр шөнө болтол бид цөм наргив.

Ууж наргиж ханаад цөм алжаан наргиж
Унтаж нойрсох хэмээн гэртээ би очив.
Хайрын гал төөнөж зүрхээ алдсан би гээр
Хамгийн дээдээр догдолсон сэтгэлээ барьж чадсангүй.





XIX
НЕСТААН ДАРЬЖААН АМРАГТАА
ЗАХИДАЛ ИРҮҮЛСЭН НЬ

Өөгүй үнэнийг хэлэхээр боол над бараалхан
Өвч нөмрөг өмссөн бүсгүй таныг сурнам» гэв
Догдолсон сэтгэлийн эрхээр томоогүй хүүхэд шиг очиход
Дотно шивэгчин Асмаг нь хуучин замаараа ирэв.

Амрагаа ширтэх харцаар Асматыг би харж
Ахуй сонин ярихаар хүндлэн зэрэгцэн сууж
Нулимсан үер бардаг хайртны мэндийг эрж
Нуулгүй үнэнийг өчихийг түүнээс би хүсэв.

Хариу бүсгүй өчрүүн «Бүгдийг би хэлье
Харилцан уулзахдаа таны сэтгэл хөдлөв биш үү.
Таныг мэдээд даруйхан намайг эгэж өчихыг
Тансаг хатантан тушаав гээд захидал над өгөв.


Адмас-адил үзэмжит жавхаат баатар чи минь
Аюулт тулааны дараа улам гуалиг болжээ.
Хайр энэрлийн нулимс урсгах учир байнам» гэж
Халамж ихт хонгор маань наддаа ийн бичрүүн:

Хэрэв чамайг магтах үнэхээр хувь байдаг бол
Хэзээ ч гэсэн чамайг би зэмлэж явахгүй шүү
Арслан зоригт эрд сарнай цэцгийг хайрлаж
Алтан нар тэтгэж би үүрд чинийх шүү

Ухаан саруул чи минь нулимс урсгах учиргүй
Уул биеэ бодоход уйдаж гуних ёсгүй
Улс биднийг үзэхдээ хэн нь гуа вэ гэлцсэн
Угаас энэ нь зөв, зүй зохисоор ярьсан

Үүрдийн дурсгал болгож нөмрөгөө над бэлэглэ
Үнэндээ миний өмссөнийг үзэхдээ чи баярланам
Эрдэнэс шигтгэсэн бугуйвчий минь ямагт чи зүү
Энэхэн шөнийн явдлыг ийнхүү хоёул мөнхөлнөм





XX

ТАРИЭЛ ЭНЭЛЭН ХАЙРЛАН МУУРЧ УНАСАН НЬ

Тариэл баатар энэлж түмэн гамшгийн эрхээр
Танхил түүний минь бэлэг гэж бугуйвчийг уруулдаа хүргэж
Өмсгөл нандин хувцсаа тайлж өөрөө хаяад
Өгөр даан зэвийж газар өнхрөн унав

Авсанд орох талийгаач шиг Тариэль хөдлөхгүй хэвтэхэд
Аюумшигт цохилтын уршгаар цээжин бие нь хөхөрчээ.
Тэвдэж сандарсан Асмат нүүр амаа маажна.
Тэгэвч цэнгэг усаар баатрын биеийг шүршэнэ.

Автандил баатар мөн л санаа алдан ширтэнэ
Асмат уйлан хашгирч хад, уулыг доргиулна
Байн байсаар Тариэлийн ухаан оюун сэргэж
«Балагт эвэ ергөнц цусанд минь ханашгүй» гэлээ.


Баатар эр сэргэж, зэвхий царайлан босовч
Балартан муурсан шинж харах нүдэнд нь хэвээр
Улаа бутарсан царай нь шарангуйлж баахан шаналаад
Учрах ярих, аж төрөх хүсэл бүхэн талаар

Автандилд тэр хэлрүүн: Ухаан оюун баларч
Алив зовлонд унагасан хайртны тухай өчье
Хонгорын минь царайг хараагүй ч чи бол аврагч нэхэр
Хосгүй бэрх хорвоод амьд яваагаа гайхнам



Өөрийн нь энэх бугуйвчийг гартаа ийн зүүж билээ.
Өнгөт энэ бугуйвчийг захианы хамт авчирч билээ.
Өвч үзэмжит нөмрөгөө хайртандаа би явуулж билээ.
Өөрийн нь энэх бугуйвчийг гартаа ийн зүүж билээ.





XXI


ТАРИЭЛ АМРАГТАА ХАРИУ ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН НЬ

Гэгээ гэрлээрээ гийгүүлсэн наран дэнлүү хатан минь
Гэмгүй зөөлөн сэтгэл надаа баясал төрүүлднэм
Чиний тансаг гуа миний оюуныг эзэлж
Чин сайхан санаа чинь тэнцэх эрдэнэ алга.

Тэр нэгэн өдөр намайг чи аварсан
Тэгээд энэ өдрийг тэр өдөртэй зүйрлэнэм.
Явуулсан үнэт бэлгээр чинь гар юугаа чимлээ
Явч ийм жаргалыг амсаж байсан удаагүй

Үнэнхүү хүссэн ёсоор чинь өмсгөл нөмрөгөө явуулав.
Үгээр хэлж баршгүй гайхам сайхан эд шүү!
Балай тэнэг намайгаа чи минь бүү мартаарай
Баяр бахдал бүхэн минь хорвоод ганцхан чи шүү!

Шивэгчинд захидлаа өгч нойронд би дарагдаад
Шийдсэн амрагаа зүүдэлж гэнэт цочин сэрэв
Хонгор хайрт тэр минь хоромхон төдийд арилж
Хосгүй гунигийн сэтгэлийг шөнийн харанхуй эзэмдэв.



XXII

НЕСТААН ДАРЬЖААНЫГ ЭРД ГАРГАХААР, ЗӨВЛӨСӨН НЬ

Ордонд ирэх зарлиг өглөө би аваад
Онцолж бүхнийг асуун эгшин зуур очиход
Хаан хатан болон гурван түшмэд байв
Халз эзний өөдөөс хэргэм ёсоор харж суув.

Ивгээлт тэнгэрийн тааллаар бидний нас элж
Идэр цаг өнгөрч, хөгшрөх гэдэг болж
Зааа золоор охин ганцтай болсон хэдий ч
Залгах хүү байхгүй, жаргалаар ер дундуур

Олон даяараа хамгаалж, хаан ширээ эзэлж
Олиг муутай дайсан биднийг хөнөөхөөс өмгөөлж
Орон улсдаа түшиг болж ялгуусан гарамгай төрсөн
Охиндоо тэнцэх эр олох хэрэгтэй болжээ

Хааны энэ үгэнд би хариу хэлрүүн:
«Харах хүнгүй гэдэг их гай билээ
Танд тэнцэх хүү байвал тэр баярлана
Тавтай зөвлөн шийдэх нь зүйтэй гэж бодно»

Хаантан дээдэс зөвлөж миний зүрх өвднөм
Хамаг явдлыг шийдэхэд нэмэргүйгээ мэднэм.
Хорезм их гүрэн, хүүгээ хаан нь өгвөл
Хорвоод өөр хүн хэрэггүй» гэж эзэн айлдав.

Тэнд байгаа хүмүүст энэ санаа шинэ биш
Тэд биенээ харалцаад шийдвэр цөм бэлэн
Хэлэх үг минь хүчгүй, эсэргүүцээд тусгүй
Хэнхдэг цээж доргиж миний бие балартав

Хатан бас хэлрүүн: «Хорезмын хаан хүчтэй
Хайрт хүүгээ өгвөл өөр хүн хэрэггүй нь баттай
Эзэн ингэж сургасан хойно зөрөхийг би зүрхэлсэнгүй.
Энэ саналыг зөвшөөрч сэтгэл санаа мансуурав.

Улс гүрэн маань их ч ширээ залгах хүүгүй
Уулаас ийм боловч ялдам сайхан охин бий
Хүүгээ хүргэн болгохыг бид хүсэж байнам.
Хүнд бэрх биш шүү» гэж Хорезмын хаанд бичжээ.

Хааны язгууртан элч өнөр бэлэгтэй эгэж
Харь орны эзэн учиргүй их баярлан
«Дээд тэнгэр өршөөж хүсэл бүхэн биелдэг
Дэр нийлэх тавилантай бидний үрс төрж» гэжээ.

Залуу хүргэний төлөөнөө элч бас зарж
«Зайгүй зөвшөөрч байгаа бол удах хэрэггүй» гэжээ.
Яахын эрхгүй гуныж, цээжинд зовлон багтарч
Ядарч сульдах эрхээр хөдөө хээр хэвтэж билээ л...





XXIII

ТАРИЭЛЬ, НЕСТААН ДАРЬЖААН ХОЕР, ЯРИЛЦАЖ ШИЙДСЭН НЬ

Амь насаа бусниулмаар зүйргүй гувьж байтал
 Асматын элч ирж надаа захидал өгөв
 «Зандан адил гуалиг залуу баатар чи минь
 Заваа дэмий үрэлгүй Нестантай уулз» гэжээ

Амьдрах хүсэл оргилж хөлөг морио унаад
 Аятай их баясаж цэцгийн хүрээлэн дамжтал
 Шилтгээн тэнд Асмаг уйлан гиншин зогсом
 Ширгэшгүй нулимс хатаах үг над дутнам

Гунигт царайг харахдаа өөрөө би автаж
 Гутарч зовсон учир урьд адил инээсэнгүй
 Усан нулимс урсган Асмаг дуугүй зогсож
 Удсан ч үгүй би бас л мэлмэрч эхэллээ

Асуусан бүхнийг Асмаг таг дуугүй өнгөрөөж
 Асарт ордноо дагуулж хивсэн үүдийг сөхөв
 Сарны гэгээ харахад гуниг баахан хөнгөрч
 Сайхан гэрэл харвавч зүрх төдий л хайлсангүй



Нандигнаж бэлэглэсэн өмсгөлийг эв хавгүй нөмрөөд
Наран дэнлүү бүдгэрч гунигланхан байнам
Гэгээн саруул дүр нь нулимс дунд живээд
Гэмшин зовсон янзтай хайрт маань хажуулам

Нар сартай зүйрлэшгүй гуа төрсөн дагина
Намайг орж очиход барс адил хилэгнэн
Хөмсөг юугаа зангидаад гэнэт босч ирлээ,
Хөнөөх аянга адил сүр ихтэй байлаа.

Амраг минь өчрүүн: «Ариун тангараг умартан»
Алив хэлснээ зөрчигч урвагч чи ирэв үү
Хар зовлон тарьсан чамайг тэнгэр гэсгээнэ
Хариу би хэлрүүн: «Хийсэн гэмээ мэдэхгүй»

Хийсэн хэргээ мэдэхгүй, хэлэх үг алга
Хилэнц нүгэл юуг хэлж болох биш үү?»
Хариу тэр өчрүүн «итгэл тэслэгч этгээдтэй
Харилцах үг алга, эндүүрсэн маань буруу»

Мэдэхгүй гэнээ чи, Хорезмын хүүтэй суулгахаар
Мэргэд, язгууртан зөвлөхөд чи суулцсан биш үү
Тангараг юугаа няцаж, сэтгэлийг чи хөсөрдүүлжээ
Таарах зохих ёсоор чамаас өшөө авна даа.

Энхрий хайрын нулимсаар талын билчээр дэвтээнэ
Эмч домч олон тэвдэж байсан биш үү?
Нулимс тийн асгавч эр гэдэг хуурамч
Нуугаад чи яахав чи буруут биш үү?

Сайн муу хамаагүй. Энэтхэгийн хаан хэн ч байг
Сайхан энэ орноо би мэдэх болно шүү!
Хуудуу хэрэг чинь бүтэхгүй, хуурамч чимгээ орхи.
Худал чалчих гэдэг чам шиг амьтны ёс

Намайг амьд байхад, Энэтхэгээс бушуу гонил
Нарлаг оронд маань хоргодвол хумхийн тоос болно.
Хөх тэнгэрт эрэвч над шигийг олохгүй гэж билээ
Хөөрхий Таризель мэгшиж яриагаа тасалж билээ.

Энэ үгийг сонсохдоо сэтгэл минь хөгжиж
Эрч хүч зангирч юунаас ч буцамгүй болж билээ
Хайртнаасаа салаад өдийд амьд ахуй минь сонин
Хар гайт энэ хорвоо хэдий хүртэл тамлана даа!

Толгой тушаа харвал магометын судар дэлгээстэй
Тонгойж түүнийг аваад тэнгэр дээдсийг магтав.
«Эрхэмсэг наран чи, намайг сүрхий занав
Эвлүүлж хэлэх үгий минь эрхиш чи болгоо!»

Өчих үг минь худал, онхийн дэмий байвал
Өндөр тэнгэр гэсгээн нар намайг хайлуулаг
Үнэн санаа санавал би буруугүй» гэхэд минь
Үгээ хэлэхийг зөвшөөрч Нестаан толгой дохив.

«Тангараг үгээ няцсан бол наран гэрэлт бүсгүй минь
Тааллын ёсоор тэнгэр догшин аянгаар ниргэг
Өөр нэгийг сэдэж, сэтгэлийн нүгэл хураасан бол
Өр зүрхий минь хайргүй хатан мэс сүлбэг

Хааны зарлигаар очиход ордонд зөвлөлгөөн болж билээ,
Харийн хүнийг урихаар цөм тохирсон байж билээ,
Тэдний шийдийг өөрчлөх арга барагдаж билээ
Тэгээд сэтгэлээ зөрчин түр зөвшөөрч билээ

Хаантан тэгж шийдсэн бол маргах гэдэг дэмий
Хариас хүн эрэлтгүй манайд хүн бий
Хаан ширээг зүй нь би залгах ёстой
Хаа холоос уриад бүтэхгүй байх учиртай

Маргаж хоосон будилснаас өөр арга хайя.
Маш болгоон хянаж гоомойдохоо байя
Ингэж хэдий бодовч зүрх гэдэг булиглана
Ийм л учир болсон доо. Буруу хэрэг байна уу?

Зүрх юугаа бодож санаагаа ийн зарахад
Зүйлийн цэцэг хөлдөөх, хүйтэн бороо намжиж
Энхэр хайрт тэр минь танан шүдээ яралзуулж
«Эдүгээ би ойлгов, чиний зөв» гэлээ.

Тэнгэр бурханд тэрсэлж бузар хэрэг хийнэ гэж
Тэмцэж өөдөөс нь босож булай бүхнийг тарина гэж
Үнэндээ би итгээгүй, Энэтхэг их гүрнийг
Үнэнч амраг хоёр,—чи бид захирах хувьтай!»

Уур омог нь тайтгарч ийн тэр хэлээд
Уян зүрх зөөлөрч, нар сар шиг гялалзаж
Энхрийлж бат янаглан, зэрэгцэн хоёул сууж
Элэг зүрх хөгжөөсөн сайхан зүйл ярьж билээ.

Ариун явдалт мэргэд гамшгаас ер айдаггүй.
Адайр муу хэрэг байвч гаарч ер яардаггүй
Харийн эрийг хоригловол эзэн чамд хилэгнэнэ.
Хаантай чи маргавал энэ орон сөнөнө.

Хорезмын хүүг ирүүлбэл хаантан биднийг гэрлүүлнэ.
Хонгорын уруул хатаж нүдний гэгээ арилна.
Тэр захирна гэхэд бидний зовлон зузаарна.
Тэгэх ёс алга, харийн мэдэлд орохгүй.

Өөдөөс нь би хэлрүүн: Түүнтэй чамайг гэрлэхгүйг
Өндөр тэнгэр мэдэг. Тэднийг Энэтхэгт ирэхийг
Анаж байгаад мэдэж зэр зэвсгийн хүчээр
Аанай тэр хаан хүүг би аргалж орхиё!»

Хариу тэр өчрүүн: «Би чинь бүсгүй хүн шүү дээ.
Хар ийм хэргийн шалтаг болохыг хүсэхгүйсэн
Хаан хүүг л хөнөөгөөд бусдыг бүү хөндөөрэй.
Хаана шударга газарт хувхай мод ч цэцэглэдэг.

Арслан адил баатар минь цэрэг цуухаар яахав,
Арга чаргы нь олоод ганц л түүнийг хөнөө!
Адгуус амьтан адил цөмийг бүү сөнөө.
Ашиггүй их нүглийг зүрх минь эс тэвчинэ.

Энэ хэргийг үйлдээд хаанд үгээ хэл.
«Энэтхэг их гүрнийг хүний мэдэлд өгөхгүй,
Хаан ширээг зүй нь би залгах ёстой.
Хамаагүй та зүтгэвэл хот хүрээний чинь бусниулна.

Харин чи гэхдээ надтай гэрлэх тухай
Хаан эцэгт үг дурсаж ер болохгүй.
Удахгүй чи зөвтөж надтай суухыг хаан гүйж
Угаас хаан ширээнд чи бид сууна.

Ингэж зөвлөж хэлсэн нь сэтгэлд нэгэнт нийцэж
Ирт мэсийн хүчээр дайсныг хөнөөхөөр шийдэж
Босож явах гэтэл өөртөө мэхийхийг дохиход
Бодол хүсэл байсан ч би-гээр тэвэрч чадсангүй.

Эгшин төдий азнаад бас л уйдан салж
Эгшдэггүй нулимс урсган цэцгийн хүрээлэнд очоод
Асмагтай баахан тэнэж охорхон жаргалаа мөрөөдөн
Ахин хагацахын гунигаар гэрийн зүг гэлдрэв.



XXIV

ХОРМЕЗЫН ХУНТАЙЗ ЭНЭТХЭГТ ИРЖ ТАРИЭЛИЙН ГАРТ АМЬ ҮРЭГДСЭН НЬ

Элч нэхэн ирж, хүргэн айсуй гэжээ.
Эвий хөөрхий амьтан учрах гайг мэдсэнгүй.
Эзэн хаан баярлаж хувь тавиландаа хангалуун.
Эрж намайг дуудаад зэрэгцэн суухыг тушаалаа.

Хаан эзэн хэлрүүн: «Сэтгэл нэг л талбиун
Хайрт дүүгийн чинь хуримыг дээдийн дээдээр хийнэ.
Хамаг орд шилтгээнээс бэлэг сэлэг авчирна.
Харам хявцаг муухай, өнөр өгөөмөр хийнэ».

Ийш тийш нь хүн зарж би мордуулав.
Ирнэ гэж болзсондоо хүргэн хүү ирэв
Эрхэм дээдэс гэрч энхрий зочноо угтав.
Эгэл замд багташгүй олон цэрэг байв.

Өндөр эзэн хэлрүүн «Өнөр хуаран босго
Өөрийн төрийн тавнангаа чи биеэрээ амрааж бай.
Чи эндээ байж хүргэн хүүг угтаарай.
Чиг өөр газраас цэрэг эрс амдаг»

Асар майхан дүүрч их чөлөө алаглана
Асар баярт согтсон тавнан морилж ирэв
Дээдэс цөм түүнийг хаалга тушаа угтав.
Дэн олон цэрэг отго отгоор жагсав.

Үйлдэх бүхнийг хийгээд гэртээ би буцаж
Үнэнийг хэлэхэд алжааж амарч нойрсохыг бодов.
Асмаг гэнэт боолоор захиа над илгээж
Амраг гуа бүсгүй чинь пэцэрлэгт хүлээнэм» гэжээ.

Сарнай цэцгийн хүрээлэнд арайхийн би очвол
Сайхь Асмаг мэлмэрэн учрыг би асууваа
Чамтай ийн учраад амар заяа үзэх үү?
Чадал хүрэхээ байлаа. Одоо өмгөөлж болохгүй нь гэв.

Хоёул бид орвол гүнж баахан хилэнтэй
Хорвоогийн нарнаас хурц гэрэл гэгээ нь сүртэй
«Үхлийн тулаан хийхээс ухарч чи саатав уу?
Үгүй бол хаанд бас үнэнч болж буув уу?» гэнэ.

Гомдох гэдэг жигтэйхэн «Хэн хайртай болохыг
Голт зүрхний янагийг мэдэж болно, яамай
Эмс тулаанд тухирах сайны ёс биш» гээд
Эргэж би гараад эр зориг шулуудлаа.

Зуун боол сонгоод тулаанд бэлтгэ» гэлээ
Зултай хөлөг мориор хотыг сэм тойрлоо.
Асар майханд орвол тавнан алжаан нойрсоно
Алалдах ёсыг зөрчин цус гаргалгүй аргалав.

Асар майхны хаяаг өм татан огтлоод
Амь үрэгдсэн дайсныг хөлөөс нь шүүрч аваад
Багана мөргүүлж гуядвал харуул сандран хашгирав.
Бамбай дуулгат бигээр тоос манарган талийв.

Элдэж нэхэх чимээ тал дүүрэн цууриатав
Эрсэлж ирсэн заримы нь эд бад хийж л байв
Дайсан хэрхэвч нэвтэршгүй хатан цайздаа ороо
Дайраад дайраад нэмэргүй, санаа нэг амрав.

Найман зовхист би элч зарлага мордуулж
Надаа туслах дайчин нэн даруй ир гэв
Уухилж яарсан цэрэг шөнөжин цувж ирэв
Учир явдлыг сонсоод амиа хайрлахгүй гэгцгээв.

Эртлэн өглөө босож зэр зэмсгээ зүүтэл
Эзэн хааны шадар гурван гүшмэл ирж
Төрсөн хүүгээс ялгаагүй дотно билээ чи
Төгс их баярыг ямар учраас гутаав?

Гэмгүй хүний цусыг урсгахыг бид цээрлэдэг
Гэрлээ гэж бодсон бол охины минь гуйхаа яав
Өсгөж тэтгэсэн намайг чи зовлонд унагав.
Өтөлж алжаасан би чамтай учрахаа болив.

Хаанд би хэлрүүн: «Болдоос хатуу билээ би
Хамаг алдар минь бүдгэрвэл үхлээс айх гэж үү?
Эзэнтэн шударга байвал хичнээн сайн нь мэдээж шүү!
Эрхэмсэг гүнжийг горьдоогүйг нар барьж тангараглая!

Энэтхэгийн хаан ширээ хичнээн хүндтэй билээ
Эрхэм таны мэдлээр би суух ёстойсон
Хааны удам сийрч та ганцаар захирнам.
Харин таны дараа би залгах хувьтайсан

Үнэнийг шууд хэлэхэд таны бодол зөвгүй
Үнэн тэнгэрээс хүү биш, ганц охин заяажээ.
Хууль ёсоо алдаж харийн хүнд төрөө өгөх гэж үү?
Хурц илд маань зэвэрч би бөхийх гэж үү?

Охины чинь би горьдахгүй, дуртай хүндээ өг.
Орон улсаа харин хэнд ч би өгөхгүй шүү!
Хэрэв надтай тэмцвэл тэрээр эрхээ алдана
Хэний ч тусламж хэрэггүй, би өөрөө дөнгөнө»





XXV

НЕСТААН ДАРЬЖААН АЛГА БОЛСНЫГ ТАРИЭЛ МЭДСЭН НЬ

Элч язгууртныг эгүүлж элдэв бодолд мансуурч
 Энхрий амрагийн тухай сураг сонсолгүй гиюүрч
 Эгц өндөрт авирч хөдөө талыг харвал
 Элэг зүрх эмгэлсэн аймшигт юм үзлээ.

Явган хоёрыг хараад би амдан одов
 Ядарч туйлдсан Асматыг үзээд ихэд гайхав
 Толгой, нүүр нь цус, уйтгар гунигт авгаж
 Тосож намайг очиход таг дуугүй мэгшив.

Энэ бүхнийг үзээд ухаан санаа балартаж
 «Элдэв учирсан гайг хэл» хэмээн хашгирав
 Тэвчих аргагүй цурхиравч тэнхээ юугаа шавхаал
 «Тэнгэр биднийг гэсгээв» гэж тэр арайхан өчлөө

Тулж очоод би үнэнийг нуулгүй тооч» гэв.
 Туйлдаж эцсэн Асмаг улам улам мэгшив.
 Амссан гамшгий нь хэлтэрхийг ч эвлүүлэх үг олдохгүй
 Асгарах цусанд нэвчээд цээжин бие нь харагдахгүй.

Үнэнийг ер нуулгүй цөмийг би тоочъё.
Үйлийн лайтай намайгаа чн өршөөж аргалаарай!
Гашуун бэрхийн босгоос гэтэлгэж өгөхийг гуйя
Гайтай хар хорвоогоос салгаж орхихыг хүсье.

Тавнанг хэн алсныг тэр дороо мэдсэн
Тайтгарч өгөхгүй хаан тэсгэдгүй их хилэгнэсэн
Яргачныг олж авчир» гэж тэр хичнээн хилэгнэвч
Яагаад ч чамайг олшгүйг өөрөө бүр мэдсэн

Чамайг зугтан одоод, цайзанд нуугдсан гэгцгээхэд
Чанд учрыг нь мэднэ. Дэмий цус урсгаагүй
Охинтой минь уулзаад, гэрлэх гэж зорьсон
Одоо тэгээд хагацахад зориг хүч дутсан

Ийм хэрэг болсонд дүүг хатуу цээрлүүлнэ.
Ингэж замы нь алдуул гэж би түүнд захиагүй
Янаг амрагийн завхралд охины минь оруулж
Яриагүй бузар булайд тэр уруу татжээ.

Хатуу ёст хаан үгээ хэзээ ч буцдаггүй
Харин хэлсэн бүхнээ ёсчлон хийхээс няцдаггүй
Гэтэл хэн нэгнээр хааны дээрх зарлигийг
Гэмт эм Даварт нэгд нэггүй өчиж.

Олны дэргэд хаантан хөнөөнө гэсэн гэжээ
Олиггүй бузар эм хариу ийн хэлрүүн
Энд над буруугүйг дээд тэнгэр андахгүй
Эгэлгүй тамд унасан учрыг ах мэдэхгүй

Нестан чамаас холдоод уйдаж зовсон хэдий ч
Нээрээ гоёлоо зүүгээд үзэмж гуалиг байсан
Булай хараалч эм гүнжийг муухай харааж
Бузар янхнаас болов, үйлээ өөрөө амс

Эр нөхрөө алуулсан балагт хар өлөгчин
Эдүгээ гэмгүй намайг чи бас хөнөөнөм
Чамаас болоод хаан ах намайг зананам
Чандлан муу гичээг үүрдийн зовлонд оруулнам,

Ингэж хэлээд эм шулам гүнжийн үсийг зулгааж
Ийм гэхийн газаргүй, зэмдэг болтол занцсан
Тэр бүх зовлонг гүнж дуугүй гэвчиж
Тэсэлгүй би гэмшсэн ч туслах чадал дутсан

Хараалч эм Давар боол зарц дуудахад
Хав хар хоёр эр балмад гэгчээр дайран
Дээрэмч адил хэтэж гүнжийг барьж аваад
Дээрэлхэн харуул адилаар завинд хийж одсон

Хараалч эм өчрүүн: «Наадхаа усанд хөмөр
Хаа хол газар аваачиж үүнийг хая!
За за» гэж цаад хоёр инээж
Заяа муутай би хөдөлгөөнгүй гөлөрсөн

Ордны хана хаагаад хаашаа одохы нь хараагүй
Олиггүй хараалч эм «Одоо үхэхэд хамаагүй
Хүний гарт үхэхээр, өөрийн гарт үхье» гээд
Хүрэн нүс асгартал хутга шааж унасан

Тэндээс амьд гарсан минь гайхмаар хэрэг биш үү?
Тэгээд үүнийг дуулаад зүгээр гэлдрэх гэж үү?
Ариун ёсыг дагаж хорвоогоос намайг салга гээд
Асгарах нулимс урсган Асмаг гуниглаж билээ

Өөдөөс нь би өчрүүн: «Чи буруут бишээ
Өөрийн хайртад би өр ихтэй билээ
Уулын өндрийг давж усны уртыг гэтэлж
Угийн амрагаа эрнэ гээд ухаан балартан унажээ.

Хамаг бие дагжиж халуу даан буцалж
Харин би сэтгэлдээ «ийн тайтгарч чадашгүй
Хаа холын газар эрж одохоос сайнгүй
Хамгийн сайн нөхөр л илрэх нь гарцаагүй» гэлээ.

Даруй би хувцаслаад хөлөг морин унаатай
Давын өмнө үеийн зуун жаран эртэй
Тэнгис далайн эрэгт завьхан хөвөх зүг
Тэртээ холыг зорьж анх хөдөлж билээ.

Далайн замыг тосож завинд би суугаад
Даяар тэнгисч олны зорчих газрыг боогоод
Горьдон хүлээвч талаар, хувь тавилан тийм
Гонсойх зовлонд хатсаар, тэнгэрийн таалал нийм


Тэнэж мөргөлж удсан ч ганц жилээс давсангүй
Тэнгисийн хүмүүс амрагий минь зүүдэн төдий ч харсангүй
Үнэнч цэрэг үрэгдэж бараг ер үлдсэнгүй
Үүрдийн заяандаа итгэн тэнгэр би гомдсонгүй

Далайн аянд алжааж хуурай газар гарахад
Дайчин нөхөр хүсэхгүй араатан шинжтэй болжээ.
Хань ижлээ барсан ганц бие тэнүүлчийг
Харин тэнгэр тэтгэж хаяж орхидоггүй байжээ.



Амьд үлдсэн нь Асгат, өөр хоёр боол
Ашгүй энэ хэд маань зовлон хуваадаг улс
Амраг бүсгүйн тухай өчүүхэн ч гэсэн чимээгүй
Асгарах нулимс урсгахаас өөр над цэнгэлгүй.





XXVI

ТАРИЭЛ НУРАДИН — ПРИДОН ХОЁР УЧИРСАН НЬ

Бүхэл шөнөжин тэнээд цэцгийн хүрээлэн үзэв
 Бүр дөхөж очвол хот ба агуй харагдав
 Амьтан хүнтэй уулзахаас зүрх сэтгэл өвдөж
 Амсхийх төдий суухдаа байгалийн сайхныг бишрэв.

Зарц боол ундалж би амсхийн хэвтэвч
 Зайгүй гуниг хатгаж тэр дороо босов
 Үнэн худал алин ч сураг ердөө гарсангүй.
 Үерлэн асгах нулимс хөндий дүүрээд багтсангүй

Тэртээд нэгэн баатар тулаанд хүн дуудан
 Тэнгисийн эргээр хурдлавч шархдаж туйлдсан шинжтэй
 Цусанд бүр нэвчиж илдний хугархай бариад
 Цутгах хараал урсган дайснаа заных нь хилэнтэй.

Одоо миний унадаг хилэн хар морьтой
 Онгон шуурга адил хөндий уруудах нь сүртэй.
 Ийм баатартай учирч боол би зөрж,
 Илт хэргий нь мэдэхээр хэн яасны нь сонирхов.

Хариу өчих байтугай, хэлсэн үгий нь дуулсангүйд
Харьж буцах нь өнгөрсөн би амдан очоод
«Яагаад чи гуниглав, явдал учраа хэл» гэв.
Яриагүй намайг хараад таалсан бололтой дөхөв.

«Авралт тэнгэр хүчтэй тая шиг эр мандана.
Арслан зоригт танд алив үнэнээ хэлье
Зэр зэмсэггүй биднийг бузар мэхээр ялж
Зэвхий муу ямаа арслан боллоо» гэнэм.

«Баахан чи тайвшир, цэцэрлэг тушаа амаръя
Байлдах халуун тулаан шиг жаргал баатарт олдохгүй»
Ингэж хэлээд би энэг, хүү уулзсан шиг
Ихийн ихээр баярлан дөдгөөн харцы нь соёрхов,

Хөөрхий нэгэн боол минь шарх анагаахдаа сайн билээ,
Хөндөх гэдгийг мэдэхгүй шархы нь тэр боож билээ.
Явдал учры нь би өчихийг баатраас хүсвэл
Яриагүй гайхмаар хэргээ өгүүлэхийг тэр зөвшөөрлөө

«Тэр баатар өчрүүн:» Хэн гэгч вэ чи?
«Тэнэж юундаа гуньж урьдын жаргалаа алдаав?
Уран сарнай, уулын мод юунд ингэж гандаав?
Угаасаа асаасан дэнлүүгээ тэнгэр юунд унтраав?»

Асуусан тухайд хэлрүүн: Мульганзарын хүн би
Алдар нэр Придон, энэ улсын эзэн хаан
Та бүхэн одоо манай нутаг дээр байнам.
Талхисан уужим биш ч өгөөмөр орон юм шүү.

Аав, авга хоёрт өвөг маань улсаа хувааж
Арлын хэсэг нутгийг миний мэдэлд өгсөн юм.
Авга гэтэл арлы маань хүчээр булааж аваад
Ашгүй гамшиг учирч тулалдах шалтгаан энэ юм.

Тэгнис хөөсрөх тэртээд өнөө би авлалаа
Тэгэхдээ шонхроор авлаж анчин олноо орхилоо
Таарах гайг зөгийлгүй цэргээ эрэг дээр үлдээлээ
Тавхан дайчин аваад арал дээрээ очлоо,

Хөнгөн хурдан завнар урсгал сөрөн явж
Хөөтэй будлын самууныг ерээсөө эс бодож
Авгынхангай уулаахдаа санаа ер зовсонгүй
Аавд хорхой хүрээд дуу шуугаа ч татсангүй.



«Тэдний хашгирахыг үзвэл бидэнд дургүйцсэн байртай
Тэгээд цэргээ авч биднийг боосон нь учиртай
Авгынхан цөм тулаанд морилон давхиж ирэв.
Авналдан уулзахаас ичиж холоос тулахыг зорив.

Далайх мэс хангинаж ширүүн тулаан болж
Дайвалзах бяцхан завиндаа суугаад би хашгирвал
Урд талаас амдаж тэдний цэрэг айсуу.
Улайран ихэд оролдовч намайг бүсэлж чадсангүй.

Хоёр талаас гэвч хүч нэмэн шахсаар
Хойт талынхаас салавч сум исгэрэн ирсээр
Ганц талд байсан бол ч тэднийг баллах байсан л даа
Гай болоход сум дуусаж илд бас хугарч л дээ.

Эргэн тойрон тэднийхэн, горьгүй гэдгийг мэдлээ
Эрмэг хөлгөө унаж эрэг дагуу хөвлөө.
Дайчид цөм үрэгдэн ганцаар би туллаа.
Даан их гайхаж надаас тэд зугтлаа.


Дээд тэнгэрийн эрхийг тэрсэлж би чадахгүй.
Дээрэмч тэднийг би өшнө гэдэг хэмжээгүй.
Үеийн үед зүхэж тэд булайгаа үзэг.
Үхдэл муу хүүр дээр хон хэрээ эргэг»

Энэх яриаг дуулахад миний зүрх дэвтэж
«Эрсэлж ер яарах хэрэггүй, сэтгэлээ барьж тогтоо
Хоёул хам очиж үнсэн товрог болгоё.
Хос баатар биднийг тэд дийлэх нь гонж» гэв.

Өөрийн тухай хэлрүүн: «Одоо ярихаа больё»
Өег тайван байж хэрэг болохоор хэлье»
Энэ үгийг сонсоод тэр над өчрүүн:
Эрхэм чамайг мэдэхсэн, эцэслэтлээ чин зүтгэхсэн

Үлэмж том биш ч үзэсгэлэнт шилтгээнд очвол
Үнсээр толгойгоо булж эмгэнэсэн цэрэг угтав.
Хүн болгон хайлж эзэнтнээ тэврэн авав.
Хүчит зэр зэмсгий нь цөмөөр тэд үнсэв.

Намайг ихэд таалан гараа хүндлэн сунгав.
Наран адил баатар гээд шархаа эдгээхийг гуйв.
Өгөөмөр баян хоты нь үзэж бид соёрхов.
Өлзий буянт хүмүүсий нь үнэхээр энэрэн сонирхов



XXVII

ПРИДОНД ТАРИЭЛ ТУС ХҮРГЭСЭН НЬ

Эзэн баатар эдгэрч тулаанд бэлэн болоод
Эр цэргээ бэлтгэж онгоц завиа базаалаа
Харсаар байтал нүд аяндаа чилж орхих
Хатан гуа баатрын гавьяаг би өгүүлэмэ

Тулаанд бэлдсэн дайсан найман онгоц хөлөглөж
Тужаар олон цэрэгтээ болд дуулга өмсгөж
Эрслэн хүрч ирэхэд нь хад шиг бат угтаж
Эрэмгий хүчээр би усанд тэднийг хөмөрлөө.

Хөлөг онгоц ирэхэд хушуу юугий нь бариад
Хөлгүй далайд хөмөрч хөнөөл сүйтгэл тарив.
Хагас зарим нь зугтаж харах бараагүй арилав.
Хамаг олон намайг магтан шагшин гайхав.

Тэнгис далайг гатлахад дайсан бас дайрав.
Тэр гэхийн тэмдэггүй догшин тулаан болов.
Эр чадал бүрдсэн Придоны гарамгайг биширч
Элгүй гуалигхан залуугийн арслан сүрийг гайхав.

Авгаа хүүтэй нь тэр илдийн ирээр унагаж
Асар хорслын тэмдэг гар юугий нь тайрч
Олзлон барьж аваад оосорлон гулдарч явахдаа
Орилон чарлахы нь үзэвч өөрөө баяртай байлаа




Эмхгүй зугтсан цэргий нь элдэн бид хөөгөөд
Эгэл хүчээ алдалгүй хот орны нь эзлээд
Олзны олон амьтныг хөл гаргүй болгоод
Олж хураасан баялгийг хэмжиж барахгүй байлаа.

Эрдэнэс сангийн түлхүүрийг Придон баатар хурааж
Эрээгүй авгын бүлгийг олзлон барьж аваачиж
Өшиж хорссоны тэмдэг дайсны цусыг уурсгаж
Өнөр баяр дүүрэн эгж хотдоо ирлээ

Онц л баяраар угтаж, Придон намайг угтан
«Оройн дээд тэнгэр бидэнд илгээсэн» гэлээ.
Одоо ч хүртэл дайсны хар цус асгарнам гэж
Олон бүгдээр нийлж бид хоёрыг биширлээ.

Хаан гэж Придоныг, хааны хаан гэж намайг
Хамаг цэрэг өргөмжилж миний боол гэлцлээ
Сарнай цэцгээ алдаад элж зовсон надад
Сайхан баяр нь туслахгүйг тэд мэдэхгүй байлаа.





XXVIII

НЕСТААН ДАРЬЖААНЫ ТУХАЙ ПРИДОН ӨГҮҮЛСЭН НЬ

Нэгэн өдөр намайг Придон авд урив
Нисэх шахам өндөр эгц хаданд гарав
Элдвээр хөгжиж явтал, баатар эрээр хэлрүүн:
Энд үзсэн сониноо эдүгээ хөөрье гэнэм

Хөх тэнгэрт шонхор шиг хөлгүй далайд нугас шиг
Хөлөг морины хурдаар авлаж явсан билээ
Энэх хадан дээр сууж биеийн чилээг гарган
Эвхрэх долгион дээгүүр хөөрөх цахлайг ажлаа

Тэнгис далайг ширтвэл тэртээ хол газар
Тэмдэг төдий юм бүртэлзэх төдий өнгөрнө
Энэ чинь юу билээ гэж үнэнээс би гайхаад
Эрэгцүүлж тойруулж харан элдвийг сүвэгчилж бодлоо

Араатан гөрөөс гэж үү? Жигүүртэн шувуу гэж үү?
Аль ч учрыг олохгүй ширтэн ширтэн зогсвол
Дориун гэгчийн хурдтай нэгхэн завь өнгөрлөө
Долоон бурхан шиг гэгээтэй тунсаг бүсгүйг үзлээ

Давирхай адил хар, хоёр боол гарлаа
Далаа давсан гэээгтэй бүсгүйг өргөж явлаа
Тэр гэгээн дагинатай тэнцэх юм дутлаа
Тэнгэр хүртэл гийж нар хүртэл бүдгэрлээ

Дайтах баяр оргилж дагжин би чичрэв.
Дайсныг нэгээр ч үлдээлгүй тулна гэж шийдэв
Цас хэзээ ч даршгүй сарнайн боол болохсон
Цахилах хөлгийн чимээг сонсогч амь гардаггүйсэн.

Хулс модыг шажигнатал хөлөг морь хазлан
Хурдлан эгшинээ хүрэхэд тэд хэдийнээ арилжээ.
Наран туссан долгионд мөр нь дөнгөж мяралзан
Найдвар хоромхон баларч би гэдэг өнгөрчээ

Энэ үгийг сонсон миний амь тэмцэн
Эр мориноос үсэрч биеэ дэлдэн тарчлав
Хайрт амрагаа үзэлгүй алдаж орхисон хойно
Халуун амиа үрэх нь дээр гэж шийдэв

Баатар хаан Придон энэ бүхнийг харж
Баахан их гайхавч эр нөхрөө харамсаж
Хэлхээ нь алдарсан сувд шиг ариун нулимс урсгаж
Хэзээ ч үнэнч байх нөхөр гэдгээ тангараглав.

Бүтэлгүй ч хэрэг болжээ, би өөрөө зовном» гэж
Бүр шаналсан Придон эмгэнэнхэн өчихөд
Зовох хэрэггүй анд минь, тэр чинь миний амраг
Зорьсон бүх хэргээ дүү чамдаа тоочъё гэв.

Амссан зовлонгоо өгүүлбэл, баатар хариу өчрүүн:
Агуу гүрний хаантыг ингэнэ гэж зүүдлэх ч үгүй
Энгүй өнөр улсын эзэн байх хувьтай
Эрсэлж зорьсон бүхэн чинь бүтэж байх ёстой.

Зулзаган модыг тэнгэр ургуулья гэж соёрхвол.
Зузаан хүдэр болтол нь эхнээс давтдаг юм
Тэнгэрийн өршөөл гэдэг тэртээ холд туяарнам
Тэвчиж зовлон давахад жаргалыг бид эдэлнэм

Уйлж баахан хайлаад эргэж хоёул буцав
Улмаар гуниг зузаарч би Придонд хэлэв
«Чамгүй бол би ганцаардана, ийм хүнийг тэнгэр
Чамламаар цөөнийг хайрлажээ хоёул учирдаг-нь аз

Үнэхээр чи хүсвэл үүрдийн нөхөр больё.
Үеийн дотно наддаа үгээ хайрлаж тусал
Амрагтайгаа уулзаж жаргалаа хэрхэн олно бэ?
Аварч түүнээ авахгүй бол эцэс болсон дээр

Энэтхэгийн эзэнтэй анд болохоос илүү
Эрхэм дээд заяа тэнгэрээс би горьдохгүй
Өндөр дээдсийг хүндлэхээс өөр өршөөл хэрэггүй
Өмөг тандаа боол шиг зүтгэхээс дээр гавьяагүй

Алс холын орноос зам бүхэн нээлттэй
Аль ч газраас гэсэн мэдээ сэлт хүртээлтэй
Элэг зүрхийг эмтэлсэн амрагийн сургийг гаргана
Эзэн тэнгэр ивгээж хэлснээ би гүйцээнэ

Даян дэлхийг тойрсон хашир тэнгисчид илгээж
Далай жаргалын түлхүүр гуа бүсгүйг олно
Хүний зовлон гэдэг мөнх биш байдаг хойно
Хүлцэж та тэвчиж сайн цагийг үзнэ

Эгшин төдийд Придон тэнгисчид дуудан хэлрүүн:
Энд тэндгүй аялж, гуа бүсгүйг ологтун!
Анхны бэрхээс шантарч бүү та нар буцагтун
Амдах мянган бэрхийг амь хайргүй давагтун

Газар сайгүй тэнэж сураг ажиг сонсогтун гээд
Гарам замтай зүг бүрд хүмүүс тэр илгээв
Тэнгисч олныг хүлээж гунигаа мартаж байсандаа
Тэсэж чадахгүй би одоо хүртэл ичдэг юм

Хаан Придон дэргэдээ над ширээ засаад
Хавигүй эрт ширээ тавих ёстой байсан юм.
Намайг та өршөө, таны төлөө зүтгэхгүй
Нарт энэ ертөнцөд амьд хүн байхгүй гэв.

Зах хязгаар хүрч бэрх бүхнийг туулж
Замд одсон тэнгисч цөм буцаж ирсэн ч
Олж авчрах байтугай сураг чимээ дуулсангүй.
Онхийн дэмий тэнэжээ. асгарах нулимс татарсангүй

Би Придонд хэлрүүн: Зовлонгийн дөнгө янзаараа
Биечилж хэлэх үг эс олдох хэвээрээ
Эрхэм чамаас салахад шөнө байтугай өдөр бүрхэг
Энэ хорвоогийн зовлонд шаналсан зүрх гаслан

Амрагийн сураг дуулалгүй энд суугаад яахав
Анд нь одоо хөдөлбө, хээр хөдөө шаналъя»
Энэ үгийг сонсож Придон цусаар уйлж
Эдүгээ жаргалаас хаганав» гэж тэр ихэд эмгэнэв

Хагацах гэдэг хэцүү ч өөрийнхөөрөө зүтгэсээр
Хамаг цэрэг сөгдөж намайг тойрон уйлсаар
Хаан бид хоёр хайлан хайлан тэврэлдсээр
Хаа ч хэзээ ч боол чинь гэж дайчин олон өчсөөр

Тэдэнд би өчрүүн: Та нараас хагацах амаргүй
Тэгэвч амрагаа ололгүй энд байх нэмэргүй
Хэн ч нандин амрагаа дайсны гарт орхихгүй
Хэрхэвч гуйгаад тусгүй, зорьсноо би няцахгүй

Эзэн баатар Придон эмээлт хөлгөө авчирч
Эрхэм гэгээн танд энэ хөлгөө барья
Үнэнч баатар танд өөр зүйл ашиггүй
Үнэхээр эрэмгий хөлгөө би магтах хэрэггүй гэв

Эцэг, хувуун хагацах мэт энэлэл хайлал болж
Эр цэрэг дуугүй, толгой гудайн гуньж
Хаан Придон бид тэврэлдэн үнсэлцэж
Халгиа гарах нулимс нуур адил мэлтийв

Зааж өгсөн замаар нь амрагаа эрж олоогүй
Задгай талд, усанд алхам ч газар орхиогүй.
Хэдий их тэнэвч бараа сураг гаргаагүй
Хэнтэй ч учралгүй би араатан болоход хэтрэмгүй

Ашиггүй тэнээд яахав, аглаг хөдөө газар
Араатан жигүүртэн дунд ясаа тавья гэж бодоод
«Хаа сайгүй би та нарт гай тарилаа
Харьж гэртээ олоцгоо, би ингэж шийдлээ»

Миний төлөө мэлмэрч намайг дагахаа боль» гэж
Мэндийн төдий үлдсэн хэдэн хүндээ хэллээ.
Тэд даруй хэлрүүн: Ийм яриа хэрэггүй,
Тэнэж хаашаа явсан ч өөр эзэн байхгүй

Таны хөлгийн мөр бидний замыг заана
Танхил сайхан дүр чинь биднийг үүрд гийгүүллэ
Тэргүүн баатрыг ч дайрдаг хар гай учиртал
Тэвчиж бид танаас хэрхэвч салахгүй» гэлээ



Хайлан уйлсан боолоосоо би хагацаж чадсангүй
Хаа хол хамаагүй дагахаас тэд буцсангүй
Янгир бугын сүрэгтэй агуйгаар би гэр хийж
Яршиг болтол тэнэхдээ уул, талыг давтлаа би

Хүн төрөлхтнийг үзэлгүй мангасан сүрэгтэй учирч
Хүч мэдэн тулж тэднийг хэдий хөнөөвч
Эдлэх зовлон гэдэг улам улам зузаарч
Эрэмгий хоёрхон боолоо тэхэд би алдлаа.

Тэнгэрт тултал хашгирч дэлхийг хүртэл донсолгосон
Тэр сүртэй амьтадтай гон бие тулахад
Ойн мод булгарч орчин байгаль доргиж
Оройн гэгээн нар ойлох тоосонд бүдгэрлээ.

Зуун мангас хөнөөж энэ агуйг эзлээд
Зуурдын үхлээ хүлээж энд би хоргодсон юм.
Үхэх цагийг жаргал гэж амрагаа бодон гуньсаар
Үйлийн лайтай Асмат зовлон хувааж суусаар

Амрагтай минь төстэй гэж охин барсын арьсаар
Ариун энэ биеэ ороох дуртай байдаг юм.
Уйлан гунилаа ч гэсэн Асмат надаа оёдог юм
Уйтгарт энэ амьдралаас ангижирч би чаддаггүй юм.

Амраг гэгээн түүний минь магтаж хэн ч баршгүй
Алдсан хохирлоо бодохоос хорвоогийн зовлонд цадашгүй
Дэлгэр хөндий дагаж араатны сүрэгтэй нийлээд би
Дээд их тэнгэрээс үхлээс өөрийг гуйдаггүй би

Ийн өчөөд баатар тансаг сайхан биеэ
Ижилгүй тамлан тарчлааж улаан цусаа урсгав.
Автандил баатар бас зүрх шимшрэн мэлмэрэв.
Асмат бүсгүй сөгдөж мөргөл уншин залбирав.

Асмат бүсгүй энхрийлж арайхийн Тариэл сэргээд
Автандил баатарт хэлрүүн: «Миний жаргал ирлээ
Хар тамд унасан хамаг бүхнээ ярилаа
Харьж амрагаа ол. Би зовлонгоо эдэлье»

Автандил хариу өчрүүн: «Чамаас хагацах гунигтай
Аяндаа холдоно гэхээс нулимс урсаад зүдүүртэй
Эр хүний хувьд үнэнийг хэлэх нь зүйтэй
Эндээ чи үхвэл амраг чинь ямагт зовуурьтай.

Дэлхий даянаа алдартай оточ чилээрхэв гэхэд
Дэмий тэр суудаггүй, өөр нэгийг урьдаг.
Тэр оточ нь ирж учир начрыг ярьж
Тэнхрүүлж анагаах талаар чадах бүхнээр тусалдаг

Чиний үгийг сонслоо, над хэлэх үг байна
Чин сэтгэлийн үгийг минь зуу дахин тунгаа
Уян зүрхний аяар яарах хүн хождоггүй.
Ухаант хонгортоо очих миний болзоо туллаа

Эрхэм түүнтэйгээ уулзаж элэг зүрхий нь хангаад
Энэ бүхнээ тоочиж эрхэм чамтай золгоно.
Хэн хэндээ нөхөр гэж тэнгэрийн нэрээр тангараглая
Хэзээ ч чухам үнэнч гэж үг үгээ өргөө.

Эндээс явахгүй гэдгээ чи над батал
Эргэж ирнэ гэдгээ чамдаа би баталъя.
Алсын замаас айхгүй хоёул тэгээд тэнээ
Амрагий чинь олж алаг зүрхий чинь амраая

Хариу тэр өчрүүн: Харийн чамайг хайрламуу
Хагацна гэж бодохоос над маш хэцүү
Ариун сарнай цэцгээс алтан гургалдай салдаггүй
Агуу тэнгэр тэтгэж чамтай заавал учирна

Найз анд чи минь надаа ийн хандвал
Наалинхай миний зүрх зээр адил зугтахгүй
Эрхэм чиний ирэх нь эрдэнэ шиг намайг гийгүүлж
Эрхбиш би хувирвал аянга ниргэх нь зайлшгүй

Тангараг үгээ андууд чин зүрхээрээ давтан
Тансаг царай нь зэвийн оюун ухаан нь бүдгэрч
Үнэн сэтгэлээс хайрлаж салж хагацаж чадашгүй
Үлдсэн ганц шөнө хамт байвч ханашгүй


Хоёул цурхиран уухилж нулимсан гол урснам
Хосгүй хоёр баатар үүрээр салахдаа үнсэлднэм
Хагацах тэрхэн агшинд Тариэл гунихарсныг хэмжишгүй
Харанхуй ойгоор одоходоо Автандил ганихарсныг хэлшгүй


Автандил баатрыг одоход Асмаг бүсгүй үдэж
Амар сайныг ерөөн алга хавсран мөргөж
Эргэж заавал ирэхийг ядарсан тэрээр гуйхад
«Эгчийнхээ үгийг дагана» гээд Автандил ийн хэлрүүн:

«Гал голомт ч саатуулахгүй, би заавал ирнэ
Гадагшаа миний нөхөр гарахгүй байвал зохино
Хосгүй амрагтаа яарах миний зовлонг мэднэ.
Хоёр сараас хэтэрвэл зэмлэхэд үл гомдоно»



МОНГОЛЫН
УЛСЫН АМГИЙН
СЭНДЭГЭЙН ГЭМЭЭГЭЙН
МОНГОЛЫН





XXIX

АВТАНДИЛ АРАБ ОРОНДОО ЭГЭЖ ИРСЭН НЬ

Эргэж гэртээ буцавч цээжий нь зовлон дарж
 Эрхэм царай нь цонхийж цэцэг адил гутнам
 Цусан мөн хөөсөн хомхой араатан адил
 Цулгүй холын замд баатар эрээр шавднам

Эр цэргээ орхисон хотод хүрэлцэн буувал
 Эгэл дайчин олон баяр хөөр болном
 Алсаас Шермадин баатар морины гүйхээр ирээд
 «Амаргүй гунигт унагасан жанжин ирлээ» гэнэм

Учран уулзан гэврэлдэж амар сайнаа мэдэлцэн
 Уярах баярын нулимс уулын хярыг давнам
 «Эгшин төдий зүүд үү? Эсвэл жанжин ирээ юү?
 Эрхэм жанжны аварсан дээд тэнгэрийг биширнэм.

Ингэж хэлээд Шермадин Автандилыг үнснэм
 Илүү ч үг хэлсэнгүй, түшмэл цөм золгоном
 Ард, цэрэг баярлаж их бүрээгээ дуутарган
 Аандаа цөм баясан хөл хөгжөөн өрнөнөм

Эцгийн гал голомтод ийнхүү баатар эгэж
Эрдэнэт ордны тэнд даяар цөм цуглав
Сүр жавхаа гэдгий нь хэн ч бахдаж баршгүй
Сүлдэт их жанжин найр наадам хийв.

Найман зовхисын орноор үзсэн, харсан бүхнээ
Найртай гагцхүү ижилсэм Тариэл баатартай учирснаа
Огнолж Шермадинд яриад, түүнтэй эс учирвал
«Ордон, овоохой хоёр надаа ер адил» гэв

«Харь оронд явсны чинь хаанаас таг нуусан гэж
Харну болгон Шермадин Автандил баатарт хэлэв.
Өдөржин жанжин наргиж өв тэгш тавтай амарч
Өглөөн гэгээ тусмагч нийслэл хотыг зорив.

Арван хоногийн газрыг гурван хоногоор товчилж
Амрах гэдгийг мэдэлгүй тэд нийслэлд очив.
Хаанд мэдээ барихаар Шермадин түрүүлж одов
Хайрт амрагтаа золгохоор арслан баатар яарав

Хаандаа баатар өчрүүн: Эзэн хаан таны
Хаа хүртэл цуурнатах алдар тань бадраг
Таны зүрхийг шаналгасан баатрын нууцыг олоод
Тавтай сайхан мэдээтэй би хүрэлцэн ирлээ»

Эрхт гүрний түшиг догшин эзэн Ростан
Энэх мэдээг дуулахаар Шермадиныг дуудаад
Тэр баатрын тухай Автандил өчнө гэхэд
Тэнгэрийн тааллын ёсоор би сонсье» гэжээ.

Үдшийн харанхуйг хөөгч Тинатинд Шермадин очиж
Үнэн сонихон мэдээтэй Автандил ирнэм гэжээ
Үзэмж гуа гүнж гэгээ туяа цацруулан
Үлэмж их шан Шермадинд хайрлан хүртээжээ

Эгнэшгүй их гавьяанд нь Автандилыг биширч
Эзэн хаан Ростан ихэс цөм угтжээ.
Хэт баярт автсан түшмэл олон данхалзана
Хэзээний балгасан юм шиг зарим нэг нь ганхалзана.

Хөлөг мориноос бууж эзний мэндийг эрвэл
Эгшин хаан Ростан Автандилыг үнсжээ.
Хөгжим баяр төгс ордон тийшээ морилж
Хөвчин олон цөм дээдийн ихээр цэнгэжээ

Тансаг гэрлий нь үзвэл ордон шилтгээн дотор биш,
Тайван хөх тэнгэрт мандаж байвал таарах
Нарнаас онцгой амрагтаа зоригтноос онцгой зоригтон
Найрсаг гэгчээр мэхийн амар мэндий нь эрэв.



Найр наадам дэлгэрч өдөржин даяар цэнгэв
Насан хутагт баатраа хаан энэрэн ширтэв
Цасан цагаан цэцэг шиг эзэн хаан тунсагхан
Цаад залуу баатар нь сарнай цэцэг шиг тансагхан

Эрдэнэ их бэлгийг эзэн хаан тараав
Эйгүй найр цэглэж эрхэм зочид тарав
Хаантан түшмэл баатраа өөрийн дэргэд үлдээж
Хамаг амссан зовлон, уулзаж учирсныг асуув

Эр нөхрөө дурсахад санаа алдах нь зүйтэй
Эгэл хүнтэй жиших арга байхгүй нь лавтай
Эрдэнэт нарнаас илүү тунгалаг гэвэл дүнтэй.
Эрхэмсэг ийм сарнай гутаж байгаа нь лайтай.

Хорвоогийн гай гэдэг ийм өршөөлгүй байдаг бол
Хонгор сарнай хатаж хогийн өргөс бүрхэхсэн
Ингэж хэлээд Автандил тэр баатрын зовлонг
Илүү дутуугүй цөмийг ихэс дээдэст ярив

Хорт мангасыг дарж агуйгаар гэр хийжээ
Хонгор бүсгүйн нь шивэгчин түүнтэй хамт суужээ
Барсын арьс хэдэрч, мяндас торго цээрлэжээ
Байнга уруудан доройтож ертөнцийн жаргалыг огоорчээ

Гунигт баатрын тухай яриагаа Автандил дуусгав
Гунхсан ариун амрагтайгаа учрыг тэр яарав
Эрхэм гавьяа бүтээв гэж цөм түүнийг магтав
Энэнээс дээд нь үгүй гэж дор дороо шагшив.

Дээрх мэдээг сонсохдоо тэсгэлгүй Тинатин баясч
Дэлгэр их найранд чиглэхийг мэдэхгүй суужээ
Автандил гэртээ ирвэл боол хэдүйн хүлээж
Амраг Тинатин дуудсан аятай мэдээ дуулгажээ.

Хилэн буцалдаг зүрх баяр хөөрөөр бялхаж
Хийморь цог нь бадарсан арслан зоригт баатар
Хөлгийн жолоо сунгаж амраг түүндээ очиход
Хөвчин хоёр зүрхэнд хайрын цэцэг соёолном

Аршаан хураар тэжээсэн агар зандан адил
Алтан туяа харавсан наран дагина заларнам
Ариун болор эрдэнэ шиг анхил гуа гүнжийг
Алдарт Грекийн мэргэд магтаж байвал зохином

Хайрт баатраа гүнж өмнө талдаа суулгав
Харилцан хоёул тавтай жаргалын дээдийг эдлэв
Цэнгэг булгийн урсгал шиг цээжний үгээ дэлгэв
Цэх зорьсноо гүйцээж бэрхийг давсанд хөхүүлэв.

Автандил хариу өчрүүн: Зорьсноо хийсэн хүн
Амссан зовлон бүхнээ тоочоод байх нь гайгүй
Дэвтээх нулимс урсгаж сарнай адил баатар
Тэртээ буйд газар гутаж байгаа нь тоогүй

Зандан адил гуалиг, болор адил тунгалаг
Залуу ганц баатартай би учирч билээ.
Эр биед хань эрэмгий сайн баатар гээд
Эмгэнэж сонссон бүхнээ амраг түүндээ өчив.

Зоргоор энэ хорвоо, хүн амьтнаас уйдаж
Зол заяаны хүндэд золбин адил тэнэсэн
Зоригт тэр баатартай тэнгэрийн ивгээлээр золгож
Зовлонг бүх намтры нь дуулснаас тэр ярив

Ганцын төдий учирвал хорвоог бүхэлд нь мартмаар
Ганган өнгөнд нь гялбаж нүдний хараа муудмаар
Уран сарнай цэцэг ч улбайж дэргэд нь гутмаар
Ухаант тэр баатрыг дээдэлж би барахгүй.

Толгойн халхгүй баатар араатан барсын адил
Том хадан агуйд амь зууж байгааг
Амраг бүсгүйн нь шивэгчин зовлон зүдүүрээ хувааж
Арслан баатраа дагасныг, энэ хорвоо энэрэлгүйг

Баатар эр гайхахад үлгэр шиг энэ ярианд
Баясан ханасан бүсгүй гэгээ гэрлээ цацруулж
Тэр нэгэн баатарт хэрхэн туслах билээ
Тэгээд ер нь би чинь яах билээ? гэв

Автандил хариу өчрүүн «Үгэндээ эс хүрвэл
Адгийн бузар нь тэр. Би ам өгсөн
Болзсон цагтаа очиж туслахаар би тогтсон
Бодлогот энэ үгээ нар барьж тангарагласан

Эр нөхөр гэдэг бол нөхөртөө туслах хувьтай
Элдэв бэрхээс шантралгүй зүрхээ өгөх хуультай
Сэтгэлийн зовлонг нэгнээ нөгөө нь энэрэх ёстой
Сэвтэшгүй дотно нөхрөөс хагацвал зовох учиртай



Амраг бүсгүй хэлрүүн: «Зорьсноо чи бүтээж
Амар мэнд ирээд жаргал бид хүртнэм
Энэлж байсан зүрх ариун рашаан уусан мэт
Эдэлсэн зовлон арилж хайрын сэтгэл дэвжнэм

Хаврын тэнгэр адил хорвоо гэдэг хуурамч
Хайруу нар шаравч аянга гэнэт ниргэдэг
Хатаж шаналсан зүрх одоо л нэг онгойлоо.
Хамаг жаргал ирж эдлэх цаг боллоо

Эрийн сайн чанар итгэл тэсэлж болохгүй
Эцсээ хүртэл нөхөртөө үнэнчээр зүтгэх нь гарцаагүй
Тэр баатарт тусал. Гэвч зовлон хэцүүеэ
Тэвчиж би холдоход нар хүртэл бүдгэрнэм

Автандил баатар өчрүүн: Амсаж байсан зовлон дээр
Аяа, амраг чи өөр нэг зовлон нэмлээ
Хатуу мөсийг үлээж ус болгож болдоггүй
Харимал хуурамч сэтгэлийг нарны гэрэл ээдэггүй

Чамдаа хоргодох хэцүү, холдох бүр ч зовууртай
Чанагш учрах зовлонг таахад ер бэрхтэй
Хорголжин суманд өртөж амь бусниж мэднэ
Хорвоогийн зовлонг давшгүй амьдрах нас богиносоно

Сааргүй үгий чинь сонсож цөмийг би ухлаа
Сарнай хэдий өргөстэй ч гараар түүх албагүй
Аян замыг чи наран гэрлээр гийгүүлж
Аж төрөх найдвар шингэсэн бэлэг надаа хайрла.

Намуун дөлгөөн баатар үнэхээр ийн гуйж
Нарны халуун элч шиг найртай яриа дэлгэж
Ирэх жаргалын тэмдэг гэж бүсгүй бугуйвч бэлэглэв.
Ихэс тэнгэр тэтгэж сайны өлзий бүрдэг.

Ариун болор, молор шүтэлцэн гялалзвал
Агар, арц хоёр шүргэлцэн ургавал
Хамарч жаргасан амрагууд харах тусмаа баярлана
Хагацан холдсон зовлонтууд «Ай хөөрхий» гэлцэнэ

Ижил хоёр амраг цэнгэлийн дээдээр цэнгэж
Идэт баатар эр уяран уяран зөөлөрч
Салж холдохын үед нулимсан гол урсгаж
«Сайхь энэ хорвоо миний цусанд ханашгүй» гэв.

Хэрэн тэнэж хагацахад нулимс гуниг л нөхөр
Хэнхдэг цээжээ балбаж баатар эр гунинам.
Нарыг үүл дайрвал ертөнц дахин бүүдийнэм
Найрамт амрагаас холдоход зүрхийг зовлон дарнам.

Урсан гарах нулимс цусны өнгөөр туяарч
Урган мандах нар ч надаа хэрхэвч жаргал биш
Тас хар сормуус хатан зүрх зүснэм
Танхил түүнээс салбал сэтгэл үүрд зовном

Өчигдөрхөн би тансагхан цэцэг байж билээ
Өнөөдөр харин намайг ирт мэсэнд даатгажээ.
Угаас энэ хорвоо хуурамч гэхийг бодохоос
Уур хилэн бадарч догшин зүрх догдолном

Хамаг бие чичирч гунигт үг цувуулж
Хар зовлонд шумбаж баатар эр шаналнам
Зүйтэй амрагаас хагацах ийм байдаг ажгуу
Зүүд зэрэглээ адил хорвоогийн жам буюу

Орон гэртээ ирэвч сэтгэл эс тайтгаран
Ордны багана доргитол гаслан тэр уйлнам
Үзэмж гуа амрагаа сэтгэлдээ ямагт бодон
Үймэрч зовсон тэр хяруу адил цайнам

Хүний зүрх гэдэг учир нь олдохгүй ээдрээтэй
Хүй зовлон ч амсана, цэнгэл ч бас эдэлнэ
Гэгээн гэрэлд ч итгэхгүй сохор юм шиг зүтгэнэ
Гэсгээх үхэл буюу дайснаас ч үл эмээнэ

Сэтгэлийн элдэв үгэнд зүрх нь баахан гайтгарч
Сэвтэшгүй амрагийн хайрласан бугуйвчийг сугалж аваад
Уруул тушаа хүргэж шүдэнд шүргэн гялалзана
Урсах нулимсаар угааж хацар дээрээ наана

Үүр гэгээрэхийн хирд ордноос элч ирж
Үнэхээр нойрсоогүй хэдий ч эс алжаасан баатар
Урьсан ёсоор очиход хүмүүс түүнийг биширнэм
Угаасаа цөмийг бэлдээд хаан авд зорином

Бүрээ, бөмбөрийн дуу чихний хэнгэрэг хагалмаар
Бүгд олон, хаантан цөм авд гарсан нь сүрдмээр
Анч нохой дүүлж, шонхор шувуу дэлж
Авд өртсөн амьтны цус талаар халив



Уужим талыг туулж цөм аваас эгэхэд
Удамт түшмэл язгууртан сүр сүлдтэй явнам
Янзтай чамин ордонд найр наргиан дэлгэж
Ятгын ая эгшиглэж дуучдын хоолой цангинанам

Эр цэрэг захаар нь эрхэмсэг түшмэд голоор нь
Эзэн хаан төвд нь эрэмгий баатар дэргэд нь
Автандил баатраас хаантан Тариэлийг гагцхүү асуунам.
Алдарт тэр баатрыг ам хуурайгүй хөөрнөм

Амрагийн тухай бодсоор Автандил гэртээ ирэхдээ
Амдах замд нь тохиолдсон талыг нулимсаар усалжээ.
Тэвчээр тэвчээр гэвч зүрхийг ямар дийлэх биш
Тэр хөөрхий баатар босон суун гиүүрчээ.

Автандил хажуулж бодруун: Хөвчийн мод шиг гуалиг
Амраг түүнээс салж зүрхээ хэрхэн анагаана вэ?
Учирч яривал жаргалан, уулзахгүй бол зовлон
Уран хайрын цэцэг минь зүүдэнд ч атугай үзэгдээч.

Ухаант мэргэний сурвалж тэвчээр гэдэг буюу
Учирсан зовлон бэрх, тэвчихээс өөр яанам?
Дээд тэнгэрээс өршөөл бид горьдвол
Дэргэд тохиолдох гайг зоригтой давах биш үү?

Чин зүрх чи үхлийг хүсээд байвал
Чигч шулуун байж зовлон бүхнийг тэвч
Тамын галд унасан ч хайрын сэтгэлд шаналснаа
Тайлшгүй оньсого мэт нуу, таалгаж бүү задал





XXX

АВТАНДИЛ АЯЛААР ОДОХЫГ ХҮСЭЖ ЭЗЭН ХААНААС СОЁРХОЛ ГУЙХЫГ ТҮШМЭЛЭЭС ХҮССЭН НЬ

Эртлэн баатар хөлөг морио унаад
Эзэн хааны түшмэлд бараа болохоор одохдоо
«Нандин нууц бүхнийг зүрх минь хадгалдаг болоосой
Найдварт ганц тэвчээр одоо туслаасай гэжээ

Угтаж өчрүүн түшмэл: «Гэрий минь гэгээ гийгүүлж
Урьдаас би таны морилон ирэхийг зөгнөжээ
Эрхэмсэг зочин ирэхэд эзэн өөрөө баярланам» гээд
Эрэлхэг баатрын өмнө толгой дохин хүндэлжээ

Алдарт баатрыг түшмэл өгөөмөр гэгч зочлон
Асар тансаг хивс өвч бүрэн дэвсжээ
Намуун сарнай анхилнам гэж хүн цөм мишээжээ
Нарны гэгээ тусах мэт баатар ордныг гийгүүлжээ

Тунгалаг хоёр нүдий нь цөм зэрэг гөлөрч
Тунсаг гуагий нь биширч нийт даяар мансуурчээ
Гайхан магтан шагшилдахад түшмэл тэднийг явуулаад
Гав ганцаар баатартай ярилцах хэмээн үлджээ

Гаднын хүмүүсийг гарахад баатар ийн өгүүллүүн:
Ганц л таны тээллээр ордны хэрэг шийднэм
Эзэн хэдий мэддэг ч таны дэм хүчтэй
Эрхбиш над тусалж миний зовлонг анагаа



Залуу баатрын зовлон мөн л миний зовлон
Зайлшгүй учралдах ёстой, миний зүрх өвднөм
Хэмжээгүй үнэнч түүндээ миний туслах тавилан
Хэзээ ч биесээ хайрлах бид хоёрын тангараг

Өөрийн андтай учрах сэтгэл нэгэнт догдолж
Өр зүрх ганихарч хөндий хоосон боллоо,
Өөр зүйлийг би өнөө бодохоо болилоо,
Өнө холын замд одоо мордох туллаа.

Эргэж би ирэхдээ хөнөөлт дайсныг сүрдүүлж
Эгэлгүй гунигт унагасан дэнлүүгий чинь олно» гэж
Тангараг үгээ өргөж болзоо юугаа тогтсон
Тамын гал төөнөх мэт хугацаа ойртож зовном

Үнэн бүгдийг хэлэхэд тэр намайг хүлээвч
Үйлийн эрхээр бас хүчин барагдвал яанам
Журамт нөхрийн ёсыг зөрчих гэдэг балай
Жудаггүй тийм явдалтан амьд байх нь булай.

Хамгийг та мэднэ чин зүрхнээс гуйя
Хаанд та өчих зүрхний шарх анагаа
Таалж соёрхвол одно, татгалзвал гутна
Та л нэг болгоож, дор хэлснийг дамжуул

Өндөр их хаантны өлмий дор сөгднөм
Өвч бие дагжиж зүрх эмээн чичирнэм
Мөхөх аюулд шаналагч журамт нөхрөө бодохоос
Мөн зүрх сэтгэлээ барих чадал барагднам

Эзэн дээд хаан минь, тэр гаслант баатарт
Энэ бие, сэтгэлээ тушаачихаад би ирсэн юм
Түүнд би тусалбал таны алдар манднам
Түших тангаргаа няцах эрх над дутнам

Намайг одлоо гэхэд танд зовох юм алга.
Наран дээд тэнгэр намайг яахаа мэдэг
Үнэхээр би дийлбэл баяртай буцаж ирнэм
Үхэж хоргодлоо гэхэд таны бие байнам» гэв

Бодож байгаа зүйлээ товч төдий хэллээ
Болгоож бүтээж өгөхийг түмэнтээ би гуйя
Харамж шанд алтан зоос бумыг танд барья гэж
Хааны шадар түшмэлд Автандил баатар өчлөө

Хариу түшмэл өчрүүн: Харамж шан хэрэггүй
Хаандаа үүнийг өчвөл шан хүртэх нь дамжиггүй
Чиний энэ санааг хаан мэдэх төдийдөө
Чин үнэнийг хэлэхэд дээд шагнал өгнө

Ийм хэрэг сэдвэл толгойноосоо сална би
Ихийн их жаргал хүртэх маань тэр дээ
Амьд явахаас илүү жаргал гэж байх уу?
Алж хөнөөв гэсэн ч хэлж би чадашгүй

Ашиггүй юм хөөцөлдөж амиа алдахаа больё
Аяндаа ийм балай үг сонсоод эс ухав уу?
Дэмий юм чалчив» гээд хаан дороо хөнөөнө
Дэлхийн шороо хөдөлгөж бөндгөртэйгээ явъя би

Хаан явууллаа гэхэд цэрэг эрсийг яах вэ?
Хаашаа ч юм явуулчихаад жанжингүй тэд хэрхэх вэ?
Адгийн муу бялзуухай ч шонхор шиг нисэх санаатай
Ар хойгуур чинь дайсан хонго ухах санаатай

Автандил хариу өчрүүн: Эрхэм дээд түшмэл минь
Анд журмын ёсыг та мэддэггүй бололтой
Таарсан үнэнч нөхөд, тангараглаж өргөсөн үгийг
Та хэрэв мэдлэг бол намайг одоо ойлголтой

Зовж гуньж явснаас амь насаа хөнөөмөөр
Зоргоор зорчигч наран яагаад эс тогтоно вэ?
Хазаарлаж аваад уячихвал өвөлгүй тэнэгэр биш үү?
Хамаагүй дэмий хөөрснөөс өөрөө бодвол дээр биш үү?

Тэнэг миний зовлонг хаантан ч цэрэг ч мэдэхгүй
Тэвчишгүй ухаан балартавч хэн ч намайг бодохгүй
Өөртөө жаргалтай улс бусдын зовлон ухахгүй
Өргөсөн тангаргаа няцахгүй, хэлсэн үгээ буцахгүй

Харваас та намайг хүйтэн хявцаг үзнэм
Хатан болдоор бүтсэн ч уян болохоо үзүүлэхсэн
Зовлонт баатрын нулимсыг диваажингийн гол ч угаашгүй.
Зорьсон хэрэгт минь туслаач, ачийг би мартахгүй

Үгүй юмаа гэхэд сэмээр би одно
Үйлээ эдэлсэн баатартай зүрх сэтгэлээ хуваана
Эзэн хаанд айлдаж өршөөл нигүүлсэл хайрла
Эрхэмсэг хаантан хилэгнэвч миний төлөө болгоо



Өөдөөс түшмэл өчрүүн: Чиний амссан гамшиг,
Өвч урсгасан нулимс өр зүрх хайлуулав
Аврах үг ч байдаг, алдах үг ч гардаг
Алин ч болсон атугай хаанд би айлтгая»

Ийн өчөөд түшмэл ордноо яаран ороход
Их эзэнтэн баяртай наран адил гялалзнам
Хэрэг бүтэхгүйг зөгнөх мэт түшмэл баахан хулчийж
Хэлэх үгээ ч олохгүй хаан эзнээс сүрднэм

Хаантан гэвч удалгүй гунигтай байхы нь таачихаад
Хар дарсан зовлонгоо юундаа нуунам» гэв.
Зөв эсэхийг мэдэхгүй гуньсан учраа өчье
Зөвлөж хэлснийг сонсоод яах нь таны хэрэг

Дарсан их гуниг нүднээ цөм нлэрч
Дагжин би сүрдэвч зуучлах ам өгсөн хойно
Анд журмын нөхөртэй уулзахгүй бол өнгөрөв» гэж
Автандил баатрын учирласныг эзэн танаа айлдъя

Эмээх хэдий боловч бүхнийг түшмэл тоочоод
Эцэс сүүлд нь мэхийн «цөмийг би хэлэв
Амь насаа ч тоохгүй урсах нулимсанд автсан
Автандилын учир ийм. Намайг яавал яа» гэв

Өндөр эзэн хилэгнэж харц юугаа гялалзуулж
Өөдөөс нь хэн ч ширтэшгүй догшин дүр тодруулж
Элдэв балай явдал сонсохдоо чи дуртай ч
Энэ тэнэг үгий чинь би ер болгоохгүй

Хар гуниг дуулгахдаа баярын мэдээ шиг яарч
Харь өшөөч дайсан ч ингэх ер ёсгүй
Тэнэг мангуу амьтан чи ийн яаж зүрхлэв.
Тэвчишгүй мунхаг чамд түшмэлийн хэргэм ахаднам

Хамаа намаагүй чалчиж хоосон ийнхүү донгосоход
Хаан эзэн хилэгнэхгүй гэж чи лав бодсон байх
Хэнгэрэг нь хагарсан чих л хээгүйгээрээ чагнахсан
Хэт мундаг чиний цусыг аван хөнөөхсөн

Автандилаас өөрд хэрэв чи зуучлаа бол
Амь голтой үлдэнэ гэж хэзээ ч бүү санагтун
Хүний зовлон мэддэг эевэрхүү буянт түшмэл гуай,
Хүйтэн цэвдэг дотор тэнэг амьтан тонил



Эзэн сандлаар шидвэл хага бутран эвдэрч
Эмээж зовсон түшмэл хутга шаах мэт тэвдэв
Оримж баатар одох нь гэж хэрхэн зүрхэлж өчив гэхэд
Онхи л дэмий тонгойж хөгшин түшмэл уйлав.

Хаантай зөрж чадалгүй үнэг шиг сэм одож
Хар гунигт багтарч түшмэл алмайрч алхнам
Зоригтон адил орж зовлонт адил буцнам
Зоргоор ийм гамшгийг дайсан ч үл таринам

Өвгөн түшмэл хэлрүүн: Дээд тэнгэрийн эрхээр
Өнөө хэдий бууралтсан ч хууртаж нүгэл үйлднэм
Эзэнтэй ингэж хэлэлцсэн хэний ч хүү гэсэн
Эртний заншил ёсоор гэсгээл цээрлэл амснам»

Зол заяандаа гомдсон түшмэл эгэж ирээд
Зовлонт Автандил баатрыг зэмлэн ийн өчрүүн:
Гайтай чамаас болж хэргэм цолоо алдаж
Ганц ч удаа эндээгүй нэрээ би хугаллаа

Урсах нулимс татраагүй ч эгшнээ эелдэг болоод
Уран үг марталгүй харамж шан сануулаад
Амласан зүйлээ түшмэлд өгөхөөс өөр аргагүй
Арван тамд ч гэсэн хахуульгүй бол барахгүй

Эзний харааж зүхсэнийг энгийн үгээр хэлшгүй
Энгүй тэнэг, балмад, мунхаг нэр хайрласан
Эрх ямба хэргэмд одоо би тохиршгүй
Эцэг тэнгэрийн өршөөлөөр амь нас хэлтэрсэн

Хаан эзэн хилэгнэсэн нь үнэндээ миний буруу
Хайрт түүнээ уурлуулж өөртөө гай тарив.
Энэ хорвоо хэцүү, хэн ч түүнийг гэтлэхгүй.
Эрхэм чиний төлөө амиа өгөхөөс буцахгүй

Автандил баатар өчрүүн: Би явалгүй горьгүй
Анхил сарнай гутвал алтан гургалдай эрсдэж
Ариун рашаан олохоор тив дэлхийг тойрно.
Аяндаа олохгүй гэхэд сэхэшгүй гунигт автана

Өдөр шөнө ялгаагүй баатрыг мөрөөдөн зовсноос
Өнчин араатан адил хээр тэнэх минь дээр
Дайсан этгээд дайръя гэж хаан намайг урьснаас
Даамай итгэлгүй намайг хаяж орхивол дээр




Эзэн хичнээн хилэгнэвч нүүр учран гуйя.
Энгүй шаналж байгааг эрэгцүүлж тэр болгоог
Энэрч үзэхгүй гэхэд сэм би одно
Эцэслэх цаг болсон бол миний од харваг

Эрхт төрийн түшмэл найр хөл болно
Эрхэм тансаг бэлэг хүн болгонд барьж
Настан, залуу ялгалгүй сэтгэл цөм цадаж
Наран орох үед сая нэг тарав.

Наран баатар тэгэхэд буман алтан зоос
Нарийн мяндсан торго гурван зуун дээлийнх
Нандин тансаг эрдэнэ жаран ширхгийг гаргаж
Найр тавьсан ёсоор төрийн түшмэлд илгээжээ

Халамж энэрэл бүхний чинь ачийн дээдээр хариулж
Харьж удахгүй ирээд үнэнч боол чинь болном
Харж тэтгэсэн тандаа хариу болгон барих
Харамж шангаа чамланам» гэж Автандил баатар өчжээ.

Өгөөмөр дэлгүүн Автандилыг магтах үг дутаж
Өвтэгш бүхний цогцос гэж хэлбэл нэг зохином
Ганихарч зовсон бүхэнтэй эв аяыг хичээж
Өв тэгш бүхний цогцос гэж хэлбэл нэг зохином





XXXI

АЯНД СЭМ МОРДОХЫН ӨМНӨ АВТАНДИЛ,
ШЕРМА ДИН ХОЁР ЯРИЛЦСАН НЬ

Аянд мордохын өмнө Шермандинд Автавдил өчрүүн:
Амар их баяр, асар итгэлийн энэ өдрөө
Ач ихтэй чинийхээ дэм бүхнийг хүртнэм
Агуу дээд хаантан аялахыг эс таалнам

Тэртээ холын баатарт зүрхээ би орхиж
Тэрүүнтэй эс учирвал үхсэн, сэхсэн ялгаагүй
Хаан мэдэхгүй болохоороо намайг ийн хориглоном
Хайрхан тэнгэр намайг эс одвол залхаанам

Буруу санаа сэдэж хуурмаг зан гаргагчаар
Бурхан тэнгэрийн дайсан юм. Би заавал явня
Хар зовлонд автаж ганцаардсан анддаа золгохгүй
Хагацан хол байвал миний зүрх тэсэхгүй

Нөхрийн журам сахих гурван үйлс байдаг
Нөгцөхөө хүртэл хамт, салж үл хагацах
Харам сэтгэл гээж байгаа бүхнээ зориулах
Хаа холоос ч ялгаагүй зохих цагт нь туслах

Далан үг дэлгэснээс цагийг жаахан хэмнэе
Дав даруй мордоход зүрхний тээш унах байна
Хөлгийн дөрөөнд хүрэхээс нааш чамдаа захиа өгье.
Хөвчин хэлэх үгийг чи сайн тогтоо

Эзэн хааныхаа зарлигийг эрхэм дээдээр сахь
Энэрэнгүй уужим санаагаа төгс ихээр хүртээ
Эр цэргээ энхрийлж энэ улсаа өмгөөл
Эдүгээ хүрсний адилаар төв шударга зүтэг

Төрсөн нутгаа өмгөөлж дайсныг хайргүй дар
Төгс итгэлт нөхөдлөө юугаа ч харамгүй зар
Найдвар тэслэгчийг хөнөө. Би амьд ирвөл
Найгүй буянт үйлст чамайгаа дээдлэн энхрийлнэм

Уйлан хайлан Шермадин «Ганцаар үлдэхээс зовохгүй.
Учирсан энэхүү зовлонг даахгүй гэж айнам
Хэрэг болж юун, намайг аваад яв» гэв
Хэзээний уншигч та ийм эрсийг хайрланам

Гон ганцаар хүн аянд хэзээ ч явдаггүй
Гоц жанжнаа, туслагч нь гайд хэрхэвч орхидоггүй
Чиний төлөө зовсоор би тэсэхгүй» гэхэд
Чин үгий минь дага гэж Автандил зандран хэлэв

Үнэнч чиний чанарыг би угаас мэднэм
Үлэмж атаархал хорсол хорвоод намайг хүрээлнэм
Дэмий ярих хэрэггүй чи эндээ үлд
Дэлгэр энэ орноо миний адил хамгаал


Чин нөхрийн ёсоор ганцаар би одно
Чилж тогтохгүй нулимсыг зоргоор би тавина
Алив хэргээ бүтээж түргэн ирэхийг бодно
Аяа бараан хорвоогийн аяыг цөм дагана

Алсыг зорьсон надаа журмыг чи сахиарай
Аюулт дайснаас айж сөгдөхгүйгий минь мэдээрэй.
Эгшин төдийд, зоригтон гунигаа орхин тулдаг юм
Эдэлсэн зовлонгоос салахгүй зууралдах эр мөхдөг юм

Хорвоогийн жаргал гэдгийг хумхийн тоос шиг огоорч
Хонгор андын төлөө баяртай үхэхэд бэлэн
Гэгээн нараи амраг намайгаа одохыг соёрхсон хойно
Гэр зуураа өнөө хоргодоод би яахав.

Хүний зэрэгт чамайг өөрөө би хүргэсэн
Хүндэт хаантан таалаг гэж гэрээс чамд үлдээнэм
Энэ бие минь үрэгдвэл гуньж чи хайрлаарай
Эр биеэ барьж өөрийн замыг хайрлаарай





XXXII

РОСТАН ХААНД АВТАНДИЛ ГЭРЭЭС ҮЛДЭЭСЭН НЬ

Сэтгэлийн гунигаа нээж хаандаа гэрээс бичрүүн:
«Сэм явахаар шийдлээ, өндөр дээд эзэн минь
Анд журмын нөхөртөө золгохгүй бол там юм.
Аргагүй намайгаа өршөөн тэнгэрийн таалал эрээрэй!

Яваа яваандаа та намайг таалах нь дамжиггүй
Яриагүй журамт ухаантан нөхрөө дайсанд өгдөггүй
Хуурмаг нөхөр гэдэг бие сэтгэлээ үрнэ гэж
Хурц ухаант Платон сургасан байдаг шүү дээ.

Хуурамч ёс гэдэг амгалан тайванг алдуулж
Хуримтлах ёроолгүй гамшгийн эх сурвалж болдог
Оюун ухааны хэрэг ойлгож ухахдаа байдаг
Онцгой мэргэдийн сургаалыг олж шингээхийг хэлдэг

Янаг сэтгэлийн учир Аностолын сургаалыг мэдэх биз
Яруу хөгжимд уянгалж, сударт бичдэг биш үү?
Янаг сэтгэл гэдэг хүнийг өргөн дэгжүүлнэ гэдэг
Ямагт энэхүү үнэнийг ухдаг нь та биш үү?

Эр биеийг заяаж бяр хүчийг хайрласан
Энэ хорвоог бүхлээр нь ид шидээр бүтээсэн
Зулайн дээд тэнгэр юм бүхнийг тааруулдаг
Зууг нэг болгож нэгийг зуу болгодог



Дээд тэнгэрийн эрхийг юм бүхэн дагана
Дэлгэр гэрлээ харамлавал сарнай ямагт хатна
Үзэмж гуа гэдэг буянт сайныг дээдэлнэ
Үнэнч андаас хагацаж амар сууж болох уу?

Айлдсан үгийг зөрөв гэж хилэгнэх авч өршөөгөөрэй!
Аяа энэ зовлонг боол би тэвчихгүй нь
Эндээс одно гэдэг гуниг арилгах рашаан юм
Эрх дураараа явбал гай гамшиг хөнгөн юм

Хоосон санаа алдаж нулимс урсгаад нэмэргүй
Хорвоод төрсөн бүхэн тэнгэрийн тааллаас гарахгүй
Гагцхүү чин зоригтон гамшиг бүхэн дагдэг
Гарцаагүй ирэх тавиланг юм бүхэн дагадаг

Ивгээлт тэнгэрийн тааллаар хэрэг бүхэн биелж
Илтэд зорьсноо гүйцээгээд би эргэж ирнэ
Дэлгэр их тусаа журамт Тариэлдаа өргөөд
Дээдийн жаргалд умбасан жавхланг тандаа золгоно.

Ийнхүү миний одоход буруу байх гэж үү?
Илүү саяа гэж үзвэл энэ биеийг цаазал
Элдэв учралаас эмээж журамт нөхрөөс урвахгүй
Энэ насны нүглийг хойчдоо дуудуулахыг хүсэхгүй

Эрхэм журмыг сахих эрдэнийн дээд эрдэнэ
Эргэж урвах гэдгийг адгийн муу гутамшиг
Өөрийгөө хэт үнэлж нөхрөө мартвал хүн биш
Өгөөмөр наран эзэндээ худал хэлбэл ёсон биш

Аюулт тулаанд цэрэг айж орохоос муу нь үгүй
Амь бие нь мөнд ч үхэл хүлээж чигчирдэг
Баширч дорой цэрэг туйлдсан эрээс дээр нь үгүй
Байлдаж олсон алдрыг баян чинээ гүйцдэггүй

Оройгүй оргил ч, ёроолгүй жалга ч үхлийг ер хаахгүй
Онгон баатар, олиггүй амьтан хэнийг ч ер ялгахгүй
Хүүхэд хөгшин хэн ч мөнх бусыг үзүүлнэ
Хүний адаг гэлдэрснээс сайн үхвэл дээр

Эрхэм дээд эзэндээ зүрх гарган хэлэхэд
Эрин цагийн эргэлтэд хумхийн тоос болохоо
Эгшин төдий ч мартвал тэрээр түмэн буруутай
Эрт орой хэдий ч нэг агшинд өртөнө

Хэрэв намайг ирэхгүй бол цагийн урсгалд автаж
Хэнийг ч гэсэн ялгагдаггүй хорвоогийн жамыг гүйцэж
Анд нөхрөөс хол ганцаар өнгөрснийг мэдээд
Ариун зүрхэндээ та намайгаа энхрийлж бодоорой

Эрдэнэ тансгийн санд хураасан зүйл хэмжээгүй
Эгэл доодост өгч боолыг та энэрээрэй
Арчгүй зүдүү хүмүүст баялгийг минь тарааж
Автандил миний төлөө буян та үйлдээрэй

Өндөр дээд эзэнтэн намайг амрааж чаднам
Өгөөмөр их баялгийг хайргүй та зарахдаа
Өнчин ядуус асрах гэр байшин босгоорой
Өргөн голын дээгүүр зам гүүр бариарай

Яриагүй ингэж бүтээвэл ядуусын дуу тэнгэрт хүрч
Яг байгаа хэвээр минь намайг тамаас аварч
Зовлон зүдүүр арилж итгэл найдвар дэгжиж
Зориг хүч нэмж сэтгэл минь тайтгарна

Хар нүгэлд автсан энэ ертөнцөөс зайлж
Харанхуй бузраас холдож жаргалын оронд халихад
Эзэн дээд тэнгэр намайг ивгээн тусалж
Эрхбиш хөөрөх жигүүр надаа хайрлан соёрхном


Тэр цагт танд надаас мэдээ ирэхгүй
Тэгээд би тандаа учраа одоо өчнөм
Сайн үйлс мэдэг муугаар шузтрах ёсон бий
Салхи үхдэл өчих биш уужим сэтгэлээр өршөөгөөрэй

Шилдэг үнэнч дайчин Шермандиныг энхрийлж
Шилшгүй их энэрэлээ та хайрлаж байгаарай.
Гай зовлонд зүдэрсэн эрхэм нөхөр түүнийг
Гаталшгүй их бэрхээс та өршөөж аваарай

Гэрээс үгээ дуусаж гартаа ойртуулж үзэхэд
Гэгээн тантай хагацахаас оюун сэтгэл бүдгэрнэм
Энэ биеийн минь төлөө гуниг бүхнээ даваарай
Эрхэм сүрийн чинь өмнө этгээд дайсан чичирнэм

Азгандил баатар гэрээсээ Шермандинд бариулж өгөөд
Анд минь чи цөмийг хаантанд зүрхлэн очоорой
Энэ миний үгэнд чамаас үнэнч нь үгүй» гэж
Энхрий хоёрын нулимс цусны өнгөөр туяарав.





XXXIII


АВТАНДИЛ МӨРГӨЛ ҮЙЛДСЭН НЬ

Сайн бүхнийг хөхүүлж, муу бүхнийг цээрлүүлж
Саруул ёсыг тэтгэж үнэн амрагийг ивгээгч
Орчлон дахины эзэн оройн дээд тэнгэр минь
Осол гайд учирсан намайгаа өршөөн соёрх!

Ертөнцийн хаан тэнгэр чи амраг сэтгэл үүсгэж
Ердийн биднийг гийгүүлж янагийн ёсыг зохиожээ.
Энэ л хорвоогийн жамаар амрагаас би холдном
Энхрий хайрын цэцгийг чи ивгээн үргүүл

Ганц л бат өмөг, оройн дээд тэнгэр минь
Гадаа хөдөө хаана ч бол намайгаа тэтгэхийг гуйя
Дайрах дайсан, давлах мөрөн, дарах харанхуйг
Давж гараад амьд үлдвэл чамдаа зүтгэе!

Мөргөл үйлдээд дайчин баатар мордов
Мөнөөх Шермадин нулимс урсган ганцаар үдэв.
Ухаант боол эрхэм жанжнаа санан хайлав
Урсах нулимсанд элгэн хад элэн бутрав.



XXXIV

АВТАНДИЛ СЭМ ОДСОНЫГ РОСТАН ХААН МЭДСЭН НЬ

Автандил баатрыг үдэж өөр дуу эхэлнэм
Алдарт Ростан хаан эртлэн босоод хилэгнэнэм
Хэн ч тэр учрахгүй мөнөөх түшмэлийг дууднам
Хэлэх газаргүй сүрдсэн түшмэл уруу царайлнам

Хараа юугаа булзан түшмэл эмээж ороход
Хаан Ростан өгүүлрүүн: «Өчитдөр өчсөний чинь мартав
Чамтай уулзсан цагаас бие нэг л тазгүй
Чанд хатуу үгээр няцааснаа л мэдэх юм

«Уйтгар бол гунигийн эх» гэдэг мэргэн үг бий
Уурлаж хилэгнэсэн учраа чухам үл мэднэм
Ухаан чи зарж намайг бүү хилэгнүүл
Учирлаж мэдүүлсэн бүхнээ дахин чи өч»

Хааны зарлиг ёсоор давтан цөмийг өчихөд
Хамаг бүгдийг сонсоод эзэн ийн хэлрүүн:
Хэрэв би таалсан бол адгийн тэнэг болох байж
Хэрхэвч үрэгдье гээгүй бол чиний хэлэх дуусаа гэ.

Эзний ордноос түшмэл Автандил-д ирвэл
Эрхэм жанжин одоод хүн цөм уйлнам
Өчигдрийнх минь болоо, өнөө ордонд бараалхахгүй,
Өнгөрсөн явдалд гэмшнэм. Өөр зүрхтэн өчиг» гэв



Зарсан түшмэл ирэхгүйд хаантан элч илгээвэл
Заяагүй мэдээг сонсохдоо хаалган тушаа нуугджээ
Зузаан гунигт автаж эзэн хаан сэжиглээд
Зуун эрээс давуутай баатар эр оджээ гэв

Автандилаа дурсан тэргүүн юугаа бөхийн
Арчгүй их шаналж түшмэлийг хаан дуудан
Хуурамч гэсэн тэр бүхнийг тоочиг гэжээ
Хувхай даасан түшмэд амьдын төдий иржээ

Хааны догшин харцаас халтирч тэр булзахад
Халаах наран одож уу» гэж эзэн түүнээс асуув
Энэ биднийг ээхгүйн тул наран дэнлүү явжээ гээд
Эрэлхэг баатар сэмээр аянд мордсоныг өчин

Энэ үгийг сонсохдоо эзэн сүртэйеэ ханширч
Энхрий хүү чи минь биднээ гийгүүлэхээ болив уу?
Тунгалаг туяа чинь арилж хаашаа чи одов гээд
Тунсаг биеэ зовоохоор ордныхон цөм сандарчээ

Хүү минь чамайг зовоход бид бас хуваахсан
Хүний газар тэнэж хэрхэн зовлонд унагана вэ?
Өөрийг чи бодоод намайг ганцаар орхижээ
Өр зүрх өвдөж учиртлаа зовох минь болжээ

Азаас будаж явах чинь бардам болоод бахдам сан
Агуу нутгаа чимж цэвэр бөгөөд цэгцхэн сэн
Уран магтаал адил дуугий чинь сонсохоо өнгөрчээ.
Ухаантай чамгүй болохоор ордон шилтгээн ч зэвийжээ

Бэрх замыг туулавч өлсөж цангахыг мэдэхгүй
Бэлэн сум чинь хурц, зорьсноо ер алдахгүй
Эндэл гамшиг давахад тэнгэр чамайг орхихгүй
Энэ бие минь халивал хэн уйлан энэлэх вэ?

Сайхь олон цуглаж энд тэндгүй гаслан
Сахал санчгаа зулгааж нийт түшмэд зовон
Энэ гашуун чимээг эх байгаль ч давтнам
Эргэж нар одоод харанхуй бүрхэв гэлцнэм.



Ямбат дээдсээ цуглуулж эзэн хаан цурхиран
Ялгуун нарны гэрэл илтэд хомс боллоо
Ямар буруу тарьснаас тэр минь биднээс зугтнам
Яаж хөөрхий зүрх минь элэг зүрхээ амраана? гэв



Удтал тэд цөм уйлан цурхирч ханаад
«Угаасаа ганцаар одож уу?» гэж хаан эцэг асуув.
Айж мэгдсэн Шермадин догшин хаанд ойртоод
Азтандил баатрын гэрээсийг зүрх тэвчин бариад

Зоригт баатрын өргөөнөөс энэ бичгийг олов.
Зовлонт түүнийг одоход боол зарц л байжээ
Залуу хөгшин цөмийг хаяад ганцаар оджээ.
Заяагүй мэдээ хүргэсэн намайг хаантан гэсгээ» гэв

Гэрээс бичгийг уншиж цөмөөр дахин уйлав
Гэгээн хаан өчрүүн: «цэргүүд зэвсгээ орхи
Бэлбэсэн, ядуус доодос цөмийг одоо цуглуул
Бэрх замд нь өршөөхийг тэнгэрээс мөргөн гуйцгаая»





XXXV

ТАРИЭЛТАЙ УЧРАХААР АВТАНДИЛ
ОДСОН НЬ

Наран хэрэв холдвол саран улам гэрэлтэй
Наашилж нар ойртзол сарны гэгээ будантай
Гэвч нар байхгүй бол сарнай хатаж гунигтай
Гэгээн амрагаас холдоход сэтгэл гутаж гунигтай

Алсад зорьсон баатрыг үлгэрийн мөрөөр хөөе
Асгарах нулимсанд нэвтэрсэн зүрхний цохилтыг сонъё
Өглөө наран мандахад амрагаа Автандил үзнэм.
Өвч наран шингэхэд өнчрөлийн нулимсаа урсганам

Үнэн гунигт автаад үг хэлгүй юм шиг
Үйлзэх нулимс урсаад Тигр мөрний ус шиг
Хань бараа хайх мэт ийш тийшээ ширтнэм,
Хаа холын газарт харах замгүй бэдэрнэм.

Хагацах учрал үүсгэсэн хар санаатан зовлон
Хань амрагаа хайрлах шиг зүрх минь чи хурдал.
Гашуун нулимс урсгасан нүд минь тийшээ очиг
Ганцхан миний янагийн сэтгэл тайтгаруулж ширтэг

Сэтгэл гэвч тогтохгүй, амар заяа үзэхгүй.
Сэтгэшгүй ийн зовсноос амь биеэ буснулмаар.
Үгүй тэгж хайртнаа үйл тамд унагахгүй.
Үерийн ус адил нулимсаа барьсан нь дээр!

Тэрээр уйлан өчрүүн: „Олон хурц жад
Тэрс шивээ өргөс мэт миний зүрхэнд шаанам
Харах хоёр нүд минь хязгааргүй уудамд чилэн
Хайрт гуа янагаа би санаж гиюүрнэм.

Аяа гэгээн нар! Дээд тэнгэрийн дүр
Алтан одны цогцос ч чиний эрхэнд билээ.
Алсад намайг ивгээж хувь заяа тэтгэж
Амраг хайрт түүнтэй минь уулзаж учруулж соёрх

Хатан болд дөнгөнд эдүгээ би шаналнам
Хайрт амрагаас холдон тансаг болор хайнам
Хагацаж бүхнээс ганцаар аглаг хөдөө гэлдэрнэм
Хамгийн дээд наран минь намайгаа энэрэн үзээч!»

Хувь заяандаа гутарч зул адил бөхөж
Хурдын дээдийг гаргаж алсыг баатар зорином,
Од түгсэн шөнийг гэгээн амрагтай зүйрлэж
Ониволзох одот тэнгэрт зовлон тоочиж өчнөм.

Сарнаа тэр өчрүүн: „Дээд тэнгэр мэднэ.
Салшгүй амраг сэтгэлтнийг чи зовоож даганам.
Хар гунигт гэвч чи ганцаар рашаан юм.
Хагацашгүй амрагтаа зөлгохыг чи минь ивгээн соёрх»

Өдөр нь зовон шаналж шөнийг удтал хүлээнэм.
Өгөөмөр бяцхан горхины усыг шохоорхон буунам.
Уяран гарах нулимсаа урсгал дунд нь нийлүүлнэм.
Унтаж нойрсох тэлгүй зөвхөн алсыг зорином

«Цэгцхэн гуалиг хэдий ч гунигтай бөгөөд зоригтой.
Цэх өндөрт азирч янгир авлах нь самбаатай
Ангийн маханд цадавч зүрхний гуниг хатгаж
Ариун сарнай алдаж хоосон хоцров» гэлээ.

Эрэмгий баатрын зовсныг энэлж шаналж явсныг
Эрхэм мэргэд ч атугай цөмийг тоочиж баршгүй.
Энэ дэлхийд үлдсэн мөр нь харин баларшгүй.
Эрсэн агуй нь харагдаж баярласныг хэлж чадашгүй.

Асмаг баатрыг харж яаран өөдөөс нь ирэв.
Ариун нулимс урсгаж цээж нь нэг онгойв.
Хөлөг мориноос бууж учран хоёул үмсэлдэв.
Хөвчин хэрэг бүтээлтэй бол уулзах сая сайхан

Анд нөхөр хаана вэ, гуныж зовох хир вэ? гэж
Автандил баатар асуухад Асмаг хайлан өчрүүж:
«Одож чамайг мөрдмөгц хөдөө хээрийг зориод
Одоо хүртэл байдаггүй, сураг чимээ алга» гэв.

Энэ мэдээг сонсоход хутга шаахаас ялгаагүй
Эгч минь та болгоо гээд Автандил баатар хэлрүүн:
Тангараг ёсоор би зорьж ирдээ шүү дээ.
Тавьж өргөсөн үгээ хоромхон няцав гэж үү?

Анд журмын нөхрөөс салгуу байх дэмий юм
Амлаж хэлсэн бүхнээ амар яаж мартаа вэ?
„Тэнгэрийн өмнө өгсөн тангараг хэрхэн няцаа вэ?
Тэгэвч зовлонг түүнийг гайхаад ер яахав

Харну Асмаг хэлрүүн: Урам хугарах чинь зөв
Халтай хуурмаг бус үнэн үгий минь болгоо
Тангараглаж өргөсөн үгийг журамт эр л дагадаг
Тариэл баатар хөөрхий ухаан санаа мансуурчээ.

Зүрх, сэтгэл, ухамсар цөм нэгэн буюу
Зүг чигийг зөвхөн зүрх заах буюу
Энэ хорвоог огоорсон өрөвдөлт тэр нэгнээр
Энэлж амссан зовлонг чи яахин таанам

Хүлээлгүй одсон болохоор урам харих чинь зөв ч
Хүлцэшгүй будилж зовсон баатраа би мэднэм,
Харну журмын ёсыг тэр ер мартахгүй.
Хамаг зовлонгий нь хувааж шаналахаа би болихгүй.

Хатуу ийм сорилт хэзээ ч үл гарнам.
Халамжит хүн байтугай хад ч уярч нурнам
Урссан нулимс хураавал далай хэзээний болжээ.
Улс амьтны зовлонг бид сайн мэджээ

Хэрэв Автандил ирвэл юу гэх вэ? гэж
Хэрж одохын өмнө түүнээс би асуухад:
Гэрэлт энэ орчлонд миний хэрхэн явааг
Гэмгүй тэр мэднэ, тангараг улам батжина.

Өргөж тавьсан таггарагтаа би хэзээд үнэнч
Өвч нулимсаа барж уулзахыг би хүлээе.
Амь алдсан байвал уйлан хайлан гуниг
Азаар мэнд учирвал баяр хөөр болог» гэжээ.

Одож баатраа явснаас хойш нарыг эс үзнэм.
Онхийн дэмий уулинхайлж хөндий талыг чийглэнэм.
Урсах долгионы аяар зовлон гамшиг хөлөглөнөм.
Учрах үхэл ч тоохгүй би нийхүү шаналанам.

«Хэн нөхөр эс хайвал өөрөө өөртөө дайсан» гэх
Хэт мэргэн үг Хятадын ууланд бий гэнэлээ.
Сарнай цэцгээс салбал өргөс болдог билээ
Салшгүй журмын андаа чи од» гэлээ

Баатар хариу өчрүүн; чиний хэлдэг зөв.
Бат журмын нөхөртөө амиа зориулах минь лав.
Ус эрсэн буга шиг ордон гэрээ орхиод би
Уул талыг дамжин уйлан хайлан хайнам

Ариун сувд тэнцэм тансаг болор эрдэнийг
Амраг дээдээр хайрлавч орхиод би гарсан.
Агуу тэнгэрийн сүртэй эрхэм дээдсээ гомдоож
Алив энэрэх сэтгэлий нь хугалаад би ирсэн.

Эрдэнэ сувдын хэлхээ шиг энгүй хайраа соёрхсон
Эрхт тэнгэрийн ивгээлт зөвөргүү ганц хаанаа
Энэ нүгэлт бигээр итгэл тэсэлж орхисон
Эзэн тэнгэрээс өршөөл горьдохоо би өнгөрсөн.

Өөрийн анд Тариэлийн гашуун зовлонг хувааж
Өдөр шөнө ялгалгүй довтлон би ирлээ.
Гуниглан санасан тэр минь алсад одсон гэлээ
Гутаж би зовон хайлан суугаа билээ.

Зав ч болохоо байлаа, яриагаа би цэглээ
Зааж сургасны чинь дагана эргэж бүү гуныя
Анд журмын нөхрөө эрэн хайж олъя
Амиа би алдагч тэнгэрт үл гомдыё»

Уйлан хайлан баатар ийм үг өчөөд
Ус, ойг гаталж хээр хөдөөг зорив.
Оргил байцын салхи сарнайг үлээж чичрүүлнэм
Оломгүй их зовлон хэзээ нэг барагднам?


Эрхт эзэн тэнгэр минь ямар хилэнц үйлдэв би?
Энэ хорвоогийн зовлон яагаад ийн нүүрлэнэм?
Амьд үлдэхээ мэдэхгүй ч хоёрын тухай шаналнам би
Амь насаа үрэхэд ер эс түвднэм би

Сарнай цэцгээр чичиж зүрхийг анд минь хөндөв
Сайхь тангаргаа дагатал баатар өөрөө няцав
Андаа би олохгүй бол аянга дайрч гутнам.
Алив өөр этгээдийг би эс таалнам

Уужим бодолт эр байж тийн гуних нь гайхмаар
Урсах нулимс л байвал боллоо гэвэл хачирхмаар
Зөв бясалгаж бодвол зүтгээд байхаас дээр нь үгүй
Зөнч тэнгэрт тэмүүлсэн андаа олтол амрахгүй»

Андгайлж ийн өчөөд эрэлд баатар мордон
Анд нөхрөө дуудан нойр хоолгүй тэнэн
Ой тал, хадаар гурван хоног бэдэрч
Олж учирч чадалгүй ахин гунигт автав

Хайлж баатар өчрүүн: «Дээд тэнгэр эзэн минь
Хагацашгүй ийм зовлонд ямар нүглээр унав би?
Алив зовлон хөнгөлж зорьсны минь ивгээ
Амь насыг богиносгоно, мөргөн өчихийг сонс»





XXXVI

АВТАНДИЛ ТАРИЭЛИЙГ ОЛСОН НЬ

Өнөөх баатар эр царай нь зэвийн гуниад
Өндрийн оройгоос харвал сүүдэр, гэрэл хоёр
Тэртээ хөндийг дагаад уралдан наадан зугаалнам
Тэнд хөлөг морин ойн дунд зогсоном

«Тариэл минь байна» гэж баатар харан баярлаж
Тас харанхуй гуниг эгшнээ ярагдан тонилж
Ариун сарнай сэргэж эрдэнийн өнгөөр гялалзан
Ахуй салхинаас хурднаар уруудан тэр одов.

Ажиг сэжиг авахгүй Тариэл таг дуугүй
Амь голтой төдий зэвхий даан суужээ.
Өмсгөл хузцас нь урагдаж өөрөө цусанд будагдаж
Өөр хорвоод очсоо мэт хамаг бие нь хөшжээ.

Алагдсан нэгэн арслан хажууханд нь сунайнам
Арай зайтай газар нэг барс гулзайнам.
Цус болсон илд баатрын дэргэд хэвтнэм.
Цутган гарах нулимс, гунигт Тариэл дарагднам.

Ухаан сэхээгүй баатар нүдээ тас аньж
Угийн гамшигт хорвоог орхиход бэлэн болжээ.
Уул талыг доргител нөхөр нь хашгиравч сэргэхгүй
Учир ёсыг бодож Автандил дэргэд нь очжээ

Анд нөхрийн нулимсыг алгаараа Автандил арчиж
Аятай зөөлөн түшээд дуудан дуудан өчив.
«Автандил чинь ирээд байна.Хоёул баяртай золгое» гэхэд
Ашгүй нүдээ нээсэн ч таг дуугүй хэвээр байв.

Бодит үнэн явдлыг гагцхүү би өгүүлнэм
Болгоож нөхрөө тэврээд сэргээхийг Автандил оролдном,
Арайхийн баатар сэргэж ах дүү хоёр шиг тээрэлднэм
Алдарт ийм хүмүүсийг олныг заяавал зохином.

Тариэл баатар өчрүүн: «Тангаргаа би сахилаа.
Тамын зовлон амссан ч амьтай голтой золголоо.
Ариун нулимсан үерээр үхэх замаа заслаа
Араатны идэш болголгүй ёс төртэй оршуул»

Автандил хариу хэлрүүн: «Чи юу яринам?
Амраг сэтгэлд шаналаагүй хүн хаа байнам?
Шулам шүглэсэн юм шиг чи юу зорином?
Шууд үхэхийг хичээх хэн гэгчийн ёс вэ?

Чи өөрөө цэцэн бол цэцэн гэсэн үгээ бод
Чимээгүй дотроо шаналбал тэр ёстой эр хүн
Түмэн бэрх амсавч хаднаас бат хатуу бай.
Түйтэр зовлон гэдэг чинь хүний оюуны гай.

Ухаантай хүний үр байж, үүнийг мэдэхгүй гэж үү?
Уурт араатан дундаас чи юу олном бэ?
Амрагийн төлөө шаналан байж хорвоогоос яаж салнам бэ?
Амар бие чинь бүтэн байж шархыг юунд хүснэм бэ?

Эрсдэх занал тойрч сэтгэлийн зовлон амсаагүй
Энэ яваа насандаа нэгэнд унаж гуниагүй
Хорвоогийн жамаас ангид тийм хүн бий юу?
Хосгүй сарнай тансаг ч өргөгсгүй нь бас байна уу?

Сарнайд нэг хэлж гэнэ: «Чи гуалиг сайхан юм
Саатан чамайг авахад өргөс чинь л бэрх юм
Хариу тэр өчиж гэнэ «Сайны зам шулуунгүй
Хамаагүй дуртай нь хүртвэл сохор зоосны үнэгүй

Амьгүй цэцэг хүртэл ийм мэргэн сэтгэхэд
Амьтан хүний үр жаргалыг хялбар олох уу?
Зовлон гай тарихгүй бол шулам гэдэг байх уу?
Зогсохгүй хувирдаг хорвоод гомдох хэрэг байна уу?

Үнэн үгэнд өр, хоёул мордон одъё
Үйлийн эрхээр учирсан зовлонд бүү сэгд
Дурыг зөнд нь тавилгүй сэтгэлийн жолоо барь
Духалж хэлснийг болгоож хар гунигийг таягд.

Өөдөөс нь Тариэл өчрүүн: «Хэл ам эвлэхгүй
Өөрийн ухаан самуурч чиний хэлснийг ухсангүй
Амссан түмэн зовлон яагаад хялбар байхав.
Авсанд орох минь дөхөж амрах цаг ойртов.

Амь алдахын өмнө тэнгэрээс гуйх зүйл бол
Анд амраг цөмтэйгээ хожим учрах ерөөл байна
Энэ хорвоогийн жаргалыг өөр ертөнцөд эдлэх байна
Эрхэм биеий минь оршуулбал чиний халамж тэр байна

Янаг сэтгэлийн аяар амрагаа хэн ч мөрөөднө
Ямар ч болсон түүнтэйгээ би заавал золгоно.
Сувдан нулимсаар цэнгэн хоёул баярлан учирна.
Сургах зуун үгнээс нэгийг өөрөө сонгоно.

Үнэн үгий минь сонс, миний үе өнгөрсөн.
Үхэл намайг гэвэрч, би ч өөрөө яарсан.
Амь хэлтрэв гэхэд над шиг балай нэгэнд
Анд чи ч баярлахгүй сүнс минь бараг одсон

Чиний хэлсэн үгний учрыг би олохгүй
Чин сэтгэлээс өчихөд бодъё гэвч завгүй
Амьдрах бүх хүсэл онхийн дэмий замхарч
Асгарах нулимсаараа дэвтээсэн газрын гүнд орном би

Мэргэн цэцний учрыг балай би мэдэшгүй.
Мэтгэлгүй хэлэхэд тэнэгүүдэд чиний үг нийцэшгүй
Нарны гэрэл дутвал сарнай цэцэг хатна
Намайг бүү зовоо, зүрх бүхнийг дийлнэ».

Автандил баатар цөхрөлгүй андаа дахин өчрүүн:
«Амь насаа хөнөөгөөд ямар ашиг гарнам?
Аргалах учир байнам, бүү ингэж тэнэглэ!
Алд биеэ тамна. Ухаан оюун зар» гэв.



Тариэл баатар дуугарахгүйд Автандил бас хэлрүүн
 Дассан андаа тоохгүй бол үг хэлэхээ больё.
 Гарцаагүй үхвэл үх, сарнай иддээ гандаг!
 Ганцхан юм л гуйя» гээд уярлын нулимс асгав.

Чамд яараад би хаан эцгээ орхисон.
 Чанга сэтгэл бариад амраг түүнээс холдсон
 Чандлан сургасны нь зөрчиж сэмээр би одсон.
 Чамайг ийм байвал хэрхэн би тайтгарах вэ?

Нэг л юмыг гуйя морин дээрээ морд!
 Нээрэн намайг бодож үгэнд ганц ор!
 Эр морио унахад гуниг арилж ч мэдэх юм.
 Эс тэглээ гэхэд дураараа чи болоорой!»

Хөлгийн дөрөө жийхэд гуниг арилгахыг мэдэж
 Хөөрхий андаа Автандил гуйн гуйн өчив.
 Сормуус юугаа өргөж чилсэн баатар дээшилж
 Соёрхон зорьсноо бүтээж баатар эр уужрав.

«За тэгвэл яахав морий минь ойртуул» гэхэд
 Залуу анд нь дөтлүүлж хоёул мордон гэлдрөв
 Эмээлт морио унаж ээрэм талаар одоход
 Эрэмгий баатрын зовлон эрхбиш баахан нимгэрэв.

Элдэв хууч хөөрч Автандил сэтгэл засав.
 Эмгэн буурлыг ч гэсэн залуужуулам сонин дэлгэв
 Эл яриаг сонсоход Тариэлийн гуниг тайлагдав
 Эрдэнэ танан шүдээ яралзуулан байж мишээв.

Гуниг тайлахдаа Автандил отчийн адил дадамгай.
 Гутарсан сэтгэл сэргээж баяр төрүүлэх нь чадамгай
 Өөрөө бас хөөрч үгээ сонгох нь сарамгай
 Өөд өөд нь ахиулсаар ихийг ярих нь сурамгай.

Байдлы нь ажиж байснаа Автандил ийн өчрүүн:
 «Баатар чи амрагаа дээдийн дээдээр мөрөөдөж
 Барьж өргөсөн бэлгий нь хадгалж явдаг шүү дэ»
 Байгаа энэ бугуйвчийг үнэхээр чи хайрлана уу»

Хариу баатар хэлрүүн: Түүнтэй зүйрлэх юмгүй
 Хамаг зовлон, жаргал тэр бугуйвчинд шингэсэн юм
 Уул, ус, мод цөм түүнийг гүйцэхгүй
 Угаас тэхдээ дэмий юм, сэтгэл ер амрахгүй



МОНГОЛ
УЛСЫН
НЭГДЭЛ
БИШ ҮҮ

Үүний тухай сонсъя гэж тэсгэлгүй би хүсдэгсэн.
Үнэндээ чи хэлсэн хойно чамд ярих үг байна
Амьгүй бугуйвч нандигнаснаас Асматыг энэрвэл дээр
Андлаа бүү хилэгнээрэй» гээд Автандил ийн өчрүүн:

«Оюун ухаангүй хэдий ч энэхэн алтан бугуйвчийг
Онцын дээдээр хайрлаж гагцхүү чи шүтдэг бол
Эгчийн адил хайртай хөөрхий бүсгүй Асматыг
Эдүгээ огт бодохгүй нь зүй ёс мөн үү?

Чиний төлөө зүтгэж чи ч эгчээ гэгчихээд
Чин сэтгэлийн амрагаа эрж хайхдаа дагуулчихаад
Хамаг бүхнээ түүнд чинь зориулсан тэр хөөрхийг
Хадан агуйд хаячихдаг шударга ёс мөн үү?

Хариу баатар хэлрүүн: «Хамгийн үнэн үг
Хайрт Нестааныг бодох нь Асматын ганцхан хүсэл
Амийг чи аварлаа, одоо би сэхнэм
Амьд байгаа хойно Асматад даруй очном»


Хоорондоо тэд тохироод хадан агуй зорином.
Хоёр баатрыг гайхаж магтах үг дутнам.
Хосгүй сувд эрдэнэ шиг тэгш шүд яралзнам.
Хорт могой ч уярмаар цэцэн цэлмэг ярилцнам

Эрхэм андын тусад хүч оюунаа хайрлахгүй
Эмзэгхэн зүрхээ чи шархлаах ер хэрэггүй.
Аятай барьж чадахгүй бол цэцэн ухаан нэмэргүй.
Арвитай зарж чадахгүй бол хөрөнгө чинээ ашиггүй

Уйдан уйдан гуньж усан нүдлэх хэрэг юу вэ?
Угийн тавиланг зөрчиж урьдаж хэн ч хорохгүй?
Сарнайд гэрэл дутвал гуравхан хоногийг ч даахгүй»
Сайны ерөөл байвал тэнгэр биднийг гээхгүй?

Автандил ийн хэлэхэд Тариэл хариу өчрүүн:
«Ашдын энэ үг чинь зүрхэнд минь хүрлээ
Учиртай ийм сургаалд ухаантан сайчуул баярлана
Угаасаа чи ч зовсон, миний гунигийг мэднэ.

Хэзээнээс лав шатдаг, галтай хоёул ихэр юм.
Хэрээ усанд унавал дороо шатах эсрэг юм
Хэн аль нь зовбол бусдын бэрхийг мэдлэгсэн
Хэт гуньсан зүрх минь хайлах нь лав дөхсөнсөн.



XXXVII

ЭР АРСЛАН, ЭМ БАРС АВЛАСАН ТУХАЙ ТАРИЭЛ ӨГҮҮЛСЭН НЬ

Амсаж өнгөрүүлсэн зовлонгоо нэгд нэггүй ярья.
 Анд нөхөр чи минь мэргэн ухаанаар тунгаа
 Эгэлгүй гамшигт шаналан элдэв горьдол тасраад
 Эрхбиш сэтгэлээ сэргээхээр аргагүй орхин тэнэлээ

Хулсан шугуй өнгөрч, уулын оройгоор одтол
 Хурдлан яваа арслан, барс ойн цоорхойд үзлээ.
 Энхрий сэтгэлтэй тэр хоёрт бахархтал
 Эвийн тангараг тасрах мэт муудалцахад нь гайхлаа

Оргил өндрийн оройгоос тэр хоёрыг ширтвэл
 Осолгүй сэтгэлтэй хоёр тул би баахан уужрав.
 Эвдэрч гэнэт уралцаж миний сэтгэл гутаж
 Эм барс зугтаж арслан хойноос нь элдэв

Улам улам даварч уур хилэн нь бадарч
 Угаас хайрлах сэтгэлгүй бие биеэ дэлсэв.
 Хайраа хал болгоод охин барс бултасхийж
 Хамаа намаагаа алдсан хилэнт арслан хөөв.

Арсланг хараад би «Чи тэнэг амьтан
Амрагаа ийн зовоогчийг гэсгээвэл зохино» гээд
Илд юугаа далайж хүчтэй гэгч цавчвал
Илт хорвоогоос салж арслангийн толгой үсрэв



Зэр зэвсгээ хаяж барыг барин тэвэрч
Зэрлэг хэдий ч хөөрхийг, амрагаа дурсан таалах гэтэл
Эм барс хүрхэрч араатан зангаар дайрахад нь
Энэ бие минь балайран хайргүй түүнийг хөнөөв.


Номхруулчихаар оролдоод бүр би цөхөрч
Ноцон барьж шидтэл толгой нь тийшээ үсэрсэн юм
Амрагтайгаа зөрснөө тэрхэн агшин санаж
Алив зовлон өтгөрч амьд үлдсэнээ гайхнам

Учирч туулсан зовлонгоо өчиж хэлэхэд сайн байна
Угийн тазиланд автаж ингэж бэдрэх буруу юу?
Үхэл сайхан санагдаж энэ хорвоогоос уйднам» гэж
Үгээ баатар дуусгаад, шүүрс алдан уйллаа

Анд нөхрөө уйлахад Автандил бас хайлж
Арсланг чи хөнөөж, зүрх гэдэг чулуу юм
Сэтгэлийн зовлонт эрийг дээд тэнгэр тэтгэдэг юм.
Сэхэшгүй үхэл ирсэн бол хувь заяагаа дийлдэг юм.

Амраг сэтгэл эрд хорвоогийн гуниг сүүдэр юм
Амсах зовлонг тэвчвэл гэгээн найр хийдэг юм
Алив зовлон өтгөрч амьд үлдсэнээ гайхнам
Ангайсан тэнэгүүд үрэгдэж ашгүй ухаантан балайрдаг юм.





XXXVIII

ТАРИЭЛ, АВТАНДИЛ ХОЁР АГУЙД ИРЖ АСМАТТАЙ УЧИРСАН НЬ

Уулын агуйг зорьж хоёр баатар хөдлөв.
Учиргүй их баярласан Асмаг тэднийг угтав.
Оргил өндрийг хальтал нулимс юугаа урсгав.
Онц л ихээр цурхиран тэврэлдэн тэд үнсэлдэв.

Асмаг тэдэнд өчрүүн: «Ухаант дээд тэнгэр
Алтан наран ивгээлт энэ хорвоог бүтээжээ».
Өмөг дээд тэнгэрийг би магтаад баршгүй
Өдий хүртэл намайг өршөөсний нь марташгүй

Тариэл харну хэлрүүн: «Эгч чамтай учирч
Тансаг нулимс урсгаж гай зовлон амсавч
Эдүгээ үүссэн зүйл биш эрт урьдын жам юм
Энэ биеэ хөнөөмөөр ч эгчээ гагцхүү бодном»

Ухаант хүмүүн усыг уухаас биш асгадаггүй.
Урсах нулимс дуусахгүйд гайхаад гайхаад баршгүй
Шимийн хур шиг нулимс арвижаад байх нь хачирхалгүй
Шяжир эрдэнэ алдаж сарнай гутсан нь харамсалтай.



Амрагийн дүр шингэсэн алтан нарнаа хандаж
Автандил баатар өчрүүн: «Хагацлыг хэрхэн барнам бэ?»
Алсад ганцаар бэдрэхэд амьдрал тэсэхүйеэ бэрхтэй
Алдарч шаналсан чамд намайг хэн хэлнэм бэ?

Нарны элч дутвал гандахдаа сарнай мэддэг.
Намайг чамайг гийгүүлэх наран шингэвэл яанам бэ?
Хүний зүрх гэдэг хүрэл чулуу ч болоосой.
Хүсэлт амрагтай учиртал бие тийн тэвчээсэй.

Дээд тэнгэрт баярлаж сэтгэл баахан уужраад
Дэндүү гунигаа барьж агуйд гурвуул оров
Асмагт бүсгүй хуучнаараа барсын арьс дэвсээд
Аятай яриа дэлгэж бие биесээ тайтгаруулав.

Ангийн мах шарж оройн зоог барив
Амтан аагтан дутавч ашгүй тавтай болов
Тариэл гэвч базаахгүй, хоол унданд дургүй
Тал зоосны хиртэйгээс илүү зооглож барсангүй.

Баяртай яриа дэлгэх хэнд ч гэсэн таатай.
Бахтай ярьсны нь голоосоо таашааж байх нь зүйтэй.
Амссан зовлон хуваах нь хэнд ч гэсэн аятай.
Асаж дүрэлзсэн зүрхийг намжааж өгөх нь олонтой.

Арслан зоригт баатар шөнөжин яриа дэлгэж
Амсаж байсан зовлонгоо ёроол уудлан ярьж
Алтан нар мандахад хэн хэндээ тавсан
Андгай тангараг юугаа давтан давтан өргөз

Тариэл баатар өчрүүн: «Урт яриагаар яахав.
Тангараг сахисан чамайг тэнгэр ивгээн тэтгэнэ
Үүрдийн тангараг өргөхдөө бид бараг согтуурчээ.
Үхэн үхтэлээ чамайг хаана ч мартаг минь өнгөрчээ.

Цахиур хавирч гаргагүй галд би автжээ.
Цаашдын зовлон хөнгөрөхөөр ухаан зарах болжээ.
Тэр галд өртвөл өөрөө ч чи шатна
Тэгсэнд орвол амрагтаа буцвал үтэр таарна.

Эцэлсэн энэх зовлонд дээд тэнгэр ч гуслахгүй
Эрхбиш яагаад зугтсаныг сонссон хэн ч андахгүй
Ухаантай олигтой бүхнээ нэгэнт би бүтээжээ.
Уураг тархи мансуурч одоо би балайрчээ.



Өөдөөс нь Автандил хэлрүүн: «Үүнийг хариулахад хэжүү
 Өндөр тэнгэрийн нэр барьж чи ийн хэллээ.
 Хорвооог бүхэлд нь гийгүүлдэг эрхт тэнгэр яагаад
 Хохирч шаналсан зүрхийг анагааж эс чаднам бэ?

Янаг амрагийн заяаг тэнгэр ийн шийдэхгүй
 Яав ч гэсэн хагацаж нулимс урсгах ёсонгүй
 Амрах сэтгэл гэдэгт дагадаг сүүдэр нь гуниг юм.
 Амэдрахыг чи хүсэхгүй бол энэ биеэ хөнөөнө би.

Хатуу сорилт дазахгүй хамаг зовлон даахгүй
 Хар гунигт автах нь хатан зориг биш ээ.
 Харамч энэ хорвоогоос тэнгэр хавьгүй ивгээлтэй
 Хайрт андаа сонсохгүй бол тэнэг илжиг гэлтэй.

Элдэв сонссон бүхнээ эрэгцүүлж сайтар болгоох нь
 Эрхэм мэргэдийн сургаал шүү, чамайг би зорихдоо
 Энхрий журамт нөхрөө гэж гал голомтоо орхисон
 Эндээс одоо буцна, дэмий ярих хэрэггүй

«Зовлонт баатарт туслах чинь наддаа үйлдэх гавьяа
 Зоригт чамдаа бахаднам» гэж амраг минь надад хэлсэн
 Хайрт түүнтэй зөвлөөд ум хумгүй гарсан
 Харин одоо очиход хулчгар амьтан гэвэл яана?

Онхийн дэмий чалчсанаас миний үгийг сонс!
 Оюун ухаан зарвал сая бэрхийг давна.
 Онолдож гэгээ тусахгүй бол цэцэг гундаж унана.
 Осолдож надаас хагацвал ганцаар сөнөнө,

Урьдын адил чи энэ хорзоогоор тэнэ
 Ухаантай, балай хамаагүй аль байдгаараа бай!
 Энэ сайхан бие эрэмгий зоригоо барь!
 Энэлэх зовлон тэвчиж үхлийг чи дав!

Үүнийг мөргөн гуйгаад жилийн дараа ирье би
 Үзүүргүй хорвоог хэрж мэдээ сэлт авчирья би
 Сарнай цэцэг соёолох хаврын урин болохоор
 Сайхан хөхөөн дуун шиг сарнай чамайг сэргээг.

Жилийн дараа ирэхгүй бол гай зовлон учирч
 «Жиг болж өнгөрөв» гэж чи тэгэхэд бодоорой
 Туждаа чи баярлах уйлж, гуних нь хамаагүй
 Тухайлж нулимс унагахад би ерөөс зэмлэхгүй

Эр морь, усан онгоц алинаас ч осолдох ялгаагүй
Энгүй тал, бэнгүй далай хаана ч өнгөрөх өөрцгүй
Адгуус мал шиг гэвч дуугүй байж тэвчихгүй.
Ачит тэнгэрийн таалам ямар болохыг мэдэхгүй

Харин Тариэл өчрүүн: «Хэлэх үг шувтарч байна.
Хандаж гуйсан үгийг тоохгүйгий чинь мэдэж байна.
Эр нөхөр зүтгэвэл түүнийг дагах ёстой
Эцэс зүүлдээ нэг учир нь олдох хузьтай.

Энэ агуйд хоргодох, эзгүй хээр тэнэх
Эгээ адил гэдгийг чи минь болгоож соёрх!
Ухаан оюун балайрсан хойно чинийхээ үгийг дагая!
Удаан хоёул салахад хүлээж би чадах уу?

Ийн яриагаа дуусгаж эргэн тойрон давхиж
Идэр хоёр баатар зэрлэг араатан авлаад
Эргэж хоёулаа ирэхдээ маргааш хагацахаа бодож
Энгүй их шаналан хоёул нийлэн уйлжээ.

Эр нөхөд хагацах хэцүү зовлон буюу
Энэлсэн зүрх холдоход элэг эмтрэх ажгуу.
Ийм зовлон амссан уншигч та хайлнам
Илтэд ер үзээгүй зарим нь эс ажирнам

Хөлөг морио унаж жавхлан сүрээ гайхуулж
Хөөрхий бүсгүйгээс салахад гурвуул тэд мэлмэрч
Арслан зоригт баатрууд нүүрнээ цог туяаруулж
Араатан, жигүүртэн сүрдтэл хайлан хашгиран өчив.

Агуйгаас холдон одоход Асмаг баатраа үдэн:
„Арслан зоригт чамайг хэн мартаж чаднам бэ?
Ариун диваажингийн нар та хоёрыг ээнэм
Аяа би шаналнам, хорвоогийн зовлон хэцүүеэ

Уулын тэртээх агуйгаас хоёр баатар холдон
Уужим талыг туулж тэнгисийн эрэгт хонов.
Удахгүй хагацна гэхээс шүүрс алдан гиюүрч
Уг биесээ тэтгэж шөнөжин цуг байв.

Автандил баатар өчрүүн: «Нулимс минь барагднам
Алс ойд ганцаар, Придоноос холдсон чинь буруу
Зорьсноо бүтээж жаргах зам тэндээс эхэлнэ
Зориуд би очъё, чи над заа!

И ариэл баатар хариуд сэтгэл юугаа тэвчин
Гал анд Придоныд хэрхэн хүрэхийг зааж
«Тэнгисийн эрэг барьж дорно зүгийг зорьсоор
Цэнгэг булгийн ундарга шиг гашуун нулимс урсгаж



Гунихын ихээр гунивч ан ав хийж
Гутаж шаналсан хэдий ч зоог зууш базааж
Эрэлхэг хоёр баатар модны нөмөрт хонов
Эрээн бараан хорвоо ийм л байх юм даа

Өглөөн гэгээ тусмагц анд хоёр босож
Өвч олныг уяруулам яриагаа бас л дэлгэв.
Цэнгэг булгийн ундарга шиг гашуун нулимс урсгаж
Цээжинд гуниг багтарч хоёр биенээ тэврэв.

Хонгор сайхан цогцсоо хайр найргүй тамлаж
Хоёр тийшээ хандаж бөглүү ой туулав.
Барааны газар тасартал дуу дуугаа авалцаж
Баатрын гунигийг мэдэхдээ нарны гэрэл бүдгэрэв.





XXXIX АВТАНДИЛ ПРИДОНЫГ ЗОРЬСОН НЬ

Аяа, хуурамч хорвоо биднийг юунд сорино вэ?
Аяа эрхий чинь дагаж бигээр шаналнам биш үү?
Хаашаа биднийг аваачиж орчлонгийн жам гүйцээнэ вэ?
Хайргүй гэсгээсэн хүмүүсийг гагцхан тэнгэр ивгээнэм.

Тэнгэрийн хаяа хүртэл Автандил уйлан өчрүүн:
«Тэнэж одоо би цусаар бас уйлнам
Уулзаж нэг зозох, салж бүр шаналах
Угаас хорвоо гэдэг яасан их алагч вэ?»

Урсгасан цус, нулимс араатныг бүрэн цатгаж
Улмаар гунигаас Автандил салж эс чаджээ
Учирсан амрагаа мөрөөдөж сэтгэлий нь зовлон дарж
Уран сарнай нэвт болор эрдэнэ туяарчээ,

Сарнай цэцэг гугаж зандан мод хатаж
Сайхь молор цайж өнгө баахан зэвхийжээ
Үхлийг гэвч давж гунигийг бүр ч дарж
«Үйлийн харанхуй бүрхээч гайхахгүй» баатар өчжээ.

Наранд баатар өчрүүн: «Миний амрагийн дүр чи
Найртай янагийн минь хамтаар уул талыг гийгүүлнэ
Тунгалаг чамайг харахад миний сэтгэл тайвширдаг юм
Тусгах гэрлээ нууж зүрх юунд хөлдөөнө вэ?»

Нар ганцаар чи нэгхэн сар холдоход
Найгүй өвөл болдог хойно хоёр нараа алдахад
Амьтай би шаналнам, хорзоо л зовохыг мэдэхгүй
Алив нэгэн шархыг мэс ер нь анагаахгүй.

Дээд тэнгэр гэгээн наранд тэрээр ийн өчрүүн:
«Дэлгэр энэ хорвоо, хааны хаан билээ л чи
Золтой нэгий нь тэтгэж хаан ширээ хайрланам.
Зоргоор өдрийг эчээлгүй амрагийн дүр харуулаач!

Санчир одон чи миний гунигийг зузаатгаж
Сайхь миний зүрхийг ёроолгүй харанхуйд унага
Илжигний ачаа шиг хүнд зовлонгийн дарамт илгээж
Ийнхүү шаналж явааг амрагт минь дуулгаж соёрх

Хоёр зүрхний маргааныг чи нягтлаи болгоож
Хосгүй шударга шийд, гэгээн гэрэлт Бархасбадь
Үнэнч нэгнийг буруутгаж нүгэл бүү хураагтун:
Үйлийн ихээр шархалсан зүрхийг бүү зовоогтун!

Ангараг одон чи намайг хайргүй хөнөөж
Аль байгаа биеий минь улаан цусаар угаагтун
Энэ яваа насанд жаргахгүйгий минь мэддэг хойно
Энэлж зовж явсныг амрагт минь чи өчигтүн

Гэгээн цолмон туслаач, над шиг хөөрхийг зовоохоор
Гэрэл гуа өнгийг харамгүй чи заяадаг
Сувдан хэлхээ шүдтэй, шүрэн улаан уруултай
Суут гуалиг нэгнийг би улам хайрладаг.

Аялал тэнүүлийн од Буд чамтай холбоотой
Аль нь ч гэсэн ялгаагүй нарыг тойрон эргээстэй
Асгарах нулимсаар бэх, энэ биеэр бийр хийж
Амссан миний зовлонг чи тоочин бичигтүн,

Сар чи хайрлагтун, чам шиг би хатнам.
Сайхь чиний адил нартай, наргүй гэлдэрнэм.
Сайхан түүнээ мөрөөдөж сааргүй зовлонд азтнам
Санаа үнэнээр өнгөрснийг амрагт минь чи дуулгагтун

Санчир Бархасбадь, Буд, гэгээн наран цөм
Саруул цолмон, Ангараг тунгалаг саран бүгд
Эгэл царай нь зэвийж энгүй их уруутай
Эрхэмсэг хайрт түүнд миний зовлонг илтгэнэм




Автандил дотроо бодруун: «Зүрх чи гуньж
Амь биеэ хөнөөж энэлэх хэцүү биш үү?
Жам ёсоор заяасан хархан үст амраг минь
Жаргал эдлэх хялбар, зовох гэдэг хэцүү

Хэлж баршгүй мөрөөдсөн наран амрагаа харах бол
Хэлмэгдэж амь дүйсэн ч амьд явах сайхан
Ингээд Автандил баатар уйлах дуулах хослуулж
Идтэй бахтай аялах нь алтан гуралдай адил

Энэх дууг сонсохоор араатан, жигүүртэн цугларч
Эрхэм ярууг магтахаар уснаас чулуу цухуйж
Энд тэндгүй уйлж, эр эмгүй хайлж
Эрэлхэг баатар дуулан өрөвдлийн нулимс үзнэм.

Уулын араатан, усны загас, тэнгэрийн шувуу
Улс олон, Энэтхэг, Грек, Араб
Орос, Франц, Иран Мисир тэргүүтэн цөм
Онцгой баатарт мэхийн ёслохоор хүрэлцэн иржээ.





XL

АВТАНДИЛ ПРИДОНТОЙ УЧИРСАН НЬ

Тэнгисийн эрэг барьж далан хоног яваад
 Тэртээ долгионд орох хөлөг онгоц үзэв.
 Аялагч хүмүүстэй уулзаж хэт нутаг хаана зэ?
 Аль улсын албат вэ, эзэн хаан хэн бэ? гэв

Хариу тэд өчрүүн: «Гансаг гуа таныг
 Хайрлаж бид биширнэм, тийшээ Туркийн нутаг
 Энд манай нутаг, эзэн хаан Придон
 Эрхэм өнгөнд чинь гялбахгүй бол элдвийг бид хөөрье.

Өргөн баян нутагтай өгөөмөр хаан Придон
 Өмөг их түшигтэй зоригт баатар жанжин
 Тэнгэр газар хоёрыг холбож байдаг дэнлүү
 Тэрс бүхнийг дийлдэг наран дээд эзэн»

Баатар хариу хэлрүүн: «Алсаас би зорином
 Бат журмын нөхөдтэй завшаанаар ийн золгов
 Хааныд яаж хүрэхийг зам хир үлдсэнийг
 Харамгүй над хэл» гэхэд тэд даван одов.

Энэ замаар явсаар манай улсад очно.
Энгүй мэргэн харваач хаантан соёрхож таална
Арваад өдөр яваад тансаг та хүрнэ
Ашид таныг мэдэхгүй ч сэтгэл дунд догдолном?

Баатар хариу өчрүүн: «Миний төлөө зоволтгүй
Баахан хатаж муудсан өвлийн сарнай байнам
Оргил өндөр адил энэ бие минь дэгжиж
Олон андын дунд жаргахыг та нар үзээсэй»

Салах ёс гүйцэтгээд аян замдаа орж
Сарнай адил баатрын зүрх гэдэг нь хатуурч
Эдэлсэн жаргалаа дурсан эргийн ой туулж
Эрдэнэ царайгий нь дагаж рашаан нулимс урсав.

Учирсан цөм түүнд хичээн байж зүтгэж
Уяхан бүсгүй адил түүнийг харахаар цуглаж
Хагацан одоход гуньж харц олныг гаргаж
Хаа холын замд үдэж зааж дэмжиз.

Урт замыг товчилж зорьсон газраа ирэхэд
Улс орон даяар ан авд гарч
Ханагар их талыг бүслэх адил тойроод
Хамаг олон араатныг хадах адил хядав

Хэн нэгтэй учирч: «Юун олон цэрэг вэ?
Хэт их шуугиан яасан их чимээ вэ? гэхэд
«Ухаант Придоны цэрэг авлаж зугаалж явнам
Уулаас уул хүртэл битүү бүсэлсэн байнам» гэв.

Дайчин цэрэгт ойртон Автандил их баяртай
Даамай гэгээн түүнийг магтах үг ховортой
Түүнээс хагацах гэдэг өвлийн жавар хайрах мэт
Түншийн ёсоор учрахад өгөөмөр наран халаах мэт

Эр цэргийн дээгүүр талын бүргэд дүүлэхэд
Эрэлхэг баатар Автандил сумаа онилж зэхэв
Ганцхан сум исгэрч хомхой жигүүртэн унахад
Галтай баатар очиж жигүүр юугий нь тайрав.

Харваач олон түүнийг гайхан гайхан харж
Хараа юугаа салгалгүй ан аваа зогсоож
Гал талаас ойртоод үг дуугүй гөлөрнөм
Таалж нэрний нь асуух гэвч эмээж баахан тэвднэм

Байц өндрийн орой дээр хаан Придон зогсоод
Бараа бологч олноо хамт тийшээ дагуулаад
Харваач ангууч цөм Автандилыг хүрээлснийг үзэж
Харц юугаа гялалзуулж хилэгнэх гайхах зэрэгцэв.

Хаан элч зарж «Яагаад эмх алдаж
Харалган мэт бэдэрнэм, үзээд ир» гэжээ.
Элч зарлага өөрөө Автандилыг харж
Эрхэм гуаг сүрдэж үг дуугүй гөлөрчээ.

Элчээ хаан илгээснийг Автандил баатар болгоож
«Эрэлхэг Тариэлийн дүү би Придон хаантай учрахаар
Энэ оронд ганцаар ирээд байнам» гэж
Эзэндээ айлд хэмээн тэрх боолд өчжээ.

Харц боол яарч эзэндээ хүрч очоод:
«Хааны мэндийг эрэн Тариэлийн дүү иржээ
Өдрөөс тунгалаг гэрэлтэй гэгээн саруул дэнлүү
Өнөр ухаантан ч харсан балайрч мэдэхээр эр» гэж

Тариэлийн нэрийг сонсохдоо хаан Придон тайвширч
Тансаг нулимс урсан, сэтгэл зүрх зөөлөрч
Сарнай цэцэг муудаж нулимсан үер давлаж
Сайн эрс учирч магтаал үг цууриатнам.

Зочныг угтахаар Придон уулын хярыг орхиж
Зоригт баатрыг үзэн, хосгүй гуагий нь гайхаж
«Хорвоогийн нарнаас тунгалаг тансаг эр ажээ» гэв
Хоёр баатар буйн энэлж хайлан мэндлэв.

Хэт нутаг хол, омог отог өөр ч
Хэн хэнээ биширч хоёр баатар тэврэлдэв.
Тэр хоёрыг харахдаа нар тэвдэн одов.
Тэнд эндгүй учрах элбэг эрс биш байв.

Эзэн Придонтой өрсөх хүчтэн байхгүй ч гэсэн
Эрхэмсэг Автандилын сүр юм бүхнийг даржээ
Гэгээн нар сар цөм бүрнээ бүдгэрч
Гэрэл туяагаар баатар шөнийг гийгүүлэн соёрхжээ.

Хөлтэй ан зогсож харвах намнахаа болиод
Хөлөг унаад ордонд баатрууд цөм иржээ
Эрэлхэг тэр жанжныг цэрэг олон үзэж
«Эрхт тэнгэр иймийг хэрхэн заяав» гэжээ

Автандил Придонд өчрүүнэ «Хэт нутаг хаана
Алдарт Тариэлтэй хэрхэн анд нөхөр болсноо
Нэгд нэггүй хэлье, чамд бас сонихон
Нээрэн хосгүй Тариэлд боол нь байвал таарахсан

Хаан Ростаны баатар, халамж хүлээсэн хүн билээ би
Хамаг цэргийн жанжин Автандил хэмээх нэгэн билээ
Дээд тэнгэрийн тааллаар хаантан намайг тэтгэнэм.
Дээрэлхэх муусайн дайсныг хэрэм шиг би хаанам

Эзэн бид олуул азд явж байгаад
Энгүй их хайлсан Тариэл баатрыг үзсэнсэн.
Урьж залсан боловч тэр баатар тоосонгүй
Уйтгар гунигий нь мэдээгүй бид гомдож билээ.

Хаан ихэд хилэгнэж барьж авахыг айлдвал
Хавьтаж ойртсон бүхнийг хайргүй тэр хөнөөж
Амьдын төдий заримын сүнс нь хэдийн тонилж
Аргалж болшгүй сар шиг баатар одож билээ

Эр цэрэг олон нь гутамшиг дэлгэхийг үзэхдээ
Эрхэм хаан өөрөө баатрыг хөөсөн билээ
Элдэж хөөрхийг хараад эрсдэх заналаас мултарч
Эгээ л байгаагүй юм шиг баатар арилсан билээ.

Олж чадахгүй болохдоо хоосон сүг бизээ гэж
Оройн дээд хаантан наргиан цэнгэл огоорч
Баатрын нууцыг тайлалгүй би ч гэсэн зовниж
Баахан гунигт автаж эрэн хайхаар шийдлээ.

Нойр хоолоо мартаж гурван жил хайгаад
Номхруулж гэсгээгдсэн Хятанаас Тариэлийн сураг гаргаад
Хатаж гутаж орхисон сарнайтай би учрахад
Хайрт дүүгийн адил найр тавин үгтсэн юм

Элгэн хадыг цусаар булж, мангасын агуйг булаан
Эмэгчин ганц боол Асматыг дэргэдээ аван
Энхрий амрагаа мөрөөдөн энэлэн байхыг үзэхэд
Эрхбиш түүнээс хагацах нь чулуу мөргөхтэй адил.

Ганцаар бүсгүй уйлж агуйг нулимсаар угаан
Ган зоригт баатар ан ав хийж
Амь гол зуувч хэрэн тэнэмээр санагдаж
Алив хүн төрөлтийг баатар бүр огоорчээ

Хамаг учры нь мэдэхийг үнэхээр би хүсвэл
Хайрт амрагаа болон өөрийгөө тоочин өчжээ.
Зол жаргалы нь үрсэн хайрт амрагаа мөрөөдөж
Зоргоор гуньсан түүнийг өгүүлэх үг дутжээ



Эргэн тойрон гийгүүлж сар адил тэнэн
Эрхэм таны өргөсөн хөлгийг унан явнам
Хүний үгийг зэвүүцэн араатан адил бултан
Хүж анд барилцсан бүхнийг ямагт зовооном

Дайрсан зовлонгий нь хувааж би уйлан гуньж
Дайчин баатрыг бодсоор ухаан оюун самууран
Хөдөө тал, хөх тэнгист тэрх бүсгүйг эрж
Хөөтэй зовлонд унагасан эзэндээ би золголоо

Эргэж аянд гарахыг ихэд би гуйвал
Эзэн хилэгнэн таалсангүй би сэм мордлоо.
Эр цэргээ орхиж уйлан гунин бэдэрч
Эрэлхэг баатрыг аврахаар газар сайгүй тэнэлээ

Алтан номын хуудсанд ч магтаад магтаад баршгүй
Ах дүү барилдсан чамайгаа дурсан дурсан ярилаа.
Уулзахгүй гэдэг гамшиг учран золгох баяр
Ухаант гэгээн бүсгүйг хэрхэн олохыг өчөөч!

Сэтгэл зүрхний үгэнд Придон баатар уярч
Сэвгүй андууд цурхирах нь дуунаас аялаг сонсдож
Хэмгүй их гаслан хэнхдэг цээж нь түхэлзэж
Хэлхээ нь тасарсан сувд сарнай цэцгийг дэвтээнэм

Энэ биеэ тамлаж өмсгөл юугаа үрж
Эр цэргийн хүрээнээ уйлаан майлаан дэгдэж
Хаан баатар Придон чанга гэгчээр цурхирч
«Хамаг сайн сурвалж нь хуурмаг хорвоо» гэнэм

Баатар хаан өчрүүн: «Холын анд түүнийг
Бахдах үг алга, нар шиг тэр гийгүүлж
Тэнгэрийн нарыг орлосон харах нүдний чимэг
Тэнэгэр амьдрал заяасан замыг заах одон

Хагацан салснаас хойш аж төрөх урагийгүй
Харамгүй үгийг огоорзол сэтгэл уужрах учиргүй
Салахыг чи тоохгүй ч би ер тэвчихгүй
Сайхан чамаас зигид жаргал бүр үзэхгүй

Гаслант дууны адил Придоны үг цууриатаж
Ганихарч өгнхий нь чагнан, хүмүүс нам гүм
Автандил баатрын дүрийг гэгээн тэнгэр тольдож
Амаргүй гунигийн нуурыг өтгөн сормуус далдалжээ.

Ордон шилтгээг чимсэн хотод тэд ороход
Ойр шадар түшмэд цөм бүрэн золгож
Илд, хуяг болсон дайчин эрс угтаж
Илт баяраа нуулгүй Артандилыг таалжээ.

Хааны ордонд олноор дэлгэр найр хийж
Хажуу талаар нь эгнэн зуун түшмэл суужээ
Магтаал үгээр хэлшгүй хоёр баатар зэрэцэн
Мана, молор тансаг бүхнээр чимжээ.

Хундага эгшээлгүй найрлаж их багагүй цэнгэж
Худ ургийн адил Автандилыг Придон дайлж
Хувин хувингаар дарс найрын ширээнд бялхнам
Хувьтай баатар Автандилыг үзэхийг цөм хүснэм

Наран шингэх үед найр сая дуусав
Нандигнаж Автандилын гоёлын өмсгөлийг гайхмаар
Мянган мянган зоосны өмсгөл зүүлтийг бахадмаар
Мяндас эрдэнэ тэргүүтнийг үгээр магтахад багадмаар

Автандил хэдий яаравч нилээд хоног саатан
Ан ав хийж тоглоом зугаа эхлээ.
Хол ойргүй араатан алдана гэхгүй намнаж
Хосгүй мэргэн харвахад нь цөмөөр гайхан магтав.

Баатар Придонд өчрүүн: «Чин үгий минь соёрх
Бас л би шаналан чамаас салах боллоо.
Хөөрхий түүнийг бодохоос яарахаас өөр аргагүй
Хөдөлж намайг мордоход хорих хэрэг байхгүй»

Асгарах нулмис бүрхэж хараа бүдгэрэх хэдий ч
Анд нөхрөө мартаж энд байж болшгүй.
Саатан удна гэдэг замын хүнд гай
Сайхан наран гүнжийг хаана үзсэнээ хэл»

Хаан харну хэлрүүн: Чамайг би саатуулахгүй.
Харийн мэсэнд шархалсан чи энд хоргодохгүй.
Тэнгэр тэтгэж одоод дайсныг товрог болгоорой!
Тэгэвч чамгүй шаналах зовлон хэрхэн гэтэлнэм?

Аян замд чи ханзтай явбал зохином
Ашгүй тус хүргэх итгэлт боолууд өгье
Ачаа бараа тээх унаа мал гаргая.
Алив иймгүй ганцаар сарнай цэцэг гутнам

Хааны итгэлт боолууд Автандилд бараа болохоор
Хатан болд зэвсэг, дуулга өргөж баринам
Алт эрдэнэ тэргүүтэй хөлөг сайн морь
Анд нөхөр Автандилд Придон бэлэг болгоном

Дээл, олбог тэргүүтнийг илжгэнд тэгнэж ачаад
Дээдийн их андаа Придон хаан үдэж
Хагацлын хүндийг бодож хайлахын ихээр хайлж
«Халаах наран одож, жавар хайрлаа» гэлээ


Автандил мордохыг сонсож хотын олон иргэн
Алт тансгийн наймаачин цөм цуглан гуньж
«Манай наран шингэв» гэж уйлан хайлан өчих нь
Маш их сүртэй, аянгын адил чимээтэй.

Анд нөхөд мордон тэнгисийн эрэгт түлж
Ариун наран дагина үзсэн газрыг олж
Хоёр баатар хайлан нулимсан нуур тогтоож
Хосгүй олзны хүүхнийг Придон дурсан өчив.

Хар царайт хоёр боол бүсгүйг завиар авчирсан.
Хас эрдэнэ туяарсан, хар нүдэт хатан явсан.
Тэдний зогссон газрыг хөлгийн хурдаар зорьтол
Тэнгэрийн шувуухай адил завьхан зугтан одсон

Зүдүүр зовлон амсаж хоёр баатар шаналан
Зүрхэнд гал дүрэлзэн дотно гэгчээр үнсэлдэн
Нэг эхийн хүүхэд шиг журамт ёсоор салж
Нэхэж баатар одон Придон хоцрон үлдэв





XVI

АВТАНДИЛ НЕСТААН ДАРЬЖААНЫГ ХАЙЖ ЖИНЧИДТЭЙ УЧИРСАН НЬ

Тунгалаг саран баатар хээр талыг зүсэж
Тунсаг амрагаа мөрөөдөн сэтгэл зүрх нь хөгжнөм.
«Энэ биесийн хооронд хорвоогийн гай үүрлэж
Эрхбиш шарх анагаагч нь чамд үлджээ» гэнэм

Хорноос гашуун дөл баатрын зүрхийг хайлуулж
Хорссон зүрх хатуурч ижлийг өөртөө эрнэм
Андын харцаас холдон гагцхүү сэтгэл шаналнам.
Алив үйлсийг цөмөөр эгшнээ бүтээвч хэцүүднэм

Тэнгисийн эргээр Автандил дөрвөн боолыг дагуулан
Тэнхрүүлэх рашаан Тариэльд энд тэндгүй хайж
Өдөржин шөнөжин тэнгисээс арвин нулимс урсган
Өвч хорвоог сүрэл мэт өчүүхэн төдийд тооцном

Эрэг барин тэнэж учирсан бүхнээс сураглаж
Элээх зуун өдөр агшин зуур өнгөрч
Наран гүнжийг хайсаар тэртээ эргийн дээгүүр
Нам гүм хэн алхах жинчин олныг үзэв.

Тэмээн жингийн цуваа тал дүүрэн жирнйж
Тэвдэж нэгнээ ноцирдож хүмүүсийн хараа гундаж
Мэхийн баатар ёсолбол жинчид зэргээр баясан
Мэнд усаа мэдэлцэн хэрэг зориггоо асүүв.

Ухаант Усам гэх жингийн даамал нэгнээр
Уламжлалт ёсоо дагаж уриалаг гэгч угтан
«Биднийг баясгагч дэнлүү амар сайн морилно уу?
Бишгүй гайгаа өчье, досшоо уруудан бууя гэв.

Автандилд тэрээр хэлрүүн: «Багдадын наймаачид билээ.
Архи дарс тэвчин магометыг шүтдэг билээ.
Далайн хааныг зорин бараагаа авч одном.
Давжхан наймаа гүйлгэдэггүй баян улс байнам.

Ийн явсаар эрэг дээр хүн хэвтэхийг олж
Илаар болгож авбал эв хавгүй ярьж
Тэр нэгнээс бид хэрэг учрыг соёрхвол
«Тэнгист аюул болж шархдан би аврагдав.

Хөлөг онгоцоор бид мисир орноос гарч
Хөл хөг ихтэй өнгийн бараатай явлаа.
Далайн дээрэмчид гэвч дайран биднийг хөнөөж
Даяар үхэхэд ганцаараа амьд гарсандаа гайхнам» гэв

Наран адил гэгээн арслан адил баатар минь
Намдаж гуньсан учир энэ, эргэвэл бөөн гарз.
Явсандаа хүрнэ гэвэл тулалдаж дадаагүй сөнөнөм.
Яах ч учраа олохгүй мэл гайхан зогсном.

Баатар харну өчрүүн: «Бэрхшээлд гутрах буруу
Байгаа орчлонгийн тавилан тэнгэрийн тааллыг гэтэлшгүй.
Гэмгүй цус чинь намайг бороо болон угааг!
Гэвч тэр дайсныг үнсэн говрог болгоном.

Өршөөл горьдох харцаар жинчин олон мишээж
«Өвтэгш зоригт баатар дээрэмчнээс бидэн шиг сүрдэхгүй
Төгс итгэлт таныг дагахдаа бид урамтай» гээд
Төхөөрч завиа зэхэн хөөсрөх долгио зүсэв.

Тэнгис гэдэг дөлгөөн, хөвж одоход бахтай
Тэмцэх тулаанаас ажрахгүй Автандил баатар хөөртэй
Тэнгэрт тултал гэнэт дээрэмчийн далбаа хийсэж
Тэвчих хүлцэнгүй завийг хөнөөх цамхаг хөөрөв

Бүрээ юүгээ үлээн дайсан хөл шуугиантай.
Бүүрлэсэн дээрэмчин сүргээс жинчид эмээж гунигтай
«Этгээд тэднээс бүү ай, эгшинд би хөнөөнө.
Эсвэл өнөө үхнэ» гэж Автандил тэдэнд өчив.



Цаг нь хэрэв болоогүй бол дайсан намайг дийлэхгүй.
Цааз хатуу тавилангийн илдийг хэн ч даахгүй.
Өндөр ч гэсэн цайз, ачтай ч гэсэн ах
Өнийн тавилан учрахад аварч чадахгүйг мэдэлтэй.

Дайн тулаан хийгээгүй наймаачин таануус аймхай
Дайлах сумнаас зайдхан нуугдаж байвал зохистой
Арслан зоригт миний дайран хөнөөхийг харагтун
Араатан цусан далай урсаж орхихыг ажигтун,

Хуяг дуулгаа өмсөөд арслан адил дүүлэн
Хувьдаа түшиг бодож төмөр муна авав.
Хөлөг онгоцны толгойд баатраар харуул шиг зогсон
Хөвчин олноо гайхуулж дайсныг хиар цохив.

Тэнгис доргитол орилолдон наймаачны хөлөгтэй тулгаран
Тэрслүү хар дээрэмчид онгоц юугий нь гоходвол
Агуу зоригт баатар хөлгийн толгойд зогссоор
Аваргуу чадал заан мунаар шатыг тасдав.

Автандил цамхгийг эвдвэл хөлөг бүтнээр үлдэж
Азгүй явдал учран дээрэмчин эмээн зугтвал
Амжиж зайлах завгүй баатар тэднийг нэхэн
Амь гарах учиргүй гавшгай гэгч шидлэв.

Янгирын сүрэг адилаар дайсныг хайргүй сөнөөж
Яралзах долгионд шидлэн завь онгоц мөргүүлж
Найм, есөөр нь нийлүүлж нааш нь түлхэлж
Навсайтал овоорсон хүүрэн дунд амьтай голтой нь нуугдав

Санасан ёсоороо дайсныг үнсэн товрог болгож
Сандарч мэгдсэн дээрэмчин тэнгэрийн нэрээр гуйвал
Алхаж ядан салгалах шархтан бүхнийг өршөөв.
Айсныг өрөвдөнө гэдэг номын сургаал энэ буюу.

Хүн гэдэг хүчээрээ сүр бадруулж таарахгүй
Хүчит тэнгэр эс таалбал хар хүчээр барахгүй.
Очийн төдий гал ч ойг шатаах чадалтай.
Онгон тэнгэр өршөөвөл бороохой ч барьсан ялалттай.

Дайсны хөлгөөс Автандил эрдэнэ баялаг олзолж
Дагасан жинчдээ дуудан онгоц цөмийг эгнүүлж
Даамал Усам Автандилыг харан харан баярлаж
Дахин дахин магтан тал найр өгөв.



Зэрэг зэргээр баатрыг дээдлэнхэн магтавч
Зэмгүй гэгээн алдры нь өгүүлж ер баршгүй.
«Бурхан тэнгэр өршөөж наран гэрлээр гийгүүлж
Бузар харанхуй тонилов» гэж ам амандаа хүүрнэжээ.

Хацар нүүр төдий биш хөл гары нь хүртэл
Харамгүй наймаачид таалж үзэстэлэнт баатрыг биширч
Харах зурамд мэргэдийн ой ухаан самуурч
Хар гамшгаас салгав гэж зоригт эрийг тахижээ.

Автандил баатар өчрүүн: «Дээдийн дээд эзэн минь
Асар тэнгэрийн тэртээгээс орчлон дахиныг залнам.
Хаяа хөшгөө нээвч далдын хүчин зарж
Хамаг идэт гайхамшгийг мэргэд цөм хүртнэм.

Хорвоогийн өчүүхэн амьтдыг тэнгэр хичнээн тэтгэнэм.
Хумхийн тоос шиг ганцаар би юу базааж бүтээнэм.
Этгээд дайсныг дарж чадах бүхнээр тусаллаа.
Элдэв бараа дүүрэн онгоц та нарын олз.

Эр цэргийн дайчин хүнд тулаанд дийлж
Эрхэм андаас шалгарч алдар нэрээ дуурсгаж
Сайн үгийг дуулбал шархтай ч гэсэн чимэгтэй.
Санаа сэтгэл уужим бие хөнгөн урамтай.

Балагт дээрэмчний олзыг тэр дор нь нэгжвэл
Багтаана гэхэд бэрхтэй, үнэ цэнэ арвитай.
Эд агуурсыг нь наймаачид олзондоо даруй нийлүүлж
Эвдэлж онгоцы нь сүйтгээд үнс болгон хийсгэжээ.

Наймаачин олны шийдвэр жингийн даамал хэлрүүн:
«Найдварт чиний ивгээлээр гулчгар бид аврагдав.
Энэ юм цөмөөр чинийхийг тэнгэр мэднэм.
Эрхбиш өөрөө бэлэглэхэд бидний санаа амарнам

Хариу баатар өчрүүн: «Аяа би хэлэв биш үү
Хайрхан тэнгэр эзэн гунигий чинь мэдээд туслав биш үү.
Эрхт тэнгэр аварчээ, намайг өргөх учиргүй.
Энэ бие, эр морь, өөр юм хэрэггүй.

Эрдэнэ баялаг төдийхөнд сэтгэл хэрэв ханадаг бол
Эрхбиш гэрээс холдохгүй алттан эдэлж болох сон.
Та нарын олзоор яана, аян замын хүн байна.
Таарч нэгхэн аварсан нь баатар эрийн зүй байна.




Тулалдаанд олсон олз цөмийг та нар ав.
Тухайлж миний шунах өчүүхэн ч юм алга.
Тусгайлж танаас гуйх ганцхан л зүйл байна.
Туулах замд нууцгайхан хүрэх нэгэн газар байна.

Баатар гэхээ больж наймаачин гэж явна.
Бараалхаж мэндлэх үед чинь би даамал болно.
Наймаачин адил хувцаслаж наймаа панз үсэргэнэ.
Нарийн энэ нууцыг ах дүү ёсоор сахиарай.

Гэгээн наран баатарт хүчин зүтгэлгүй яах вэ?
Гэсэн ч бидний хүссэнийг та онож хэлчихлээ.
Таны аяыг дагана» гэж Усам даамал өчвөл.
Тал өгч жинчид сэтгэл санаа уужрав.

Аюул гамшиг дүүрэн эргийг яаран орхиж
Аз болоход тэнгэр намуун тавиун ажээ.
Тансаг зоригт баатрыг элдвээр дээдлэн биширч
Танан шүдийн нь адил эрдэнэ сувд барьжээ.





XLII

АВТАНДИЛ, ГУЛАНШАРОД ХҮРЭЛЦЭН ИРСЭН НЬ

Харах нүдний чимэг Автандил тэнгис гэтэлж
Хаа хол хүртэл сүндэрлэсэн хот үзэв.
Өнгийн цэцэг алаглаж нүдний хараа булаасан
Өтөөмөр үзэсгэлэнт орныг магтах үг дутнам.

Цэцгийн хүрээлэн тушаа завь юугаа орхиж
Цэгцхэн наймаач өмсгөлтэй Автандил суудал эзэлж
Эд агуурс буулгахыг зарц барлагт тушааж
Энэ биеэ нууцлан наймаа панз хийжээ.

Тэдний буусан газар удалгүй цэцэглэгч ирэн
Тэнцэх, юмгүй гвад сэтгэл өгөх мэт балмагдав.
Хашир түшмэл адил Автандил түүнийг ээрч
Хаанах газрын улс-вэ, эзэн хаан чинь хэн бэ?»

Үнэтэй бараа юу байна? Ямар нь бас хямд байна?
Үзэж мэдсэн бүхнээ тов годорхой өч» гэв.
Харуу цэцэглэгч өчрүүн: «Наран адил танд
Хамаг үнэнийг тоочъё надаа итгэж болном

Далайн их гүрнийг арван сар явавч туулшгүй
Даяар орны алдар чимэг нь Гуланшаро хот юм.
Хэн ч гэсэн эд агуурс энд авчрах эрхтэй.
Хэмжээгүй дээд эзэн Мелик Сурхава хаантай.

Эцэж туйлдсан настан энд ирэхдээ залууждаг.
Элдэв дуу, бүжиг наргианаар өдөр өнгөрөөдөг.
Сарнай цэцэг гандахгүй жилийн турш ургадаг.
Сааргүй их баялагт харийнхан ухаан мансуурдаг.

Хөлтэй баян наймаачин олз омог ихтэй.
Хөндлөн гулд панзалж хожих алдах олонтой.
Гарцаагүй ядуу хүн ч ганцхан сард тэнхэрдэг
Гар хоосон хэн ч эд агуурсаар баяждаг.

Наймаачны ахлагч Усений цэцэглэгч билээ би.
Наад цэцгийн хүрээлэн минь түүний эзэмшил билээ.
Худалдагч олонтой учирдаг байдлы нь би өчье.
Хураасан тансаг эдийг эзэн эхэлж үздэг.

Аль ч газрын наймаач түүнтэй учирч танилцаад
Алив эд уурсаа анхлан нарийн үзүүлдэг
Үнэтэй бүгдий нь авч хөрөнгө зоорь зузаараад
Үнэндээ хүссэн бүхний нь харамгүй тэрээр зардаг.

Тан шиг хүндэт хүн манайд тавладаг жамтай.
Тансаг ард гаргахыг эзэнтэн тушаадаг зантай.
Одоо тэрээр эзгүй биеэр угтаж чадсангүй.
Орж гарсан зочныг өөрөө л урин залдаг сан.

Гэргий Фатьма—хатан нь гэртээ одоо байнам.
Гэмгүй их зочирхог, наргиж хөөрөх дуртай.
Сайхь таныг мэдвэл дотночлон урьж
Сар мандахаас янар ордонд морилох хувьтай.

Хариу баатар өчрүүн: «Хэн хүссэн нь ирэг.
Хар хөлсөө цувуулж цэцэглэгч гүйн одлоо.
«Мандах нараас гуа нэгэн зочин иржээ» гэж
Мань нэцэглэгч Фатьмад яаран тэвдэн эллээ»

Аяа тэр наймаачин жингийн даамал юм гэнэ.
Арван тавны сар шиг цэмцгэр төрсөн эр юм.
Улаан өмсгөл дотроос алтан цогцос гэрэлтнэм
Уулзаж надаас тэрээр юмны ханин асуулаа.

Элч зарлагаа хатан эрхэм баатарт явуулжээ.
Эд уурс буулган агуулах сав базаажээ.
Арслан барсын шинж эр биенд нь шингэсэн
Ариун болор баатар урьсан ёсоор морилжээ.

Хотынхон цөм цуглаж хөл үймээн ихтэй.
Хоромхон ч нэг харахсан гэж шивнэлдэн ярих нь бахтай.
Эрэлхэг баатрыг магтан ухаан алдах нь гайтай.
Эмс эрээ голж эгдүүцэн байх нь түйтэй.


Эзэн хатан баярлаж зочноо биеэр амдан.
Энх тунхы нь соёрхож элбэг сайн утгжээ.
Хамгаар ордноо морилж баярын магнай тэнийн
Хатан баахан шохоорхож сэтгэл ихэд үймжээ.

Хатан Фатма хижээлхэн ч сэтгэл санаа нь ануухан.
Ханагар талбиун цогцостой, харах нүдэнд дулаахан.
Хундага дарс балгаад дуулж бүжих нь тухтайхан.
Худалдаачны танхил гэргий хөл хөгжөөнд дуртайхан.

Сайн санааны үүднээс шөнөжин Фатма дайлж
Сайхь бэлгээ баатар хатанд баривал таалж
Унтаршгүй нэг дөл хатны цээжнээ дүрэлзэж
Уригдаж зочлуулж ханасан баатар амрахаа оджээ.

Өглөө болоход баатар эд уурсаа задалж
Өнгөтэй өөдтэй болгоныг хатны өмнө дэлгэж
«Наймаагаа сайн хийгээрэй, нууцыг бүү нээ гэж
Найдаж дагуулсан жинчиддээ үнэн үгээ» өчжээ.

Зодог адил хөнгөн наймаачны хувцас өмсөн
Зоригт баатартай Фатма учран яриа дэлгэжээ.
Раминаас салах гэдэг Вист үхлийн адил
Алдарт баатарт Фатма амь дүйн дасжээ






XLIII

ФАТЬМА, АВТАНДИЛД СЭТГЭЛТЭЙ БОЛСОН НЬ

Хэдий бэрх авч эмсээс хөндий байлтай.
Хэрэв нэг наалдвал холдоход хэцүү байртай.
Эгшин зуур хувирч хаях ч байдаг бололтой.
Элдэв нууцыг ер нь итгэж хэлэхэд осолтой.

Автандилыг таалж Фатъма сэтгэлээ өгч гэнэ.
Анхил дүрий нь харж зүрх нь оргин догдолж гэнэ.
Нууя гэж бодовч тэвчээр ер хүрдэггүй гэнэ.
Нууран нулимс урсган авралыг эрэх болж гэнэ.

Хайр сэтгэлээ илчилбэл үүрд орхичих бол уу?
Хамаг бүхнээ нуучихвал сэтгэлдээ уусчих бол уу?
Үхэх, сэхэх хамаагүй, хэлж байгаад дүүрье.
Үнэнээ хэлээгүй шаналагчийг оточ хэрхэн анагаанам.



XLI V

АВТАНДИЛД, ФАТЬМА ЯНАГ СЭТГЭЛИЙН ЗАХИДАЛ БИЧСЭН НЬ

Нулимс урсган байж Автандилд захиа бичиж гэнэ
 Нууцгай амрагийн зовлонг хайрын сэтгэлтэн мэддэг гэнэ.
 Хэн хүний зүрхийг тэр захидал догдлуулж гэнэ.
 Хэт хайрын захиаг нандигнаж явах нь зүйтэй гэнэ

Наран дэнлүү чамайг дээд тэнгэр заяажээ-
 Насанд чамаас хагацаж шаналж явах ч сайхан.
 Хажууд чинь байвал гал адил төөнөнө.
 Харагдах ч үгүй байвал учирч уулзахыг горьдоно.

Оюун санаа өнчирч бүхнээр чамайг таална.
 Онц л гуагийн өмнө амьд бүхэн гандана.
 Алтан гургалдай шунамаар тансаг сарнай чи юм.
 Амжиж нар чи ээхгүй бол хатаж орхих нь би юм.

Янагийн захидал илгээхдээ айсныг тэнгэр гэрчилнэ
 Ямар ч аргаа алдсан ядуу би чинь яах юм?
 Алаг зүрхийг зүү дандаа шивээд байх юм бол
 Амьд яаж явах вэ? Чи минь чамайг авраач!

Энэрэл гуйсан захидалд эчнээ хариу авахгүй бол
Элэг зүрх шаналавч ертөнцөөс өөрөө явахгүй.
Сэхэх, мөхөх гэдэг сэтгэлийн хоёр үзүүр хойно
Сэтгэн дотроо мөрөөдөж үхлээ хүлээх нь аргагүй.

Хатан захидлаа илгээж баатар хүлээн аваад
Хайрт эгчийн захидал шиг тайван гэгч уншаад
Хэнд сэтгэлээ өгснийг тэр ер мэдсэнгүй
Хэрхэн зовлонт надтай. түүнийг зүйрлэх билээ.

Хэрээ, сарнай хоёр өнгө нь ядаж адилгүй.
Хэлэмгий алтан гургалдай ч сарнайд дуулах чадалгүй.
Гамшиг бүхний уршиг үүнд байдаг ажээ.
Гайтай энэ Фатьма юу донгосон бичнэ вэ?

Дотроо ийн зэмлэвч дараа нь бас бодруун:
«Тохиолдсон үйлийн эрхээр амрагаа эрэн бэдрэхэд
Харь хүний нутагт хэн над туслах вэ?
Хавьтаж ойртсон бүхнийг түшиж явбал дээр биш үү.

Энэ нутгийн эзэн хойно бүсгүй бүхнийг мэднэ.
Энд тэндхийн хүмүүсээс элдэв сонин дуулна.
Ихэрхэж туних явдалгүй аяг нь одоо дагая.
Эелдэг дотно байхад чадвал тэр тусална.

Хэрэв эмс хайрлавал бүх сэтгэлээ өгчихдөг
Хэн түүнийг хаячихвал хайр найргүй зүхчихдэг
Ойртож хавьтсан эрд нууц бүхнээ нээчихдэг.
Одоо түүнийг дагая зам ер нь дөхчих дөг.

Хүний заяа хүрвэл бүгд таатай өнгөрнө.
Хүссэн нэг нь олддоггүй, олдсон нэг нь тэнцдэггүй.
Хорвоо дэлхий гэдэг чинь эрээн бараан болохоороо
Хумхийн тоос шиг бужигнаж үнэн гэгч нь байдаггүй.





XLV

АВТАНДИЛ ФАТЬМАД ЗАХИДАЛ
ИЛГЭЭСЭН НЬ

Автандил Фатьмад бичрүүн: «Намайг магтсан захидлы чинь
Авч уншаад миний сэтгэл зүрх шатлаа.
Ариун сэтгэл хадгалж хоёулаа хамтран суухсан
Ашдын жаргал эдэлж үнэн хайраа амсахсан.

Хариуг үзээд Фатьма хэлшгүй их баярлаж
«Хагацлын зовлонд ханажээ. Ханилан одоо сууя.
Ганц биеэр хүлээе, чи минь надаа ир
Гарцаагүй хурдлах хэрэгтэй. шөнөжин жаргалд умбая» гэв

Гэгээ тасрах үеэр баатар яаран одвол
Гэнэт түүний өөдөөс хатны элч иржээ.
«Дурласан хоёр зүрхийг өнөөдөр нийлүүлж болохгүй» гэхэд
Дурамжхан баатар зорьсондоо Фатьмад хүрэлцэн очжээ

Урьж дуудсан болохоор эргэж баатар буцсангүй.
Учирлаж гуйсан хатныд шуудхан орохоос няцсангүй
Гуньж зовсон Фатьма түүний ороход хиртхийв.
Гуйвж гайхсан ч юмгүй сэтгэлээ баатар барив.

Зэрэгцэж хоёул суугаад үнсэн таалж байтал
Зэгсэн чийрэг биетэй, булиахан баатар орж ирж
Зэр зэмсэг агссан боол бас дагаж
Зэрэвхийн Автандил босож замыг хад шиг боов.



Хатан Фатьма айж бүх бие нь дагжихад
Хамаг жаргалд нь атаархаж ирсэн баатар хэлрүүн:
«Цэцгээс цэцэг дамжиж хатагтай чи жаргаарай
Цэнгэлийн богиныг амсаж хариуг маргааш аваарай»

Шалиг эм чи нэр хүндий минь гутаавч
Шанд нь би чамаас цусаар өшөө авна.
Багачуул хүүхэд цөмийг хүйс тэмтэрч орхином.
Бардам хэлснээ хийхгүй бол би өөрөө мөхнөм.

Сахлаа имрээд баатар хилэгнэнхэн одоход
Сайхан хатан хайлж нүүр амаа ноцов.
Үер адил нулимс хоёр нүднээс урсаж
Үхвэл зохих амьтан гэж өөрийгөө тэр зүхэв.

Эр нөхөр, үрсээ эдүгээ би үрлээ
Эрхэм баялгаа алдаж гуйланч би боллоо.
Асран тэтгэсэн ачтан минь, нөхдөө яаж харна би.
Алиа шалигаас болж гай би тарилаа.

Чухам ямар учиртайг Автандил гайхаад баршгүй
Чухал юу болоо вэ? Яагаад чи гунинам.
«Хэний хэн гэгч яагаад чамайг занана вэ?
Хэрж хаашаа одсоныг нуулгүй чи өч» гэв

Уйлсаар байгаад баатар минь, ухаан балартаж орхижээ.
Учирлаж тавьсан асуултад зөв хариулах нь өнгөрчээ.
Сайхан үрсээс салж сарнай цөм гутна.
Сааргүй чамайг мөрөөдөж сэтгэл бас хатна.

Хоёргүй нууцыг задалдаг булай балар ухаантай
Ховч хар новшийг цээрлүүлж байвал зохилтой.
Хайрлаж чи аварвал бүхнийг чамд хэлэлтэй.
Хар амиа бодвол тус болох нь барагтай.

Одоо чиний өмнө хоёр л зам байна даа.
Олны тусыг бодвол түүнийг алах хэрэгтэй.
Энэ шөнөөс хэтрэлгүй нууцаар албал зохино доо.
Эргэж чамайг ирэхэд учрыг тоочих болно доо.

Эсвэл чи өнөө шөнө унаа унашаа базаагаад
Эх нутгаас минь гарч алсад одвол зохистой.
Хамаг гамшгийг харан байж биднийг чи хаяхгүй биз.
Хар өглөөгүүр тэр ирж намайг барихыг хүсэхгүй биз.

Энэ үгийг сонсохдоо баатрын сэтгэл догдолж
Энгүй гуагаа илтгэж эгцлэн босож зогсоод
«Эмэ хүүхдийг элэг барих мунхаг балай амьтан
Эрдэнэт хүн төрөлтөнд байх ёсгүй» гэлээ

Зэр зэвсгээ авч замчин хүн дагуулж
«Зэрэгцэн бараа болох туслагч над хэрэггүй.
Харгалдах тэр баатар хаанд ч үгүй, гуянд ч үгүй
Хамгийг ирээд тоочно, сэтгэлээ амраа» гэлээ

Хатан Фатьма боолоо замчин болгож явуулаад
Хатуу болгоомж хэрэгтэй, туслах хүчин ав.
Тэр нэгнийг сөнөөвөл, бөгжий минь авчраарай
Тэнгэр адил шүтэж чамд мөргөнөм» гэлээ.

Үзэмж гуагаа гайхуулж бүх хотыг туулан
Үйлзэх мананд торойх чулуун байшин үзэв
Давхар давхар тагттай, түмэн эрдэнэ чимэгтэй
Далан давхар хэрэмтэй өндөр ордон харав.

Наран баатрын хамт замчин алсыг туулаад
Нам зөөлнөөр хэлрүүн: «Эрсэн орд чинь энэ
Дор дээргүй давхар дээвэр байгааг хараарай.
Доод танхимд тэрээр сэрүүн эсэхийг мэдээрэй.

Орох үүдний тушаа хоёр манаач хэвтэхэд
Ойртож сэмхэн очоод баатар тэднийг багалзуурдав.
Хооронд нь духдуулан хайргүй мөргөлдүүлж байгаад
Хоёулыг хөнөөж амь насы нь тонилгов.

Уур омог нь бадарсан эзэн сэрүүн хажуулахад
Урьд нь гэнэт Автандил шидтэн адил очив.
Мэдсэн сэн бол сайн ч, хэрхэн алсны нь дуулсангүй
Мэсийн ирийг амтлуулсан нь газарт шаасан гэнэ билээ


Харахад дөлгөөн боловч тулаанд араатан шинжтэй
Хатан баатар Автандил бөгжтэй хурууг огтлоод
Хүүрийг усанд шидэв, хүрз зээтүү ч орсонгүй.
Хүн оршуулна гэж авс булш ч эрсэнгүй.

Энэ хэрэг өнгөрч, яриа шүүгнэн гарсангүй.
Эрэлхэг баатар одоодоо элдэв юм бодсонгүй.
Учирсан энэ явдал ухаанд ер багташгүй.
Урьдын замаа дагасан хоёр сүүдэр хагацашгүй.

Арслан адил сүртэй наран баатар эгж
Алагдсан хүн гэдэг маргаашийг үзэх ёсгүй
Алж хөнөөсөн гэдгийг танай боол гэрчилнэ
Адын цустай хутга, бөгжтэй хуруу энэ байна.

Ямар хэргээр зовно вэ? Яагаад тэр зүхнэ вэ?
Явдал учрыг өчиж, санаа амрааж өгөөч
Хариу хатан хэлрүүн: Чамд би тэнцэшгүй.
Хайрын гал оволзож зүрхний шарх анилаа.

Эр нөхөр үр хүүхэд, бид цөм аврагдлаа.
Энэ бүхний учир магтах үг алга.
Итгэл эвдсэн дайсныг хатуу цаазлах хувьтай.
Ингээд миний өчихийг анхаарч сонсвол зүйтэй.





XLVI

НЕСТААН-ДАРЬЖААНЫ ХУВЬ ЗОХИОЛЫН
ТУХАЙ ФАТЬМА ӨГҮҮЛСЭН НЬ

Манай энэ хотод хаврын баяр болдог.
Маймаачин олон саатаж зугаа цэнгэл хийдэг.
Баярын гоёл өмсөж үзэмж гуагаа илтгэдэг.
Баатар хааны ордонд төрийн жагсаал жигдэрдэг.

Заншил ёсоор наймаачид ордонд бэлэг өргөдөг
За тэгээд хариуд нь хаан бэлэг хайрладаг
Чавхдаст ятгын ая арван хоног эгшиглэдэг
Чансаат олноор уралдаж дуулж хөгжиж наргидаг

Баян наймаачдыг ордонд манай нөхөр аваачдаг
Бас гэргийчүүлий нь би дагуулж очдог.
Хааны хатанд бараалхаж бэлэг сэлэг болдог.
Ханатал наргиж байгаад гэрийн зүг буцдаг.

Нэгэн удаа бид тэгж наргиж билээ.
Нээрэн үлэмж бэлгээр эзний ордон дүүрлээ
Сэвгүй сайхан найраа үеийнхэнтэйгээ хийлээ
Сэтгэл гэдэг тавтай гэртээ би эглээ.

Үдэш болохын хирд цэцгийн хүрээлэнд очиж
Үеийн олон хатнаа заншил ёсоор дайллаа.
Ая хөгтэй дууг дуучин олон эгшиглэж
Ай даа би ч гэсэн бишгүй л наргиж байлаа.



Тэнгисийн мандал дээгүүр үзэмжит тагт хөөрч
Тэр гуа сайханд бид цөм очиж
Намайг олноор тойрч биднийг зүйлээр зочилж
Наргиандаа бид мансуурч жаргал эдлэн суулаа.

Хэзээд хөгжүүн бигээр наймаачдын гэргий дайлж
Хэмжээгүй цэнгэж явтал тэнхээ гэнэт барагдлаа.
Үүнийг мэдээд зочид цөм л гарч одлоо.
Үдшийн харанхуй адил зовлон намайг ороолоо

Эрүүл агаар амьсгалж зовлонгоо нимгэлэх санаатай
Эргэн тойрныг ажиж гэгээвчээ би нээлээ.
Алсад тэнгисийн давалгаанд нэг юм торолзоно.
Араатан шувуу ч юм уу, бөөн бараа бүрэлзэнэ.

Ойртоод ирэхий нь ажвал осолгүй л нэг завь
Онхийн хар царайтай хоёр хүн явнам.
Уснаас хоёул гараад манайд бүр ойртлоо
Учры нь олохгүй болохоор дэмий л би гайхлаа

Сэм сэмээр хоёул цэцэрлэгт завиа орууллаа.
Сэрэмжилж байгаа бололтой ийш тийшээ харуулдлаа.
Айхаар юм тэд олж ер мэдсэнгүй.
Амьсгал даран даран ажихаа би больсонгүй.

Эрэг дээр завинаас нэгэн бүсгүй гарах нь
Эгнүүлж жиших аргагүй тийм анхил гуа юм.
Хар малгай өмсөж ногоон нөмрөг хэдэрч
Хашийн арнун царай нь нартай гагцхүү дүйцмээр.

Эргэж бүсгүй харахад сарны туяа тусаж
Эрхэмсэг цогцсын нь гэрэл үүл даван туяарч
Харах аргагүй гялбаж хоёр нүд анилзаж
Харин өөрөө мэдэлгүй хаалгаа түгжсэн байлаа.

Харуулын дөрвөн боолд би ийн хэлрүүн:
«Хаш эрдэнэ дагиныг энэтхэгчүүд олзолсон байнам.
Анир чимээ гаргалгүй нам гүмхэн очигтун.
Алт мөнгө хайлалгүй, худалдвал түүнийг авагтун.

Учир хэлээ өгөхгүй бол хүчээр түүнийг булаагтун.
Уг хэргээс айлгүй саран дагиныг авчрагтун.
Өдтэй юм шиг хөнгөн, боолын явах нь аниргүй.
Өнгө бараан царайтан хилэнтэй гэгч нь аргагүй



Хэлэлцэж тохирохгүй болохоор нь тагтан дээрээс хашгирч
«Хэмх цохивол таарна» гэхэд дайсны толгой цавчив.
Хүүрийг усанд шидчихээд эрдэнэ адил нандигнан
Хүүхнийг нааш нь авчрахад би тосон учрав

Эрдэнэ гуа цогцос, элбэг дөлгөөн ааштай
Эгээ л наран адил тийм гуа бүсгүйсэн.
Харвах туяанд нь өртвөл дээдийн жаргал мөн сөн.
Хамгийн дээд ухаантан ч магтаж ер барахгүй сэн.

Хацар нүүрээ ноцон Фатьма дуугүй болоход
Халуун нулимс урсган Автандил гунигт умбав.
Хэн хэнээ умартаж хоёул ухаан манарч
Хэт нулимс урсаж гол горхи халгив.

Уухилж ханаад баатар «ярьж дуусга» гэвэл
Урьдаас нь тэр өчрүүн «Эгч дүү болохыг хүсэж
Идэр эрийн адил анхил цогцсы нь үнсэн
Исар дээр өргөж тавиад дэргэд нь зогсож билээ»

Нарны гэнээн гэрэл чи хаанаас туяаран ирэв
Найгүй хар эрчүүдийн гарт яагаад оров?
Элдвээр би аргадавч ганц ч үг хэлдэггүй
Энэлэн хайлах нулимс нь булаг болсон ч больдоггүй.

Асуух үг олширвол асгарах нулимс ихсэж
Алив гунигт автан эхэр татан уухилж
Нарийн шимийн хур шиг сувдан хэлхээ цуврахад
Над ч гэсэн зовлонтой өөрийн мэдэлгүй хайлав.

Эгшнээ нэг сэргэж «Ээжээс илүү ачтан минь
Эрхбиш миний ярих нь гунигт нэгэн үлгэр
Зол заяаны эрхээр тэнэж яваа амьтан
Зорьсон үйлсээ илчилбэл нэг ёсны нүгэл» гэв

Хэрэг зоригий нь дуулах гэж яаран их оролдвол
Хэт дээ дэмий зовооно гэж би дотроо бодлоо.
Хэлж байгаа үгий нь болгоож хэрэв үзвэл
Хэлэлцэж хөөрөх цаг болоогүйгий нь мэдлээ.

Ариуь тансаг биеий нь алгаараа би илэвч
Алтан нарны гэрлийг хэрхэн хаах билээ л?
Хүнд хөшиг сөхөж түүний цаана нуувал
Хүй их нулимс даваад болохоо байлаа л.

Хөвчийн мод шиг гуалиг гэгээн тэр бүсгүйг
Хөөрхийлж би энэрээд тусгай орон бэлдлээ.
Амьтан хүнээс нууцгай цөжжлонхон асарч
Анир чимээ гаргалгүй сэмхэн уулзах боллоо.

Хэрхэн зүдэрч байсны нь хэлэх арга алга.
Яаж гутарч явсны нь ярих арга алга.
Өдөр шөнө ялгаагүй уйлан хайлан суудаг сан.
Өнчирч түүнээс салаад миний зовсон бэрхсэн.

Орж очоод харахад нулимсан дундаа суудаг сан.
Онцгой тэр нууранд нь сувдан хэлхээ унадаг сан.
Зүү адил хурц сормуус жирийгээд хөөрхөнсэн.
Зүйлийн эрдэнэ адил шүд нь яралзаад сайхан сан.

Учир явдал юу, яагаад ийн зовсныг
Урсах нулимс дунд нь би ер сураагүй.
Буянт хүн гэхэд тэвчиж тэсэх байтугай
Бул хар чулуу ч ийм зовлон дамааргүй.

Ганган тансаг хивс, хөнжил ер хэрэггүй.
Ганц хар өмсгөл хучлага дэвсгэр болно.
Хоёр булбарай гар нь хажуулах дэр болно.
Хоол унд гэвэл урсах нулимс хүрнэ

Нэг сонин гэвэл өмсгөл зүүлт нь гайхмаар.
Нээрэн ихийг үзсэн ч хаанаас ч эс олмоор.
Харж үзэхэд зөөлөн ч гангаас бөх баймаар.
Харин түүнийг илтгэхэд үг хэл дутмаар

Наран дагина манайд бишгүй л их удсан.
Найдаж итгэхгүй болохоороо нөхрөөсөө ч нуусан.
Хэрэв мэдвэл тэр хаантанд айлдаж мэднэ.
Хэт бодолд дарагдан хэлэхгүй л байхаар шийдсэн.

Хэлэхгүй байна гэхэд яавал тэгээд зохих вэ?
Хэрхэн энэ бүсгүйд энэрэл тус хүргэх вэ?
Хамгаас гуа бүсгүйг нуугаад байдаг хэрэг үү?
Хар хүн минь мэдчихвэл надаа ёстой үхэл шүү.

Ганцаараа би яахав дээ алдаж онож мэднэ.
Гайгүй байлгүй Усен, хэлэн байж шийдые.
Хэрхэвч ам нээхгүй гэж надаа тэр амлавал
Хэлж баталсан үгнээсээ эгээ ч нэг буцахгүй биз.



Эр нөхөртөө очиж би ийн өчрүүн:
Эрхэм чухлыг хэлье. Эхлээд гэвч ам өг
Хэлсэн үгэндээ хүрч хэзээ ч нууцыг бүү нээ»
«Хэрхэвч нууцыг задлахгүй, хэнд ч би хэлэхгүй».

Хадам ураг, харь дайсан, хашир өвгөд
Хавтай залуу. идтэй баатар хэн ч үл сонсмуу» гэж
Хань нөхрөө өчихөд «асарт хоёул оръё» хэмээн
Хамаг нууцаа дэлгэж наран дагиныг заалаа.

Хатны өрөөнд ортол эр нөхөр мансуурч
Харах нүд нь гялбаж ой ухаан нь мангуурч
Хэн гэгч нь энэ вэ? Хорвоогийн хүн лав биш
Хэрэв мөн байдаг бол нас буян нимгэрэг» гэлээ

Хариу би хэлрүүн: «Учрыг би мэдэхгүй
Хаанахын хэн болохыг ухааж ер чадахгүй»
Нөхөр бид хоёр хөөрхий бүсгүйг аргадаж
Нөр их зовлонд яагаад унасныг асуув.

Наранд туссан сүүдрийг арилгая гэж бодохдоо
Найгүй тунгалаг гэгээгий нь үзье гэж сэдэхдээ
Навч нь гандсан цэцгийг сэргээе гэж санахдаа
Нарийн учрыг асуувч ам ер нээсэнгүй.

Ухаарсан эсэхийг харц нь ердөө огт илтгэлгүй
Уран сувдан шүд нь уруулаас бүр цухуйлгүй
Намираа цэцгийн адил хар гэзэг нь унжина.
Нар жаргатаг сахивч үг хэлгүй өнжинө.

Аргадаад аргадаад нэмэргүй дэмий үгээ барна.
Алив хорвоод гомдох мэт нулимс юугаа үрнэ.
Эм барын адил заримдаа сүртэй барайна
Энэ биений минь орхиоч» гэх эцсийн хариу ирнэ.

Эр бид хоёр эн зэрэгцэн суугаад
Энэ хорвоогийн нүглээ эрэгцүүлж цөмийг хэлхээд
Өчүүхэн тайвшрах төдийд нь алим жимс баривал
Өдөөс авах байтугай гараа ч үл хөдөлгөнө.

Хань нөхөр хэлрүүн: «Өнөөгийн зовлон мартуулбал
Хавьтаж ойртох аргагүй гэгээн наран гаалмаар
Энэ дагиныг гомтговол эцэст нь өөрөө зовно.
Эрхэмлэж хайрлах үр минь ч халин одвол зохино.



Харж харж одохдоо хөөрхийлэн шүүрс алдаж
Хавьтаж нэг учрахдаа баахан баясаж,
Торонд орсон адил зүрх сэггэл тэмүүлж
Тоогүй их дасаж учралыг өдөржин мөрөөднө.

Ид нойсох цагаар эр маань нэг ирж
«Их дээдэст бахархалгүй бас овоо удав.
Хэрэв чи зөвшөөрвөл бэлэг барин очъё гэвэл
Хэлэх үг чинь зарлиг» гэж өөдөөс нь би өчив.

Эрдэнэ сувд тэргүүтэн бэлэг сэлт зэхэж
Эзэн хааныд одоход нь эрдээ би хэлрүүн:
Архи дарсанд халаад нууцаа чи дэлгүүзэй гэхэд
Амь насаа барьж ам тангаргаа түүз өгөв

Ордон дүүрэн оволзсон найранд Усен оржээ.
Олон жилийн зузаан эзэнтэн таалан соёрхжээ
Эрхэм бэлгийг нь тогтоож эгнүүлж дэргэдээ суулгажээ.
Энхрий мутраа хайрлаж, халсан наймаачид байцгаажээ

Хаантан баахан тогтоож халсан гэдэг нь жигтэйхэн
Хаш эрдэнэ сэлтийг надаа үргэлж барина.
Ам тангараг юу билээ, аль хэдийн умартаж
Адгийн гэнэг илжиг алтыг ч гэсэн сэгсэрнэ.

Гэнэг дээрээ согтсон Усенийг хаан магтана.
Тээж ирсэн бэлгийн нандин сайхныг бахадна.
Хаш эрдэнэ сэлтийг надаа үргэлж барина.
Хариу барья гэхэд үнэндээ бэл дутна.

Өөдөөс нь Усен эчрүүн: Их эзэнд галархнам.
Өндөр тэнгэрийн нар чи доод биднийг ивгээнэм.
Эхийн алтан хэвлийгээс авч төрсөн цогцос
Эрдэнэ баялаг цөмийг ганцхан та заяажээ.

Алт мөнгө юу ч биш, өөр тансаг бэлэг бий
Ачит эзэнд тэнцэх гуа нэгэн дагина бий.
Наран хатныг үзэхдээ та ёстой гаалнам
Найрын хундага юугаа улам дээш нь өргөнөм

Ийн тангараг няцжээ. Ярихын ч дургүй шаналжээ.
Идэт хатны тухай нэгд нэггүй тоочжээ.
Эзэн хаан соёрхож баяр хөөр бялхжээ.
«Эрхэм хатныг авчир» гэж харуулын цэрэгтээ тушаажээ.



Зовлон гуниг нимгэрч хөөр баяртай суутал
Золгүй явдал зөгнөж жаран боол айсуй
Ахлагч нь түрүүлж хаалга юугаар ороход
Авралт тэнгэр хэрхэв гэж би сандран тэвдэв

Эзэн хааны тушаалаар боол бид ирэв.
Эрхэм Усенний бэлэг энд бий гэнэм.
Гаргаж даруй өг» гэж ахлагч нь над хэлнэм
Галав юүлэх адил бэрхийг би амснам.

Гайхсандаа болоод би «Хэнийг эрнэм» гэвэл
«Гайхамшигт гоо хатан» гэж тэд өөдөөс өчнөм.
Эцэслэх цаг ойртож хэрхэх аргаа баран
Энэ бие дагжин амь голтой салгалнам.

Гүйн гүйсээр ороход бүсгүй хайлан суунам
«Гүн гай учрав гэж түүндээ би» хэлнэм
«Тэнгэр бурхан хилэгнэж хаантан таныг уринам
Тэр санаатан ховлож ийм гамшиг учирнам»

Хариу тэр өчрүүн: «Юуг ч бид тэвчнэм
Хар зовлонгийн түймэр очноос ч гэсэн үүснэм.
Зовлонг гайхах ёсгүйг, жаргалыг гайхвал зохином
Золгох шинэ зовлонгоос хэзээ ч үл буцнам

Сувдан нулимс хэдийгээр урьдын адил урсавч
Суут баатрын зүрхтэй эм барс босож
Жаргал зовлон хоёрыг адилд тооцон бодож
Жавхаат нарыг бүдгэрүүлж нөмрөг юүгээ өмсөв.

Үнэт эрдэнийн сангаа даруй би нээгээд
Үй их баялгаа тэр бүсгүйд бариад
Алтан бүсээ бэлэглэж арвин эрдэнээ өгөөд
Аль ч газраас олохгүй бэлэг сэлтээ тушааж

«Амь насы чинь энэ аварч ч магадгүй» гээд
Алтан нартай тэнцэх хатантнаас хагацав.
Хөлчүүрч чилсэн хаантан өөдөөс нь угтан ирвэл
Хөөрхий бүсгүй алжааж тэргүүн юүгээ тонгойжээ.

Олны хөл ихсэж дуу шуугиан дэгдэж
Омоорон цугласан тэд харуулын хоригийг ч давж
Хасын гуа бүсгүйг хаан гайхан ширтэж
Хаанаас мандсан нар вэ? гэж асуунхан соёрхжээ

Харсан бүхэн гөлөрч харах нүд нь гялбаж
Хаантан ийн өчрүүн: «Иймийг би үзээгүй
Дээд тэнгэр заяасан ийм хатныг бодож
Дэндүү сэтгэлээ өгөгч нь тэнэхээс өөр авралгүй»

Хаан дэргэдээ суулгаад таатай гэдэг нь аргагүй
Хаанахын хэний үр вэ? гэж асуувч ер нэмэргүй
Гэгээн харцаа буруулж таг дуугүй суунам.
Гэм зовлон амсаж уйдан гунин шаналнам.

Эзний хэлэх үг сэтгэлд нь ер хавьтахгүй
Эрхбиш өөрийг бодохоос зүрх нь бүр тогтохгүй.
Үг хэлгүй юм шиг амаа тэр нээхгүй.
Үлэмж гуаг биширч олны гайхах нь хэмгүй.

Хаан эзэн өчрүүн: «Үнэнийг хэрхэн олном
Хаашаа ч гарах гарцаагүй хоёр зам л байнам.
Хэн нэгийг мөрөөдөн сэтгэл санаа нь одоод
Хэрхэвч өөрийг болдоггүй нэгэн ёсон бий.

Эсвэл хорвоогоос хэдийдэж тэнгэрийн мандалд нисээд
Энэ ертөнцийг огоорч юуг ч тоохгүй ёсон бий.
Үлгэрт гардаг адил жаргал, зовлонг ялгахгүй
Үүлэн тийшээ сэтгэл нь шувуу шиг хөөрөх ёсон бий.

Харь дайсны нутгийг хүү минь дайлаад ирэхэд
Хасын тунгалаг нарыг бэрээ болгон тушаая.
Хамаг учрыг тэгээд хун тайзаас сонсьё.
Харин түүнийг иртэл эрдэнийг дээдлэн хадгалъя

Хун тайз гэгч хувьтай нэгэн баатар
Хувиршгүй үнэн зантай гуа төрсөн эр
Дайн тулаан хийж удтал алсад оджээ.
Дайчин хүүдээ хаан бэр ийн хадгалжээ.

Эрд очих бүсгүй гэж шийвэгчин эмс гангалж
Эрдэнийн чулуун чимэгтэй өмсгөл зүүлт базааж
Шижир алтан тэтэм, болор тансаг тэргүүтнээр
Шинэхэн сарнай цэцэг эрхэм бүсгүйг мялаажээ

Хатанд ширээ зэхэхийг эзэнтэн зарлиг болбол
Хамаг олноо ёсчлон алтан ширээ бүтээжээ.
Бараа бологсдоо дагуулж их хаантан ирж
Бадам лянхуа хатныг ширээнд аваачин залжээ.

Эрхэм хатныг харгалзахаар есөн харуул гарч
Эртний заншил ёсоор хурим найр дэлгэжээ.
Эрхэм бэлэг барьсан Усенийг дээдлэн шан өгч
Эгэл олныг хөгжөөн бүрээ, бөмбөр эгшиглэнэ.

Хундага тагш харшин хурим найр дэгжвэл.
Хувьдшгүй наран хатан гэнэт ийн өгүүллрүүн:
«Хатуу хувь тавилан үхлийг над хайрлаж
Хаана би ирчихээд хэний эрхэнд орчихоо вэ?»

Хорвоогийн зовлон гэдэг даах аргагүй бэрх гэвч
Хосгүй сарнайн адил гуа үзэмж эс буураг.
Тэнгэр намайг тэтгэн дайсныг би дийлэг.
Тэнэг мангуу биш бол үхлийг яаран эрдэггүй

Харуулын эрс та нар миний үгийг сонс!
Хамаагүй олзны эм гэж тэнэг л гагцхүү бодном.
Бэрээ болгож авна гэж мангуу эзэн л сэднэм.
Бүрээ бөмбөр дуугаргаж дэмий л хөл уднам.

Өөрийн гэсэн ханьтай хатан, болж чадашгүй.
Өвтэгш гуа эр ч надтай гэрлэхийг бодошгүй.
Өөр хувь тавилан над байгаа болохоор
Өнөр олон та нартай хамт байвч ашиггүй.

Хэрэв намайг албадвал мэсийн ирэнд өнгөрнөм.
Хэмгүй их хилэгнэн хаантан та нарыг хөнөөнөм
Алтан бүс хүртэл арвин бэлэг барья!
Алдаа гунихгүйн учир тавихыг гагцхүү гуйя!

Эрдэнийн хайрцгаа нээж, алтан бүсээ тайлж
Эрхэм тансаг тэтэм цөмнийг тэдэнд тарааж
Эрхт дээдсийг бодоод намайг одоо тавиач
Эзэн тэнгэр та нарыг ивгээх болно» гэлээ

Хомхой сэтгэл дийлж эрдэнэсийг дордос шохсорхон
Хотол их хаантны зарлиг болгоныг огоорон
Анхаарч энэрсэн мэтээр бүсгүйг тавихаар шийдэж гэнэ.
Алт мөнгөний эрхшээл ийм л байх ёстой гэнэ.

Алтны хойноос амь тавих жаргал биш буюу
Ахуй бүх насандаа үүнийг гагц хөөх буюу.
Хураасан юмаа чамлан ихийг ямагт горьдном.
Хувьт хүний сэтгэл хумхийн тоос мэт арилнам.

Хатны хэлсэн бүхнийг ёслон тэд дагаж
Харуул цэргийн хувцсыг эрхэм түүнд өмсгөжээ.
Ордонд цөмөөр хөлчүүрэхэд ондоо хаалгаар гарч
Омогт раахын залгихаас танхил саран аврагджээ.

Эзний зарлиг сөрж боолууд удалгүй арилжээ.
Эрхэмсэг хатагтай ирээд манай хаалгыг дэлджээ.
Тэр дор нь таньж тэврэлдэж бид золгожээ.
Тэгэвч гамшиг учирна гэж бүсгүй орохоос зовжээ.

Надаа тэр хэлрүүн: өгсөн бэлгийн чинь хүчээр
Нас бие минь аврагдлаа, чиний төлөө мөргөнөм.
Хаантны хөөхөөс өмнө эндээс би арилъя.
Хавтай сайхан хөлөг надаа өгөхийг горилъя.

Хамгийн сайн хөлгөө барьж би эмээллээд
Хашийн туяагаар даллагч энхрий бүсгүйг мордууллаа.
Наран дагины эрхээр арслан хөлөг дүүлж
Найгүй хүчээр ургуулсан тариалан минь хатлаа.

Үдэш дөнгөж болмогц манайхыг зорин ирж
Үй олон цэрэг бөөн хөл боллоо.
Хэрэв та нар олбол яргачин гээрэй» хэмээн
Хэрцгий тэлний өөлөөс шүүд би очлоо.

Ололгүй тэд буцахдаа сайн, муу үг ч үгүй
Осолгүй л хаантныхан уйлалдаж хар хувцасгүй нь нэг ч үгүй
Оройн нар шингэж одоо, бид гэрэл ч үгүй
Ордныхон вй гашуудаж ийн өчөөд хариу ч үгүй.

Харийн бүсгүйн учрыг дараа би хэлье.
Харин хэрцгийн баатрыг одоо би ярья
Эр эмийн адил дотно болсон хоёр сон.
Эрээгүй эм, хэнэггүй эр ичгэвтэр хэрэг тарьдаг сан.

Царай муу, доожоогүй эрээсээ би уйдаж
Цаглашгүй их хэргэмтэй, ордны ганц чимэг
Энэхэн баатартай нөхцөж хоёул сэтгэлтэй болсон.
Эдүгээ гэвч хөнөөхөд нь түмэнтаа чамд талархсан.

Хайр сэтгэлийн халуунд нууцаа би алдаад
Харийн бүсгүйг бодож явуулснаа баатарт хэлсэн.
Энэ нууцаар сүрдүүлж зовоож явдаг нь тэр шүү.
Эрхбиш түүнийг хөнөөж намайг аврах чинь энэ шүү.

Дандаа тэр сүрдүүлж намайг айлгаж явдаг сан.
Даанч эзгүй гэж бодоод чамайг би урьсан сан.
Чамтай түүний тулгарахаас ухаангүй би айж
Чанагш буцаахаар элч зарсан учир энэ сэн.

Гэгээ гэрлээр гийгүүлж хэрэв чи ирвэл
Гэнэт түүнтэй тулгарч цавчилдах байх гэж бодлоо л доо
Хэлэх үгээ олохгүй дэмий л сандарсан нь тэр шүү дээ.
Хэрцгий тэр баатар санаагаа л хэлсэн нь ил шүү дээ.


Хэрэв тэр амьдсан бол эзэн хаанд очиж
Хэмжээгүй тачаалын эрхээр нэгд нэггүй өчихсөн.
Хаантан ихэд хилэгнэж орон гэрий минь шатаахсан
Хамаг үрийнхээ хамтаар үнсхэн төдий болохсон.

Чи хэрэв байгаагүй бол хорт могойд хорлогдном.
Чин сэтгэлийн үүднээс тэнгэрт чамайг даатганам.
Одоо сэтгэл тайвширч хувь тавиландаа хананам.
Ондоо хорвоод очихдоо нүгэлтэй гэж эс айнам.

Автандил хариу өчрүүн: «Эртний сургаалыг сонсогтун.
Андын багтай дайснаас илэрхий дайсан хялбар гэнэ.
Хуурамч нялуун үгэнд ухаантан эс илгэнэ.
Хувь тавилангаа амссан түүнээс айх ёсгүй гэнэ.

Холын замд үдсэн бүсгүйн тухай яригтун.
Хожмын үед сонссон юм байвал хэлэгтүн.
Эхэр татан уйлж цээж нь гунигаар багтарч
Эрхэм наран бүдгэрэн ахин мандаагүй» гэлээ.





XLVII

НЕСТААН ДАРЬЖААНЫГ БОСОО ОРООЛОН ОЛЗОЛСОН ТУХАЙ ФАТЬМА ӨГҮҮЛСЭН НЬ

Лоромхон зуурын хорвоо албин шулмын адил
Хомхой булай явдалд нь хязгаар ер байхгүй
Саран дагина бүсгүйг хэрхэн чи зовооно вэ?
Саар бузар бүхний чинь би бүр андахгүй

Хатан Фатьма өчрүүн: Харийн бүсгүйн хамтаар
Хамаг жаргал арилж харанхуй зовлонд автсан
Тэр цагаас хойш амар заяа үзсэнгүй.
Тэсэх аргагүй нулимсны мөрийг арилгаж барсангүй.

Хань нөхөр. орон гэр, хайрт үрсээ хүртэл
Хайрлаж хүндлэхээ болиод түүнийг л боддог байлаа.
Гангараг няцсан Усен бүх хэргийн эзэн
Таашааж үзэхгүй болохоор надтай учрахаа болилоо

Тэр нэгэн үдэш тэнгэрийн хаяа туяарлаа.
Тэсэлгүй харийнхны ордныг хааяа би хардаг байлаа
Нөхөцсөн адил хүйтэн ч сэтгэлдээ бүсгүйг дурсана.
Нөгөө харчуулд итгэвэл өөрийгөө тэрээр хорлоно.

Гурван нөхрөө дагуулсан нэгэн боолыг харахад
Гуниггүй сайхан хувцастай, бусад нь харин ядуухан.
Ганцхан зоосны зоог авсны нь үзвэл тааруухан.
Гайгүй гэвч ярилцаж хөгжиж байгаа нь тавилуухан.



Яриагий нь би чагнавал «Энд уулзсан нь аз байна.
Ямар хэрэг зорьж хаанаас гарснаа мэдэлцье.
Нэр усаа хэлэлцэж нутаг усан танилцъя гэж
Нэгд нэггүй ярилцахы нь би сонсож байлаа.

Уйтгар гунигаа сэргээж яриа хөөрөө дэлгэхэд
Учирсан нөхөддөө боол ийн өчихийг сонслоо
«Дээдийн хишгийг би хүртэж яваа эр шүү.
Дэлхийн хөрсөнд би сувд тарих юм шүү.

Хэлэх үг минь сонин л доо, хүчит эзний боол би
Хэрцгий өвчинд нэрвэгдэж эзэнтэн гэвч хальсан юм.
Өмгөөлж тэтгэгчээ алдаж өнчин хоцрох хэцүү дээ
Өөрийн нь гурван-хүүхэд эгчийн нь гар дээр үлдэж дээ.

Хааны эгч гэдэг ч лут ханагар авгай сан.
Халдсан дайсныг сөнөөдөг бат цэрэгтэй хүн сэн.
Эр хоёр зээгий нь Росан, Родья гэдэг сэн
Эзний ширээг эгч нь ёс төртэй залгасан сан.

Гэтэл дүү бүсгүй нь тэртээ оронд нөхцөж
Гэр хотлоор цөм уй гашуу болжээ.
Халамжит наран шингэснийг хатантанд хэрхэн хэлнэм» гэхэд
Харуулын дарга Рашак хариу ийн өчрүүн:

«Албал намайг алагтун, уйлан гиншихийг сонсохгүй.
Аглаг хөдөө тэнэж олз хайхаас дээр нь үгүй
Нэртэй баян болоод болзсон цагтаа ирнэм.
Нэн дээдийн бэлэг хатантанд барихаар яарнам.

Намайг хэн даганам гэж цэргүүдээсээ асуугаад
Насан туршид үнэнч гэж зуун эрийг сонгоод
Өдөр шөнийг ялгалгүй амсхийх зав алдаад
Өнөр баялаг хуримтлуулж жинчдийг тонож явлаа.

Тэр нэг шөнийн харанхуйд хээр тэмтчин явтал
Тэртээ талын тэндээс тодхон гэрэл харагдлаа.
Нар мандах нь энэ үү? гэж хооронд зуураа гайхавч
Нарийн учры нь олохгүй дэмий л нэг тэвдлээ.

Үүрийн туяа ч гэмээр, үдшийн сар ч баймаар
Үнэний нь гэвч мэдэхээр бид дөхөж очлоо
Ойртож очихын цагт гэгээг бид хүрээлсэн
Оройн нар шиг туяатан хүний хэлээр өчлөө.

Ямар улс та нар? яах гэж ийн тосно вэ?
Явах за тавиагч, ороолонгийн орныг зорином би»
Тал бүрээс нь бид бүслэх адил дөхвөл
Танхил нарны адил нэгэн баатрыг үзлээ

Уужим талын дунд сарны туяа сацруулсан
Уудам алсын гүнд нарны гэгээ мандуулсан
Гийм нэгэн эр үг хэлэхээ болиход
Тэгш сувдан твья түүнээс бас харавлаа.

Уран үг хайрлахгүй элдвийг бид хүүрнэсээр
Учрыг сая ухаж бүсгүй болохыг мэдлээ.
Үүнийг мэдээд Рошак улаан нүүрээр тулгарч
Үхдэл гэмтэл гаргаагүй ч догшин гэгчээр барилаа

Үнэнээ чи өчөөч, үүрийн туяаны дүү юу.
Үлэмжийн гэгээн нар уу? Энэ хорвоогийн үр үү?
Хоргоож бид асуувч харну өчихгүй хайлнам.
Хорт могойд өртсөн саран дагиныг хайрланам.

Ил далд хоёрын алиныг ч тэр нууж
Ингэж яагаад зовсноо хэлэхгүй бүр хааж
Аман дотроо үглэвч учир нь ер олдохгүй.
Аягүй сүртэй харцаар хааяа цоргихоос холдохгүй

Өчиж хэрэв хэлэхгүй бол албадах хэрэг байхгүй.
Өвч зовлон эдэлснээ ярих гэдэг амаргүй,
Хавь ойрдоо гайхуулсан их эзэн хаанд маань
Хатан дээд тэнгэр бэлэг хайрлах нь энэ биз.

Хаандаа биднийг бариг гэж дээд тэнгэр хайрлажээ
Хамгийн дээд бэлэг гэж хаантан тал өгнөм.
Хэрэв бид нуувал эзний хилэн бадарнам.
Хэзээ ч хүүрмаг явдал адгийн хар нүгэл мөн

Асууж байцахаа больж үгий нь бид даган
Ариун дагиныг авч ороолонгийн цайзыг зорилоо
Айлгаж гомдоох явдалгүй аялж яваа атал
Асгарах нүлимсаа барилгүй эхэр татан уухиллаа.

Амь биеэ хайрлахгүй чамд хүчин зүтгэлээ.
Алив нэгэн хэргээр Гуланшаро орёе гэхэд
Харуулын дарга зөвшөөрч ирээд байгаа минь энэ дээ
Хамаг баялгаа авч одоо би буцаа даа



Үлгэр адил ярианд нь аянчин тэд баярлаж
Үнэнийг хэлэхэд би ч нулимсаа арчин гайтгаварав.
Наран гуа бүсгүйгээ тэр дор нь таниад
Найдах өчүүхэн сэтгэл миний цээжинд төрөв.

Тэр боолыг урьж дэргэдээ би суулгаад
Тэнд очсон бүхнээ ярихыг хичээн хүсвэл
Урьд ярьснаа тэр нэгд нэггүй тоочиход
Урам зориг орж сэтгэл баахан уужрав.

Үнэндээ хоёр илбэчин над тэгэхэд байж билээ.
Үзэгдэхгүй болон хувирах увьдас чадал төгс билээ.
Айж эмээх явдалгүй, ороолонгийн оронд очигтун
Аюулд нэрвэгдсэн бүсгүйн сургийг гаргагтун» гэлээ

Гурав хоног яваад ийм сурагтай ирлээ.
Гунхсан сайхан бүсгүй далайн тэртээ байнам,
Харж ханашгүй түүнийг хаанд бэлэглэсэн гэнэм
Хааны хүү Росантай гэрлэх гэж цөм баярланам

Хатантан зарлиг болж гэнэ Росантай үүнийг гэрлэнэ
Харин одоо завгүй цээжинд зовлон багтарна
Хол тэртээгээс ирэхдээ эрт, орой ч хуримлана»
Хосгүй дагина шилтгээнд харуул манаатай суудаг гэнэ.

Эр цэргээ авч хатантан аявд мөрдөж гэнэ
Эрслэх зам нь хэцүү, дайсны орон байдаг гэнэ.
Эрэлхэг ороолон зоригтой нь хэн хүнд ил гэнэ
Эгч хатан нь дүүдээ ёслол гүйцэтгэх юм гэнэ.

Тэдний хотод харийн хүний мөр гараагүй гэнэ.
Тэнгэрт тулсан хадан бат бэх цайз байж байна.
Цайз хэрэмд орох газар доогуур замтай юм
Царайлаг хатан тэнд тэнгэрийн сар шиг залрах юм

Язгуур удамтнаас сонгосон түмэн цэрэг манаатай
Яг л хаалган тушаа өдөр шөнөгүй жагсаатай
Гурван хаалгын дэргэд тэд үргэлж сахиатай гэнэ.
Гуниг зовлонд автсан түүнээ өрөвдөн гиюүрнэ.



МОНГОЛ
УЛСЫН
ЭРХЭМ
УЧРЫН
АХУЙН
ТӨСӨВ

Энэх сургийг сонсохдоо Автандил баатар мишээж
Эрхэм учрыг олсон ч хариу юу ч өчсөнгүй.
Санаандгүй явтал ивгээв гэж дээд тэнгэрийг биширч
Сайхь замыг гаргаад баярлах гэдэг хэмжээгүй.

Автандил Фатьмад хэлрүүн: «Чамд би талархнам.
Аяндаа миний мөрөөдсөнийг чи тодорхой өчлөө.
Энэ ороолон шулам чинь барих биегүй биш үү?
Эдүгээ тэд яагаад хүний бодийг олоо вэ?»

Тэр бүсгүйг өрөвдөж миний сэтгэл өвднөм
Тэврэх биегүй ороолон эхнэрээр яах юм бэ?»
Хариу Фатьма өчрүүн: «Чиний санаа буруу
Харин ороолон гэдэг чинь ууланд бүгдэг хүмүүс.

Тулалдсан хэн бүхнийг тэд дийлдэг хувьтай.
Тулгарсан хүн бүхэнд гай тарьдаг хуультай.
Далдыг хүртэл мэддэг илбийн их увьдастай.
Даанч адтай болохоор нь босоо ороолон гэжээ

Харах нүдий нь бүдгэрүүлж дайсан бүхнийг сандаргана.
Хамгаас шидтэй хувингаас далайг гэнэт үерлүүлнэ.
Далайн ёроолыг дуртайдаа хув хуурай болгочихно.
Даанч бэрх амьтад өдөр, шөнийг ч сольчихно.

Учир иймээс улсууд босоо ороолон гэсэн юм.
Угтаа тэд бидэн шиг яс махтай төрсөн юм.
Их тус хүргэлээ чамд тал өгье» гэж
Итгэлт бүсгүй Фатьмад Автандил баатар хэлэв

Уужирч тайтгарсан Автандил дээд тэнгэрийг биширч
Учирсан гуниг тайлж зовлон бэрхээс аврагч минь
Уулзаж эс харагдавч алсаас тэтгэгч тэнгэр минь
Уян сэтгэлээр нигүүлсэж намайгаа аврав» гэжээ

Баярын нулимс унаган тэнгэрт Автандил өчихөд
Байгаа сэтгэлтнээ алдав гэж Фатьма хатан атаархаж
Наймаачин гэх нууцаа баатар хэвээр хадгалахад
Наалдаж Фатьма тэврээд үнсэн таалан цэнгэжээ

Сэтгэл юүгээ хангаж шөнөжин баатрыг таалахад
Сэртхийн баахан харамсавч Автандил хатныг тэвэрч
Сүй амрагаа бодохоос элэг зүрх чичирхийлж
Сүйдэт араатан адил зүрх нь аглаг тэнэжээ.

Үер шиг урсах нулимсаа нуун хаан арчихал
Үлдэж тогтсон нууранд нь бяцхан завь хөвжээ.
«Сарнай цэцгэнд дуртай алтан гургалдай билээ би.
Сайхь луулин дээр суудаг хэрээ болчихжээ» гэлээ.



Нулимсан үерт автахдаа чулуу хүртэл зөөлрөх сөн.
Нугын тийшээ одож сарнайг нулимс зорьсон сон.
Хэрээ, сарнай олчихвол өөрийгөө гургалдай гэдэг сэн.
Хэнэг ч үгүй Фатьма гургалдай дүүриан донгоджээ.

Өглөө мандахаар наран нүүрээ угааж байхад
Өнгө бүрийн өмсгөл, элдэв тансаг эрдэнэ
Наймаачны гэргий авчирч хайр сэтгэлийн бэлэг
Надаас зовох юмгүй, өмсөгтүн гэж өгчээ.

Наймаачин гэхээ болих гэж баатрын хувцсаа өмсөхөд
Наран гуа баатарт арслангийн сүр оржээ
«Өнөөдрөөс эхлэн нууцаа би задалъя» гэж
Өмөг их баатар хийморь цог нь бадарчээ

Хатан зоог базааж хүлээн хүсэн суутал
Хавтай баатар морилоход гайхахын дээдээр гайхжээ.
Ингэж байвал сайхан бүхнээр чамайг биширнэ» гэж
Итгэлт баатрыг хүндлэн наймаачны гэргий таалжээ.

Эр баатрыг үзэхдээ хатан улам догдолж
Элэг зүрх шаналавч өнгөндөө баатар инээвхийлж
Сэтгэлтэй юм шиг байхаас өөр замгүй учир
Сэргэж хөөрсөн Фатьматай зугаланхан суужээ.

Ханатал наргиж цэнгээд өргөөндөө баатар очиж
Халж баахан хөгжсөн тул тавтай нойронд умбажээ.
Орой хир босож гэгээ гэрлээ сацруулан
«Орон гэртээ хүлээе» гэж Фатьмад элч заржээ

Хатан Фатьма ирээд санаа алдан хэлрүүн:
«Хавтай гуа эр чи зүрхий минь бүр хуваалаа»
Дэргэдээ түүнийг суулгавал гомдон гаслахаа больсон ч
Дэлгүүн зоригт баатрын царай баахан барайжээ.

Автандил баатар өчрүүн: Үнэнээ чамд хэлье.
Аварга могойнд хатгуулсан мэт чи намайг гуниглуулам.
Өнөө болтол чамд худал хэлдэг байлаа.
Өөр бүсгүйн нулимс намайг эзэлж ирлээ.

Жингийн даамал наймаач гэж чи намайг боддог.
Жинхэнэ үнэнээ хэлэхэд Ростайны жанжин билээ.
Идтэй цэргийг манлайлдаг зоригт баатар билээ.
Ихийн их баялгийг эзэлсэн эр билээ.

Нууц бүхнийг сахина гэж чамд би найднам.
Нутгийн сайхан Арабт нэгэн бүсгүй хүлээнэм.
Гэгээн ариун туяанд нь миний бие урснам.
Гэсэн ч түүний тушаалыг даган би тэнэнэм

Энд байсан бүсгүйг газар сайгүй хайнам.
Энэ хорвоог бүхэлд нь туулаад эс олном.
Амраг сэтгэлт эр нь энэ ертөнцийг огоорч
Амьтай голтой төдий тарчлан хүлээн суунам.

Өөрийн хувь тавилан, андын гуниг зовлон
Өрөвдөм бүсгүйн учрыг Автандил нуулгүй өчөөд
Тэр бүсгүйн сормуус шинэ золоор мишээхэд
Тэвчих эрхгүй зовсон баатарт чи тусал» гэв


Анд нөхдөд Фатьма, хоёул хүчин зүтгэе!
Амраг хоёрыг нийлүүлэх арга зүйг бодъё
Хүн биднийг дуулахдаа сайнаар дурсах болно.
Хүсэлт хоёр уулзах баярт өдөр ч ирнэ.

Итгэлт нэгэн боолыг ороолонгийн оронд явуулъя
Илэрч мэдсэн бүхнээ олзны бүсгүйд дуулгая.
Яавал чухам зохихыг бүсгүй бидэнд хэлэг.
Ямар ч атугай дайсныг өшөөлөх цаг ирэг»

Хариу Фатьма хэлрүүн: «Тэнгэр биднийг өршөөнөм.
Хамаг зовлонгоос салах тэр цаг ойртном.
Ууган итгэлт боолоо Фатьма хатан дуудаж
Урт зам туулан ороолонгийн оронд очигтун.

Увьдсын хүчээ чи харуулах цаг боллоо.
Удаан зовлонгоос намайг салгах хувь ноогдлоо.
Анагаах арга олов гэж хориотой хатанд хэлэгтүн»
Амжуулж өнөө бүтээе» гэж боол ам өгөв.





XLVIII

НЕСТААН ДАРЬЖААНД ФАТЬМА ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН НЬ.

Уран цэцэн ухаан мөнхийн хайраар таалдаг
 Усан болор адил үеийн үед туяардаг
 Орчлон дээдийн наран оройн гэгээн дүнлүү минь
 Онцын зовлонт амьтад чамаасаа хагацан шаналнам.

Бэрх хүнд амьдралаа чи хэдий нуувч
 Бэдэрч би сэдсээр бүхнийг олж мэдсэн.
 Уй зовлон амссан Тариэл тайтгарах хувьтай
 Учрахдаа тэрээр сарнай, чи линхуа болном.

Арабын цэргийн жанжин, алдарт нэгэн баатар
 Автандил хэмээх нэртэй Тариэлийн энд ирсэн.
 Өө зөөгүй зоригтон, Ростан хааны жанжин гэнэм
 Өөрийнхөө тухай чи дэлгэрэнгүй өчвөл зохином.

Олж чамтай учруулахаар энэх боолыг зарав.
 Ороолонгийн цэрэг эрс алсаас ирсэн эсэх
 Хортны хотын дайчин хир олон болох
 Хорио манааны толгойд хэн байхыг мэдэхсэн.

Босоо ороолонгийн орныг мэдэх бүхнээ өчигтүн.
Болгоож мэндийн сургаа хөөрхий янагтаа бичигтүн.
Үйлийн эрхээр таануус хагацан шаналсан боловч
Үнэхээр тэнгэр таалбал эргэж заавал учирна»



Захидал минь чи, өвдөг тэнийн шавдагтун
Задлах гуа эзэнтэй чамд би атаархана.
Зовлон амссан тэрээр чамайг үзэхдээ баярлана.
Зоригоор танилцсан биднийг чи ерөвдэн соёрх

Ийн өчөөд Фатьма боолд захидлаа гардуулан
«Ивгээлт наран хатанд хүргэж өгөгтүн» гэв
Илбийн ногоон өмсгөлөөр боол биеэ ороогоод
Идийн их хүчээр дээвэр дамжин одов.

Харавсан сумын адил идэт боол шавдаж
Харуй бүрий болоход ороолонгийн оронд хүрэв.
Олон давхар манааг онцын болгоон өнгөрч
Оюун гэгээн хатанд янагийн сураг дуулгав.

Бат бэхэлсэн хаалгаар нээлтгэй юм шиг нэвтэрч
Бараан царайт сахалт эр, бүсгүйн өргөөнд оров.
Сарнайн дүр гутаж сайнгүй явдал зөгнөн
Саруул наран дагина сэтгэл улам хямрав.

Харин боол өчрүүн: «Та бүү гунигтун
Хатан Фатьма намайг зориуд нааш зарсан.
Өчих үгэнд итгэхгүй бол захидал болгоож мэднэ.
Өнөр гэгээнд нь ивгээлт нар удахгүй мандана.

Үлгэр домог адил энэх мэдээ гайхалтай
Үнэхээр сайхан хатан нүд тавин ширтэнэ.
Энэрэл хайраар дүүрэн захидал нээх нь бахтай.
Эрэгцүүлж тойруулж уншаад нулимсанд аанай л живэв


Хэн намайг хайнам, амьд гэлдэрч яваагий минь
Хэтийн ид шидтэн ч үл мэднэм гэхэд
Хариу боол хэлрүүн: «Чамаас хагацсан цагаас
Хар зовлонд умбаж бидний наран жаргав.

Хатан Фатьмын цээжийг харамслын мэс нэвтэлж
Хайргүй урсах нулимс тэнгист цутгах болсон.
Нууцы нь би мэдчихээд харуулыг гэтлэн ирсэн.
Нууцгай уухилсан Фатьмын нүдний харц бүдгэрсэн,

Харах нүдний чимэг баатар нэгэн ирж
Хатан Фатьмад чиний амссан зовлонг өчсөн
Харьж буцах янзгүй баатар эр билээ.
Харин түргэн эгэхийг надаа захисан гэлээ.

Үзэсгэлэнт бүсгүй өчрүүн: «Хэлсэн үгэнд чинь итгэнэм»
Үнэхээр энд байгааг Фатьма хэрхэн мэднэм.
Зүрх сэтгэлээ шатааж хонгор минь мэнд л аж дээ
Зүйргүй янагтаа өчье. Чи ч гунигий минь хэлээрэй дээ.





XLIX

НЕСТААН-ДАРЬЖААН ФАТЬМАД ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН НЬ

Наран гуа дагина бичрүүн: «Бат журамт хатан та
Найгүй миний зовлонг эхээс минь илүү мэджээ.
Дээд тэнгэр гэгсгээж ийн би шаналнам
Дэлгэж захиагий чинь уншихдаа итгэл найдвар төрнөм.

Дайсны савраас намайг хоёр удаа аварсан ч
Дахиад би ороолонгийн гарт оржээ.
Өчүүхэн тайтгарал өнгөрч төмөр цоожны цаана
Өнөд хэлэлцсэнээ бүтээлгүй өнөө болтол суужээ.

Өөр юу ч бичих вэ дээ? Хатан хаан нь эзгүй.
Өнөр бүлтэй ороолон ч нэгнээ зориод сураггүй.
Үй олноор мануулж үйлээ эдэлж суунам.
Үнэндээ бүү итгэ дээ, аврах хүчин дутнам.

Эрж ирсэн баатар дэмий л биеэ зовоожээ.
Эрхбиш намайг бодон шаналахгүй байвал зохихсонжээ.
Наран гуа эртэй минь учирсанд нь атаархам
Насан турш түүнтэйгээ уулзахгүйн түмэн гамшиг

Янаг сэтгэлийн учир чамд дурсаагүй билээ.
Ямагт тийн хайлахыг тэвчиж чадахгүй байлаа.
Өршөөл гуйж хэлэхэд тэр нэгэн баатар
Өнөөс хойш намайг бүү эрэн бэдрэг.

Өөрийн минь, зовлон хүрнэ, бусдыг үрээд яах вэ.
Өшөөлөгдсөн баатрыг харахад давхар зовлон нэмнэ.
Хэдий гунигтай авч тусалж чадахгүй нь үнэнтэй.
Хэлэх үгэнд минь итгэ, хадан хэрэм нь баттай

Амар сайны нь эрхийг чиний хүссэн ёсоор
Анх над өгсөн өмсгөлийн тасархай илгээв.
Хайрт янагийн барьсан хар дээл нь үнэтэй.
Хатамжилж байгаа зовлонтой өнгө нь ч бас гөстэй





1

НЕСТААН-ДАРЬЖААН ЯНАГТАА ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН НЬ

Урсах нулимс давж гинших дуун сонсодно.
Уярах янагийн галыг усан нулимс унтраана.
Зовлонт бүсгүйн бичсэнийг хэн ч уншаад догдолно.
Зоригоор туяа харавсан болор сарнайг чимнэ.

Энэ хэдэн мөрийг өөрийн гараар бичнэм.
Энхэр бие минь эцэж нулимсаа бэх болгонэм.
Хоёр азгүй зүрхээ нэгэн болгож нийлүүлнэм
Хонгор зүрхэн дээр тэгээд цаас лугаа адил сийлвэм.

Хатуу хорвоо гэгчээр биднийг ийн хагацааж
Харвах гэрэл байвч харанхуй адил байнам.
Эрхэм мэргэд түүнийг харж үздэггүй нь учиртай.
Энэрэлт чамгүй ганцаар хязгааргүй зовох бэрхтэй.

Балай энэ хорвоо хоёр амрагийг холдуулж
Баярт нэгхэн хуримаа чи бидэн хийсэнгүй.
Илдэнд зүрх өртөж эдэлсэн жаргал зайлжээ.
Ихэд амссан зовлонг оюундаа чи болгоодоо.

Сүнс сүлд олоод би гэдэг мөхжээ.
Сүүлд нэгэн жаргах чадал, горьдол тасарчээ.
Сайныг одоо дуулахдаа тэнгэрт би биширнэм.
Сайхь баярын мэдээнд зовлон баахан нимгэрнэм.

Амьд мэнд яваа чинь итгэлийн хийморь сэргээж
Алаг зүрх шархтай ч өчүүхэн дөл аснам.
Ядуу бүсгүйн дүрийг сэтгэлдээ чи хадгалаарай
Янагийн ганц сэтгэлээ цэцэг шиг таалахыг болгоогоорой.

Үзэж амссан бүхнээ өчье гэж бодовч
Үнэндээ хэл цуцаж зүрх минь даах өнгөрчээ.
Дээд тэнгэр ивгээмээр буянтан Фатьма өршөөсөн ч
Дэндүү хуврамч хорвоо дахин намайг зовоожээ.

Бузар хар хорвоо зовлон улам зузаатгавч
Булай ийм учрал хараахан тохиолдоогүй явсан сан.
Ороолон шуламд баригджээ, тэдэнтэй тулах аюултай.
Одоо ингээд бидний тавилан ийм байжээ.

Өндөр өргөөнд хориотой алсыг гиюүрэн ширтнэм.
Өдөр шөнөгүй харуул нь амьтны хөл мөрднөм.
Газар доогуур гаритай, олон манаач сахинам.
Гайхал эд дайснаа, галан уул буулган дарнам.

Дээрэмчин адил тулна, хүнтэй тэд ижилгүй,
Дэмий зовлон нэмж чи ирэх хэрэггүй.
Чамайг харсаар үхэхэд эрвээхэй адил шатна би.
Чангалан, чулуу шиг сэтгэл барьж сууж бай даа чи.

Эргэлзэж зовохоо боль, миний хайртай эр
Энэ биеий минь, өөр нэгтэй нөхөцсөн мэт бод.
Хайрт чамгүй би аж төрж жаргаж чадахгүй.
Хатан илд, хадан гэр алинаас ч би буцахгүй

Саран би чинь туяагаа өөр хэнд ч хайрлахгүй.
Саруул гурван нарыг шингээсэн нэгийг ч хавьтуулахгүй
Хар нүхний ёроолд энэ биеэрээ унана.
Хан тэнгэрт сүнс маань чамайгаа бодон халина.

Гал усны гашуун зовлон амсан байгаа намайг
Гайтай бөглүү хорионоос аврахыг тэнгэрээс гуйгтун.
Мөрөөдөн хүсэх газраа би нисэн хүрээд
Мөнх нарны туяаг өдөр шөнөгүй амсыя.

Догдос нэгтэй учраас чамгүй бол нар эс гийнэ.
Цохолсон тавилан ижилхэн нарны хань чи.
Наранд дүрий чинь харахад сэтгэлд туяа харвана
Найгүй зовлонд автаж үхвэл санаа амарна.



Сүнсээ чамд тушаагаад үхэвч би гомдолгүй.
Сүйдтэй харанхуй бунханд ч зүрхний гал намдахгүй.
Хагацан салснаа бодоход шархнаас цус урсана.
Хайртнаа хальсныг санаад чи минь бүү уухил.

Энэтхэг нутагтаа очиж эцгий минь чи тэтгэ дээ.
Энэ бие ганцаарыг дайсан хүрээлээд зовооном.
Ганц үрээсээ хагацаад шаналж яваа аавд минь
Гашуун зовлон амсан ингэж явааг дуулга даа.

Зол заяагүй би хувь тавиландаа ханалаа.
Зорьсон үнэнч зүрх ижлийнхээ сэтгэлийг бодлоо.
Амьд явах хэрэггүй нь, зовлон л би таринам.
Амрагийн төлөө үхэхэд хэрээ намайг тоншном.

Өнгөрч байгаа янаг чинь үүрдийн дурсгал болгож
Өөрийн чинь хайрласан өмсгөлийн тасархайг чамдаа илгээе
дээ

Долоон бурханд гэсгээгдсэн чи бидэн хоёрын
Догдолсон их итгэлийн тэмдэг болж үлдэг дээ.

Илгээлт юугаа бичээд итгэл зүрхээ явуулаад
Ихэд нандин дээлээсээ эн дагуулж өмлөөд
Дунирсан хар үстэй тэргүүн юүгээ өргөхөд
Дуулим сайхан үнэр агаар адил сэнгэнэв.

Өнөөх боол эгж эх нутгаа зорьсоор
Өдрийн хугархай төдийд эсэн мэнд ирэв.
Эрхэмсэг бүсгүйн сургийг гаргасан Автандил баярлаж
Энгүй баяраа илтгэж дээд тэнгэрт мөргөв.

Хатанд баатар хэлрүүн: Баярлах цаг дөхлөө.
Хайр өршөөл бүхний чинь төлшгүй өртэй билээ.
Он жил удлаа, одоо би буцъя.
Ороолон шуламтай үзэлцэхээр нөхрөө дагуулж одъё.

Хариу бүсгүй өчрүүн: Миний сэтгэл хөдөлнөм,
Хайр сэтгэлээс холдож харанхуйд зүрх умбанам.
Ухаан сэхээгүй нөхөртөө чи яаран одогтун.
Улигт ороолонгууд эгвэл зорьсон чинь талаар өнгөрнөм

Дагуул боолоо баатар дав даруй дуудан
Дахин үхлийн даваанаас бид ийн мултарнам.
Хүлээсэн сураг гарч итгэл баяр төрнөм.
Хүй дайсны бахыг хангах үхэл эс ирнэм.



Өөрөө би очихгүй, өөр тийшээ зорино.
Өөдрөг овоо явааг Придонд та нар дуулга.
Аянга адил нижигнэж эрэлхэг баатар мордог
Атаат дайснаас олзолсон бэлгийг та нар аваарай.

Үнэн зүтгэсэн та нарыг хөхүүдсэн нь бага атугай ч
Үнэхээр дахин учрахдаа хариуг би базаана.
Хар дээрэмчний уурсыг та бүхэнд өгөхөд
Харамч хявцаг гэлээ ч өөр зүйл алга.

Харьд яваа болохоор над юм хомсхон гээд
Харамж шан болгож боолд бэлэг өгөв.
Энэ бэлгийг аваад төрсөн хотдоо эч доо.
Эрхэм анд Придонд энэх захидлыг өг дөө.





LI

АВТАНДИЛ ПРИДОНД ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН НЬ

Автандил баатар бичрүүн: «Атаатны цус урсгагч
Арслан адил хүчит, наран адил туяат
Хааны хаан болсон таныхаа амрыг эрж
Харь холоос дүү чинь эдгээр боолыг зарав.

Гамшиг зовлонгийн туйлд хэрэг бүтэх дөхөөд
Гашуун бэрхийн эцэст урам зориг оров.
Ороолон шулмын гарт хатантан орсныг дууллаа.
Орчлон дэлхийн гүнээс ч бүсгүйг олох боллоо.

Идэт ороолонд баригдаад наран бүсгүй шанална.
Их тулаан болсон ч төвөггүй түүнтэй учирна.
Хархан нүдний мэлмийгээс хасын борсоо буунам.
Хар ороолон эзгүй олон цэрэг нь сахинам.

Урсах нулимсаас хагацан зүрх баяраар бялхаж
Учран тантай золговол угаас таатай байх сан
Та хоёр уулзвал зорьсондоо заавал хүрэхсэн.
Таарах хүн байтугай хад хүртэл нурахсан.

Дайрч учирч золгоогүйд эрхбиш өршөөх ажаа муу.
Давын түрүүнд Тариэлтэй уулзах ёстой ажгуу.
Шаналсан баатраа дагуулаад очихын цагт баяртай.
Шадар нөхөртөө үнэнч танд өөр юу ч хэлэхэв.




Аян замд ядрахгүй чиний боолд өртэй.
Адилгүй гавьяа байгуулсан тэдэндээ бахдах ёстой.
Сайшаал магтаал гэдэгт Придоны үе дургүй ч
Сайнаас сайн төрнө» гэж мэргэдийн үг байдаг

Энэх захидлаа дуусаж эрхэмлэн нандигнан наагаад
Эргэж буцах боолуудад өөрийн гараар бариад
Ашдын эрдэнэт шүдээ Автандил баатар яралзуулж
Аминчилж хэлэх үгээ амаар боолд айлтгав.

Өргөн дэлхийд хэрсэн хөлөг онгоц олоод
Өгөөмөр нар шиг гийгүүлж баатар эр мордов.
Хатныг орхих хэцүүхэн, хатамжилж зүрх тэссэнгүй.
Хайлсан цусан нулимс урсаад ер татсангүй.

Хэн хэнгүй уйлж хэлтэй бүгд үглэрүүн,
«Хэтдээ гийгүүлсэн нар чи биднийг орхин одоход
Хасын туяа татарч харацхуй манан бүрхлээ
Хаяж ингэж орхисноос хөнөөвөл дээр биш үү»





ЛН

АВТАНДИЛ ГУЛАНШАРААС ОДОЖ ТАРИЭЛТЭЙ УЧИРСАН НЬ

Замын тэр онгоцоор тэнгис далайд оров.
Залуу эр ганцаар ч хөгжөөнтэй алсыг зорив.
Сайхан мэдээ өвөрлөж Тариэлтэй удахгүй золгоно.
Сайхь гараа сарвайж дээд тэнгэрт мөргөнө.

Ид хавар болж дэлхий байгаль цэцэглэнэ.
Ийм тансаг үед сарнай бас дэлгэрнэ.
Зуны шөнийн богинод зургаан марал гялалзана.
Зуурдын гуниг бас сарнайд шарх суулгана.

Аянгын дуу нижигнэж шүүдэр өнгөлөг гялалзана.
Аялаг уруулын өнгөт сарнайг баатар таална.
Эелдэг харцаар сарнай чамайгаа би ширтэхэд
Эрхэм журмын нөхөртөө золгох лугаа адил гэнэ.

Андгайт нөхрөө дурсахад сувдан хэлхээ тасарна.
Аяндаа улам шамдахад амаргүй холыг туулна.
Эзгүй цөл, усгүй тал, жимгүй газрыг давна.
Элбэг олноор тохиолдох арслан, барсыг намнана.

Аянд нэг үзүүр бий, агуй бараатан харагдав.
Амраг нөхрийн харагдсан хадан хана үзэгдэв.
Хоёргүй журамт нөхөртөө үзсэн бүхнээ өчье.
Хосгүй анд эзгүй бол одоо би чинь яая даа.

Эргэж эндээ ирсэн ч яаж удаан тогтох вэ дээ.
Ээрэм хөдөө тэнэж ан хийгээ байлгүй дээ.
Агуйд одоо орсноос хээр хөдөө л зорье гээд
Агтын жолоо залж бөглүү ойг чиглэв.

Нэгэн дуу аялан хатирч яваа нь урамтай.
Нэхэж журмын нөхрөө дуудан очих нь жавхаатай.
Алтан нарны туяа мөдхөн гэвч гийлээ.
Анд Тариэлийн бараа ойн тэртээ харагдлаа.

Илд мэс нь цустай арслан нэгхэнийг хөнөөжээ.
Идэр баатар явган шугуйн захад зөгсжээ.
Автандилын дууг гайхан гайхан сонсжээ.
Анд нөхрөө амдан ухаантай ухаангүй харайжээ.


Хатан илдээ орхиод харавсан сум шиг довтолжээ.
Хайрт хөлгийн нуруунаас Автандил гялбаа шиг үсэрчээ.
Хүч мэдэн тэврэлцэн үнсэн таалан золгожээ.
Хүний хоёр үр ихэрлэж сарнай дэлгэрчээ.

Уйлан хайлавч Тариэль уран цэцэн ярина.
Урьдын эрүүл цус хацар тушаа харвана.
«Хайрт чамайгаа үзээд түмэн зовлонгоо мартав» гэнэ.
Хайлах нулимсан үер гуа цогцсыг угаана.

Тариэль ийн уйлахад Автандил хөхүүн инээнэ.
Тансаг сувдан эрдэнэ сарнайн дундаас ярайна.
Энд тэндгүй тэнэж хувь заяаг эргүүлэв.
Эдүгээ хүртэл гандсан сарнай дэлгэрнэ гэв.

Харуу Тариэль өчрүүн: «Өнөө их баярлав.
Халамжит чамтай учирч хэрэг зориг бүтэв.
Энэ хорвоод зорьсноо дээд тэнгэрт амсдаг
Эрхбиш анагаах рашаан өөр ер байдаггүй?»

Учрыг нэг л ухахгүйд нь Автандил баахан гайхаад
Уулзсан дуулсан бүхнээ эгшнээ сонсохыг яараад
Амрагийн нөмрөгийн тасархайг авч баатарт өгвөл
Анх өөрөө бэлэглэснээ Тариэль төдхөн санаа.

Бэлэг захиа хоёрыг баяраар бялхан аваад
Бэлхнээ нүүрнээ тулгахад сарнайн өнгө зөвхийрэв.
Харцаа баахан духайлгж ухаан нь манан шиг сарнив.  ᠑᠘᠕᠑᠑᠑᠑᠑᠑
Хатамжилж ийм зовлон Канс, Саламан ч тэвчихгүй биз.

Тариэль ухаан балартахад Автандил ихэд тэвдэв.
Тарчлаах зовлонг хөнгөлөхийг хөөрхий тэрээр оролдов.
Таатай захидал авсан амраг эр унахад
Тамын гал дундаас андаа аврах бэрхтэй.

Аюулхай зүрх өвдөж ангир адил ганганан
Алмасан эрдэнэ хучсан зөөлөн жигүүр хумив.
Ган бат шигтгээг уран гэгчээр сийлэн
Гарах нулимсан үер цусан өнгөөр туяарав.

Элбэрэлт нөхрийн гунигийг харан харан хайлахдаа
Энэ биеэ Автандил түмэнтаа зэмлэн буруушаав
Асаж байгаа галд ус яаран асгах гэж
Аяа зовлонг зүрх минь ийм баярыг даах болов уу?

Болгоомжгүй хэрэг тарьж андаа би хөнөөв.
Бодлоггүй үг хэлж буруутан би болов.
Яарвал даарна гэж мэргэдийн сургаал бус уу?
Яах гэж бүтэлгүй бигээр ийн яаран тэвдэв.

Амьдралын гал буурч Тариэль ухаангүй байваас
Автандил яаран гүйж уулын горхиноо одов.
Гал адил улайрсан арслангийн цус олоод
Гамшигт учирсан андынхаа цээжин биенийг шүршив.

Арслан адил баатраа арслангийн цусаар анагаавал
Аюумшигт гайн сум нүдэн дээгүүр шунгинаж
Амь орох мэт тэнхээ тамир сууж
Атар талыг гийгүүлэн сарны туяа мандав.

Цацаг чимэг нь унахад өвөл сарнай нүшгэрнэ.
Цагийн дулаанд цэцэглэхэд мөндөр хайргүй цохилно.
Амраг сэтгэлийн дуугаа алтан гургалдай донгодис.
Аяа хөөрхий сарнай өвөл, зүнгүй зовно.

Хүний сэтгэл гэдэг сарнай лугаа адил
Хүй баяр амсавч зовох лугаа ижил.
Хорвоогийн зовлонд гансрахдаа эгшнээ шүүрс алдана.
Хотол орчлонд сэгдвөл өөрөө өөрийгөө хөнөөнө.

Үхэл зөгнөм захиат Тариэль ямагт гөлөрнө.
Үнэхээр балартсанаа мэдэвч залхах завгүй уншина.
Гэгээ гэрэл тасарч нулимсан үер бүрхэнэ.
Гэрээс адил үгээ анддаа Автандил хайрлана.



Эрдэмт хүний үр ийн бачимдах ёсон бус,
Эрхэмсэг мэдээ сонсохдоо гиншин цурхирах зүй бус.
Сүлдэт гэгээ бүдгэрсэн тансаг түүнээ зорьё.
Сүйт амрагийн хувиар чи минь түүндээ золгоё.

Жаргал ийяхүү ирэхэд гунигийн мөр аридаг!
Жавхаат бүсгүй биднийг ороолонгийн цайзнаа хүлээнэм.
Хувь тавилан бүхнээ хурц мэсэндээ даатганам.
Хувхай ороолонг хөнөөгөөд зовлонгүй бид эргэнэм.

Асуусан бүхэнд нь Тариэльд эевэргүү гэгч өчив.
Алдарт баатрын нүд алаглан сүртэйеэ туяарав.
Нарнаа гялалзах болор шиг тунгалаг царай нь гялалзав.
Нандин ийм хишгийг ёстой эр л хүртнэм.

Автандилд тэрээр өчрүүн '«чамайг магъя гэхэд
Алдарт мэргэдийн ухаан надаа хэрэгтэй байнам.
Талын цэцгийг сэргээхээр голын ус буулаа.
Тал нөхрийн нулимс хатаахаар чи хүчин зүтгэлээ.

Дээд тэнгэр чамайг зүй ёсоор хөхүүлнэ.
Дэлгэр их ивгээлээ харамгүй чамд хүртээнэ.
Эрчүүд хөлгөө дөрөөлөхөд сэргэлэн дуу төрнө.
Эрхгүй зовсон Асмаг амар заяа үзнэ.

Агуйн өмнө Асмаг ганцаар гуниглан суутал
Анд хоёр баатар гэнэтхэн хүрч очив.
Алтан гургалдай адил хөхүүн сайхан аялна.
Асмаг тэднийг ажингаа дан цамцтай амдана.

Урам зоригтой байхы нь нэгэнтаа Асмаг үзээгүйсэн.
Уйтгар гунигийг мартаx нь Тариэльд ер байдаггүйсэн.
Учрал сайхан явдлы нь ухаалан тааж мэдээгүй ч
Уулга алдсан юм шиг бүсгүй тийн гүйжээ.

Бүсгүйг харахдаа баатрууд яралзтал ишээнэм.
Бурхан тэнгэрт биднийг ивгээн тэтгэлээ гэнэм.
Үүлэнд орсон сарыг олж барилаа гэнэм
Үйлээ эдэлсэн бидэнд шинэ цаг ирлээ гэнэм.

Хөлгийн нуруунаас үсрэн бууж Автандил бүсгүйг тэврэв,
Хөвчийн модыг донсолгох мэт үнэнч түүнийг таалав.
Аяа, хөөрхий цогцсы нь ариун нулимсаар угаав.
«Авчирсан мэдээгээ өчмүү» гэж энхрий бүсгүй асуув.



Энхрий таны тэтгэсэн эрхэм тэр ахайтан
Элбэг зовлон амссан саран гуа дагина
Ивгээж явуулсан нь энэ гэж захидлыг бүсгүйд өгөөд
Их зовлон нь ухагдана, гэвч удахгүй аврагдана гэв.

Танил бичгийг харахдаа айх, гайхах зэрэгцэн
Тав баахан алдан, оюун ухаан нь бүдгэрэв.
Энэ бие нь бадайрч нэг л жигтэй болоод
Эдгээр бүхэн үнэн үү? гэж хоёр баатраас асуув.

Автандил харну өчрүүн: «Айх гайхах явдалгүй.
Алив бүхэн үнэн. Зовлон арилах нь дамжиггүй.
Мунхаг харанхуй тонилж гэрэл тусах нь маргаангүй.
Муу бүхэн арилж сайн ялах нь хэлцээнгүй.

Энэтхэгийн их эзэн уран үгээ дэлгэнэ.
Элбэрэлт эгч Асматаа уулзаагүй юм шиг таална.
Сарнай цэцгийг умдаалж рашаан бороо цутгана.
Сайхан үйлст хүнийг тэнгэр үл орхино.

Буян хишгийн эх тэнгэр бурхныг биширнэ.
Буруугүй үнэн бүхнийг эцэг тэнгэр тэтгэнэ.
Энэтхэгийн хаан алга хавсарч наманчлан мөргөнө.
Энгүй баярт тэд агуйд орж зоог базаана.

Гаризель Автандилд хэлрүүн: «Нэгэн нууцыг дэлгэе.
Гаашааж чн сонс, журамт нөхрийн ёсоор
Гал голомты нь тасалж мангасыг дарснаас хойш
Гар хүрээгүй баялаг агуй дүүрэн үлдсэн.

Аж төрөл иймээс нээх хэрэггүй байлаа.
Авдар савы нь нэгжиж одоо хэдүүл үзье.
Барлаг бүсгүй гурвуул төдөл үгүй дээшилж.
Баян санд орохоор дөчин хаалга онгойлгов.

Хэн ч ороогүй санд эд агуурс арвин.
Хэм хэмжээгүй овоолсон эрдэнийн уул олон.
Илдийн чинээ шилтгээн авдар саваар дүүрэн.
Ид шидтэн ч тооломгүй алт мөнгө бүрэн.



МОНГОЛ
ХАМГААГАХ
УРСАЛ

Дэвэрээ хүртэл дүүрэн дөчин сан байнам.
Дэндүү баян сан бүрд тулаанд зориулсан бэхлэлттэй
Хуяг дуулга, бамбай цөм бүрэн зэхээстэй.
Хумсын чинээ ч хөндөөгүй зэвсгийн их сантай.

«Гантиг чулуун бамбай, хоёр үзүүртэй илд
Гайхамшигт зэр зэмсэг цөм бүрэн энд.
Ороолон хэрэв дайрвал цөвийн цаг ирнэ.
Онгойлгохыг зүрхлэх нэгээр амиа үрэх болно».

Ийм пайз байсан ч баатрууд ер тоолгүй
Их санг нээвэл гурван баатрын өвч хэрэгсэл.
Илд хуяг, дуулга, хурц нум, сум
Ид бахтай зэмсэг цөм бүрэн байлаа.

Ган сум даашгүй хуяг, дуулга тэргүүтэн
Гарамгай сайн хэрэгсэл хоёр баатар базаав.
Болдыг эгшинээ хэрчих илд мäs авав.
Болзооргүй далай шиг баялгийн үүд хаалгыг нээв.

Жаргал нээсэн дийз гэж гурвуул зөвшин хэлцэж
Жавхлант тэнгэр заяав гэж эрхэм дээдлэн шүтэж
Хуяг дуулгаа баатар өмсөж зэхэж гарахдаа
Хувьд ноогдох зэвсгий нь Придонд бас авчээ.

Алт мөнгө, эрдэнэс нөөцлөн байж аваад
Агуулах сангийн үүдийг бэхлэн хаав.
Автандил баатар өчрүүн: «Гарт минь илд наалджээ.
Атаатныг дарахын төлөө үүрлэн мордьё» гэжээ.

Бийр янтай барьсан эрхэм уран та
Бие биеэ түшсэн журамт баатрыг зурагтун!
Аюумшигт ороолонгийн цайзыг сэт цохих үеэр
Алдарт баатруудын сууг дээдлэн та үзэгтүн.





ЛШ

ТАРИЭЛЬ АВТАНДИЛ ХОЁР ПРИДОНТОЙ УЧИРСАН НЬ

Асгат бүсгүйг авч Придон хааныг зорьж
 Анд хоёр баатар эрт гэгчээр мордов.
 Алт мөнгө өгч панзчингаас морь авав.
 Автандил газар мэдэхээрээ бусад хоёроо замчлав.

Яв явсаар тэд Придоны нутагт ороход
 Ялгуум их нутгийг мал сүрэг нь бүрхжээ.
 Тариэль алиалан өчрүүн: «Хааны сүргийг дайрах уу даа
 Тансаг хаантан тэгвэл нэгийг хийх байх даа

Дайсан этгээд тононом гэж хэл сураг хүрэхэд
 Дайсан хөнөөхийг Придон цэрэгтээ тушаана байх даа.
 Анд биднийг мэдэхдээ уур хилэн нь намдаж
 Алиалан бас зүгээр гэж бүгдээр инээлдэх байх даа.

Ингээд тэр хоёр Придоны сүргийг элдэхэд
 Ихэд айсан адуучид гал утаа тавиал
 «Хэн гэгч нь вэ та, яасан ичгүүргүй амьтад вэ!
 Хэзээ ч та нарыг Придон өршөөхгүй» гэж хашгирав



Адуучин сүрэгчнийг айлгахаар баатрууд нумаа онилбод
 Айж мэгдсэн тэднээр газар доргитол хашгиран
 «Дээрэмчин биднийг хөнөөнөм, авраарай та минь» гэлдээ
 Дээд эзэн Придонд гай гамшгийг мэдээлэв.

Хөлөг морио унаж тулаанд бэлэн Придон
 Хөдөө тийшгээ мордохоор цэрэг эрээ дуудав.
 Нар шиг хоёр баатар эн зэрэгцэн ирэв.
 Найдварт хуяг дуулга, зэр зэмсэг гялалзав.

Зорьсон хүн маань энэ гэж Придоныг Таризель таниад
 Золбоот баатрын өөдөөс дуулгаа аван очоод
 «Ингэж биднийг дайлна уу, зочлох гэдэг энэ үү» гээд
 Инээмсэглэн инээмсэглэн Тариль Придоныг угтав.

Эмээлт мориноос үсрэн бууж баатар нөхдөө тосож
 Эзэн хаан Придон цөм тэврэлдэн золгов.
 Гар юугаа хавсарч бурхны ном уншиж
 Гайхамшигт Придон бүгдэд тал өгч мэндлэв.

Хаан Придон өчрүүн: «Удах хэрэг юун
 Хайрт нөхөд таанууст хүчин зүтгэхэд бэлэн»
 Нар сар учрах шиг бие биенээ гийгүүлж
 Найтай баян хааны сүртэй ордноо бараалхав.

Эзэн Придоны ордны тансаг гуаг гайхав.
 Эрхэм анд Автандилаа Придон хажуудаа суулгав.
 Үзэмж төгс хивсэн дээр Таризель баатар суув.
 Үлэмж үнэт бэлгээ хаан Придонд барив.

Дээдийн сайн бэлэг одоодоо алга атугай ч
 Дэргэд юм шиг ойрхон агуй бий гэвэл
 «Өгч байгаа бэлэг өгөөмөр мутартай чинь адил» гэж
 Өмөг их тал өгч Придон баатар мэхийв.

Наргиж цэнгэж хотлоор өглөө эртлэн босож
 Нарийн ёсоо даган угаалга юугаа үйлдээд
 Анд Придоны бэлэг алт, эрдэнэ болсон
 Ариун гуа өмсгөлөө цөм бүрэн базаав.

Эзэн Придон хэлрүүн: «Зочлох ёсонд хязгааргүй
 Эндээ нэг хоноход бидэнд ер уйтгаргүй.
 Ороолон шулам эгвэл ялахад ер амаргүй.
 Одоохон эндээс мордохоос өөр зам байхгүй.

Олон цэрэг хэрэггүй, хэдхэн зоригтон болно.
Ороолон дайсан хөнөөхөд гурван зуу хүрнэ.
Атаат тэднийг устгахад мэсээ хурцалбал зохино.
Алагдахын даваан дээр байгаа гуа бүсгүйг аварна.

Ороолон шулмын орон газарт би нэг очсон.
Олон хадан уултай, дээрэс нь ороход хэцүү.
Илэрхий хурдлах хэрэггүй, нууцгай одвол таарна.
Ийм ч учраас ер олон цэрэггүй нь дээр»

Андын үгийг таалж аянд хөдлөхөөр шийдэв.
Асматад хаантан бэлэг өгч тэрээр энд үлдэв.
Үнэндээ ялалт хийхэд тэвчээр хэрэгтэй гэж заншсан
Үхэхээс буцахгүй зоригтон гурван зуун эр сонгов.

Тэнгис далай гатлан гурван баатар давшина.
Тээр сааданд торохгүй өдөр шөнөгүй довтолно.
Баатар Придон өчрүүн: «Дайсны орон ойртов.
Баахан бид боягоомжилж шөнөлөн явах нь зүй» гэв.

Андын зөвлөсөн ёсоор өдөр нь цөм амарч
Ашгүй бүрэнхий болохоор аяндаа тэд орно.
Ойртон очвол цайз өндөр гэдэг сүртэй.
Олон харуул хэрж орилон хашгирах нь жигтэй.

Газар доорхи гарцыг түмэн цэрэг сахина.
Гадаа сарны гэрэлд цайзыг баатрууд ажна.
Арга ухаан гэдэг арван түмээс хүчтэй.
Аюумшигт дайсныг хэрхэг хөнөөхөө зөвлөө гэлцэв.





LIV

ПРИДОН ЗӨВЛӨН САНУУЛСАН НЬ

Эзэн Придон хэлрүүн: «Үнэнийг би өчье.
Энэ цайз бат, бид үнэхээр цөөн.
Тулалдаж авна гэвэл хөөрцөглөсөн хэрэг болно.
Тухайлж хүчээр үзвэл мянган жил ч дэмий.

Угаасан би гэртээ биеийн сургууль хийсэнсэн.
Уян хатан хөдөлж үсэрч харайж дассансан.
Утас дамжаад гүйхэд минь хэн ч харж чаддаггүйсэн.
Улс орон даяарт гайхагдаж явсан хүнсэн.

Цалам шиддэг нэг нь урт оле аваад
Цайзны цамхгийг уургалан авах хэрэгтэй
Хээр талаар гүйх шиг би дүүлэн одъё.
Хэн ч гэсэн намайг хэрхэвч олохгүй нь баттай.

Илд бамбай авахад онцын их тээргүй.
Их хэрмийг даваад шуурга адил орно.
Харуул манааг хөнөөж хаалга би нээнэ.
Хамгаар шуугих цагт та нар яаран ороорой»



XLV

АВТАНДИЛЫН САНАЛ

Автандил Придонд хээрүүн: «Чи сайн баатар,
Арга хүчиндээ итгэсэн хойно чи ер зүдрэхгүй.
Чиний энэ саналаар дайсныг дарах нь мадаггүй.
Чин үнэндээ гэвч харуул даанч ойр байна.

Зэр зэмсгийн хавгинахыг дайсан дөрөө сонсоно.
Зөвхий санаат тэд элсэг тэгээд огтолно
Маргаж зорөх хэрэггүй, чи тэгээд өнгөрнө.
Маш их гайд унахгүйн тул, өөр арга хэрэгтэй

Бөгчим халуунаас халхлах тэр газар нуугдангаа.
Бөөн бараа тээсэн наймаачин болж ирье би.
Араар нь тэднийг тавьж илжиг хөтлөн орохдоо
Аль бүх зэвсгээ ачиж аваад орьё би.

Гурвуул орох хэрэггүй, тэгвэл тэд мэдчихнэ.
Гудиггүй нэг наймаачин гэж хуурч би дөнгөнө.
Зэр зэвсгээ яаж ийж өмсөж зүүж амжаад
Зэрлэг юм шиг дайръя. Тэнгэр биднийг илгээнэ.

Дотроос нь би тэднийг гайд өртөхгүй цохье.
Догшин баатрын ёсоор гаднаас нь та нар цохиорой.
Цоож цуургыг эвдэж цайзыг би нээе.
Цохолж сайныг хэлбэл би ер гажихгүй.





УЛААНБААТАР
САНСАГАРЧИЙН
СЭНТЭР

LVI

ТАРИЭЛИЙН САНАЛ

Тариэль баатар хэлрүүн: «Санал бодлыг чинь ухав.
Таануусын энэ санал зоригтой чинь адил мэргэн.
Илд дэмий далайгаагүй, тулааныг та нар хүсэж байна.
Ид бэрх үед юунаас ч буцахгүй баатар байна.

Гэлээ хэдий боловч бодох юм бас байна.
Гэнэт тулаан дэгдэхэд гэгээвчээр амраг минь харах байх.
Үг тулалдаан дунд би биш, таануус байдаг.
Ямар муухай гутамшиг олны өмнө хүлээнэ би!

Эр баатрын ёсоор тулаанд орвол сайн.
Эрэлхэг цэргээ гурвуул тэгш хуваан авъя.
Үүр дөнгөж тэмдгэрэхэд гурван талаас нь дайрч
Үймсэн дайсныг дийлж дайсныг эзэлж авъя.


Дайсны харуул чимээгээр тосон гараад ирэхэд
Дахин хаалга хаалгахгүй нэг нь дайраад орё.
Үлдсэн хоёр нь хаалга тушаа эр зоригтой тулж
Үйл нь ирсэн хортны цусан далай урсгаг.


Хажуунаас Придон хэлрүүн: Маргаашийн тулаан бэрхтэй
Хайран сайхан хүлгээ чамд өгсөн минь харамсалтай.
Хамгийн түрүүнд чи цайзанд нэвтэрч ороод
Хар дайсанд бууж морийг минь бэлэглэх санаатай.



Алиалж ийн хэлэхэд анд цөм хөгжилдөв.
Алив зугаа гарган наргиан хөл болов.
Омголон хөлгөө эмээлэж зэр зэвсгээ базаан
Онцгой тулалдаанд бэлтгэн тэр шөнийг нөхцөөв.

Тариэлийн өгсөн ёсоор эр зоригт цэргээ
Гааруу гурав хувааж дайран орохоор зэхэв
Хөхүүн үг хаялцаж зэр зэвсгээ янзлаад
Хөлгийн дөрөө гишгэж дайсны цайз зорив.





LVI

ОРСОЛОНГИЙН ЦАЙЗ ЭЗЭЛЖ НЕСТААН
ДАРЬЖААНЫГ АВАРСАН НЬ

Баатар гурвын дүр нарнаас хурц гийхүйеэ
Бадралт гэгээн туяагаар долоон бурхан ивгээв.
Хэр морин хөлөглөсөн үзэсгэлэн гуа Тариелийг
Харсан дайсан бахардаж хавьтсан нөхөд нь баясана.

Анд гурван баатрын адил дүрийг өгүүлбээс'
Аадрын ширүүн бороо, уулын догшин урсгал
Аянга цахилгаан дуун, атираат нуурын мандал
Арвин тэнгисийн гүн аг чиг байх мэт.

Автандил Придон хоёр аргагүй сайн баатар гэвч
Анд нөхөр Тариельтэй нь үзэлцэх зүрхтэн байхгүй.
Алтан наран мандахуйяа оддын гэгээ бөхөхчлөн
Аюумшигт давалгаан чимээ алга болон намхарчээ.

Бат гурван хаалгыг оноож баатрууд аваад
Баатар удамт дайчин гурван зуугаа дагуулаад
Үнэгэн харанхуй ахуйг аян юундаа сонгон
Үзүүрт жад гозолзуулж үүрийн бүрийгээр дайрчээ.

Тэгэхдээ уулгалан давхилгүй гэмгүй мэт гэлдрэхэд
Тэндхийн улс мэдэж тэмцэх шунал өвөрлөсөнгүй.
Төвдэн сэжиглэх шинжгүй тэднийг бүр ойртуулав.
Төвчээрт манай баатрууд хуяг дуулгаа базаав.

Ташуурын сур исгэрч хурдан хөлөг ухасхийв.
Тарчлан хэлмэгдэгч олноор хот дүүрэн орилолдов.
Тал талаас нь дайраад гурван баатар оров.
Талцан тулсан тулалдаан, орилоон маалиан хослов.

Ороолонг тэнгэр гэсгээн маш ихээр хилэгнэхэд
Онгон нарны хүрээлэн тас харанхуй болов.
Мангар дайсан этгээдийг тэнгэр дээдэс эс тааж
Махан овоо, цусан далай энд тэндгүй үүсэв.

Хурмаст тэнгэрийн дуугаар Тариэль дайсныг хиаруулж
Хуяг, бамбай нэвсийн, дуулгат толгой хяргав.
Хотын гурван хаалгыг анд гурвуул эвдлэн
Хоромхон зуур цөмрөн үерийн ус шиг дайрав.

Атаат дайсныг хядсаар цусан далай урсган
Арслан зоригт Придонтой Автандил ордноо учрав.
Аялаг хонхын чимээгээр дуудан дуудан өчिवч
Анд нөхөр Тариэлийг олноос эс олов.

Анд нөхөр Тариэлээ айн сандран эрсээр
Атаат дайсныг хуйлруулан цайзны хаалганд хүрэв.
Алмасан хурц илдээр бамбай, хаалтыг цавчлан
Арван мянган хүүр хаалгын дэргэд овоолов.

Үүдний сахиул цэргүүд үндуй сундуй хэвтэнэ.
Үжирсэн хуягны яранхайгаар хүрэн шарх үзэгдэнэ.
Үүд хаалга нь яйраад цоож цуурга нь бутарчээ.
Үнэнч нөхөр Тариэлийнхаа үйл байдлыг таньжээ.

Газар доорхи гарцаар хүүрэн дотуур явбал
Гайхал босоо ороолон саран авхайг тавьжээ.
Гайхамшигт тэр авхай, Тариэльтай учран золгоод
Ганган сайхан гараараа тас тэврэн зогсжээ.

Гал халуун тэврэлт, ганц үнсэлтээр ханасангүй
Гариг ертөнцийн дагина газар буусан шиг байв.
Ган зүрхийг уяруулан наран гэрлээр гийв.
Гашуун зовсонг амьдраад ашдын жаргал ирээ.

Санан санан тэврэлдэж, ухаан жолоогүй үнсэлдэв.
Сарнай цэцгийн цоморлиг салж ядан таалалдав.
Автандил, Придон хоёр анд руугаа ирэв.
Алтан наранд залбиран амар мэндээ мэдэлцэв.



Наран гэрэлт дагина найр тавин угтав.
Найз хоёр нөхдий нь хүндлэн бишрэн үнсэв.
Найраг сайхан үг ус адил урсган
Насан туршийн ачий нь магтан дээдлэн өчив.

Эр бие гуалиг эрхэм Тариэльдаа сөгдөн
Эрүүл энхийн тухай эхлэн тэд лавлаад
Эсэн мэнд яваад нь энгүй их баярлан
Эндэх ороолонг дагуулсандаа эрэлхэг сүртэй байв.

Гурван зуун цэргээс нь тэн хагас нь үлдсэнд
Гуньж бухимдсан Придон, дийлсэндээ хэдий баясавч
Үлдэж хоцорсон дайсныг хүйс тэмтрэн устгав.
Үнэт эрдэнэ, мал хөрөнгө үй түмнээр нь олзлов.

Илжиг тэмээ тэргүүтэн даац сайтай мал
Эрдэнийн чулуу, лавай, онц сайхан шаазан
Эд агуурс бараа, үй түмнийг авав.
Эрхэм наран авхайгаа жууз тэргэнд суулгав.

Жаран цэргээ орхиж үлдэх юмыг мануулаад
Жаргалын дээд авхайгаа залж аваад явав.
Лусын хотыг зорин уртын замд гарав.
Лут их тусалсан Фатьмагаа баярлуулахаар шийдэв.





LVIII

ТАРИЭЛЬ ЛУСЫН ХААНД ОЧСОН НЬ

Лусын хааньд элч зарж Тариэль хэл болруун:
«Лут хүчтэй дайснаа дараад би эгнэм
Элэг зүрх шархалсан дагинаа авч явнам.
Элбэрэлт хүүгийн адил эцэг ёсоор угтмуу.

Ороолон дайсныг хөнөөж орон улсы нь дагуулсан
Онцгой их гавьяа хаан танаа ноогдном.
Эрхэмсэг хатан Фатьма эгчийн хайраар энэрэн
Энэх наран дагины маань дайснаас аварсан гэнэм.

Танай орныг зорином, угтан та золгомуу.
Тансаг таны мэдэлд эзэлсэн орноо тушаанам.
Хүн ардаа хүндэлж засаг төрөө бэхлэгтүн.
Хүрэлцэн очиж чадахгүй, өөрөө морилон ирэгтүн.

Хатан Фатьмаг ирүүл гэж Усенд та тушаагтун.
Хайрлаж аварсан хүнээ амьдыг үзээд баярлаг!
Эрдэнэт наран адил дагинатай учрахаас илүү
Эрхэм дээд жаргал түүнд яахин байх билээ.

Тариэлийн элч ирмэгц хаантан хэмгүй баярлаж
Таатай үнэний учир дээд тэнгэрт тал өгч
Хэн хүнийг хүлээлгүй өөрөө яаран мордож
Хэрцгий дайсныг дарсан баатартай учрах болов.



Үнэ өнгө, булаалдсан эрдэнэ тансаг шилж
Үй түмэн агуурс тэн тэнгээр ачиж
Арслан баатар эр, наран дагинатай учрахаар
Арав хоног турш Фатьмаг дагуулан оджээ.

Баян лусын хаантай учрах гэдэг таатай.
Баатар эрс тэврэлдэн цэрэг эгнэн жагсав.
Магтаал үг сонсон Тариэль тал өгөв.
Манлай эрдэнэ дагиныг харсан бүхэн гайхав.

Ариун дагинатай учран Фатьма баахан тэвдэж
Амар мэндий нь эрж эрээ цээргүй үнсээд
«Мунхаг харанхуйг гийгүүлсэн дээд тэнгэр мандаг!
Муу юм насгүй сайн юм мөнх» гэв.

Тансаг дагина Фатьма тэврэн зөвөргүү хэлрүүн;
Туйлдаж зүдэрсэн зүрхийг баярын салхи үлээвэл
Түмэнтаа элсэн сар ч хорвоог бүхэлд нь гийгүүлж
Түүртэж гандсан сарнай ч нарыг хүртдэг гэнэм.

Баярын хундага өргөн лусын хаан наргиж
Балмад ороолон дарсан зоригт баатрыг хөхүүлж
Долоон хоног тэд ертөнц доргитол найрлав.
Дов, гүүрийн адил алт эрдэнэ халив.

Эрдэнэ тансаг тэргүүтэн мяндас торго бүхэн
Эрхэмсэг Тариэльд өргөсөн, үнэлж баршгүй тэтэм
Гал улаан өнгөтэй, мөнгөн хаан ширээ
Гандашгүй дээд чимэгтэй баатар цөм зохицжээ.

Оюу, мана шигтгэсэн өмсгөл зүүлт бүхнийг
Оройн гуа дагинад хаан бэлэг барьжээ.
Хос сэтгэлтний ширээнээс туяа очлон цацарна.
Хотол олны зүрхийг тэр хоёр хайлуулна.

Автандил, Придон хоёрт мундахгүй бэлэг барина.
Адил хоёр хөлөг, эмээл хазаартай өргөнө.
Өнгөт сайхан хувцас, эрхэм бүхнийг базаав.
Өгөөмөр хааны ёс доо» гэж баатар тал өгөв.

Эрэлхэг Тариэль өчрүүн: «Тантай учирсандаа баярлана.
Эрхэм хаан таны бэлэг зэлэгт хананам.
Бие биенээсээ гуа элбэрэлт бид бүгдээрээ
Бишгүй сайхан цэнгэж зөв зүйтэй наргив.



Хаантан харну өчрүүн: «Арслан зоригтон эр
Хас төрийн эзэн, ашид хамт байхсан.
Чамтай эс уулзвал амь нас богиносоно.
Чармайж нэг учирвал үүрд мэнд явна.

Тариэль Фатьмад хэлрүүн: «Чи эгч минь болтугай.
Тандаа би тэгээд мөнхөд өртэй явтугай.
Ороолонг дарсны учир өргөсөн бүх бэлгийг
Одоо би тандаа өөрийн гараар баринам.

Харну Фатьма өчрүүн: «Хаантантай учирч баярланам.
Хагацаж одох төдийд ухаан сэхээ алднам.
Тантай хам одвол миний жаргал тэр сэн» гээд
Талархан дээдлэх үгээ дахин дахин дэвшүүлэв.

Үзэсгэлэнт гурван баатар лусын хаанаа бараалхаж
Үнэхээр танаас хагацах хэнд ч гэсэн бэрх.
Зорих газар хол, явахаас өөр аргагүй.
Золтой дээд хаантан биднээ өршөөн соёрхмуу.

Итгэл бүхнийг шингээсэн эцэг минь чухам та.
Ивгээл хайраа соёрхож хөлөг онгоц өгмүү» гэв.
Хаантан харнуд өчрүүн: «Юу дуртайгаа авагтун.
Харихаар нэгэнт шийдсэн бол дураа дагаж явагтун.

Эрэг тушаа зогсох хөлөг онгоц бэлэглэж
Эр гурван баатар уйлан хагацан одов.
Улс олон хайлж гиншин гаслан үдэв.
Уй гашууд автсан Фатьма нулимс урсгав.

Андгай тангараг нэгтэй анд гурван баатар
Аялаг эвээ зүзаатган хөх далайд хөвнөм
Аялгуу дуу хангинаж инээд хөөр цууриатан
Амраг сэтгэл уужирч улам ч гуа болном.

Зүйргүй сайхан мэдээг эгч Асматад дуулгахаар
Зүйтэй их ялалтыг Придоны шадарт сонсгохоор
Элч зарлага мордуулж наран дагина айсуй.
Эдүгээ бид ажрахгүй, хүйтнээс ч айхгүй» гэжээ.

Далайн эргээр одоход дагина жуузана заларнам.
Дамай зовлонг мартаж инээдэм наадам болном.
Хаан Придоны нутагт ороод ирэх дөхнөм.
Хамгаар тэднийг угтаж ая дуу баринам.



Хаан төрийн түшмэл үй олон цуглажээ.
Хайрт бүсгүй Асматын зүрхний шарх аньжээ.
Дагнын тэврэн үнсэж тэр хоёр салдаггүй.
Даанч үнэний хүчин хөөрхий бүсгүйг орхиогүй.

Асматад Нестан хэлрүүн: «Чамайг ихэд зовоолоо.
Ариун тэнгэрт гэвч ивгээл өршөөл хүртээлээ.
Уужим тэнүүн сэтгэлтэй энхрий бүсгүй чинийхээ
Уудам их ачийг хэрхэн хариулам билээ дээ»

Хариуд Асмаат хэлрүүн: «Сарнайг гандуулж хаяагүй
Хатан дээд тэнгэр гэгээ гэрлээ хайрлаж
Далд бүхнийг нээж чамайг аварсан ажээ.
Дамай үнэн байх нь боолын ёс гэжээ.

Дээд язгуурт түшмэлүүд гурван баатрыг магтаж
Дэлгэр их ивгээлтэй бурхан тэнгэрийг биширч
Зовлон гамшиг барагдав, тантай учрах таатай гэлээ
Зориудаар учруулсан шархаа тэнгэр өөрөө анагаав гэлээ

Эртний заншил ёсоор баатрын гарыг үнсэж
Эзэн Тариэль хэлрүүн «Бидний төлөө танайхаас
Амь үрэгдсэн баатруудын цуу алдар мандаг!
Ариун тэдний сүнс диваажинд очиж төрөг.

Хөөрхий тэд үрэгдэж би ихэд шаналсан
Хөх тэнгэр гэвч тэднийг нигүүсэн өршөөнө»
Ийн хэлээд хайлахад нулимс, цас холилдоно.
Ид гурван есийн догшин жавар тачигнана.

Хаан эзнээ хайлхуйяа цөм даган мэгшиж
Хамгийн хатуу эрч элэг зүрх нь зөөлөрч
Адаг сүүлд нь олноор «Мэргэн дээд эзэн минь
Ачит тантайгаа учраад хайлаад бид яанам бэ?»


Таны адил зовсон хүн бидэнд байхгүй бишүү?
Тансаг эзний төлөө хэн ч үхэхэд бэлэн» гэв.
Хажуунаас Придон өчрүүн: «Санаа бүү зовогтун
Хатан дээд тэнгэр хариуд нь жаргал заяав биш үү?»

Нөгцсөн баатрыг эмгэнэж Автандил үг хэлэхүйеэ
Нөр олон дагаж «одоо бид жарганам
Арслан баатар, дагинатай учран золгосноос хойш
Аль байдгаараа бид наргих ёстой» гэлээ

Ийн явсаар тэд хотын захад оров.
Их хэнгэрэг цан сүртэйеэ нижигнэв.
Бүрээ бишгүүр хангинаж хөл үймэн дэгдэв.
Бүгд улс зээлээс энэх чимээгээр цугларав.

Орон гэрээ орхиж, олз олбороо мартаж
Олон бүгдээр хурж наймаачин панзчин ирэв.
Хотол олноор шахцалдан баатрыг харахаар тэмүүлэхэд
Хотын харуул ганцаардан аргаа баран зогсов.

Алдарт Придон хааны тансаг ордноо морилоход
Алтан бүс бүсэлсэн боол олноор угтав.
Өргөө ордон цөм алтаар нэхсэн хивстэй.
Өнөр цэргээ зугаацуулж алт тэнд овоолоостой.





LIX

ТАРИЭЛЬ, НЕСТААН ДАРЬЖААН ХОЁР ПРИДОНЫ ОРДНОО ХУРИМЛАСАН НЬ

Хуримлах хоёрт зориулж улаан, цагаанаар ялгарсан
Хурц эрдэнэ тоногтой үзэмжит ширээ бэлтгэжээ.
Хар шар өнгөтэйг Автандил баатарт зэхжээ.
Хамгаар ширтэн баясаж тэд ширээндээ заларчээ.

Дуучин хуурчин жигдэрч ая өргөн түрнэ.
Дуутай цуутай хуриманд бэлгийн дээдийг барина.
Эзэн Придоны найр хөл хөг ихтэй
Эрхэмсэг хатантныг олноор таалан бишрэх нь бахтай

Галууны өндгөн чинээ есөн том сувд
Гайхамшигт наран хиртэй эрдэнийн үнэт чулуу гэх
Харанхуй шөнийн цагт гэрэлд нь урламаар
Хамгийн дээд бэлгийг хаан Придон барив

Оюун эрдэнээр урласан хүзүүний нандин чимэг
Олж тоолоход бэрх бэлэг бүхнийг өргөв
Автандил баатрыг бас Тариэлийн анд хэмээн
Аяганы алтан тавиур, бас бусыг барив

Алтан тэр тавиур дээр том эрдэнэ тавьж
Андын үнэн сэтгэлээр Автандил баатарт өргөжээ.
Мяндас, тансаг, торго уужим ордноо дүүрэн
Мянга түм тал өгч Тариэль цэцнээ гайхуулна.



Найман хоног турш хурим найр дэлгэрч
Нандин бэлгийг зочдод өдөр бүр барьж
Аялгуут ятга, хуур өдөржин шөнөжин хангинаж
Аялаг гуагаа илтгэж залуу хос туяарна.

Ид найрын дунд Придонд Тариэль хэлрүүн:
«Идэр анд чи намайг цэнгүүлж өгөв.
Намайг аврахын төлөө өөрийгөө чи хайрласангүй.
Нандин рашаан болж намайг чи анагаасан.

Автандил баатрын ач туйлын их билээ.
Андынхаа зовлонг хариуд нь хөнгөлөхийг би хүснэм.
Тусын нь хирээр би хүчин зүтгэх ёстой.
Тухайлж яавал зохихыг түүнээс асуу» гэлээ.

Автандилд чи хэлээрэй. Ачий чинь хариулахад бэрх
Аяа дээд тэнгэр гэвч биднийг өршөөн нийгүүлсэнэм.
Санаж зорьсны чинь хэрэв биелүүлж эс чадвал
Сайхь миний бие хээр хөдөө өнгөрнөм.

Яахин тус болохыг түүнээс чи асуугаарай.
Ямар ч атугай би Араб оронд очихсон.
Эвээр яриад болохгүй бол эр хүчээр олно
Эхнэртэй нь эс нийлүүлбэл амрагаас би сална»

Энэ хэлсэн бүхний нь Автандилд Придон уламжилбал
Элэг зүрхний угаас хөхүүн гэгч инээгээд
Ямар тус эрэх вэ дээ? Айхавтар шарх амсаагүй.
Янаг ганц түүний минь ч ороолон шулам тамлаагүй.

Гэгээн тунгалаг хатантан ширээнээ тайван заларнам.
Гэм хорын дайснаас эрхэмсэг тэр эс айнам.
Ороолон шулам, идтэн түүнийг эс дарланам.
Онхийн хэрэггүй атал тусламжаар би яанам бэ?

Амссан зовлонгийн учир дээд тэнгэр өршөөж
Алаг зүрхний зовлонг баяр баяслаар хөөж
Алтан нарны туяанд энэ бие минь гийтэл
Алив жаргал ээрэх нь үнэндээ л нэг талаар юм.

Учирлах энэ үгийг минь Тариэль чн сонсгоорой.
Ухаант эзэн минь өршөө, намайг талархах хэрэггүй.
Чиний төлөө зүтгэх гэж энэ хорвоод мэндэлжээ.
Чигч шударга явсаар өнгөрөх тавилантай ажээ.

«Амрагтай нь учруулахыг хүснэм» гэж хаантан чи айлджээ.
Анд нөхрөө боддог чиний сэтгэл мөн ажээ.
Өчих үг минь явцгүйн адил сэтгэлд мэс хэрэггүй буюу.
Өндөр тэнгэрийн ивгээлийг хүлээн суух минь дээр буюу.

Эрхгүй миний мөрөөдөл биелэхэд нь мишээх зүйл бол
Энэтхэгийн эзэн болоод чи алтан ширээ зэхэх буюу.
Хэзээ ч үл шингэх хатантан зэрэгцэн заларч
Хэтэх нэгэн дайсангүй жаргах цаг ирээ буюу.

Хүчин эцэслэтэл зүтгэх ганц зорилго энэ билээ.
Хүсэлт ханьтайгаа золгохоор тэгэхэд би буцах болой.
Эргэх цагийн улиралд миний зовлон нимгэрнэм.
Эрт дэмий магтуулахыг сэтгэл үл тэвчнэм.

Автандилын энэх үгийг Тариэль сонсоод өчрүүн
«Алив шуламтай ч атугай тулалдахыг үл хүснэм.
Наран дагиныг олоход хүчин зүтгэсний нь адил
Нандин хайрт андаа би туслах учиртай.

Автандилд чи өчигтүн: «Эзэн хаантай чинь учрахсан.
Албат боолы нь хөнөөж гай гамшиг тарьж билээ.
Өршөөл гуйж танилцаад эх орондоо буцах сан.
Өөр бодох зүйл над байхгүй билээ.

Нэхэж бас хэлээрэй «Дэмий нуршаад яахав.
Нэгэнт тогтсон ёсоор мордохоо өглөө бэлтгэнэ.
Арабын эзэн хаантан эвийн үгийг зэмлэхгүй.
Амраг охиноо өгтөл хүлээхээс өөр замгүй.

Ахин Придон Автандилд Тариэлийн үгийг өчөөд
Андаа гомдоож хэрэггүй» гэж хувийн зүгээс нэмэв.
Эзэндээ үнэн байх нь боолын үүрэг билээ гэж
Энэ үгийг сонсохдоо Автандил бас л шаналав.

Тариэль баатрын хөлд Автандил зөвхийрэн мөргөөд
Таарах харцаа буруулж хөлий нь тэвэрч аваад
«Эзэн Ростаны өмнө хийсэн нүгэл хэмжээгүй.
Эрхбиш ингэж дэмжвэл хөнөөлөөс ер ялгаагүй.

Тэнгэрийн цааз хатуу чи зорьсноо давахгүй.
Тэрслүү өшөөтөн нь болж эзэндээ би чадахгүй.
Эрхэмсэг түүний өмнө хурц илд минь мохно.
Эзэн хааны өөдөөс боол сарвайбал мөхнө.



Ийм хэрэг таривал амрагтай муудаж мэднэ.
Ихэд хилэгн сэн бүсгүйн янаглахаас илүү хүчтэй
Дахин учрахыг горилхийлж түмэнтаа би шанална.
Даамай зовлонтын заяаг хорвоогийн хүн эс шүүнэ» гэлээ


Наран лугаа адил Тариэль баатар мишээн
Насан бага андаа тэврэн босгож ирээд
Чиний хүчээр би жаргалаа олсон биш үү.
Чин үнэнч анд минь жаргах ёстой биш үү.

Ижил дасал нөхөд нэрлэхэхэд би дургүй
Их зантай ч юм шиг хөндий явбал урамгүй.
Анд нөхрөө гэсэн нь надтай хавьтвал таарна.
Аандаа тэгэхгүй нэг нь холдож байвал зохино.

Сүйт чиний бүсгүй Арабт байдгийг мэднэ.
Сүлдэт журмын нөхөд учрахаас булзах хэрэг юун.
Элдэв яриа хөөрөөгөөр Арабын эзнийг биширч
Эзэн ширээндээ залрахад нь учрахыг би хүссэн юм.

Хааны охинтой гэрлэх нь дээдийн шан учраас
Хамаг бүх чадлаараа би гуйх болно.
Энэ биеийн чимэг, хагацаж явах амаргүй.
Эрхбиш учрахыг зорьсоор эндээс шаналах нэмэргүй.

Тариэль хэрхэвч буцахгүйг Автандил баатар ухаад
Тас зөрөхөө больж аяы нь аргагүй дагав.
Эр зоригтон шилж Придон хаан дагуулаад
Элбэрэл журмын нөхөд алсыг зорин мордов.





LX

ГУРВАН БААТАР АГУЙ ДАЙРЧ АРАБ ОРОНД ОЧСОН НЬ

Дээд тэнгэр гэдэг бол гагцхүү сайныг бүтээнэм.
 Дэмий булай юмыг эгшин төдийд тонилгоном.
 Сайн юмыг тэтгэж ашид мандуулж байнам гэж
 Сайхь их ухаантан Дивнос гэгчээр номложээ.

Наран гурван баатар арслан адил дүүлэнхэн
 Нандин ганц чимэг гэгээн дагина залранхан
 Эрдэнийн туяат царайд нь эрэвгэр сормуус зохижээ.
 Эрхэмсэг чимэг болсон шүд нь яралзан мишээжээ.

Жууз тэргэнд дагинаа дээдлэнхэн тахиад
 Журамт нөхөд замдаа авланхан намнаад
 Явсан газар бүрд нь баярланхан угтаад
 Ямагт сайны үг цууриатанхан байжээ.

Төвд нь Тариэль баатар үдийн нар шиг гэгээтэй
 Төгс мэргэн яриа өдөр бүр дэлгээтэй.
 Эл хуль газар өргөн хөндий зурайна.
 Энэ газрыг Тариэль эрхий хуруу шигээ мэднэ.

Баатар Тариэль өчрүүн: «Хувь заяаны эрхээр
Баялаг энэ нутгийн эзэн нь би байгаа юм.
Энд би зовж билээ л, АсMAT зоог бэлдээрэй
Эрхгүй цөм гайхахаар бэлэг би авчирья»



Хадан ханан дундуур агуйд цөм очив.
Хайрт бүсгүй АсMAT бугын мах шарав.
Зол заяандаа бахдаж наргин цэнгэн хөгжив.
Зоригоор жаргал ивгээсэн дээд тэнгэрийг бишрэв.

Хөхүүн гурван баатар агуй дундуур тэнэж
Хөлгүй баян санг олж цөм үзэв.
Баян ядуугүй болж эгнэгт жаргасан хойно.
Байгаа энэ баялгийг хэн хэмжиж явахав.

Эзэн баатар Тариэль өгөөмөр бэлэг хайрлаж
Эрхтэн ямбатан, эр цэрэг цөмийг ханатал хөхүүлэв.
Алс холын аянд дагасан дайчид урамтай.
Арвин их баялаг огтхон ч дундрахгүй төлөвтэй.

Тариэль Придонд өчрүүн «Чиний ач үлэмжхэн.
Тансаг энэ сан, олдох бүхэн чинийх.
Зүй ёсоор ноогдох өөрийн хувь юугаа
Зүрхний анд чи минь гэртээ аваачигтун» гэлээ

Хаан Придон мэхийн харну ийн өчрүүн;
«Харамж шанд шунана гэж хэрхэн та бодном бэ?
Чамтай гэвч маргавал гутамшиг тарихын тэмдэг
Чи намайг энхрийлбэл миний жаргал тэр»

Тоймгүй их баялгийг гэртээ зөөж аваачихаар
Тоогүй олон тэмээнд Придон хүн илгээжээ.
Араб орныг зорьж анд баатрууд мордоход
Амраг наран дагинадаа золгохыг Автандил яарчээ.

Өнө удтал аялсаар зорьсон газраа хүрчээ.
Өнгөт ордон харш, тосгон айл дайралджээ.
Хатан зоригт Автандилыг дурсах тэмдэг болгож
Хамаг олон иргэн хар хөх хувцас өмсчээ.

Эзэн хаан Ростанд Тариэлийн элч хүрээд
Энэтхэгийн хаан би танайд зорин ирэв.
Эрхэмсэг их хаантантай учран золгохыг гөрддэм.
Энхрийн гуа сарнай чинь эсэн мэнд явнам.

Та бидэн хоёр таагүй учирч билээ.
Тасалж замы минь боохоор та элдэж билээ
Өөрийн эрхгүй хилэгнэж, танай цэрэг нэхэхэд
Өмөг сайн эрчүүдийг хайргүй сөнөөж билээ.

Хөлгийн жолоог нааш залж тантай учрахаар ирлээ.
Хөндийрч өнгөрснийг умартаж сайнаар уулзахыг хүснэм.
Хаан Придон мэднэ, өргөх бэлэг багатай.
Хамгийн дээд бэлэг л таны үнэнч Автандил»

Эрхт эзний өмнө боол өвдөг сөгдөв.
Эрхэмлэн өчих үгий нь хаан эгшинээ ухсангүй.
Хатан хаан Тинатин улам гуа болоод
Хавирган сар шиг сормуус нүүрнээ сүүдэр буулгав.

Хөнгөрэг цан дэлдэж үй олон бужигнана
Хэл заргүй зочдыг цэрэг олноор угтнам.
Агтын туурай тачигнаж хээрийн билчээрээс авчирнам.
Арслан зоригт эрс үер адил үймнэм.


Эзэн хаандаа бараа болж язгуурт олон даганам.
Энэх сургийг сонссон хэн хүнгүй цугланам.
Муу юм насгүй, сайн үйлс мөнх гэж
Мутраар хайрлан адислагч дээд тэнгэрийг ерөөнөм.

Элбэрэлт нөхөд харилцан сэтгэл ихэд хөдлөн
Энхрий зөөлөн үгээ Автандил Тариэльд өчрүүн,
Үнс хийсэн бужигнах тэртээ хөндийг ажмуу.
Үйлзэх тэр гал дунд би шатсан билээ.

Хүний зэрэгт хүргэсэн их эзэн тэнд бий.
Хүндэлж бидэнтэй учрахаар яаран тэрээр явж бий.
Очно гэхэд ичнэм, та нар өөрсдөө мэдэгтүн!
Одоо намайг яахаа Придон хоёул шийдэгтүн!

Гариэль хариу хэлрүүн: «Эзнээ наманчлах зүйтэй.
Тамлан зовоох гамшиг дайчидтай хуваалцах ёстой.
Хаан Ростантай учирмагц чиний намууныг өчмүү
Хайрт наран гуа чинь чамтай нийлэхэд итгэмүү.

Арслан адил сүртэй Автандил хуарнаа эргэхгүйеэ
Анд Тариэль амрагтайгаа санаа үймүүлэн суунам.
Амраг Нестаны сормуус зүсэх адил зурайнам.
Алдарт Ростаныг угтаж идэт Тариэль одном.



Баатар Тариэль, Придон давжхан талыг туулж
Баярт гуа Тариэль яарахыг хаантан харж соёрхном
Хөлгөөс хаантан яаран бууж Энэтхэгийн хааныг урхнам
Хөөрхий эшгийн адил хүндлэл бүхнээ хүртээнэм.

Эзэн хаанд мэхийж Тариэль амрыг эрэхэд
Эрхэмсэг хаантан түүнийг таалан таалан үнснэм.
«Өдрийн хугархай хагацамгүй гэгээн тунгалаг нар» гэж
Өндөр их эзэнтэн баатрыг хүндлэн соёрхном.

Баатар Тариэлийн гуад Арабын эзэн согтуурч
Бардам сүр жавхланг гайхан гайхан ширтнэм.
Эзэн хаан Придон түүний өмнө мэхийж
Эрхэмсэг Автандил баатрыг хаан хүсэн соёрхном.

Тариэлийг магтан бишрэвч хааны дотор гунигтай.
Таны зүрхний зугаа, би боол гэлтэй,
Сайн үйлс би олныг бүтээсэн боловч
Сайхь Автандил лугаа тэнцэх нэгэн үгүй.

Автандил болзоо хожигдсонд хилэгнэх хэрэг алга.
Алив хорвоогийн сайхныг эзгүй хээрд амсъя.
Яагаад Автандил саатсан учрыг би өчмүү.
Ямар ч гэсэн үгээ ялгуум зоригтой эхэлмүү.

Хаад ноёд морилж цэрэг эр ирэв.
Хамаг олны дунд Тариэль онцгойрон туяарав.
Үзэмж гуад нь автаж хүний оюун бүдгэрнэм.
Үгүүлж ярих үгийн уран цэцэн нь гайхагднам.

Өчих ёстой үгийг цөмний илчлэх бэрх буй заа.
Өчүүхэн би гэвч тантай учирсан завшаанаа
Наран тунгалаг баатар, харанхуйг тонилгогч гэгээний
Нандин ганц хүслийг тандаа айлтгахыг зорином.

Өөрийн зовлонг мартан таны баатар Автандил
Өр зүрхний жаргал олоход надаа тусалжээ.
Олон үг нуршихгүй, чухам үнэнээ өчье гэж
Онцлон бид хоёр ийнхүү шийдсэн үнэн ажээ.

Танай охинтой Автандил сэтгэл нэгтэй билээ.
Тамын зовлон баатар амсдагий нь мэдэх билээ.
Эцэг хүний ёсоор та тэднийг өршөөмүү?
Энгүй зоригт баатарт ганц охиноо хайрламуу?

Хэлэх үг минь дуусав гээд баатар эр босон
Хэлхээ мэт алчуураар хүзүү юугаа ороов.
Өвдөг сөгдсөн Тариэлийн өчих үг нь гунигтай.
Өнө явдлыг харсан хүмүүс гайхах нь жигтэй.

Өвдөг сөгдсөн зочныг Ростан хараад гунив.
Өөрийн эрхгүй тэрээр газар тултал мэхэхсийв.
Баяр жаргал бүхэн минь алсад одсон бүлгээ.
Баатар таныг гунихад сэтгэл зовном» гэлээ.

Эзэн дээд хаан минь, санасан бүгд чинь бүтнэ.
Эрхэмсэг ганц охиноо харамлах сэтгэлгүй өгнө.
Өөрөө уламжилж болно. Миний хэлэх үгийг
Өр зүрхний Автандилиг хаана ч хэн ч олохгүй.

Автандил шиг үрийг тэнгэр над заяахгүй
Амраг охин түүндээ ширээгээ өгөхөөс дээр нь үгүй
Өнгөрч байгаа би чинь цэцэглэж байгаа сарнайдаг
Өгөөмөр их эрхээ зүй зохисоор шилжүүлнэм.

Боолд ч гэсэн охиноо би өгөхөд бэлэн
Болох болохгүй учрал тэнгэрийн тааллаар тохиолдоно.
Энхрий хайрт Автандилтайгаа учран золгох юмсан.
Эрхт тэнгэрийн зааврыг зөрөх учир алгасан.

Хааны үгийг сонсохдоо Тариэлийн сэтгэл таатай.
Хайр хүндлэлээ илэрхийлж толгой мэхийх нь зүйтэй.
Хэн хэнээ дээдлэн эзэд намалзах сүртэй.
Хэргэм дээд хаантны ёсон ийм ажгуу.

Баярт мэдээг Автандилд Придон хүргэхээр яарав.
Бараг өөрт нь ноогдсон мэт учир зүггүй баярлав.
Автандилыг дагуулан алхаж явах нь урамтай.
Ачит эзнээс баатар эмээж байх нь горимтой.

Эзэн хаан дээшлэхэд баатар мориноос буун
Энгүй зовсон нүүрээ нөмрөг юундаа нуухад
Нарыг үүл бүрхэн, сарнайг хяруу дарах шиг
Нандин гуагаа гэвч нуух аргагүй болох шиг.

Хайрт баатраа таалахаар Ростан хаан бөхийвөл
Харах дэнлүү эзэндээ баатар хөлд нь сөгдөхөд
«Энхрий хүү минь бос, ичих зовох хэрэггүй
Эрхэм хувь зохиолоор бид учирсан билээ гэв.

Хаан баатар хоёр эцэг хүү шиг үнсэлдэхэд
«Хар гай тарьж очийг усаар унтраасан» гэж
Эзэн хаан хэлэвч тунгалаг царай нь гэрэлтэй.
Энхийн үүрийг угт гэж хүүдээ захих нь сургаалтай.

Арслан адил баатраа ахин дахин таалнам.
Аялаг үгээр магтан дэргэд зуураа суулганам.
Эхэндээ зовсон хэдий ч хожимдоо жаргах баяртай.
Эрхэмсэг хааны ёсыг баатар дагах нь бахдалтай.

Алдарт Тариэль өчрүүн: Эзний үгэнд хайллаа.
Амраг бүсгүйг гэвч харах цаг минь туллаа.
Ёстой төртэй чи минь жавхаатай угтвал зохино.
Ёроолгүй хайраа илчилж бүхэнд таалагдан золгогтун.

Хэлэлцэн гохирсон ёсоор Нестанаа цөм очиход
Хэргэмт их баатруудыг үдийн нар ивгээнэ.
Илд атгасан гар чилнэ гэхийг мэдэхгүй.
Илтэд ханна зориход алжаана гэхийг бодохгүй.

Хаантан хүлгээс шилжин хатны амрыг эрхүйеэ.
Харах нүд гялбуулам гуа бүсгүй туяарна.
Ариун үгээ өчиж хатантан харну мэхэсхийнэ.
Алив учры нь тунгаахгүй ч хаачтан соёрхон угтана.

Хаан хатнаа хэлрүүн: «Цэлмэг өдрийн тэнгэр шиг
Хайрт сайхан охин чи дурлал жаргалыг ивгээнэм.
Хорин дөрвөн цагт зогсолтгүй эргэдэг саран чи
Хонгор уулын цэцэг шиг үзэмж төгс охин чи

Гуа бүсгүйн сайхныг хэн хүнгүй биширч
Гуалин модны мөчир шиг цөм тийшээ ханарчээ.
Хаана л хатан явбал тэнд буйгаар цугларч
Харваас нэг амрах мэт хөөрхий харцуул дагана.

Арабын нийслэл зорин олөн бүгдээр мордоход
Амраг наран дагинатай долоон бурхан зүйрлэхгүй.
Үнэн гуа царай нь хүний сэтгэлд багтахгүй.
Үй түмээр бүжигнан хааны ордноо зорино.

Эрийн зүрхийг зүсэх гуа төрсөн Тинатинд
Эзэн хааны ширээ, элдэв бүхэн зохижээ.
Эрэлхэг баатрууд бараалахваас гэрээр таалан соёрхож
Энэтхэгийн хаан Тариэль баатрын ёсоор мэхийжээ.

Хатны хамтаар Тариэль амар мэндийг асууж
Харилцан таалж тэврээд урт яриа дэлгэжээ.
Орд харш дүүрэн гэгээ туяа цацарч
Онцгой эрдэнэ шилтгээн энд тэндгүй гялайжээ.

Хаан ширээнээ суухыг Тариэльд Тинатин урихуйяа
Харин тэрээр өчрүүн: «Өөрөө чи суугтун.
Өнөө чи суухад улам ч таатай байнам
Өвч их баатар чиний дэргэд суунам»

Хатан хааныг хөтөлж хаан ширээнээ залаад
Хажуу талд нь бас Автандил баатрыг суулгав.
Алив ганган бүхэн эдний өмнө бүдгэрнэм.
Рамин, Вис хоёр ч гутааж үл чаднам.

Янагийн дэргэд суухдаа Тинатин баахан зовно.
Ялдамхан жарай нь улайж бие цогцос нь дагжина.
Хаан эзэн айлдруун: «Надаас бүү эмээгтүн.
Хайр сэтгэлийг бид мэргэдийн ёсоор тэтгэнэм.


Урт насалж удаан жаргаж яваарай.
Учрах гамшиг, уулзах зовлонгүй байгаарай.
Дээд тэнгэрийн ерөөснөөр халамж энэрэл сахнарай
Дээр настай миний ясыг таануус бариарай»

Эзэн хаантан цэрэгтээ Автандилыг дагахыг тушаан
«Эрхт тэнгэрийн зарлигаар энэ хүүг явуулнам
Насан өндөр миний хаан ширээг залгагтун
Надтай адил үүнийг зүй ёсоор бишрэгтүн» гэжээ.

Ямбат дээдэс цөмөөр, эр цэрэг бүгдээр
Ялгуусан баатар Автандилд тал өгөн мэхийжээ.
Халдах дайсанд мэс болж, хавьтах нөхөрт буян хийжээ.
Хамаг олноор Автандилд андгай тангараг болгожээ.

Эр эм хоёрыг Тариэль бэлэгдэн ерөөж;
«Эрхэм та хоёрт түймрийн гал ч хавирахгүй.
Амраг та хоёрыг дүүгээ гэж тэтгэнэ.
Аюулт дайсан таануусыг хорлож чадахгүй» гэжээ





LXI

АВТАНДИЛ ТИНАТИН ХОЁРЫН ХУРИМ

Энэхэн өдөртөө Автандил хаан ширээнд суужээ,
Эрхэм дотно Тариэль хамт бас байжээ.
Хатан эмсийн гуа бүхэнд элчээ хүртээжээ
Хайрт хоёр бүсгүй ихэр нар шиг заларчээ.

Элбэг дэвжээг хаантан өгөөмөр хурим төхөөрчээ.
Эрхэмсэг олондоо зориулж идээ цагаа базаажээ.
Өнөр олон зочиндоо бэлэг сэлэг барьжээ.
Өгөөмөр хуримын тэргүүн гуа хатантай мишээжээ.

Харийн дархан урласан хундага тагш тэргүүтэн
Хаа газрын үзэмж энд цөм хуржээ.
Хэрэв чиний бие энэх хуриманд морилбол
Хэзээ ч гэсэн холдохгүй сүүлий нь үзэх байжээ.

Сүлд хийморь эгшиглэн, бүрээ бишгүүр хангинаж
Сүйт хоёрт бэлэглэсэн алт мөнгө овоорчээ.
Архи дарс урсан хундага тагш хавиран
Арвин шөнийн уртыг элээн элээн хороожээ.

Доодос ядуу цөмийг эзэн дээдэс ивгээж
Дорой буурай ялгаггүй алт мөнгө хайрлажээ.
Амтат сархад түшигтэй энэх их найр
Арабын хааны ордноо гурван хоног болжээ.

Өглөө болохын хирд Арабын хаан хэлрүүн
«Өгөөмөр наран Тариэль минь, харахад урамтай билээ.
Хааны хаан чиний өлмийгээс чинь адисланам.
Харин таны мөр бидэндээ чимэг болном.

Эрхэмсэг тантай бидэн энэ зэрэгцэх ёсгүй» гээд
Эзэн хааны ширээг доош буулган тавьжээ.
Автандил, Тинатин цөм эн зэрэгцэн суугаад
Алдарт Тариэль баатарт бэлгийн дээдийг өргөжээ.

Арабын эзэн хаан олон бүгдийг дайлнам.
Алив нэгнийг ялгахгүй өгөөмөр гараа сунганам.
Хүн хүний ерөөлийг ханатлаа тэрээр сонсном.
Хүндэт найрчны ёсоор Автандил Придон суунам.

Хуримлагч хоёрын цээжнээ Ростаны зүрх цохилном.
Хуудуугүй сэтгэлээр хаантан хүргэн охиноо базаанам.
Хаш чулуун титэм, хаан ширээ бүхэн
Хайрлаж бэлэглэх юмыг гоочих үг дутнам

Хөлөг сайхан морь сүрэг сүргээр өгнөм.
Хөвч их эрдэнээс мянга түмээр хайрланам.
Эрхэмсэг өгөөмөр бэлгийг эгнүүлж хэрэв үзвэл
Энэ хорвоод ер нь хэзээ ч байхгүй ажаам.

Хаан Придонд бэлэглэж есөн таваг эрдэнэ
Хазаар, тоног бүрэн есөн хүлэг өгчээ.
Балгаж уусан нь их ч эрүүл саруул Тариэль
Баяр тал бүхнээ Арабын хаанд дэвшүүлжээ.

Найр хурим удаж бүтэн сар унжирчээ
Намалзах долгионоо хөвөх завь адил сунжирчээ.
Арслан адил зоригт, Энэтхэгийн хаан Тариэльд
Алт мөнгө, эрдэнэ ахин дахин өргөжээ.

Цасан ширхэг мялаасан сарнай адил Тариэль
Цаана наанагүй үнэн эелдэг үгээ хэлж:
«Амар жаргалд умбавч эх орон минь зовсоор» гэж
Автандилаар уламжилж Ростан хаанаа айлтгажээ.

Элбэрэлт таныг гомдоохгүйн тул дайснаа дарах хэрэгтэй.
Энд ихэд удвал гай ихсэх төлөвтэй
Атаат дайсныг дарж алдар цолоо мандуулаад
Ачит аав тантайгаа дахин би золгомзаа.



Эзэн Ростан өчрүүн: «Ичиж зовох хэрэггүй.
Энэ толгойгоо мэдэх учир өөрөө та шийдэгтүн.
Шилдэг дайчнаа аваад Автандил бас одогтун.
Шийдэмгий энэхүү баатрыг дайсан бас мэдэгтүн.

Эзний өчсөн бүхнийг Тариэльд Автандил хэлэхэд
Эрслэн өөдөөс нь өчрүүн: «Ингэж ярихаа болигтун.
Нар сар хоёр дөнгөж учирсан биш үү? гэхэд
Намайг няцаах гэвэл чи дэмий болно шүү.

Ганцаар намайг орхиод чи явахаар шийдэв үү?
Ганган залуу авгай андаас дээр гэж бодов уу?
Анд чамаас хагацахад би хичнээн зовном бэ?
Аялаг нөхрөө гайд орхиж өөрөө зовлон амснам» гэв.

Гоморхох үгийг няцааж Тариэль баатар хэлрүүн:
Гоц нөхөр чамаасаа хагацаад би уйднам.
Элдэв үгээр яахав, хүсвэл хамт яв л даа» гэв
Эрхэмсэг Автандил цэрэгтээ аянд бэлдэхийг тушаав.

Автандил баатар даруйхан дайчин цэргээ цуглааж
Аян замд дагуулан найман түмийг авав.
Хорезмын зэмсэг хэрэгслээр цэрэг, хүлгээ базаажээ.
Холдон одно гэхээс Арабын эзэн барайжээ.

Эгч дүүгийн ёсоор хоёр хатан салав.
Эрхэм үнэн үгээ хэн хэндээ хэлэв.
Амраглан гэврэхий нь харсан хэн ч гэсэн уйлна.
Ашдын сайхан үйлсий нь хэн ч гэсэн биширнэ.

Сар өглөө шингэвч туяа нь хамт замхардаг
Сайхь үүрийн гэгээтэй сарны туяа эс нийлдэг.
Хувь тавилан гэдэг ийм байдаг буюу.
Хуурамч хорвоогийн ёсон ингэж ирдэг буюу.

Дээд тэнгэр гэдэг бүхнийг бүтээх атлаа.
Дэндүү их зоргоороо бас хагацаах ажгуу.
Сарнай адил бүсгүйчүүд хатуу хорвоог гайхан
Салахын бэрхийг хүүрнэн уйлан хайлах ажаамуу.

Хатан Нестан хэлрүүн: «Учраагүй бол дээр сэн.
Хагацна гэдэг үгийг сонсохгүй амар байх сан.
Хэн хэнийхээ сургийг хэл амаараа мэдчихээд.
Хэзээ чухам уулзнам гэж хөөрч ярьж суух сан.



Харну Тинатин өчрүүн: «Наран чиний дүрийг
Харсандаа би баярланам, хагацахдаа би гуниглацам.
Хорвоо гэдэг хэцүү цөм түүнийг дагана.
Холдлоо ч гэсэн миний нулимс хаттал жаргаарай.

Салан одохдоо хатад сүүлийн удаа тэврэлдэж
Сажлан холдох бүсгүйг Тинатин ширтэн ширтэв.
Хариуд Нестаан харж бие биенээ мөрөөднө.
Хагацах хоёр дагиныг хэлэх үг дутна.


Хаан Ростан бас бие нь баахан тавгүйцнэ'
Харан харан хагацахдаа байнга санаа алдана.
Тогооны хөлс адилаар нулимс дуслан дусална.
Тодхон цасан ширхэг шиг Тариэлийн царай цагаарна.

Өөрийн хүүгээс ялгалгүй Тариэлийг хаантан таалан
Өмөг түшиг чи минь ойр байвал сайн сан.
Учрахдаа чи баярлуулж, буцахдаа чи гуниглуулнам.
Уйдан шаналах гэдэг зуу дахин ихэснэм» гэлээ.

Сайны ерөөл тавиад Тариэль мордон одоход
Салах ёс гүйцэтгэн дайчид цөм уйлав.
Хаана чухам учирна, хагацал хэцүү» гэхэд
«Хамгаас илүү бид зовном» гэж хариулжээ.

Гоц гойдын ухаант гурван баатар мордож
Гол төв замаар хотыг орхин одов.
Найман түмэн цэрэг тэдний хойноос дагаж
Найрам эв гэдэг нь замын уртад бэхжив.

Хосгүй гурван баатар элс замыг зорином.
Хортон дайсан учирвал сөнөх л үйл ирнэм.
Хөдөө хээрийн салхинд наргихаар тэд шийднэм.
Хөхүүн баяр дэлгэж дарс ундаан зооглоном.



LXII

ЭНЭТХЭГИЙН ХААН ХАЛЬСНЫГ ТАРИЭЛЬ МЭДСЭН НЬ

Тэртээ уулын бэлээр жингийн цуваа жирийнэ.
Тэнд яваа хүмүүс бүдэг хувцастай барайна.
Үсээ цөм тайрсан нь яавч нэг л учиртай.
Үүнийг нааш авчир гэж хаад айлдах нь сүртэй.

Даамал юугаа дагасаар наймаач олон ирэхэд
Даамай гунигийн учрыг хаантан тэднээс соёрхвоос
Энэтхэгийн оронд очсон Мисир түмний улс билээ.
Эндхийн заншил дагаж ийнхүү гашууднам» гэлээ.

Өөрийн орноос яваад нь Тариэль ихэд олзуурхан
Өтөл наймаачид тэднийг баатрууд хуурахаар шийдэн
Араб хэлээр ярилцан энэтхэг зүсээ хувилгахад
Аргагүй л өөр яриа, хувцас хунартай байжээ.

«Энэтхэгийн тухай ярьсугай гэж хаан зарлиг бууваас
«Эднийг дээд тэнгэр одоо гэсгээж байнам.
Онцгой мэргэд хүртэл ой ухаам нь бүдгэрч
Орон даяар олны нулимс урсан гасалнам».

Жингийн даамал өчрүүн: «Дээд тэнгэр таалсан
Жишээлшгүй их ямбатай Парсадан хаан байж гэнэ
Гэр нэвт гэрэлтэй, туурга нэвт туяатай
Гэгээн наран адил ганц охин заяаж гэнэ.



Алдарт нэгэн жанжин охинтой нь сэтгэлтэй болж гэнэ.
Авааль нөхөр болох хүн жанжны гарт үрэгдэж гэнэ.
Хар гай учрав гэж эзэнтэн ихэд зовж гэнэ.
Хаанытны эгч гэгч адтай амьтан байж гэнэ.

Эгч ч гэж дээ тэр нь ороолон шулам байж гэнэ дээ
Энэх хорвоог орхихдоо бөөн гай тарьж гэнэ дээ
Арга ядаад тэрээр амиа хорлосон юм байхаа.
Амраг бүсгүй, алдарт жанжин алс холд гэнээ.

Хөөрхий бүсгүйг эрээд жанжин одсон гэнэ дээ.
Хөдөө хээр өнгөрөөд хоёр од харваж гэнэ дээ.
Эрээд эрээд тэднийг олоогүй юм гэнээ.
Эдэлсэн ийм зовлондоо хаантан гутарсан гэнээ.

Охин, баатар хоёроо хаантан өрөвдөх болжээ
Онц л баярын оронд уйлан хайлан суужээ.
Олон дайсныг дарсан тэр баатар хаан
Олигтой ч их удалгүй шаналан шаналсаар нөгцжээ.

Наймаачин үгээ дуустал Нестаан цурхиран унажээ.
Найгүй гамшгийг мэдээд Тариэль ч дуу алджээ.
Эзэн хаан ааваа хоёул гашуудан санжээ.
Энгүй их зовлонг эзгүй хээр хуваажээ.

Танхил хатны тэргүүнээс хүжийн үнэр анхилна.
Талын уудмыг ээсэн нарнаас гуа үзэгдэнэ.
Магтан өчихийг горьдовч мэргэдийн ухаан дутна.
Манлай эрдэнэ адил сувдан шүд нь яралзана.

Эцгээ мөрөөдөн цурхирах нь алтан гургалдай уянгалах мэт.
Эцэсгүй зовлонд шаналах нь өнгөө гээсэн сарнай мэт.
Хонгор үсээ зулгаан, нулимс юугаа урсгана.
Хосгүй гэгээн наранд үүлэн сүүдэр тусна.

Үр болсон би чинь таныхаа ачийг хариулсангүй.
Үнэнч охины ёсоор тандаа зүтгэж чадсангүй.
Хар нүдний пөцгий минь, харах ганц түшиг минь.
Харшсан зовлонгоо хувааж яахин бид учирнам бэ?

Харамгүй тунгалаг гэгээгээ хэндээ чм тусганам бэ?
Хамаг гай зовлон яагаад эс арилнам бэ?
Ийн хайлаад Нестан үс зүсээ урна.
Илтэд нулимс мэлэрч эцгээ дурсан гиншинэ.




Хаан Таризель цурхиран: «Өмөг түшиг эцэг минь
Хас төрийн эзнийг халилаа» гэхэд гайхнам.
Өгөөмөр эзэн өнгөрснөөс хойш нар гийгээд яанам.
Өчүүхэн намайг өршөөхийг тэнгэрээс эцэг минь гуйгаарай.

Өөр зүйл байна уу гэж Таризель баатар соёрхвоос
«Өндөр дээд эзэн минь Энэтхэгт зэвүүн цаг болжээ.
Өгөөмөр их хоты нь Хятан очоод бүсэлжээ.
Өвч, нутаг орны нь Рамаз гэгч эзэлжээ.

Хатан хаан байвч зүрх сэтгэл шархтай.
Хамаг горьдол унасан ч Энэтхэг цэрэг тулаастай.
Хэрэм цайз бүхнийг дайсан этгээд эзэлжээ.
Хэцүү ийм цагт догшрон шуурах чинь болжээ.

Эгэл бидний адил цөм хар хувцастай.
Эзэн Рамазны өмнө мисир ёсоор очлоо бид.
Манай эзэн хаантай тангараг тасраагүй учир
Мань бүгдийг ийнхүү чөлөөтэй явууллаа» гэжээ.

Өчиж хэлснийг сонсохдоо Таризель амрахаа болиод
Өдөржийн хол газрыг мөчийн төдийд товчлоод
Гардан барьсан тугаа галын дөл шиг намируулжээ.
Ган төмөр цээжээ үлсынхаа төлөө дэлгэжээ.





LXIII

ТАРИЭЛЬ ЭНЭТХЭГТ ИРЖ ХЯТАНЫГ ДАРСАН НЬ

Энэтхэг орны орчим уул хад ихтэй билээ.
Энгүй олон цэргийг үзэж гайхсан гэлээ.
Баатар Тариэль хэлрүүн: «Хүлээгээд бид яахав.
«Балмад дайсныг хөнөөе, тэнгэр тэтгэнэ» гэлээ.

Илдний минь амтыг тэд амсаж л байсан сан.
Ил далдгүй цавчиж хайргүй хөнөөж явсан сан.
Харну Автандил өчрүүн: «Тэр муусайн новшид
Хатуу үгээр яах юм, одоохон арчъя» гэлээ.

Тулаанд орохсор бэлдэн ачаа бараагаа хөнгөлөн
Туурт хүлгээ унаж эр цэрэг бэлдэнэ.
Түмний газар алдартай удамт олон дайчин
Түрэх шуургын адил уул уруудан довтолжээ.

Толгойн харуулын дайсан хэдий зугтсан айтугай ч
Тоо ёсоор цөмийг олзлон барьж иржээ.
«Хаанахын улс вэ та нар?» гэж хүлэгтэй тэр олныг
Харваас догшин Тариэль ам өчгий нь арчээ.

Хариу тэд өчрүүн' «Хаан эзэн Рамаз
Хамаагүй жир биднийг хуурч авчрав» гэжээ.
Үнэхээр тийм бол явцгаа, эзэндээ очиж хэлцгээ.
Үхлийн дайн зорином гэж жанжиндаа очиж дуулгацгаа.



Эзэн дээд хаантан заларч явнам гэж хэлээрэй.
Эсрэг муусайн дайсанд өршөөлгүй гэж мэдээрэй.
Энэ биеийн тухай нүдээр үзсэн нь яриарай.
Элэг зүрх тэвдэвч үхлээс аврахгүйг санаарай.

Эр зоригт бидэнтэй үзэлцэхийг яаж зүрхлээв?
Энэтхэг их орныг дайрахыг хэрхэн зориглоов.
Тэнэг мугуйд амьтдад тэнцэх цээрлэл хүртээнэ.
Тэмтэрч муусайн тэднийг илдээ мохтол хөнөөнө.

Сүүлгүй хулгайч адил хэтэж би чадахгүй.
Сүр сүлдээ илтгэн эгнээ эгнээгээр жагс!
Дайсанд харин мэдэгд, тэд хөөрхий амьтад
Дайчин дуулга ч аврахгүй үнсэн товрог болгоно»

Дайсны харуул эгж яаран яаран одож
Дайчин Тариэлийн үгийг Рамазд цөмийг өчжээ.
Энэтхэгийн хаан иржээ. Цэрэг дайчин нь олон.
Эр хүчээ гаргавч бид дийлэх нь хэцүү.

Энэтхэг орны туг жагсаалын толгойд намирч
Эн зэрэгцэн бас Арабын далбаа дэрвэнэ.
Араб цэрэг гэдэг жадаар л гагцхүү тулалдана.
Алдарт дайчдын дунд Придон баатар явалцана.

Урагш баахан явтал таван зуун цэрэг айсуу.
Ухасхийн бүслэхийг оролдоход Тариэль хориглож хэлрүүн:
«Дайрах довтлох хэрэггүй, үнэндээ тэд зэвсэггүй,
Дайснаас хамгаалж өмссөн хуяг, бамбай дуулгагүй».

Өмнө нь явсан нэгээр газар сөгдөн мөргөөд
Өндөр тэнгэр гэсгээг, өршөөж хайрла намайг
Амьд үлдэх хувьгүйгээ би сайтар мэднэм.
Андгай тангараг няцаж эв эвдсэнээ ухнам.

Арван жил та сураггүй алга боллоо.
Аврах эзэнгүй гэдэг шувуунд ч бэрх билээ.
Хуучин өшөөгөө бодон хомхой санаа өвөрлөлөө.
Хугарсан арал адил амьдралын тэнхлэг эвдэрлээ

Ганц би буруутан, үхлийг зөвхөн бодном.
Гайтай гаван зуун түшмэл энд ирээд байнам.
Толгойгий маань, хярга, бид цөм үхье.
Тоогүй гэнэдсэн цэргийг хөнөөхгүй байхыг гуйя.

Өшөөлсэн дайснууд сөгдөн андгай тангараг өгч
Өршөөх, байх хоёрыг өөрөө мэд» гэжээ
Хаан Рамаз сөгдөвч Тариэль эс хөнөөв.
Хар гэмээ наманчилбал өршөөх гэдэг ёсон буюу.

Нүгэл хийсэн этгээд наманчлах гэж байдаг.
Нүүгэлтэн урсах нулимс уруудан буусны тэмдэг.
Ийн хайланд тэд тэнгэрийн өршөөл хүртдэг.
Их хөрвоогийн зовлонг баяраар сольж болдог.

Уян зөөлөн сэтгэл л зоригтны чимэг гэдгийг
Ухаантны сургаал соёрхогч хэн бүхэн ухнам.
Хорлох чадалгүй дайсныг энэрэн өршөөх гэдэг
Хосгүй сайны иш энэхэн үгийг бүү март.

Дээд тэнгэр адил уужим ухаант Тариэль
Дэлбэрэх шахан айсан дайсан этгээдэд хэлрүүн:
«Амь насы чинь хэлтрүүлье. Зөв замд орогтун
Алив мууг огоорч үнэний мөр хөөгтүн»

Өндөр эцэг тэнгэр, өршөөлт эзэн Тариэлийн
Өгөөмөр уужим сэтгэлийг цөмөөр бахдан хашгирав.
Амь насаа өршөөгдсөн тэдгээр этгээд баярланам.
Аюул тарьж чадалгүй Энэтхэгийн илд зэвэрнэм.

Хаан Тариэлийн догшин дуу аялгуу мэт цууриатна.
Хамаг олноор түүний гэгээн дүрийг шохоорхоно.
Дайсны цэрэг айхдаа дэлхий хавчих мэт сандарна.
Даяар Энэтхэг орныг тэнгэрийн өршөөл ивгээнэ.

Баярт сайхан мэдээг цэрэг олонд түгээнэ.
Баатар хаан өршөөв гэж тэнгэр тултал ярина.
Хөхүүн сэхүүн яриа, бүрээн дуу сонсдоно.
Хөнөөж нэг хохироосон баатар иржээ гэлцэнэ.

Энэтхэг олноор ирж эзний өлмийд сөгдөвч
Эрхэмсэг туг өөр тул тэндээ л нэг тавгүйцнэ.
Урссан нулимс хатаж Тариэлийг ирнэ гэж бодоогүй тул
«Урван төрсэлсэн хэрэг үү» сэр нь сүрхий эвгүйцэнэ.

Тариэль баатар хэлрүүн: «Эзэн би чинь ирлээ.
Тансаг хааны охин надтай цуг ирлээ.
Дээд тэнгэрийн нар их багагүй гийгүүллэ.
Дэргэд цөм ирцгээ, уулзаж бушуу учиръя»

Зүг зүгээс хүн үй олноор цуглав.
Зүс царай орж байшин, хэрэм гялалзав.
«Зовлон гамшгаас айхгүй, тэнгэр биднийг ивгээв» гэж
Зоргоороо олон хүн энд тэндгүй хүүрнэв.

Хаалга үүд нээж түлхүүр цоож хангинажээ.
Харагдах хүн бүр эмгэнэлийн хувцас өмсжээ.
Хацраа улаан болтол ирсэн зочид уйлав.
Хар нүдний сормуус өөрийн эрхгүй буув.

Хүүгийн ёсоор хаанаа Тариэль баатар дурсаж
Хүй их нулимсаа үер адил асгав.
Хасын тунгалаг нулимс хацар даган урсаж
Хайр найргүй биеэ маажин малтан балбав.

Ихэс цөм бэлбэсрэлийн хувцастайг харахдаа
Идэт баатар Тариэль улам улмаар хайлав.
Цус ус хоёр цутгалан адил урсав.
Цүглэсэн цөмөөр Тариэлийг тэврэн таалахаар тэмүүлэв.

Тариэль, Нестаан хоёрт бүгдээр эмгэнэл илтгэвч
Таг дуугүй гөлөрсөн хатантан уйлж ч чадахгүй.
Аяндаа унасан сарнайг хэн босгож чадахав
Алдарт хааны ордонд инээх баялах чимээгүй.

Хатан ээж мэдэнгээ тэднийгээ амдаж ирээд
Хайлж уйлаад яанам тэнгэр хилэгнэхээ болилоо
Хал зовлон халж буян хишиг заяалаа.
Хатан дээд тэнгэрээ биширвэл барав» гэлээ.

Өөрөө тэсэлгүй хайлж Тариэлийг тэврэн өчрүүн:
«Өнчрөл зовлон нимгэрч би дахин сэхлээ.
Сэтгэлээ чангалан барьж миний үгийг сонс!
Сэргээж өнчин биднийг бурхан тэнгэр тэтгэлээ»

Охин цурхираа хэлрүүн: «Ээж минь би яанам бэ?
Онхийн бараан хувцас өмсөөд байдаг чинь юу юм бэ?
Аав минь юу гэж ширээгээ авсаар солио вэ?
Ачит ээж минь га одоо хайлаад яах юм бэ?»

Төрсөн гагц охиноо эх нь үнсэн үнсэв.
Төгс гуа сарнай уруулд үнэгэгдэн үлгэгдэв.
Сайхан цаг ирнэм. Мууг дурсаад яанам» гэж
Сайхь охиндоо ээж сачан бодсоноо өчив.




Эгшин зуурын төдий ихэс дээдэс цөм
Эзэн Таризэлийн өмнө хүрээлэн мэхийн сөгдөв.
Ижил хоёр дэнлүүг сэтгэлийн угаас бахархан
Их багагүй цөм сайны ерөөл тавив.

Автандил, Придон хоёрыг ам амандаа шагшина.
Алдарт Таризель өчрүүн: «Хүндэт хатан ээж ээ!
Энэ хоёр анд биднийг аварсан юм шүү.
Элдвийг нуршаад яахав, зоригтой эрс шүү» гэлээ

Хүлгийн нуруунаас эмээл салган ордноо цөм орохуйяа
Хөөрхий хатан хаантан яруу үг айлднам.
«Тэнгэр бурхан тэтгэж дайснаа дарсан хойно
Тэн их найраа хөлтэй бүлтэй хийе» гэвээ

Эмгэнэл юугаа авч хуур хөгжмөө эгшиглэ.
Энэтхэг хааны ордноос наргиан шуугиан дэгдэг.
Алтан бүс юүгээ эмс охид бүсэл.
Асгарах нулимс татаж дуу хуур больё





LXIV

ТАРИЭЛЬ, НЕСТААН-ДАРЬЖААН ХОЁРЫН ХУРИМ

Хүргэн, хүүхнээ, хатан хаан ширээнээ залахад
Хүй олон язгууртан баяр ерөөл дээшлүүлэв.
Зүрх сэтгэл чангарч гуниг бүр арилан
Зүг зүг бүрд наргиан хөөрөө болов.

Хатан ээж хувцсаа сольж өмсөөд цэмцийв.
Хааны шадар түшмэл цөм хувцсаа солив.
Их багагүй олонд үнэт бэлэг тараав.
«Ид жаргал ирлээ. енгөрснийг бодоод яанам» гэв

Тариэль Нестаан хоёр аавын ширээг чимнэ.
Тансаг хоёр амраг ив ижилхэн хосолно.
Хар толгойт амьтад ингэж жаргадаг нь үгүй.
Хавтай хосыг дуулах тийм нэгэн ч үгүй.

Эр эм хоёр зорьсноо нэг гүйцээв.
Энэтхэгийн долоон ширээг хууль ёсоор залгав.
Зол жаргал ирэхээр зовлон ч ашид мартана.
Зөвлөн үзээгүй хүн жаргалын амтыг үл мэднэ.

Ширээнээ залрах хос үдийн нарнаас тунгалаг.
Ширээнээ залрах хос үдийн нарнаас тунгалаг.
«Шинэ хаанаа өргөмжилж олон цөм цэнгэлэг.
Хүүгийн адил хүрээлж сангийн түлхүүр барина.
Хүнд ёслол үйлдэн их бүрээ хүнгэнэнэ.



Автандил Придон хоёр тус ширээнээ заларна
Амьтан хүн цөмөөр тэднийг дээдлэн биширнэ.
Хилэнцэт амьтны дотор эдэн шиг хүн байхгүй.
Хийсэн барьснаа хуучил гэж улс шалаад болохгүй.

Хаан төрийн ёсоор хөлтэй хурим дэлгэв.
Харц барлаг олноор хөгжин зооглон наргив.
Өгөөмөр хуримын эздэд өргөсөн бэлэг тоолшгүй.
Өнчин ядуу хүмүүст хүртээсэн хишиг тоймлошгүй

Хатан хаан өчрүүн: Өнчин бэлбэснийг дуудагтун.
Харамгүй их хишгийг ирсэн бүхэнд хүртээгтүн.
Улсад хүртээсэн зүйлийг хэмжиж ер барахгүй.
Урт насалж удаан жаргахыг эзэн дээдэст ерөөе.

Тариэль хаатан өчрүүн: «Хатнаас ганц зүйл гуйя.
Тарчлаах үхэл хүлээсэн Рамазыг би өрөвдсөн.
Нүгэлт этгээд өршөөх тэнгэрийн ёс байдаг.
Нүнжиггүй гэмээ мэдсэн түүнийг өршөөн соёрхмуу»

«Өршөөн хэлтрүүлье» хэмээн хатан хаан өчвөөс
Өндөр эзний зарлиг эгшин төдийд биелжээ.
Найрын дуу нижигнэж дуучин хуурчин эгшиглэж
Насандаа зовсноос илүү дээдийн жаргал эдэлжээ.

Алт, мөнгө эрдэнэс уул адил овоорч
Аль дуртай бүхнээ хэн хүнгүй хүртжээ.
Дээд доод ялгалгүй улс олон цөм
Дэлгэр их хаантны харамж шанд багтжээ.

Автандил Придоны цэрэгт их хаатан айлдруун:
Аливаад нэрэлхэн зоволгүй тэнгэрийн хишиг хүртэгтүн!»
Тоолж баршгүй бэлэг тэн тэнгээр хайрлаж
Тоймлож болшгүй эрдэнээс шуудай шуудайгаар барив.

Автандил, Придон хоёрын хүртсэн их бэлгийг
Амаар хэлэхийг зоривч хэл ер цуцна.
Ачаалж зөв гэвч тэмээ мал дутна.
Ахуй байлаг цогцолсон эрдэнийн сан нээлттэй.

Авран тэтгэгч хэмээн Автандил, Придоныг шагшина,
Ариун дээдсийг авчрав» гэж ам амандаа шуугина,
Өмөг хоёр жанжинд баяр тал дэвшүүллэ,
Өдөржин улс цувж ордонд хөл ихсэнэ.



«Тангараг няцсан нүглээ алтаар чи наманчил» гээд
Тариэль хаантан Рамазыг өршөөж бэлэг өгчээ,
Гансарсан санаа нь амарсан тэрээр мэхийн ёсоод
Гайгаас мултраад баярлан эг маггүй арилжээ

Үнэнч шивэгчин Асматад эзэн дээдэс өчрүүн:
«Үр эхээс илүү ачтан билээ чи,
Энэтхэгийн долоон улсын нэгийг чи захирагтун,
Эрхэмсэг ширээнээ заларч эрх дураараа жаргагтун.

Санаандаа тохирох эрийг өөрөө чи сонгогтун,
Салшгүй үнэн зүтгэх дайчин баатар шилэгтүн,
Асмат сөгдөн өчрүүн: «эрхэм журамт баатар минь
Анд дотнын ёсоор чамдаа зүтгэх жаргал сан.

Эзэнтэн бүү хилэглэгтүн танаас холдоод яанам би,
Эзэмшил нутгаа бүхэлд нь өгсөн ч эс явнам би,
Гай барцад өнгөрч таны ивгээл хүртнэм би
Ганц өмөг хатнаас хагацаж эс чаднам би»

Хаантан хариу айлдруун. «Амссан зовлон чинь хүрнэм,
Харьшгүй шаналан цурхирч явсны чинь мэднэм,
Өчиж байгаа үгий минь хүлцэн чи дагагтун,
Өнөр дайчид толгойлж сайн үйлс бүтээгтүн.

Арга буюу зөвшөөрч Асмат бүсгүй өчрүүн:
«Амссан зовлон их ч арилах тавилантай ажээ
Сайн эрийг сонгон хаан ширээнээ уриад
Салшгүй хоёр амрагийн хурим найрыг хийв.

Өдөр шөнийг элээн гурван баатар найрлаж
Өнөд их хөгжин бэлэг сэлэг базаажээ,
Алт мөнгө, агт хүлэг аль бүгд бүрэн ч
Автандил баатар ганцаар амрагса санан гиюүрчээ.

Үүнийг Тариэль ажаад» амрагаа баатар сананам.
Үнэхээр намайг зэмлэхийг би бас ухнам.
Улам улмаар чиний шаналж байгааг болгооном.
Учирсан жамаар ганцаардан гиюүрэх минь ойртном гэв

Эзэн Придон өчрүүн: «Миний одох ч туллаа
Эргэж чамтай золгоход нутаг ч таньдаг боллоо.
Зарлиг болгох үгий чинь боолын ёсоор даганам.
Замагт нуурын усанд загас дурлах шиг шүтнэм.



Аян замд нөхдөө Энэтхэгийн хаан үдээд:
«Андын ёсоо бодон эргэн эргэн зочлоорой.
Автандил чамайг одоход миний сэтгэл хэцүүдэвч
Арсланг наран хүлээх хойно явуулах гэдэг зүй» гэв.

Хаан эзэн Ростанд өнгийн тансаг өмсгөл
Хаш эрдэнэ шигтгэсэн завьяа Тариэль бариад
Бэлгийг эзэнтэн тунгаана. Замдаа сайн яваарай гэв.
Бэрхтэй хагацлыг тэвчишгүй гэж Автандил баатар өчив.

Хангисаг өмсгөл сэлтийг Тинатинд Нестан илгээв.
Хатан үнэхээр зохисон таатай тансаг эдлэл байв.
Үдшийн харанхуй гийгүүлж урдах зам заадаг.
Үлэмжийн нандин шигтгээ хатанд бас барив.


Ах дүүгийн ёсоор хоёр баатар салахад
Аягүй их гуниг, гал адил төөнөв
Ой, талыг бялхтал энэтхэгчүүд уйлан хайлахад
Олиггүй хорвоогийн хорыг амсахсан гэж Автандил өчив.

Сайхан яриа дэлгэн хоёр баатар оджээ.
Салаа замын үзүүрээс зорьсон зорьсноо чиглэжээ.
Хос баатрын үйлс санасан ёсоор бүтжээ.
Хотол Арабтаа Автандил аз хийморио мандуулжээ.

Хас төрийн чимгээ арабчууд цөмөөр угтан
Хайрт наран дагинаа Автандил хараад тайтгарчээ.
Хаан ширээнээ хоёул жаргал эдлэн суухад
Хатан тэнгэрийн зарлигаар эзний титэм өмсгөжээ.

Мөр мөрөө түшсэн гурван хаантан жаргаж
Мөд мөдхөн учирч амар сайныг эдэлжээ.
Харь дайсан халдвал хамтын илдээр дарж
Хаант улсаа тэлж хөрөнгө зорио зузаатгажээ.

Өршөөл ивгээл юүгээ үер адил хүртээн
Синхи ядуус дэгжин зовлонгийн дуу тассрчээ.
Хортныг дарахдаа аянга шиг хооронд зуураа хонь шиг
Хонь, чоно хүртэл цуг явах нь анд шиг



ТӨГСГӨЛИЙН ҮГ

Энэх хорвоогийн гамшиг, элдэв учралыг амсан
Эргэх шөнийн зүүд шиг амьдрал урсан өнгөрчээ.
Эгшин төдийн үзэгдлийг хэн л мөнхөд тоолох вэ?
Эгнэгт ийм зовлонг Руставели яахин тоочих вэ? -

Ашдын наран ивгээлт хаан Давидын төлөөнөө
Аялгуу шүлгээ нягтланхан энэх туульсныг хэлхэв ээ.
Аюул гамшиг тарин дорноос өрнийг туулахдаа
Атаат дайсныг хөнөөн шударгыг тэрээр тэтгэв ээ.

Дээдийн гавьяа байгуулсан үзэмжит хаан Давидын
Дэлгэр их үйлсийг би бишрэн өчихдөө
Харийн хаадыг магтсан үлгэр домог тэргүүтнийг
Хатан гараар дархалсан шүлэгтээ ийн өрөв өө.

Энэ хорвоо гэдэг итгэх аргагүй хуурамч.
Эгэл хүний амьдрал нүд ирмэхийн төдийхөн.
Орчлонгийн хар гай сайныг ямагт ээрнэм.
Онхи л тоохгүй явбаас жаргалыг тэрээр эдэлнэм.

Амиран Дарежанийг дээдлэн Мосэ Хонели өчжээ.
Абдүл-Мессийг бишрэн Шавтели найраг бичжээ.
Саргис Тмогвели Диларгетийг алдаршуулан дуулжээ.
Сайхь Руставели би-гээр Таризлийг хайлан таалжээ.

ГАРЧИГ

Оршил

I. Арабын хаан Ростаны үлгэр	13
II. Ростан, Автандил хоёр авласан нь	18
III. Арабын хаан барсан хэвнэгт баатартай золгосон нь	20
IV. Тинатан барсан хэвнэгт баатрыг эрээр Автандилыг мордуулсан нь	25
V. Автандил торгон цэрэгтээ захидал хайрласан нь	31
VI. Автандил Барсан хэвнэгт баатрыг эрээр бэдэрсэн	33
VII. Автандил, АсMAT хоёр агуйд ярилцсан нь	40
VIII. Тариэль Автандил хоёр учирсан нь	47
IX. Хувь зохиолынхоо тухай Автандилд Тариэль өчсөн нь	51
X. Тариэлийн сэтгэлэл дуун	55
XI. Нестаан—Дарьжаанаас янагтаа илгээсэн анхны захидал	60
XII. Тариэль янагтаа эхний захидал илгээв	62
XIII. Тариэль хятанчуудад захидал илгээсэн нь	64
XIV. Нестаан Дарьжаан Тариэлийг урив	65
XV. Хятань Хаан Рамаз Тариэльд хариу захидал ирүүлэв	67
XVI. Тариэль, Нестан Дарьжаан хоёр уулзсан нь	69
XVII. Тариэль Хятаньг дайлсан нь	72
XVIII. Тариэль Энэтхэгийн хаанд захидал илгээж нутагтаа эргэж ирсэн нь	78
XIX. Нестаан Дарьжаан амрагтаа захидал ирүүлсэн нь	82
XX. Тариэль хайлан энэлэн муурч унасан нь	84
XXI. Тариэль амрагтаа хариу захидал илгээсэн нь	86
XXII. Нестаан Дарьжааныг эрд гарахаар зөвлөсөн нь	87



XXIII. Тариэль, Нестаан Дарьжаан хоёр ярилцаж шийдсэн нь	89
XXIV. Хорезмийн хунтайз Энэтхэгт ирж Тариэлийн гарт үхсэн нь	92
XXV. Нестаан Дарьжаан алга болсныг Тариэль мэдсэн нь	93
XXVI. Тариэль Нурадин—Придон хоёр учирсан нь	100
XXVII. Придонд Тариэль тус хүргэсэн нь	103
XXVIII. Нестаан Дарьжааны тухай Придон өгүүлсэн нь	105
XXIX. Автандил араб орондоо эгэж ирсэн нь	112
XXX. Автандил аялаар одохыг хүсэж эзэн хаанаас соёрхол гуйхыг түшмэлээс хүссэн нь	119
XXXI. Аянд сэм мордохын өмнө Автандил, Шермадин хоёр ярилцсан нь	125
XXXII. Ростан хаанд Автандил гэрээс үлдээсэн нь	128
XXXIII. Автандил мөргөл үйлдсэн нь	132
XXXIV. Автандил сэм одсоныг Ростан хаан мэдсэн нь	133
XXXV. Тариэльтэй учрахаар Автандил одсон нь	136
XXXVI. Автандил Тариэлийг олсон нь	141
XXXVII. Эр арслан, эм барс авласан тухай Тариэль өгүүлсэн нь	146
XXXVIII. Тариэль, Автандил хоёр агуйд ирж Асмастай учирсан нь	148
XXXIX. Автандил Придоныг зорьсон нь	153
XL. Автандил Придонтой учирсан нь	156
XLI. Автандил Нестаан Дарьжааныг хайж жинчидтэй учирсан нь	163
XLII. Автандил, Гуланшарод хүрэлцэн ирсэн нь	168
XLIII. Фатьма, Автандилд сэтгэлтэй болсон нь	171
XLIV. Автандилд Фатьма янаг сэтгэлийн захидал илгээсэн нь	172
XLV. Автандил Фатьмад захидал илгээсэн нь	174
XLVI. Нестаан—Дарьжааны хувь зохиолын тухай Фатьма өгүүлсэн нь	175
XLVII. Нестаан Дарьжааныг босоо ороолон олзолсон тухай Фатьма өгүүлсэн нь	189
XLVIII. Нестаан Дарьжаанд Фатьма захидал илгээсэн нь	196
XLIX. Нестаан—Дарьжаан Фатьмад захидал илгээсэн нь	199
L. Нестаан—Дарьжаан янагтаа захидал илгээсэн нь	201
LI. Автандил Придонд захидал илгээсэн нь	205
LII. Автандил Гуланшараас одож Тариэльтэй учирсан нь	207
LIII. Тариэль Автандил хоёр Придонтой учирсан нь	213
LIV. Придон зөвлөн сануулсан нь	216
LV. Автандилийн санал	217
LVI. Тариэлийн санал	219
LVII. Ороолонгийн цайз эзэлж Нестаан Дарьжааныг аварсан нь	221
LVIII. Тариэль лусын хаанд очсон нь	224



УЛАМ
04.03.53.20
0125.010133

LIX. Тариэль, Нестаан Дарьжаан хоёр Придоны ордноо хурим ласан нь	229
LX. Гурван баатар агуй дайрч Араб оронд очсон нь	233
LXI. Автандил Тинатин хоёрын хурим	240
LXII. Энэтхэгийн хаан хальсныг Тариэль мэдсэн нь	244
LXIII. Тариэль Энэтхэгт ирж Хятаныг дарсан нь	247
LXI. Автандил Тинатин хоёрын хурим	252
Төгсгөлийн үг	256

Шота Руставели
БАРСАН ХЭВНЭГТ БААТАР
ВИТЯЗЬ В ТИГРОВОЙ ШКУРЕ

Техникийн редактор *Ц. Содов*
Хянагч *Б. Лхагвасүрэн*

*

А—10734. Хэвлэлтэнд 1962 оны
3 дугаар сарын 29-ний өдөр
Цаасны хэмжээ 60X92 1/16
Хэр хуудас 16,25. Хэвлэсэн хувь 15000.
Зах № 460 үнэ тө мө

*

Сүхбаатарын нэрэмжит
Хэвлэлийн комбинат
Улаанбаатар
Сүхбаатарын талбай, 2.

